

# ЗАХ ЗЭЭЛИЙН

## “БҮЭ ХАМГААЛАГЧ”





МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ  
ХУДАЛДАА АЖ  
ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

# ЗАХ ЗЭЭЛИЙН “БИЕ ХАМГААЛАГЧ”

Улаанбаатар хот  
2012 он

## АГУУЛГА

Өмнөх үг	4
• Хөгжлийн өнөөдөр ба маргаашийн асуудлаар МҮХАҮТанхимын байр суурь	5
• Монголбанк инфляцийг онилно гэж худлаа ярьдаг. Тэд хэзээ ч байгаа онодоггүй	30
• Бизнесийн орчинд яаралтай шинэчлэл хийх хэрэгтэй	36
• Мөнгөний бодлогыг зөвхөн цөөн хэдэн хүн шүүмжлээд байгаа юм биш	44
• Нэг сая төгрөг тараалаа гээд эдийн засаг хөрөхгүй, халахгүй	45
• Хувьцаанаас үүдэн хамгийн муу компанийн засаглал бий болно гэдгийг баттай хэлье	50
• Сэтгэлгээ, хөгжлийн загвараа өөрчлөх асуудлыг улс төрийн намууд эхлэх ёстой	55
• Монголчууд өөрийнхөө гараар өөрсдийгөө хорлож байна	59
• Улс төрийн сонголт хийх цаг нь болсон	62
• Эдийн засгийн гэхээсээ илүү улс төрийн шалгуураар төсвийг үнэлж дүгнэдэг болчих гээд байна	68
• Таван Толгойд Монгол компаниудыг үндсэн тоглогч болгох эрх нь УИХ-ын мэдэлд байна	74
• Төрийн өмчийг шүтэх дуршил бүхий бодлого нь эцэг - төрийн зарчмаар явж байгаа хэрэг	75
• Хоёр дахь “Эрдэнэт” болж мэдэх Тавантолгойд бүгд очиж баясаад л ... ямар хэрэгтэй юм бэ	80
• Төр бизнесмэн болчихоод компаниудтай өрсөлдөөд байдгаа болих хэрэгтэй	84
• Намууд хоцрогдсон арга барилтай байна	94
• 630 төгрөгөөр өөрсдөө талхаа авч ид	97

• УИХ-ын гишүүд Монголбанкны олон хуудас мөнгөний бодлогын материалд хууртагдаж болохгүй	104
• Ажлын арга барил хуучнаараа явах юм бол бизнесийн орчин байх байдгаараа л байна	113
• Туулыг бохирдуулсан арьс ширний үйлдвэр шиг хөрөнгө оруулалт цаашдаа орж ирэхгүй	119
• Манай нөхцөлд бонд гаргах нь арай эртэднэ	121
• Эдийн засгийн өсөлтийг сайжруулахад бизнесийнхэнтэй хамтран ажиллах шаардлагатайг онцоллоо	126
• Зах зээл рүүгээ бурууг тохдог хандлага бий болж байна	128
• Би өөрт байгаа зүйлдээ сэтгэл ханачихсан хүн	131
• Нийтээрээ хувьцаа эзэмшиж, аз жаргалтай нийгэм байгуулна гэдэгт би итгэдэггүй	137
• Монгол мөнгө хадгалах мундаг баян орон болохгүй, баталгаатай хэлчихье	144
• Монголбанк өвдсөн нэг компанидаа эмчилгээ хийж байна	148
• Эдийн засгийн хямрал 2010 оны эхний улиралд үргэлжлэх шинжтэй байна	150
• Байгаль орчинд ээлтэй 50 жилийн гараа эхэллээ	158
• Зээлэхгүй бол мөнгө байршуулах хэрэг юу байна.	158
• Нострадамус маягийн хүмүүс намайг Сү.Батболдын захилгаар ИЗНН-д орж, дарга нь болно гэж зөгнөж байсан	163
• Хэт их зохицуулалттай байдал биднийг алж байна	168
• Сэтгэлгээ, хөгжлийн загвараа өөрчлөх асуудлыг улс төрийн намууд эхлэх ёстой	172
• Эдийн засгийн шинэчлэл ба хөгжил: Юуг Яаж хийх вэ?	177

## ӨМНӨХ ҮГ

Өнгөрсөн жилүүдэд сонин хэвлэлүүдэд өгч байсан ярилцлагууд, ганц нэг бичиж байсан зүйлээ нэгтгээд энэхүү бэсрэг номыг уншигч Таны анхааралд толилуулж байна. Яагаад? Яагаад гэвэл хэрэв бид зөвхөн төрийн үгээр л яваад төрийн хийж буй зүйл бүхнийг нь хүлээн зөвшөөрөөд явбал нийгмийн амьдрал олигтой урагшилж ард түмний амьдрал та бидний хүсэж, байдаг шиг дээшилж чадахгүй. Та, би, бид бүгдээрээ л дуугарч байж, шүүмжилж байж сайн төр, сайн засаглалыг бий болгоно уу гэхээс дор бүрнээ ТВ үзээд дотроо шүүмжлээд, санал бодлоо гаргаад явбал бид муу төр, муу засгийн горьг өөрсөд дээрээ амсаж мэдэрдэг. Тиймээс л таны, миний, бусад мянга мянган хүний бодол санал нийлж байж л энэ нийгмийг өөрчилж чадна. Өөрчлөлтийн эзэн нь, гардан хэрэгжүүлэгчид нь та бид байх ёстой. Тиймээс Та дуугар, шүүмжил, саналаа хэл, санал бодол тань маш үнэтэй гэдгийг зөвхөн 4 жилд нэг удаа л мэдсэний хэрэггүй. Өдөр бүр энэ нийгмийг, амьдралаа өөрчлөхийн төлөө тэмц. Өөрчлөлтийн салхи Монгол орон руу минь айсуй.

Их салхин хөдөлбөөс нижигнэнхэн хөдөлтүгэй!

МУХАҮТ-ын дарга



С.Дэмбэрэл



## ХӨГЖЛИЙН ӨНӨӨДӨР БА МАРГААШИЙН АСУУДЛААР МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН БАЙР СУУРЬ

### Өнөөдөр:

Засгийн газрын зүгээс макро эдийн засгийг удирдах, төсөвт орж ирж буй болон ирээдүйд орж ирэх орлогыг хувиарлах, зохистой, үр ашигтай байршуулах, дахин байршуулах замаар эдийн засгийг идэвхжүүлэх, бодит секторын нэмэгдсэн өртөг бүтээх үйл явцыг дэмжих, хэрэглэгчийн зах зээлийг тогтворжуулах, инфляцыг залуурдах боломжтой түвшинд барих зэрэг бодлогын зорилтууд гацаанд орж эдийн засаг маневарлах чадвараа алдаж байна. Сангийн яам “бондын” нярав, Монгол банк мөнгөний няравын чиг үүргийг гүйцэтгэхээс хэтрэхгүй хязгаарлалтанд оров.

Сангийн болон мөнгөний бодлого хоорондын уялдаа зохицолдоог хангах боломжгүй болж энэ талаарх хүчин чармайлт анхнаасаа бүтэлгүйтэх байдалд орж байна. Инфляц, түүний хүлээлтэнд нөлөөлнө гэж эдийн засгийн бодит амьдралаас тасархай төсөөлөн Монгол банк боловсруулж, УИХ баталдаг мөнгөний бодлого нь сэргэх яагаа ч үгүй байгаа бодит секторын үйл ажиллагааг архаг сульдаанд оруулж, арилжааны банкуудыг буруу авир төрх, хүлээлттэй болгодог хандлага 2007 оноос хойш архагшив. Эдийн засаг эдийн засгийн утгаа алдаж хязгаарлагдмал нөөцийг хамгийн зохистой хувиарлаж чаддаг зах зээл, хамгийн зохисгүй хувиарлаж чаддаг төр хоорондын зохистой харьцаа алдагдаж үнэн хэрэгтээ төр эдийн засагт давамгайлах үүрэг гүйцэтгэж байна.

Энэ бүхний цаана олон шалтгаан бий хэдий ч хамгийн гол, суурь шалтгаан нь сангийн болон эдийн засгийн зохистой бодлого хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан бэлэн болон бэлэн бус мөнгөний улс төрийн популист амлалтууд, эдийн засгийн бодит боломжоос давсан нийгмийн төрөл бүрийн халамж юм. Тиймээс амлалтуудаа ажил болгох гэж эдийн засгаа мөн чанарыг нь эвдэх үү эсвэл эдийн засаг гэсэн олон зуун жил хүн төрөлхтөн мөрдсөн

сонгодог тодорхойлолтоор нь авч үлдэх үү гэсэн нэг сонголт, хавтгайрсан халамжийг цэгцлэх ёстой, халамжийн реформ хийх шаардлагатай гэсэн улс төр биш эдийн засгийн зохистой сэтгэлгээ давамгайлсан нэг хэсгийнхээ зөв гаргалгааг “ширүүн реформ хэрэггүй, шилжилтийн үед явж байна” гэх мэтээр юу ярьж байгаагаа өөрсдөө ч ойлгохоо болчихсон нөгөө хэсгийн “уярмаар” учирлалаар үгүй хийх үү гэсэн нөгөө нэг сонголт Монгол улсын төр баригчдын өмнө байна. Хэрэв эдгээр сонголтыг зөв хийж чадвал хүсэл, хүлээлт үүсгээд байгаа хүүхдийн мөнгийг тэгш хувиарлах замаар биш тэгш боломжийг олгох зарчмаар зорилгот бүлэгт нь олгох хэрэгтэй. Энэ тохиолдолд хүүхдийн мөнгө нь халамж биш хүүхдэд оруулж буй хөрөнгө оруулалтын утга агуулгатай болно. Хэрэв үнэхээр бүх хүүхдэд олгоно, алаг үрсээ ялгаварлахгүй гээд байгаа юм бол тэдний төлөө “за” гэж хэлэх маш олон ажилд нь зориулж, ядахдаа Яармагийн дэнж дээр яах гэж байгаа нь мэдэгдэхгүй хашчихсан байгаа сул газрууд дээрээ хүүхдийн хотхон, хүүхдийн парк байгуулаад өгчих, ядахдаа агаар сайтай юм.

#### **Өнөөдөр:**

Монголын бизнес эрхлэгчдийн нэлээд хэсэг төсвөөс байршуулж буй 30 млрд төгрөг, шударга, ил тод хэрэгждэгсэн бол илүү үр ашгтай, үр өгөөжтэй болох ёстой төсвийн хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалт, хувийн хэвшилд олгож буй гадаадын зээл, хөтөлбөрөөр амь зогоож байна. Бичил болон жижиг бизнес эрхлэгчид сумдад 40-60 сая төгрөг хувиарлахыг дэмжиж байгаа, Улаанбаатар хотод дүүрэг болгонд бас ийм сан бий болгоосой гэж хүсэж байгаа, жижиг, дунд бизнесийг дэмжих санг нэмэгдүүлж, зээлийн баталгааны тогтолцооны эрх зүйн үндсийг яаралтай бий болгохыг хүлээж байгаа. Томоохон үндэсний компаниуд нь хөгжлийн томоохон төслүүд дээр тэдэнд боломж олгож төртэйгөө хамтран түүний дэмжлэгтэйгээр үндсэн тоглогчоор оролцуулахыг хүсэж байгаа, тэдний араас туслан гүйцэтгэх гэрээний үндсэн дээр үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөжүүлэхийг хүсэж байгаа олон мянган жижиг, дунд бизнес эрхлэгчид зах зээлийн боломж хүлээж байгаа. Энэ бол компаний өсөлт, хөгжлийн явцад үүсэж гарах жам ёсны хүсэлт бөгөөд үүнийг Монголын төр дээд зэргээр ойлгон хүлээн авах учиртай. Монголын компаниуд чаддаг юмаа өөрсдөө хийх, чаддаггүй юмаа бусадтай хамтраад хийх боломжийг нь олгочихвол л төрийн хамгийн зөв бодлого болно.

#### **Өнөөдөр:**

Монгол улс авилга, хээл хахуулийн сүлжээгээр л онцгойрдоггүй юм бол бусад улс орноос ердөө ч ялгарах юмгүй, нөөц баялаг ихтэй, далайд гарцгүй, хүн ам цөөн, эмзэг, жижиг эдийн засагтай улс орнуудтай л адилхан хөгжиж буй орон. Бид улс төрийн ч эдийн засгийн ч хувьд бусдад үлгэр үзүүлээд байхаар загвар орон биш. Авторитари дэглэмтэй зарим улс орнуудыг бодвол ардчилсан замаар 20 гаруй жил замнасан хэдий ч эцсийн үр дүн нь ардчилал, түүний үнэт зүйлс нь нийгмийн бие, эд эсэд бат бөх шингэж, итгэл үнэмшил болж чадаагүй өнгөц ардчилалтай улс орон болсон гэдгийг нийгэм өөрөө хүлээн зөвшөөрөөд бодит баримт, судалгаагаар тогтоочихсон. Ийм л улс оронд, ийм л эдийн засагт бид хөгжлийн тухай ярьж, төсөөлж, төлөвлөж байгаа болохоор бодит байдлаасаа тасарч тэнгэрт хөөрөлгүйгээр, хаа ч байхгүй „гайхамшигтай өсөлт, хөгжилд“ хүрэх хаа ч байдаггүй өвөрмөц, цоо шинэ хөгжлийн арга замыг зохиогоод байх хэрэггүй юм. Энэ бол үүлэн чөлөөний нар ч биш ердөө л хуурамч зэрэглээ юм.

#### **Өнөөдөр:**

Ард иргэдийн аж амьдрал доройтож нийгэм саарал, гундуу байдалд орж байна. Үнийн өсөлтийн өмнө өвдөг сөхрөөд байгаа ард иргэдээ үе үе шоконд оруулахгүй гэж бодож байгаа бол өргөн хэрэглээний гол нэр төрлийн бараануудын үнэ бүрдэлтийн замын зургийг нь нийлүүлэлтийн гинжин хэлхээний бүх сувгаар гаргах хэрэгтэй. Импортлогдсон инфляц, эрчим хүчний зардлын инфляц, хариуцлагагүйн инфляц, хүнд суртлын инфляц халамжийн инфляц, ханшийн инфляц, “үйлдвэрчний эвлэлийн” инфляц, үрэлгэн зарлага, үр ашиггүй хөрөнгө оруулалтын инфляц..гээд бараг морины цол дуудаж байгаа юм шиг үргэлжилсэн юм гарна. Гэхдээ энэ бүхний шийдэл нь эдийн засгаас мөнгийг татаж бодит сектороо саажуулах замаар бус, эдийн засгийн “цусны эргэлтийг” удаашруулж архаг цус багадалттай болгох замаар бус гэдэг нь тов тодорхой байгаа. Танхимаас энэ асуудлаар урьд өмнө нь удаа дараа байр сууриа илэрхийлж өнөөдрийн мөнгөний бодлогыг өөрчлөх саналаа тавьж байсан. Гэхдээ юуны чихэнд юу ч хийсэн сэгсрэнэ гэдэг шиг л юм болдог юм байна лээ. Бүүр арга ядаад “Монгол банкны хэлж ярьж байгаагаас яг эсрэгээр нь хий” гэсэн зөвлөмж хүртэл Засгийн газарт өгч байсан. Нийгмийн ядуу хэсэгт хамгийн хүндээр тусч, нийгэмд дунд анги бүрэлдэх үйл явцад хортойгоор нөлөөлж байдаг инфляци гэдэг энэ үзэгдэлд эрэлт нийлүүлэлтийн талын маш олон хүчин зүйл нөлөөлдөг нь бодит



амьдрал дээр улайн цайм харагдаад байхад л эдийн засагт байгаа мөнгийг ихэсгэх, багасгах замаар инфляцийг удирдаж болно, нэг оронтой тоонд барьж болно хэмээн монголын бодит амьдралаас хийсвэр тасархай төдийгүй /зөвхөн хийсвэр, амьдралаас тасархай байсан бол ч яая гэхэв, тэсч болох/ хамгийн гол нь эдийн засгийг, бодит секторыг хорлодог энэ бодлогыг хүлцэн тэвчээд, хүлээн зөвшөөрөөд, хууль болгоод яваад байх уу цаашдаа?! “Цалин-үнэ-цалин” гэсэн спираль “хавтгайрсан халамж-үнэ-хавтгайрсан халамж” гэсэн спиральтай зуузай нийлүүлж шогшоо инфляцаас цогио инфляцийг үүсгэж байхад үйлдвэрчний эвлэлийг буруутгаад ч яах билээ. Орлогын тэгш бус байдал эрс хурдацтай нэмэгдэж атаа хорсол, уур хилэн, айдас түгшүүр араасаа дагуулдаг нийгмийн хуваагдал холгүй болж нийгмийг чирж явдаг, хөл дээрээ баттай зогссон дунд анги улам бүр үгүйлэгдэж байна. Ард иргэд нь төрийн бэлэн мөнгөний хишиг авах гэж дугаарлан зогсох бодит дүр зураг Монголын нүүр царайг огт сайхан харагдуулахгүй харин ч төрийн хишгийг тэгш хүртээх гэсэн энэ социалист угшилтай үзэл номлол нь үндсээрээ буруу гэдгийг л харуулж байна. Ард иргэддээ аж амьдралаа дээшлүүлэх тэгш боломжийг л олгох нь төрийн чиг үүрэг болохоос биш тэгш хувиарлах номлолыг төрийн бодлого болгон хөгжлийн талаарх нийгмийн сонголтыг сатааруулан эвдэх нь төрийн чиг үүрэг огт биш билээ. Хүмүүст хөгжих эрхийг нь хангаж өгдөг, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тэгш боломжийг тэгш хуваарилалтаар орлуулахыг оролдох нь хүмүүсийг нийгмийн төдийгүй биологийн амьтны хувьд нь ч гутаан басамжилж янаглан хорлож буйтай агаар нэгэн буйзаа.

#### **Маргааш:**

Бид маргаашийн гэрэлтэй байж болох ирээдүйн талаар их тодорхой ярьж ард түмэнд эерэг хүлээлт, горьдлого, найдлага төрүүлж байгаа мэт харагдавч үнэн хэрэгтээ өнөөдрийн харанхуй, саарал гундуу нийгмийн суурь дээрээс маргаашийн “гэрэлт ирээдүйг” төсөөлж, төлөвлөх нь өнөөдрийнхөө харанхуйг гэрэлтүүлж чадахгүй байна. Хүмүүст маргаашийн амьдралынх нь суурь дэвсгэрийг хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын түвшинд тавьж өгөх нь зөв хэдий ч өнөөдрийн амьдралын асуудлуудыг нь онцлон анхаарч хэлэлцэх, шийдвэрлэх асуудлуудынхаа дэс дараалал, цаг хугацааг оновчтой тогтоохгүй байгаа учраас нийгмийн эрэлт, хэрэгцээнд хариу урвал үзүүлэх төдийгүй, түүнийг угтаж харсан хууль эрх зүй, гүйцэтгэх засаглалын шийдвэр хоёрын хооронд том ангал үүссэн байна. “Монгол мал”

гэсэн хөтөлбөрийг маш том үнийн дүнтэй баталчихсан хирнээ Монгол хүний эрүүл мэнд, түүний даатгалыг зохицуулсан хуулийг батлахыг яарахгүй, онцгой анхаарал хандуулахгүй байгаа нь үүний нэг жишээ.

Өөрөөр хэлбэл бид хөгжлийн өнөөдөр, маргаашийн тэргүүлчлэл /приоритет/ дээрээ алдаад байгаагийн улмаас нийгэм хүсээд байгаа, нийгэмд яг одоо, өнөөдөр хэрэгтэй буй асуудлуудад бодлогын бүх түвшинд хариу өгөх, зохистой шийдвэрлэх асуудал орхигдоод, удаашраад эсвэл оновчтой биш шийдвэр гараад байна. Энэ нь эргээд нийгмийг бухимдуулж төрд итгэх итгэлийг сулруулж байна.

#### **Өнөөдөр:**

Газрын дорхи нөөц бол монголын ард түмэнд заяагдмал зүйл бөгөөд үүнийг эрдэнийн хувь, эх орны хишиг гэх мэтээр юу ч гэж нэрлэж болох боловч эдийн засгийн „хуурай“ хэлээр бол „resource endowment“ буюу „заяагдмал нөөц“ л гэдэг. Харин энэ заяагдмал нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулснаар л баялаг бүтээгдэж эдийн засгийн үнэлэмж нь бий болж эхэлдэг. Энэхүү бүтээгдсэн баялгийг шударга ёсны зарчимд нийцүүлж хуваарилах нь зах зээлийн эдийн засгийн зарчим, ард түмэнд наалдацтай эдийн засгийн өсөлтийн бодлого, орлогын хэт ялгаралтыг багасгах, ядуурал, ажилгүйдэл, авилгын эсрэг бодлого гэх мэт эдийн засаг, нийгмийн цогц бодлогоор „заяагдмал нөөц“ байхад нь биш баялаг бүтээгдэж эхэлсний дараагаар тодорхойлогдох, сонгуулийн амлалтыг биелүүлэхийн тулд биш эдийн засгийн хөгжлийн боломж, зохистой байдал, бодит үр дүнгээр, мөнгө-санхүүгийн нөөцийг зохистой, үр ашигтай байршуулах, дахин байршуулах зарчмын дагуу л тодорхойлогдох ёстой.

Тэгш боломж, тэгш хуваарилалт 2 бол тэс ондоо ойлголтууд бөгөөд эхнийх нь 20 жилийн өмнө Монгол улс эргэлт буцалтгүй сонгосон ардчилал, шударга ёс, зах зээлийн эдийн засгийн тогтолцооны нэг гол ойлголт, нөгөөх нь Монгол улс 20 жилийн өмнө орхисон социалист тогтолцооны гол ойлголт. Гэтэл бид өнөөдөр заяагдмал нөөцөө эдийн засгийн эргэлтэнд оруулаагүй байж, эдийн засгийн эргэлтэнд оруулае гэсэн дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад харилцан хүлээн авч болохуйц хөрөнгө оруулалтын тэгш боломжийг эрх зүйн болон эдийн засгийн утгаар нь олгоогүй хэрнээ, ард түмэндээ амьдрал ахуйгаа дээшлүүлэх тэгш боломж олгохын оронд „алаагүй баавгайн арьсыг“ аль хэдийн тэгш хуваарилах зарчмаар хуульчлахаар зэхэж байгаа

нь Монголын нийгэм эрүүл бус болсныг, эдийн засаг дахь ашигт малтмалыг тойрсон нийгмийн хийрхэл, төрийн хэт их оролцоо түүнээс улбаалсан эрдэс баялгийн салбарт төрийн авторитар дэглэмийг ард түмний төлөө гэсэн нэрээр түүний нэрийн өмнөөс тогтоох гэсэн бодлого, эдийн засгийн үр ашиггүй менежмент, хөгжлийн бодлогын буруу номлол бий болсныг харуулж байна.

### **Маргааш:**

Нөөцөөр баялаг эдийн засагтай улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэхэд бодлогын шийдвэр гаргагчид нь ч ард иргэд нь ч онцгой анхаарч зайлсхийвэл зохих 2 зүйл: „голланд өвчин“, „нөөцийн хараал“ гэж байдгийг, ямар симптом, шинж тэмдэгүүд илэрдгийг монголын нийгмийн тодорхой хэсэг мэднэ. Энэ талаар олон улсын байгууллагууд сануулаад л байгаа. Өнгөрсөн жилүүдэд эрдэс баялгийг тойрсон маргаан, нийгмийн буруу хүлээлт рүү хөтөлсөн сурталчилгаа, түүний үр дүнд өнөөдөр бодитойгоор бий болсон нийгмийн сэтгэл зүй, монголын хөгжлийн тухай төсөөлөл, стратегийн гэж нэрлэгдсэн орд газрууд, уран зэргийг тойрсон „нийгмийн хийрхэл“ гэж нэрлэж болохуйц эдгээр гаж үзэгдэл нь Монгол улсад „голланд өвчин“, „нөөцийн хараалын“ тодорхой шинжүүдийг агуулсан төдийгүй өөр шинэ симптом, шинж тэмдгүүдээр баяжсан нийгмийн шинэ өвчин үүссэнийг харуулж байна. Түүнийг „Заяагдмал нөөцийн дархлал хомсдолын олдмол хам шинж“ /the immune deficiency syndrome of resource endowment/ гэж нэрлэж болох бөгөөд үндэсний хөгжлийн дархлааг сулруулах, устгах дараах шинж тэмдэгүүдтэй нь тодорхой байна. Үүнд:

- Ажилгүйдэл, ядуурал ихтэй, авилгал хүнд сурталд идэгдэж архагшсан засаглалын технологтой, ард түмэндээ газрын дорхи баялагтаа хэт дулдуйдах, бэлэнчлэх сэтгэлгээ, хүлээлт, хишиг горьдолтыг системтэйгээр төлөвшүүлдэг, өөрсдөө бараг итгэл үнэмшлээ болгосон төртэй,

- Хуулийн засаглал гэхээсээ илүү намын засаглал /намын доторх болон нам хоорондын фракц, нэгдлүүд / үнэн хэрэгтээ хэрэгждэг улс оронд заяагдмал нөөцөө баялаг болгож эдийн засгийн эргэлтэнд оруулахаасаа өмнө улс төрийн амлалтанд суурилсан тэгшитгэн хуваарилах сэтгэлгээ, номлол улс төрчдөд нь зуршмал болж эхэлдэг,

- Заяагдмал нөөц дээр суурилсан “хамгийн дөт, хамгийн гайхамшигтай бөгөөд цорын ганц” хөгжлийн үзэл баримтлал, номлол, арга замыг нийгмээрээ эрэлхийлж түүнийг нь улс төрчид

нь бодож олон санаачилж хуульч лахыг эрмэлздэг,

- Эрдсийн түүхий эдийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс төсвийн орлого, зарлагын хуваарилалт нь ихээхэн хамаардаг эдийн засагтай улс орны хувьд төсвийн болон сангийн бодлого нь улс төрийн эрх баригч намын амлалтын нөлөөнд орж төсөв, санхүүгийн нөөцийг зохистой, үр ашигтай байршуулах, дахин байршуулах эдийн засгийн шалгуур нь сонгуулийн улс төрийн амлалтын барьцаанд орж хөгжлийн санхүүжилтийн тэргүүлчлэл, цаг хугацаа, дэс дараалалыг мэргэжлийн байгууллага нь эдийн засгийн бус улс төрийн „шалгуураар“ шахалтаар тогтоодог болсноор нийт эдийн засгийн бодит үр ашиг “хөөсөн” өсөлтийн үзүүлэлтүүдийг эс тооцвол үнэн хэрэгтээ буурч эхэлдэг,

- Хөрөнгө оруулагчдад зориулсан „түрүүлж ирсэн нь түрүүлж үйлчлүүл“ гэсэн зөв зарчмын мөн чанарыг нь гажуудуулж лицензээр угаасаа наймаа хийж болохгүй эрх зүйн үндэслэлтэй байтал лицензийн наймааг албажуулж хавтгайруулсан, эрдэс баялгийн салбарын тогтвортой хөгжил, ил тод байдлын үзэл баримтлалыг эл салбарын үйл ажиллагаанд тууштай нэвтрүүлээгүйгээс байгаль орчинд ихээхэн хор уршиг учирч бизнес ба иргэний нийгмийн хооронд үл ойлголцол, зөрчил үүсч тэр нь аажимдаа улс төрийн бүлэглэлүүдийн явцуу эрх ашгийг хангах арга хэрэгсэл болж хувирах, нийгэмд “эрдэс баялгийн бизнес бохир”, “иргэний нийгэм худалдагдсан” гэсэн ойлголтыг төрүүлж эцсийн дүндээ зах зээлийн эдийн засгийн 2 гол институц болох хувийн хэвшил, иргэний нийгмийн нэр хүндийг нийгэмд унагахад хүргэдэг,

- Төрийг шүтдэг уламжлалт нийгэмд үүсэн бий болсон зах зээлийн эдийн засаг буюу капиталын нийгэмд эдийн засаг дахь төрийн оролцоо социалист шинж чанартай болж төр өөрөө том “бизнес эрхлэгч” болсноор авилгал, хээл хахуулийн шалтгаан, үр дагавар нь төр өөрөө болж, энэ нь эрдэс баялгийн салбарт хамгийн тодоор илэрч эхэлдэг,

- “Заяагдмал нөөц” үндсэн хуулинд тусгагдсанаар “ард түмний мэдэлд” буюу нийтийн өмчлөлд байх тухай заалтыг “төрийн өмч” хэмээх ойлголтонд шилжүүлснээр ард түмнээс сонгогддог институцууд нь ёс төдий, эрх мэдэлгүй, гагцхүү УИХ буюу ард түмнээс сонгогддог дээд институц нь нийтийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхүүдийг төрийн гүйцэтгэх эрх мэдлийн институцэд шилжүүлж “ард түмний мэдлийг” эрх зүйн хувьд хадгалах байтал төр=засгийн газар- өмчлөгч гэж шийдвэрлэснээс эрх зүйн хувьд төдийгүй эдийн засгийн утгаараа ч буруу тогтолцоотой болдог,

- Эндээс үүдэн эрдэс баялгийн салбарт төрийн оролцоог давамгайл болгох, “төрийн өмчийн” компаниудыг байгуулах дуршил нэмэгдэх, хувийн хэвшлийн эрх мэдлийг хязгаарлах, зарим тохиолдолд бүр булааж авах, эрдэнийн хувь, эх орны хишиг, түүнчлэн “Эрдэнэс Монгол”, “Баянмонгол корпорац” гэх мэт нэртэй зөвхөн Монголд л бодож олж болох санхүүгийн бүтэц /тэр нь нийт ард түмэнд хувьцаа эзэмшүүлж ногдох ашиг хуваарилаж дэлхийн хөрөнгийн зах зээл дээр „цахиур хагална“ гэж байгаа/ зэргийг хуульчилж эхэлдэг зэрэг хам шинжүүдтэй бөгөөд эдгээр хам шинж бүр нь дангаараа болон бүхэлдээ хөгжлийн дархлааг урт хугацаанд сулруулах, гэмтээх аюул заналыг өөртөө агуулж, хөгжлийн зөв номлол, арга замыг дэлхийн улс орнуудын хөгжлийн туршлага, орчин үеийн чиг хандлагад суурилан тодорхойлох аргагүй болгож нэг хүнд ногдох ДНБ-ийг 5,10,15 мянган доллар болгоно гэх мэт „хүслийн жагсаалт“ л хөгжлийн албан ёсны баримт бичиг, бодлогын чиг баримжаа, стратеги болдог.

#### **Өнөөдөр:**

Эрдэс баялгийн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах үйл явцад эдийн засгийн хувьд хамгийн оптимал хувилбарыг олж хэрэгжүүлэх учиртай байтал улс төрийн 2 гол намын дээрх амлалт, хандлагыг гол зорилго болговол 2 намаас эвслийн шийдвэр гарсны хамгийн том, үр дагавар нь олон жилийн дараа ч үргэлжлэх алдаа болно. Үүнийг үндэсний эрх ашиг, ард түмний сайн сайхан байдал гэх мэтээр яаж ч өлгийдсэн энэхүү алдааны хор уршгийг үндэстнийхээ хувьд бид амсах л болно. “Голланд өвчин”, “баялгийн хараал” гэж бусдын алдааг саяхнаас олж мэдсэн Монгол улс өөрөө эдгээрийг шинэ симптом, агуулгаар баяжуулсан улс болох зам сонгож болохгүй. Бөөний худалдааны сүлжээ байгуулна, /байгуулчихсан ч билүү ?/ хөдөө аж ахуйн түүхий эдийн бирж байгуулна, өөр юу юу ч байгуулна билээ гэх мэт “бүтээн байгуулалтаа” төвлөрүүлэх, хувиарлах, өөрсдөө эсвэл өөрийнхөө ажилладаг институцээс хамааралтай болгохыг хүсдэг, ийм ч зорилготойгоор хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр бэлтгэж оруулдаг түшмэдээс бус, нийлүүлэлтийн гинжин хэлхээний /supply chain/ дотор нь ажилладаг зах зээлийн операторуудаас илүүтэй асууж, тэдэнтэй зөвлөлдөж, санал бодлыг нь бодитойгоор тусгадаг байдлаар хэрэгжүүлдэг хууль эрх зүйн болон бодлого, шийдвэр гаргалтын технологийг нэвтрүүлэх нэн шаардлагатай байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн үзэл баримтлалыг баталж гаргачихсан мөртлөө түүнийгээ өөрөөсөө

эхэлдэггүй УИХурал буюу “ард түмний элч” нар байж таарахгүй. Төрийн ордонд ард түмний элч нар чуулдаг танхим гэж байхад тэднийг сонгодог иргэдийн танхим гэж бас бий болсон. Энэ 2 танхимыг хооронд холбох амьд сүлжээ бий болгох ёстой байтал “музей үзэх” маягаар дугаар тойргийн сонгогчдоо УИХ-ын танхимд авчирч байгаа нь, зөөлнөөр хэлэхэд, марзан байна. Шинээр ямар нэг хууль батлахдаа, ёс шиг, нэг мундаг эрх мэдэлтэй шинэ институтцийг гаргаад баталчихдаг буруу практикаас татгалзах ёстой. Маргаашийн өргөн, нарийн царигийн талаар өндөр итгэл үнэмшил, үнэнхүү эх оронч байр сууриа тайлбарлан нотолж буй сайд өнөөдөр салбартаа бугшсан хүнд суртлыг яаж үгүй хийхээ дуугарахгүй л байна. Халамж хавтгайрсан өнөөдрийн нийгэмд шинэчлэл хэрэгтэй гэж УИХурал нь үзээд байхад “ширүүн реформ хэрэггүй, шилжилтийн үед явж байна” гэж “матрын нулимс” унагаж байгаа сайдыг бид юу гэж ойлгох вэ? Утаагүй Улаанбаатар, үндэсний парк, мастер төлөвлөгөө ярьж, 61 аж ахуйн нэгжийг ядуурлаас үүсэлтэй архидалт, гэмт хэргийн үүр уурхай гэж яллаж бизнесийн үйл ажиллагааг нь зогсоож байгаа Улаанбаатар хотын захиргаа, иргэдийн хурлын сонорт бүх төрлийн зөвшөөрөл, лицензийн тоог 2 дахин багасгана гэх мэт бизнесийн орчны шинэтгэлийн жилийн үг үсэг, үзэл санаа хүрсэн болов уу?! Замбараагүй болсон хотжилтын гажуудлуудыг засахад хэрэгтэй хот байгуулалт, архитектур төлөвлөлттэй холбоотой хэд хэдэн хууль шаардлагатай байгаа талаар мэргэжлийн хүмүүс, байгууллагууд нь ярьж хэлсээр байгаа хэдий ч “даанч эрх мэдэл дутаад байна”, эрх мэдлийг маань нэмэгдүүлчихвэл ёстой ажиллаад өгнө” гэх маягийн юм ярьж хууль лоббидож байгаа удирдлагад нь итгэж болох уу? Сүхбаатар, Чойбалсангийн хөшөөг хүрэл болгоно гэх мэт элий балай нь мэдэгдэхгүй юм ярьж байхын оронд тэр илүүдээ гараад байгаа мөнгөө байгаль орчноо хамгаалах төсөвт нэмж суулгах нь дээр бишүү?!. “Төр хамгийн муу менежер байдаг” гэсэн энэ либерал тодорхойлолтын үүднээс авч үзвэл Улаанбаатар хот түүний сонгодог жишээ болж хамгийн муу менежменттэй төдийгүй хамгийн муу байгаль хамгаалагч болон хувирсан байна.

#### **Өнөөдөр:**

Өнөөдрийн Монголыг 4 тойрогт /сонгуулийнх биш/ хувааж болох бөгөөд 1-р тойрог буюу пирамидын ёроолын зах зээлийн харилцаанд ордог ядуу хэсэг албан статистикаар хүн амын 37 хувь амьдралын статистикаар 50 илүү хувийг эзэлж, хувь



хэмжээ нь 20 жилийн турш тууштай буухгүй харин ч нэмэгдэх хандлагатай болсон байна. Тогтвортой амьжиргааг бий болгох гэгээн зорилготой төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж ирсэн ч “тогтвортой ядуурал” л гүнзгийрсэн бараан үр дүнтэй байна. 2-р тойрог буюу албан бус секторын тойрогт ойролцоо тооцоогоор 400 гаруй мянган хүн аж амьдралаа зохицуулах, дээшлүүлэх гэж, ядуурлын тойрогт уначихгүй юмсан гэж чардайн хөдөлмөрлөж байгаа. Эдэнд чиглэсэн, түүний дотор Де Сотогийн нэрлэснээр “үхмэл капитал”-ыг “амилуулах” замаар албажуулах төрийн дорвитой, иж бүрэн бодлого одоо хүртэл алга л байна. Де Сото бүр өөрөө ирээд учирлаж яриад, ухуулан сэнхрүүлээд ч нэмэр алга л байна. Ингэхлээр 1-р тойрогтой адил энэ тойрог өнгөрсөн хугацаанд мөн л томорсон бүүр оноод хэлчихвэл “томсгосон тойрог” болсон гэсэн үг. 3-р тойрог буюу албан секторын тойрог. Албан ёсны статистикаар энэ тойрогт өдгөө 60 гаруй мянган аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 35 гаруй мянга нь л бодитойгоор үйл ажиллагаа явуулж, эдгээр аж ахуйн нэгжийн 90 гаруй хувь нь 10 хүртэлх ажиллагсадтай, өөрөөр хэлбэл энэ тойргийн олонхи нь жижиг, дунд бизнес эрхлэгчид юм. Өнгөрсөн 20 жилд энэ тойрогт тооны хувьд ихээхэн өөрчлөлт гарсан хэдий ч чанарын дорвитой, бүхнийг хамарсан өөрчлөлт гарах боломж олгосонгүй. 4-р тойрог Засгийн газрын буюу нийтийн секторын тойрог бөгөөд энэхүү тойрог сүүлийн 20 жилд ихээр цүлхийн томорч урьд өмнө байгаагүй, хүлээн зөвшөөрч боломгүй “тарган тойрог” болон хувирсан байна. Гэхдээ энэхүү “тарган тойрог” эхний 2 тойрогтой шууд болон шууд бусаар холбогддог олонхи, төрийн эрх, мэдэл, санхүүгийн нөөц, хөрөнгийг өөрсдөдөө ашигтай өрөөл бусдадаа хортойгоор ашигладаг “тарган” цөөнх гэсэн 2 хэсгээс бүрэлдэж байна.

### **Маргааш:**

Тэгвэл эдгээр 4 тойргийг хооронд нь холбосон сэжим судаснууд нь чухам юу юм, яаж ажиллаж байгаа, яаж ажиллах ёстой юм гэдэгт оновчтой хариу өгч төрийн бодлого, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлийн механизмыг үүнд чиглүүлэх нь Монголын хөгжлийн бодлогын гол зорилт, тулгуур асуудлууд мөн. “... Of the people, by the people, for the people” гэсэн ардчилалын энэ алдарт тодорхойлолт нь зөвхөн улс төрийн ардчилалын тухай биш бөгөөд хүмүүс өөрсдийнхөө төлөө, илүү шударга, сайн сайхан нийгмийг, амьдралыг хүмүүс өөрсдөө санаачилдаг, зохиогч нь болдог, өөрсдөө оролцдог, бүтээдэг тийм л нийгмийн

байгууламж, тулгуур зарчмуудын тухай өгүүлсэн хэрэг юм. Гэтэл манай улсад энэ нь өнөөдөр “... of the state, by the state and for the people” гэх маягтай юм болж хувираад байна. Энэ бол патерналист төрийн муу хэв шинжит төрөл Монгол улсад газар авч буйн нэг баталгаа мөн. Тийм ч учраас дээр өгүүлсэн 4 тойргийг хооронд нь холбох учиртай 2 сэжим судас болох **хүмүүст тэгш боломж олгож дэмжих**, хүмүүсийн нэг хэсэгт нь заяагдмал байдаг боловч ихэнх хэсэгт нь олдмол буюу төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийн бодлогоор суулгаж өгч болдог **овсгоо самбаачлалын /entrepreneurship/ үзэл санаа, үүр амьсгалыг** бий болгон төлөвшүүлвэл, ядуурлын тойрог нь байнга хүрээгээ хумиж, албан бус секторт дээрх 2 зүйлийг оновчтой хослон хэрэгжүүлснээр хүрээ нь мөн хумигдаж, албажих үйл явц нь албан бусжихаасаа хамаагүй илүү хурдацтай хэрэгждэг, албан секторын үйл ажиллагаа чанарын хувьд сайжирч Монголын олон компаниуд олон улсын худалдаа, төрөл бүрийн зах зээл дээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж үүсэх болно. Сүүлийн тойрог буюу Засгийн газрын тойрогт ч ахиц дэвшил, шинэчлэл хэрэгжиж төр нь чиг үүргээ зах зээлд саад болохгүйгээр хэрэгжүүлдэг, зарим чиг үүргээ төрийн бус байгууллагуудад шилжүүлж төр, хувийн хэвшлийн түншлэлийн механизмыг засаглалын гол технологи болгосноор бүтэц нь цомхон, бүтээмж нь өндөр, үрэлгэн зарлага нь бага, үр ашиг нь их болох юм. 4-р тойрог уг номоороо бол өмнөх 3 тойрогтоо үйлчилгээ үзүүлдэг бүтэц боловч 1-р тойрогтой ажиллах механизмаа түүнд халамж үзүүлэх механизм болгон хувиргасан, 2-р тойрогтой ажиллах механизм нь өнөө хүртэл төлөвшин бүрэлдээгүй, 3-р тойрогт үйлчилгээ гэхээсээ илүү хүнд суртал ихээр үйлдвэрлэж нийлүүлдэг болон хувирсан байна. Ийм нөхцөлд бид яаж ч Жини коэффициент, Кузнецийн муруй ярьсан дунд анги, өнөөх нийгмийг авч явдаг “цөм сүрэг” бүрэлдэхгүй.

### **Өнөөдөр:**

Өнөөдрийн хамгийн их тулгамдсан асуудал бол ядуурал, ажилгүйдэл гэдгийг бүгд мэдэж байгаа. Гэвч эдгээр асуудлыг шийдэх гэж сүүлийн 20 жилд оролдсон хандлага, арга барил, бодлогодоо өөрчлөлт оруулахгүй бол, Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам, түүний сайдын асуудал мэтээр хандах, олон улсын байгууллагуудын хандив, төсөл, хөтөлбөрт найдан сул орхиж олон улсын байгууллагуудын хэллэгээр бол “country ownership” буюу тухайн улс өөрөө гол санаачлагч, хэрэгжүүлэгч, хариуцлагыг нь засаглалын бүх түвшинд хүлээх шинэчлэлийг эрс

шийдвэртэй хэрэгжүүлэхгүй бол эдгээр асуудал шийдэгдэхгүйнээ. Гэхдээ энэ нь УИХ-ын ажлын хэсгийн дүгнэж байгаа шиг хөдөлмөр эрхлэлт хариуцсан тусгай агентлаг шинээр нэмж байгуулах замаар бус, ажлын байрыг хадгалах, шинээр бий болгож буй хэсэгт сэдэл санаа, урамшууллын механизм бий болгох замаар, хүмүүст тэгш хувиарлалтын үзэл санаа, хүлээлтийг бий болгох бус тэгш боломжийг бий болгох замаар хүмүүс өөрсддөө болон өрөөл бусдад ажлын байрууд бий болгох санхүү-татварын орчинг бүрдүүлэх замаар өмнө дурдсан 4 тойрогт эрс шинэчлэл шаардагдаж байна.

### **Маргааш:**

Хоёрхон яамны төсвийн зарлага, түүний төлөвлөлтийг жишээ болгон авч үзье. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын багцын 2009 оны төсвийн гүйцэтгэл нийт үнийн дүнгээрээ 318.175.4 сая төгрөг, үүнээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 21.494.3 сая төгрөг буюу 6.75 хувь нь зориулагдаж, 2010 оны тодотголоор дээрх тоонууд 486.832.4, 20.560.0 буюу 4,22 болж байна. ХХААХҮЯамны сайдын багц нийт дүнгээрээ 2009 онд 76.520 сая төгрөг үүнээс тариалан дэмжих санд 24.049.4 сая төгрөг буюу 31.4 хувь, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих санд 30.907.3 сая төгрөг буюу 40.3 хувь тус тус зарцуулагджээ. 2010 оны төсвийн тодотголоор дээрх тоонууд 134.391.5 сая төгрөг, 29.921.0 сая төгрөг /22.2 хувь/, 30.078.8 сая төгрөг /22.3 хувь/ болохоор байна. Хүмүүсийн оролцоотой эдийн засгийн өсөлт буюу an inclusive economic growth гэсэн ойлголтыг зөвхөн төсөл, хөтөлбөрийн хүрээнд семинар, хурлын үеэр л яригддаг зүйл гэсэн ойлголт бодлогын ой санамж, файл дотор гүнзгий шингэсэн байна. Энийг өөрчилнө гэдэг маань ядуурал, ажилгүйдлийг бууруулах талаар өнөөгийн баримталж буй гол хандлага, арга барил болох бүх хүмүүст тэгш хувь хүртээх гэсэн үзэл номлолоос татгалзаж хүмүүст тэгш боломж олгох, овсгоо самбаачлалын үзэл санааг нийгэмд төлөвшүүлнэ гэсэн хэрэг юм. Дэлхий энэ л замаар явж байгаа.Хувийн хэвшилд, иргэдэд өөрсдөд нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулах чиглэлээр ямар нэгэн хөшүүрэг, сэдэл санааны механизм хууль тогтоомжийн хүрээнд, бодлогын хүрээнд бий болгоогүй цагт бид “гэрэлт ирээдүйг” харанхуй, саарал гундуу нийгэмд төсөөлсөөр, төлөвлөсөөр байх болно. Пирамидын ёроолыг халамж анхаарлын бүс гэж харахаасаа илүү зах зээлийн боломж гэж хардаг сэтгэлгээ, сэдэл санааг төр болон хувийн хэвшилд төлөвшүүлэх төрийн бодлого хэрэгтэй байна.Пирамидын ёроолын зах зээл” гэдгийг

ядуу хүмүүсийг басамжилсан нэр томьёо гэж ойлгож болохгүй бөгөөд таван жилийн өмнөөс олон улсын байгууллагуудын эдийн засгийн бодлогод шинээр орж ирсэн хэллэг гэдгийг бас дурдах нь зүйтэй.Монголын компаниуд сүүлийн үед ядуурал, байгаль орчны доройтол гэх мэт асуудлуудад ихээхэн анхаарал хандуулж компаний нийгмийн хариуцлага гэдгийг маркетингийн арга хэрэгсэл биш, эсвэл томоохон компаниудын нэрийн ард ордог чимэг зүүлт төдийхнөөр ойлгохоо больж компаний хөгжлийн шинэ загвар гэдэг талаас нь илүү анхаарч эхлэв.ТОР-100, өрсөлдөгч-50 аж ахуйн нэгжийн болон бусад шалгаруулалтанд Компанийн нийгмийн хариуцлага гэсэн чиглэлээр юу хийв гэдгийг нь 2008 оноос онцлон анхаарч ирсэний үр дүнд энэ чиглэлээр Монголын компаниудын үйл ажиллагаанд тодорхой ахиц дэвшил харагдаж эхэллээ. Гэхдээ л Монголын компаниуд энэ чиглэлээр асар их юм хийх боломжтой бөгөөд энэ бол төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлвэл зохих ажил мөн. Наад зах нь л гэхэд Өмнөговь аймагт лицензийн зөвшөөрөлтэй бүх компаниудыг Өмнийн говь хэмээх асар их баялагтай гэхдээ эко системийн хувьд мөн л асар их эрсдэлтэй нутагт загийн ой сэргээх, шинээр бий болгоход татан оролцуулбал Өмнөговийн төдийгүй Монгол улсын хувьд стратегийн чухал ач холбогдолтой болно. Гэхдээ үүнийг Гансүх сайдаас бус Зоригт сайдаас санаачлахыг хүлээсэн нь дээр байх.

### **Өнөөдөр:**

ҮСХорооноос амьжиргааны баталгаажих доод түвшингийн /энд уул нь эдийн засгийн утгаараа ч ёс суртахуун талаасаа ч “баталгаажих” гэдэг үг илүүц юм/ хэмжээг 101,6 мянган төгрөг гэж тогтоосон. Цалингийн доод хэмжээ 108 мянган төгрөг, дундаж тэтгэвэр 96 мянган төгрөг байгаа. Нийт тэтгэвэр авагчдын 50 хувь болох 140 мянган хүний бүрэн тэтгэврийн доод хэмжээ 81 мянган төгрөг, 42 мянган хүний амьдралын үндэс болсон халамжийн тэтгэвэр сард 41 мянган төгрөг. Яг эдгээр тоог УИХ-ын хаврын чуулганы хаалтын үеэр УИХ-ын дарга маань дурьдаад: “..Зонхилох иргэдийн амьжиргаа амьжиргааны баталгааны доод түвшингээс доогуур оржээ.. гэсэн “нээлт” хийсэн” төдийгүй эдгээр тооноос хамгийн “гайхамшигтай” дүгнэлт хийж байх юм: “..Халамж хавтгайрлаа” гэх буюу иргэдэд төсвөөр хуваарилах туслалцааг хумих, урьд нь хүрсэн түвшингээс нийгмийн халамжийг бууруулах гэсэн элдэв арга саам, оролдлого /бид онцлов/ ашиггүй болох нь бодит тооцоо ийнхүү харуулж байна. Ийм учраас 2011 оны

төсвөөр хүн амын нийгмийн хамгаалалын нэмэлт арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна” гэжээ. Хэн “элдэв арга саам, оролдлого хийгээд байгаа юм бол? Зорилтот хэсэгт нь л халамж очих ёстой, тэр ч байтугай ийм нөхцөлд халамжийг нэмж ч болно гэж үздэг Дэлхийн банк, МҮХАҮТанхим гэх мэт олон байгууллагууд, эдийн засагчид уу? Тэр тусмаа дээрх тоонууд чинь халамж хавтгайрч бараг хүн бүхэнд хишиг хүртээхийг хуульчлаад, нийтэд нь хавтгайруулж тарааснаас зорилтот хэсэг нь амьжиргааны доод түвшинд хүрэхгүй мөнгө авч байгааг харин харуулаад байгаа бус уу?!

Хүн амын зонхилох хэсэг гэж хэдэн хувь? 66,3 хувь ? эсвэл 50 хувиас дээшүү? Үүн дээр харин тантай санал нийлж болно, гэхдээ энэ чинь бүгдэд тэгш хувиарлах, халамж хавтгайрсны л үр дагавар шүү дээ.

#### **Өнөөдөр:**

Саявтархан Ховд, Увс аймгийн алслагдсан сумуудаас ажилгүй 10 хүнийг Улаанбаатар хотод авчирч танхимын дэргэдэх нарийн боовны сургалт-үйлдвэрлэлийн төвд голланд, франц талх, нарийн боов хийж сургаж. 7 хоног зарцуулсан. Төгсөөд тэр эмэгтэйчүүд талх, нарийн боов нутагтаа очиж хийх авсаархан тоног төхөөрөмж хүссэн. Бид мөдхөн нийлүүлнэ. Ажилгүй байсан 10 эмэгтэй ингэж ажилтай болно. Үсчний явуулын иж бүрэн багаж Улаанбаатарын зах дээр 200 мянган төгрөг байдаг. 4 иж бүрдлийг 800 мянган төгрөгөөр авч Ховд аймгийн сумын малчны хотхонд байгаа ажилгүй залуусыг аймгийн төв дээр үсчний дамжаанд явуулж уг багажийг жилийн хугацаатай лизингээр олгов. 800 мянган төгрөгөөр 4 залуу ажилтай болж малчид заавал сумын төв рүү очиж үсээ засуулах шаардлагагүй болов. 3 дахь жишээ. Увс, Баян-Өлгий, Ховд аймгийн 8 суманд “ буухиа зээл” нэртэйгээр 3-5 сая төгрөгийн зээлийг малчдын бүл, хот айл, эсвэл тодорхой нөхөрлөл, хоршоо, хэсэг бүлэг иргэдэд олгохоор төлөвлөж, зээлийг хэнд өгөх, яаж өгөх, хэн, яаж хяналт тавихыг бид биш, хүмүүс өөрсдөө шийддэг тогтолцоог санаачлан эхлүүлж байна. Хэнтий аймгийн Батширээт сумын хэсэг эмэгтэй малчдад словак маягийн бяслагаа савлах төхөөрөмж олгож Улаанбаатар хотод зах зээлтэй холбож өгөв. 10-аад эмэгтэй орлого, цалинтай болов. Иймэрхүү байдлаар бүх аймгуудад 10-12 сая төгрөгийн зөөлөн нөхцөлтэй зээл олгож 400-600 сая төгрөг байршуулав. Эдгээр нь ямар ч банкаар дамжаагүй, гаднын түншээс хөрөнгө босгож хөгжилд зориулсан, тэгш боломж олгосон цөөхөн жишээнүүд. Хас

банк болон томоохон хэдэн компанитай нийлж “Органик Монгол” хөтөлбөр хэрэгжүүлж Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт 500 сая илүү төгрөгийн төсөл хэрэгжүүлээд байна. Голландын Засгийн газрын тусламжаар ногоон зээлийн баталгааны сан байгуулж, Голомт банкттай хамтран төрийн хөгжлийн сангаар дамжуулан зээлдэх механизмыг ашиглан тэрбум төгрөгийн зээлийг 20 гаруй аж ахуйн нэгжид зөөлөн нөхцөлөөр олгосноор хэд хэдэн шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ бий болсон гэхдээ сүүлийн 2 жилийн санхүү-эдийн засгийн хямралаас болж цөөхөн хэдэн компани зээлийн хугацааг сунгах, дахин сунгах хүсэлтээ ирүүлээд байна.Банкны шалгуураар бол энэ бол “чанаргүй” зээлийн ангилалд орно, гэхдээ бидний ангилалаар бол нэр нүүрээ барахыг хүсэхгүй байгаа, зээлээ заавал төлнө гэсэн “чанартай хүмүүс” юм.Хаан болон Хас банкттай хамтран ЖДҮйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн лизингийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх эхлэлийг тавьж байна. Энэ мэтээр хүмүүст тэгш боломж олгох, овсгоо самбаачлагыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжиж буй олон өөр төсөл, хөтөлбөр, санал санаачилгууд нийгэмд байна.Гагцхүү эдгээрийг хооронд нь уялдуулж дэмжих үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлмээр байна.

#### **Маргааш:**

ЖДҮйлдвэрлэлийг дэмжих 30 тэрбум төгрөгийг 200 тэрбум болгох. Гэхдээ зөвхөн яам- агентлаг-сонгогдсон банкууд гэсэн схемээр биш альтернатив санхүүжилтийн дээр дурдсан болон бусад хувилбаруудыг сонгож хооронд нь өрсөлдүүлэх, банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын дунд мөн өрсөлдөөн үүсгэх нөхцөлүүдийг бүрдүүлэх шаардлагатай байна.Зээлийн баталгааны санд 2010 онд хувиарлагдсан хөрөнгийг танхимын ногоон зээлийн баталгааны сантай нэгтгэн хамтран ажиллах боломжийг нээн өгч заавал төр бүхнийг хийхийг оролдох гэхээсээ илүү хувийн хэвшилтэй хамтарч ажиллах, бидэнд итгэл үзүүлж, төр хяналтаа тавих чиглэлийг илүүтэй баримтаар байна.

Монголын эдийн засгийн бүтцийн нилээд том, хэмжээ нь сүүлийн үед хурдацтай нэмэгдэж буй хэсэг болох албан бус сектор, түүнийг албажуулах, санхүүжүүлэх механизмыг боловсронгуй болгох асуудал бол өнөөдрийн бас нэг тулгамдсан асуудал болоод байна. Нийгмийг авч явдаг “цөм сүрэг” болох дунд ангийг бүрэлдүүлж болох томоохон нөөц энд оршиж эсвэл ядуурал руу эргэж унах эсвэл албан секторт дэвшин орж дунд анги бүрэлдэх үйл явцыг түргэсгэхэд тус дөхөм болох гэсэн 2 сонголттой байгаа.

Энд мөн л тэгш боломж олгох, овсгоо самбаачлалын уур амьсгалыг төлөвшүүлэх гэсэн хосолмол арга зам, шийдэл байгаа. “Нинжа” гэж нэрлэгдсэн албан бус секторын томоохон хэсгийн талаар УИХ дээр хэлэлцэж буй явц, Засгийн газраас тайлбар өгч буй байдлыг харахад сонин дүр зураг харагдаж байна. Албан бус секторт байдаг хуулиас гадуурх энэ хэсгийн ядуурлаар гул барьсан гэмт үйл ажиллагааг хуульчилж өгөх гээд ч байгаа юм шиг, сум болгонд хүмүүсээр нүх ухуулах гээд тэндээсээ арван мянга найман зуун төгрөг авах гээд ч байгаа юм уу эсвэл энэ асуудлыг Швейцар улсын татвар төлөгчдийн мөнгөнд даатгаад ч байгаа мэт. Хамгийн хачирхалтай нь энэ асуудлыг эрдэс баялаг, эрчим хүчний сайд нь хариуцаж оруулж байх юм. Учир нь “бичил уурхай” гэсэн нэртэй юм гэнэ! Өнөөх хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эдийн засаг, байгаль эрчин, хууль зүйн сайд нарт нь хамаагүй юм байх?!

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг 100 млрд төгрөгт хүргэх. Гэхдээ мөн л төвлөрсөн хэлбэрийг нь задалж ил тод, тэгш боломж олгосон, дүүрэг, аймаг, сум бүрд Засаг дангаараа мэддэггүй, хүмүүс өөрсдөө оролцдог, шийдвэр гаргадаг альтернатив санхүүжилтийн механизмыг бүрэлдүүлэх шаардлагатай байна. Мэргэжлийн боловсролын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэнд зохицуулан хөгжүүлэх асуудлыг зөвхөн НХХЯам, БСШУЯамны өнөөгийн бодлого, үйл ажиллагаагаар хязгаарлах бус хувийн хэвшлийн дотор байгаа мэргэжилтэй ажилчид бэлтгэх асар том нөөцийг бүрэн эргэлтэнд оруулах нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулах нэг гол түлхүүр юм. Өнөөдрийн байдлаар Монгол улсад 65 мэргэжлийн боловсролын төв үйл ажиллагаа явуулж байгаагаас 45 нь төрийн өмчийнх бөгөөд эдгээрт Мянганы сорилын сангаас төсөл хэрэгжүүлэх гэж бараг мянган сорилт хийж байх шиг байна. Танайд хууль чинь болохгүй байна гэж Америкчууд хэлсэн, Монгол улс хуулийг нь шинэчилсэн, одоо юу нь болохгүй удаад байгаа нь тодорхойгүй, баахан л зөвлөх үйлчилгээний зарууд сонингуудаар тавиад байна. Уул нь “country ownership” гэдэг ойлголтыг МССангийнхан мэдэхийн дээдээр л мэдэх учиртай. Багш нарыг нь сургаад давтан сургаад, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг нь яаралтай авч нийлүүлээд “ядуурлыг бууруулах замаар эдийн засгийн өсөлтийг хангана” гэж тунхагладаг сангийнхаа уриаг хурдан л хэрэгжүүлмээр юм...

### **Өнөөдөр:**

Засгийн газар 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” хэмээн зарласан нь учиртай. Урьд өмнө зарлаж байсан жилүүдээс ялгагдах хэд хэдэн онцлог энэ жилд байгаа. Юуны өмнө бизнесийн орчны шинэтгэлийн жилийн үзэл санаа, зорилтууд, хэрэгжүүлэх арга хэлбэрүүд, механизм нь өмнө дурдсан зарчмын дагуу “.....of the business, by the business, for the business” буюу бизнесийнхэн өөрсдөө санаачлан төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд нь өөрсдөө оролцож биелэлт, хэрэгжилтийг нь өөрсдөө хянах, үнэлгээ өгөх боломжтой болж байгаа. Мөн түүнчлэн шинэтгэлийн жилийн тогтоолд анх удаа монголын бизнесийн орчны тухай олон улсын байгууллагуудын, тухайлбал, Дэлхийн банкны бизнес эрхлэлтийн индексийн үзүүлэлтүүдийг оруулж, эдгээрийн дагуу хүрэх зорилтуудыг томьёолж тавьсан нь засаглалын баримт бичиг боловсруулах технологид шинэлэг зүйл болсон гэдгийг хэлэх хэрэгтэй. Өөр нэг онцлог бол энэ жилийн үзэл санаанд төрийн тодорхой чиг үүргүүдийг төрийн бус байгууллагуудад бодитойгоор шилжүүлэх талаар олон жил яригдсан зүйлийг ажил хэрэг болгох талаар тодорхой ажлууд хийгдэхээр тусгагдсан. Гэвч үзэл санаа нь зөв, агуулга нь шинэтгэлийн шинж чанартай, хэрэгжүүлэх, дүгнэх механизм нь шинэлэг энэ тогтоол яагаад хэрэгжихгүй байна? Хэн хэрэгжүүлэхгүй, эсвэл хэрэгжүүлэхийг хүсэхгүй байна? Яагаад, тухайлбал, бүх төрлийн зохицуулалт, бичиг баримтыг 2 дахин багасгах, барилгын секторт байдаг өнөөх алдарт 140 гарын үсгийг 90 хувиар багасгана гэх мэт заалтууд жил зарласнаас хойш бараг хагас жил өнгөрөх гэж байхад огт хэрэгжихгүй, эхлээ ч үгүй байна? Яагаад Ерөнхий сайд нь энэ жилийн үзэл санаанд итгэл үнэмшлээ илэрхийлээд бүх сайд нараа цуглуулж үүрэг даалгавар өгөөд тэр тусмаа шинэчлэлийн жилийн эхний улиралд л ажил урагшлахгүй байгааг мэдрээд эрчимжүүлэх талаар нэмж захирамж гаргаад байхад оны эхний 5 сарын байдлаар үнэхээр сэтгэл гонсойлгом, дур гутмаар дүр зурагтай байна?!

### **Маргааш:**

Төрийн зарим чиг үүргүүдийг /үнэн хэрэгтээ төр өөртөө “сайн дураар”, хуулиар наачихсан “чиг үүргүүдийг”/ төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлэх ажлыг орон даяар эрчимтэй хийх ажлыг түргэвчлэх хэрэгтэй байна. Дэндүү удаан ярилаа. УИХ-аас ажлын хэсэг гарч 7 мянган ажилтанг цомхотгох, дэд сайдуудыг цөөрүүлэх, зарим агентлагуудыг татан буулгах, нэгтгэх гэх мэт саналууд нь асуудлыг

шийдвэрлэх оновчтой хувилбар биш. Нэн түрүүнд бид “яам-агентлаг” гэсэн засаглалын энэ бүтэц өөрөө зөв үү, 1990-ээд оны сүүлээс хэрэгжиж ирсэн эл загвар өнгөрсөн хугацаанд засаглалын үр ашгийг дээшлүүлж чадсан уу гэдэгт хариулах ёстой. Яам, тохируулагч ба хэрэгжүүлэгч агентлаг гэсэн энэ бүтэц анхнаасаа амьдралаас тасархай, хиймэл байдлаар Монголд орж ирээд өдгөө архагшсан, “амжилттай” нутагшсан хүнд суртлын механизм болон хувирсан. Энэ асуудлыг шийдэх үйл явцдаа чиг үүрэг шилжүүлэх асуудлыг зэрэг шийдэх нь зохистой. Энэ нөхцөлд Яам /principal/- чиг үүрэг шилжүүлэх контракт-төрийн бус байгууллагууд, иргэний нийгэм /agent/ гэсэн PPP механизмыг өөртөө шингээсэн засаглалын технологи үүснэ. Төрийн албан хаагчдын эдийн засгийн мэдлэг дэндүү нимгэн, амьдралаас тасархай байгаа нь тэдний буруу биш тэднийг бэлтгэдэг тогтолцоонд байгаа. Жозеф Штиглицийн “Төрийн эдийн засгийн онол” гэсэн сайн орчуулгын ном гарсан, тэр номын дагуу төрийн албан хаагчдаас нийт орон даяар шалгалт авах хэрэгтэй. Улсад ч ,тэдэнд ч хэрэгтэй зүйл болно.

#### **Маргааш:**

Эдийн засгийн хөгжлийн бодлогын хувьд цаг хугацааны мэдрэмж, хямралын гол цэгүүдийг олж харан шуурхай, иж бүрэн арга хэмжээ авах чадвар илт дутагдаж байна. Өнөөдөр бидэнд тулгараад буй гол асуудал бол хямралыг хэрхэн даван туулах, өсөлтийг хэрхэн тогтвортой бөгөөд хүмүүсийн оролцоотой болгох тухай асуудал. Дэлхийн банкны гүйцэтгэх захирал ноднин Монголд айлчлахдаа хямралыг боломж болгох талаар тодорхой санаа, зөвлөмж өгсөн. Гэтэл бодит байдал дээр Монгол улс баахан мастер төлөвлөгөө, урт хугацааны стратеги боловсруулаад тулгамдсан гол гол асуудлаа донор орон, ОУБ-уудад найдаад л орхиж байна гэхэд хилсдэхгүй. Бодит сектор бартерийн харилцаанд аль хэдийн орж одоо бараг „цэнг нь дуусаж байна“ , Төв банк нь 2009 оны 3 сард албан ёсоор тодорхойлсноор „...тэртээ тэргүй унаж буй хувийн хэвшлийг“ зөнд нь орхиод, „инфляцийг онилох“, валютын ханшийг тогтворжуулах мөнгөний хатуу бодлого явуулсаны хүчинд л арайхийж эдийн засгийг зогсолтгүй уналтаас аварч чадлаа гэж шал худлаа сүржигнэн илтгэж байх хооронд нь банк ба бизнесийн амьд орчил нь энэ бодлогын л гайгаар аль хэдийн тасраад одоо „амь тариа“ нэхэх хэмжээнд очсон байна. Амь тариаг амьтай байхад нь хийдэг болохоос амь тасарчихсан хойно нь хийдэггүй. Төсвийн хөрөнгө оруулалтын тендер, ЖДҮйлдвэрийг дэмжих

зээл, гадаадын зээл тусламж, хөтөлбөрөөр нэг хэсэг нь амиа “зогоож нөгөө хэсэг нь “бор зүрхээрээ”, инерцээрээ л явж байгаа. Томоохонууд нь банктай банкгүй өөрсдийгөө болгоод л явж байна. Үүнийг хямрал дууслаа гэж ойлгоод байгаа юм болов уу?!

#### **Маргааш:**

Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсүүд, шинжлэх ухаан-технологи, аж үйлдвэрийн паркууд гэх мэтийн эрх зүйн үндэс байхгүй гэж арван жил явлаа, дараа нь бий болох гэж арван жил явлаа. Одоо дэд бүтэц, зам харилцаа гээд дахиад арван жил болно. Дээр нь олон том цогцолбор, хөтөлбөр, парк нэмэгдэх нь. Бүгд л сүүлийн үед моодонд орсон “нэмэгдсэн өртөг бүтээх”, хүнд аж үйлдвэрийн цогцолборууд байгуулах эдийн засгийн “хүйтэн” үндэслэл тооцоо, өрсөлдөх чадвар зах зээлийн хандлага дээр суурилахаасаа илүүтэйгээр “халуун” эх оронч үзэл санаа, хэтийн төлөвлөгөө хийдэг байсан үеийн “бүтээн байгуулагч сэтгэлгээ” дээр суурилагд байна. Энэ зөв үү ?. Ер нь энэ олон хөтөлбөр, мастер төлөвлөгөө, цогцолбор бүтээн байгуулалтын баримт бичгүүдэд квот тогтоовол яасийн? Хавсралт 1-д 20 жилийн өмнө үндэсний дэвшлийн намын их хурал дээр хэдэн нөхдүүдтэй хамтран боловсруулсан эдийн засгийн илтгэлийн хэсгээс ишлэл авч 2008 онд үйлдвэржилт гэсэн сэдвээр юу бичиж байсныг харуулав. Гол зорилго нь өнгөрсөн 20 жилд төрийн бодлого ямаршуухан удаан, мэлхийн хурдацтайгаар хэрэгжиж ирснийг, тэр үед 20 жилийн өмнө бидний ярьж бичиж байсныг зарим зүйл одоо хүртэл олигтой хэрэгжиж ирээгүйг л харуулах гэсэн хэрэг. Хавсралт 2 буюу “Монголын ардчилсан намын /МОАН/ эдийн засгийн үзэл баримтлал” хэмээх түүхэн баримт бичгийг 20 жилийн дараа анх удаа дэлгэн тавилаа. Ардчилал сонины 1991 оны 1 дүгээр сарын дугаарт товчлон нийтлэснийг авч тависан бөгөөд үүнийг тэрлэгч би вээр Д.Батбаяр хэмээх андтайгаа хамтран бичиж Ардчилсан намын онц их хурал дээр өдгөө Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга “казино” хэмээх Д.Батулга анд маань уншиж сонордуулж билээ л... Энэ бол ардчилалын 20 жилийн түүхийн нэг салшгүй хэсэг бөгөөд 20 жилийн өмнө эдийн засгийн бодлогын талаар бид юу бодож, ярьж явсныг, зах зээлийн эдийн засгийн суурь тоосгонууд Монгол улсад яаж тавигдсаныг харуулах болно...

#### **Өнөөдөр:**

МҮХАҮТанхимаас 2007, 2008 оноос л байнга сануулж 2009 оны 1 сард арга ядахдаа „Хямралын эсрэг эдийн засгийг идэвхжүүлэх

төлөвлөгөө” хүртэл боловсруулж УИХ, Засгийн газарт хүргүүлсэн. Бизнес эрхлэгчдийн нэгдмэл санал, улс орнуудын хямралын эсрэг менежментийн туршлагыг харгалзсан практик ач холбогдолтой иж бүрэн санал байсан. Харамсалтай нь хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлэх чиглэлээр цаг хугацаа, дэс дараалалын хувьд ч бодлого, арга хэмжээний тэргүүлчлэлийн хувьд ч алдаанууд гарсан. Хувийн хэвшилтэй байнга, шуурхай зөвлөлдөж байх бодлогын соёл, мэдрэмж, засаглалын шуурхай технологи дутсан. 2010 оны сүүлч 2011 оны эхний хагаст гэхэд аядуу инфляцтай / заавал нэг оронтой тоонд байх гэсэн үг биш/, идэвхжсэн бодит сектортой, өрсөлдөөнт орчин дахь банкны сектортой байх боломж бас байсаар байна. Гагцхүү үүнийг УИХ, Засгийн газар хямралын эсрэг бодлогын менежментээ сайжруулах замаар, бодит секторыг идэвхжүүлэх Сангийн болон мөнгөний бодлогын уялдаа холбоог хангах замаар, Төв банкны мөнгөний бодлогыг УИХурлаас өгсөн даалгавар чиглэлийн дагуу, Төв банкиг бодит амьдралаас тасархай, хөндий хоосон юм ярихыг нь болиулж инфляцийг биш эдийн засгийн өсөлтийг онилуулах замаар хэрэгжүүлэх нь чухал. Инфляцийг онилох бодлогыг хэрэгжүүлж буй орнуудыг харахад хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн эдийн засгийн өрсөлдөх чадвар дунд болон түүнээс дээш түвшинтэй бүтэц нь өрөөсгөл бус, эдийн засгийн операторуудын хүлээлтийг удирдаж болдог, банкны сектор нь өрсөлдөөн эрчимтэй өрнөсөн, банкуудын үйл ажиллагаа нь сайтар хэвшин тогтсон, засаглалын зөв бүтэцтэй байдаг. Гэхдээ эдгээр нь хэдийгээр маш их хүсүүштэй нөхцөлүүд мөн боловч заавал урьдчилан бэлтгэгдсэн байх ёстой нөхцөлүүд биш бөгөөд Монгол мэтийн орнуудад ч мөнгөний бодлогын энэхүү төрлийг нэвтрүүлэх оролдлого хийж болно. Гэхдээ банкны сектор сайн засаглалын зарчмууд хэрэгжээгүй, зарим банк нь цөөхөн хэдэн зээлдэгчдээс хамааралтай, тэдэндээ “үлэмж дотнотлон үзэх” зарчмаар хандаж ирсэн, Төв банк нь банкны секторт эрүүл, шударга өрсөлдөөн өрнүүлэх талаар ямар нэг тодорхой алхмууд хийдэггүй, бодит секторын хүлээлт, авир төрхийг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдээр бүрэн удирдах боломжгүй ийм улс оронд инфляцийг онилох гэгч бодлогын эдийн засгийн утга агуулга, үр дүн хоосон, хийсвэр шинжтэй байдаг байна. Тэр тусмаа Төв банк нь монголын эдийн засгийг сонгодог мөчлөгийн эдийн засаг гэж гэнэнээр боддог нөхцөлд энэ бол “мөнгөний бодлого” болж “тоглож” буйгаас өөрцгүй. Монгол улс монетаризмын туршилтын талбар биш, ард түмэн, бизнес эрхлэгчид нь “туршилтын туулай” биш./Хавсралт 3-д байгаа тоонуудаас мөнгөний бодлого, инфляци,

бизнес эрхлэгчдийн хүлээлт ямархуу хоорондоо холбоотой байгааг, мөнгөний бодлого хир зэрэг “байгаа” онож ирснийг харж болно.

Монголын эдийн засаг мөчлөгтэй эдийн засаг гэдгийг хэн, хэзээ, ямар судалгаа шинжилгээгээр тогтоож яаж баталсан юм бол?! Сүүлийн 20 жилд Монгол улсад тогтсон эдийн засгийн бүтэц, эдийн засгийн хэрэгжүүлж ирсэн бодлого, шинэтгэлийн арга хэмжээнүүд мөчлөгт эдийн засгийн нөхцөлд зохицоогүй хэрэг үү?! Эдийн засаг нь мөчлөгтэй, тэгээд түүний үе шатуудыг нь Монгол банк л ганцаараа “мэдээд” эдийн засгийн бодлого явуулдаг байсан юм шиг ойлгогдохоор зөөлнөөр хэлэхэд “ийм балай” зүйлийг төрийн мөнгөний бодлого хэрэгжүүлдэг Төв банк нь бичиж буйд үнэхээр харамсахаас өөр ч юу хэлэхэвдээ? Дэлхийн зах зээлийн конъюнктурын мөчлөг түүхий эд экспортлогч Монгол улсын хувьд сүүлийн жилүүдэд “магнайг нь тэнийлгэж” баахан цамаан загнасныг дээр, дооргүй мэдэж байгаа бөгөөд бизнес эрхлэгчдийн зүгээс энэ талаар байнга сануулсаар ирсэн билээ. Мөчлөгийн гэхээсээ илүү улирлын шинж чанартай Монголын эдийн засаг, түүний экспортын өрөөсгөл бүтэц, импортын хэт хамаарал, аж үйлдвэр, түүний дотор импорт орлох үйлдвэрлэлийн сул хөгжил, бизнес хөрөнгө оруулалтын орчны тааламжтай бус байдал, мөнгөний бодлогоор дамжсан зээл-санхүүгийн хүндрэлтэй орчин, бодит секторыг дэмжих талаар төрийн тодорхой бөгөөд үр дүнтэй бодлого дутагдсан дээрээс нь бодлогын асуудал хариуцсан төрийн институтүүдийн, тухайлбал, Монгол банк, Сангийн яамны бодлого үйл ажиллагааны уялдаагүй байдал олон жил ужгирч ирсэн, түүнийг нь засах талаар УИХ, Засгийн газраас дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй - энэ бүхэн бол Монголын эдийн засгийн сүүлийн жилүүдийн болон өнөөгийн байдлын бодитой шалтгаанууд. Чухамдаа эдгээрээс л бид алдаагаа харж засна уу гэхээс нэг нь мөчлөг “ойлгодог” одоо тэгээд хэрэгжүүлж байгаа, нөгөө нь “ойлгодоггүй” тэгээд буруу бодлого явуулж ирсэн, одоо л ойлгоод ОУВС гэдэг байгууллагын зөвлөмжөөр зөв бодлого явуулж эхэлсэн, үүнээс өөр ямар ч гарцгүй маягийн юм ярих нь үнэнээс, бодит амьдралаас даанч хол, дэндүү зөрөөтэй хэрэг юм. За тэгээд л эрэлтээр өдөөгдсөн инфляци нь эдийн засаг халж байгааг хэлээд л байхад л буруу бодлого явуулаад, хэн ч эдийн засгийн энэ өсөлтийг тогтвортой эсэхийг сонирхдоггүй байсан юм байхаа. Монголын инфляцийн учир шалтгаан, төрөл, хэлбэрүүд нөлөөлж буй мөнгөний болон мөнгөний бус хүчин зүйлүүд, гадаад болон дотоод хүчин зүйлүүд түүн дээр суурилсан мөнгө санхүүгийн



бодлого, бодит секторт ямар дэмжлэг, яаж үзүүлэх шаардлагатай байгаа талаар МҮХАҮТанхимаас сүүлийн жилүүдэд ярьж хэлж, бичиж байсан зүйлүүдийн талаар Монгол банк эрхбиш гадарлах байх гэж найдая. Эдийн засгийн энэхүү өсөлт тогтвортой бөгөөд хүнд наалдацтай буюу “sustainable and inclusive economic growth” байх ётой, ингэхийн тулд ЖДБизнес, хувийн хэвшил, албан бус хэвшлийн талаар баримтлах макро эдийн засгийн бодлого, түүний дотор мөнгөний бодлогын талаар бид байнга дуу хоолой, санал, зөвлөгөө гаргаж байсныг Монголын ард түмэн, хувийн хэвшлийнхэн мэддэг гэдгийг Монгол банкинд сануулах нь зүйтэй болов уу.

### **Маргааш:**

Аливаа шинэчлэл, тэр тусмаа эдийн засгийн хүрээний, хүмүүсийн хүсэж хүлээсэн шинэчлэлийг хийхэд эсэргүүцэл, тэр тусмаа чимээгүй эсэргүүцэл зайлшгүй гардаг гэдгийг Монгол улсын өнгөрсөн 20 жилийн туршлага харуулдаг. Тэгвэл энэ чимээгүй эсэргүүцэл хаанаас гараад байна? Төрийн дээд шатны албан тушаалтнуудын зүгээс энэ чиглэлээр өгсөн үүрэг даалгавраа эргэж шалгадаг арга барил нь үр ашиг муутай, хоцрогдсон, эсвэл эргэж тодорхой үр дүнг нь огт шалгадаггүй, шахаж шаарддаггүйн улмаас тодорхой асуудлыг боловсруулах хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн дунд шатны албан тушаалтнууд, мөн “яам-агентлаг” гэсэн засаглалын бүтцийн сул талууд дээр дулдуйдан түшиглэсэн агентлагуудын албан тушаалтнууд, аймаг, нийслэлийн засаглалын зорилт, үйл ажиллагаа нь улсын хэмжээнийхтэй ижил юм шиг хэдий ч бизнесийн орчны шинэтгэл хэмээх үндэсний хэмжээний энэхүү шинэтгэлийн бодлогод засаг захиргааны эдгээр нэгжийн оролцоо, хэрэгжилтийг хангах механизм нь үнэхээр сул, иймээс шинэтгэлийн давалгааг хажуугаараа аятайхан өнгөрүүлэх, аргалах гэсэн хандлагатай албан тушаалтнууд бол шинэчлэлийг чимээгүй эсэргүүцэгч хүч бөгөөд мөсөн уулын зөвхөн ил харагдаж буй хэсэг нь юм. Үүний цаадах суурь шалтгаан нь ерөөсөө засаглалын хоцрогдсон технологи, эдийн засагт төрийн зүгээс хэт их оролцож буй арга хэлбэрүүд л юм. Долоон мянган төрийн албан хаагчдыг цомхотгоод долоон серверээр орлуулаад дуншиж ядаад байгаа цахим Засгийн газраа бодитойгоор бий болгочихвол засаглалын технологийг сайжруулахад ихээхэн дөхөмтэй болохсон.

Бизнесийн орчны талаар Засгийн газар маш зөв, чухал шинэчлэлийг эхлүүлсэн. Үр дүн нь одоогоор гараагүй байгаа.

Гэхдээ бизнес эрхлэгчдэд энэ шинэчлэлийн үзэл санаа хүрсэн, тэд хамгийн их хүлээлттэй байгаа. Шинэтгэлийн жилийн төлөөлөгөөнд эдийн засгийг удирдах, зохицуулахдаа хамгийн түрүүнд зах зээлийн зохицуулалт, дараа нь бараг буюу квази зохицуулалт, хамгийн сүүлд төрийн зохицуулалт гэсэн маш чухал, урьд өмнө ингэж албажиж байгаагүй зарчмын шинжтэй заалт орсон бөгөөд хэрэв Монгол улс хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын бүх түвшинд дээрх заалтыг хэлбэрэлтгүй мөрдөн хэрэгжүүлбэл дараагийн арван жилд манай улсын засаглалын бүтэц, технологи, эдийн засгийн бүтэц, хөгжлийн үйл явцад чанарын өөрчлөлт гарах юм. Гэтэл УИХ энэ талаар таг чиг, ямар нэг бодлогын дэмжлэг, хамтын ажиллагаа Засгийн газартай яриагүй л байна. Дараагийн хагас жилд, наадмын дараагаас эхлээд төрийн 3 институц энэ шинэчлэлийн талаар ярилцаж эрчимжүүлэх арга хэмжээ авах нь нэн чухал.

### **Өнөөдөр:**

Таван толгой, Оюу толгой, дэд бүтэц, төмөр зам гэх мэт томоохон “толгой, хөлнүүдийг” ярьж шийдэх, эргэлтэнд оруулах гэх мэт нь зайлшгүй хэдий ч математикийн хэлээр бол “зайлшгүй бөгөөд хангалттай нөхцөл” биш.

Үүний тулд нэн тэргүүнд өмнөх дурдсан 4 тойргийн асуудлыг зохистой шийдэхэд бүх хүч анхаарал, нөөц боломжоо чиглүүлэх шаардлагатай байна. Яагаад гэвэл энэ бол одоо, өнөөдөр юм. Том том төслүүд ярин маргаашийн “гэрэлт ирээдүйг” хараад байгаа хирнээ өнөөдрийн харанхуйд дасаж болохгүй билээ.

Зээл хүссэн таван мянган компаниас дөрвөн мянга нь авч чадаагүй бол, тавин мянган төгрөгөө 7 дугаар сарын 1-нээс аваад зарцуулах нийт хүмүүст иймэрхүү “төрийн хишиг” цаашид ч танд зүгээр л очно гэсэн сэтгэлгээ нийгмийг хамарсан сэтгэлгээ болж, энэ хооронд ядуурал, ажилгүйдэл багасахгүй л байсаар байвал эдгээр л олонхийн санал бодол нийгмийн санал бодлыг тодорхойлж төрийн үйл ажиллагааны тухай, төрд итгэх эсэх тухай санал бодлыг голчлон бүрдүүлэх болно. Өнгөрсөн хугацаанд ч ийм л байсан одоо болон ирээдүй цагт ч ийм байх болно. Хамгийн энгийнээр хэлбэл, дээрх 4 тойргийн асуудлыг хэрхэн, яаж шийдсэнээс улс төрийн сонгуулийн тойргийн хувь заяа томсгосон, жижгэрсэн ч бай ялгаагүй, нам нь ч байна уу хүн нь ч байна уу ялгаагүй хамаарах болно.

**Өнөөдөр:**

Бид нийгмээрээ эргэцүүлэн бодож, ярилцан шийдэх бас нэг “одоо, өнөөдөр” байна. Энэ асуудалд “маргааш” гэж байхгүй, яагаад гэвэл хэтэрхий оройдно. Албаны хэлээр бол “тогтвортой хөгжил” гэж олон жилийн турш “тогтвортой” ярьсан тэр зүйлийн нэг хэсэг болох байгаль орчны доройтол, энгийнээр хэлбэл, монголчууд бидний оршин ахуй, амьдрах орон зайн хумигдалын талаар энд өгүүлж байна. Энэ бол монголын нийгэмд тулгараад байгаа хөгжлийн дилемма, магадгүй цаашдын хөгжлийн талаарх бидний хүсэл мөрөөдөл, санаа зорилгын бодитой хязгаарлалт болох хандлагатай байна. Усны тухай том хөтөлбөр батлагдаж байхад Туул голын ус нь өмхийрөн ширгэж, цөлжилтийн эсрэг бодлого ярьж байхад цөлжилт нь улам тэлэгдэж, уушиг хордуулсан утаа, улаанаараа эргэлдсэн шороо Улаанбаатар хотын шинэ өнгө төрхийг тодорхойлж, ногоон эдийн засаг ярьж байгаа үед хүрэн нь хүчээ авч байгаа энэ үе бол одоо, өнөөдөр юм. МҮХАҮТанхимаас 2010 оныг “Ногоон бизнес, ногоон эдийн засгийг дэмжих жил болгон зарласан нь өнөөдрийн тулгамдсан асуудлуудад бид тодорхой хариулт өгч маргаашийн сорилтуудыг хэрхэн амжилттай даван туулах нийгэм-сэтгэл зүйн хөрс дэвсгэрийг тавьж өгөх, өнөөдрийн бидний мөрөөдөж, төлөвлөж буй олон том төслүүд эко систем, түүний дотор усны асуудлаас болж зогсох, тодорхой байдлаар хязгаарлалтанд орж болно гэдгийг урьдчилан сануулж буй хэрэг юм. Тийм учраас бид “хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих” концепцийг хүчтэй сурталчлах төдөийгүй ийм нэртэй хөтөлбөр боловсруулж 20x20x20x20 буюу таван 20-ийн зарчмыг түүнд тусгахаар ажиллаж байна. Өөрөөр хэлбэл 2020 он гэхэд Монгол улс хүлэмжийн хийн ялгарлыг 20 хувиар багасгах, эрчим хүчний үр ашгийг 20 хувиар дээшлүүлж, сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг одоогийн байгаа 4,7 хувиас 20 хувь хүртэл нэмэгдүүлэх гэх мэтээр тодорхой зорилтууд тавьж тэдгээрт хүрэх тодорхой механизм тодорхой сэдэл санааны тогтолцоог бий болгож өгөх шаардлагатай юм. Ногоон дотоодын нийт бүтээгдэхүүнийг 2011 оноос альтернатив байдлаар тооцон эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлд тусгах, ногоон худалдан авалтын хэмжээг төсөв захирагч бүрийн багцад 30 хувиас доошгүй байлгах, цэвэр үйлдвэрлэл, цэвэр технологи нэвтрүүлсэн, эрчим хүч, усны үр ашгийг дээшлүүлсэн аж ахуйн нэгжүүдэд урамшил, сэдэл санааны тогтолцоог төсөв, татварын болон бусад арга замаар хэрэгжүүлэх, ногоон зээл, зээлийн баталгааны тогтолцоог илүүтэйгээр урамшуулах, greeneurship” буюу ногоон овсгоо

самбаачлалын үзэл санааг корпорацийн түвшинд түгээн тархааж дэмжин урамшуулах гэх мэт олон зүйл энэ хөтөлбөрт тусгагдаж хамгийн гол нь хэрэгждэг байх ёстой. Тэгэхгүй бол сүүлийн үед хэрэгжүүлэх механизмыг нь анхнаасаа суулгаж өгөөгүйн улмаас хэрэгждэггүй хууль, том том хөтөлбөр, мастер төлөвлөгөөний илүүдэл үүсч байна. Газар нутгийнхаа өчүүхэн хувь эзэлдэг ойн сантай мөртлөө барилгын тулгуураа модоор, монгол гэрээ модоор хийж, модны зах зээл нь цэцэглэсэн, модны хулгай газар авсан ийм улс орон байдаггүй.

PPP /polluter pays principle/ буюу “Бохирдуулагч нь төлөх зарчим”-ыг одоо хүртэл хуулиндаа тусгаагүй, тусгах талаар ч санаа нь зовж санаачилга гаргадаггүй төрийн түшээдтэй, 1000 л усыг уул уурхайн компани нь 150 төгрөгөөр, ундны усаар гачигддаг иргэн Дорж 1000 төгрөгөөр авдаг ийм гажиг тогтолцоотой улс орон бас байдаггүй.

**Маргааш:**

Дэлхий өнөөдөр “an inclusive and sustainable development” буюу тогтвортой бөгөөд хүмүүсийн оролцоотой хөгжил гэж ярьж, бүтээж байна.

Дэлхий өнөөдөр түүхий эдийн үнийн өсөлтөөр олддог, хүмүүсийн оролцоогүй эдийн засгийн өсөлтийн загварыг тогтвортой биш гэж үздэг болсон, ямар ч үнээр хамаагүй нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээ нэмэгдүүлэх зорилгоор хөгжлөө төсөөлж, төлөвлөдөг улс орноос мушилзан инээвхийлж эелдэгээр татгалздаг болоод байгаа. Энэ бол өчигдөрийнхөө явдлаас өнөөдөр сургамж авсан дэлхий ертөнцийн өнөөдрөөс эхэлж буй маргаашийн хөгжлийн глобал хандлага юм.

Тун удахгүй бид үндэсний баяр наадмаа дэнж хотойтол, дэлхийг дэлдийтэл тэмдэглдэгээрээ л тэмдэглэнэ. Өнөөдрийн, одоогийн хэцүү хатуу асуудлуудаа түр зууртаа мартан үндэсний мэдрэмж, бахархлаараа бардамнаж үнэхээр гоё тэмдэглэдэг Монгол наадам гайхамшигтай. Гэхдээ л наадмын дараа намар ирдэгээрээ л ирэх билээ.

---

 СОНИН ХЭВЛЭЛД ...
 

---

## **С.ДЭМБЭРЭЛ: МОНГОЛБАНК ИНФЛЯЦИЙГ ОНИЛНО ГЭЖ ХУДЛАА ЯРЬДАГ. ТЭД ХЭЗЭЭ Ч БАЙГАА ОНОДОГГҮЙ**

**-Валютын ханш өсөхөөр дагаад өргөн хэрэглээний бараа нэмэгдэж байна. Үнэхээр хэдхэн ченжүүдийн тоглолтоор Монголын эдийн засаг явж байгаа юу?**

-Мах болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, цалингийн хэмжээ зэрэг чинь инфляцийг бүрдүүлдэг. Гэтэл ард түмний дунд ийм яриа явдаг. Ченжүүд нэмчихлээ гэж. Гэтэл манай судалгаагаар ченжүүд нэмдэггүй байхгүй юу. Бизнесийн газрын зураг гэж юм бий. Түүн дээр тухайлбал цагаан будаа Монгол руу орж ирэхийн тулд 50 хоног зам туулдаг. Ингэхдээ долоон сая төгрөг зарцуулж байж хэрэглэгчдийн гар дээр очдог. Энэ хооронд цагаан будааг 20 хоног галт тэргээр тээвэрлэж авчирлаа гэж бодъё. Тэгтэл хил дээр саатчихна. Дээж өгч байна, бас бус гааль, мэргэжлийн хяналт гээд явсаар байгаад долоон сая төгрөг зарцуулдаг. Тэгэхээр манай орон Зүүн Азийн хориод орнуудтай харьцуулахад ямар нэг бизнес эрхлэхэд гардаг зардал, шат дамжлага зэргээрээ номер нэг орон. Үүнээс ямар гаргалгаа гарч байна гэхээр мах, будаа, бензин тос, наран цэцгийн тос, алтан тариан гурил гээд бүх бараа бүтээгдэхүүний үнэ ялгаагүй болж хувирна. Хэрэв бизнесийн газрын зургийг харвал ойлгоно. Өөрөөр хэлбэл нийлүүлэлтийн талд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг сайн судал. Тэгэхээр иргэдийн гар дээр очих бараа бүтээгдэхүүнийг олон шат дамжлагаар дамжуулж үнийг нь өсгөдөг Зүүн Азийн цорын ганц хүнд сурталтай орон Монгол Улс байсаар байх уу. Эсвэл энэ олон шат дамжлагыг үгүй хийж бараа бүтээгдэхүүний үнийг бууруулах уу гэдэг дээр төр засаг анхаарах цаг нь болсон. Гэтэл төр өнөөдөр Монголбанкны үгийг л дагаж байна.

**-Төв банк нь арай өөрөөр ажиллаад байх шиг. Магадгүй олон тэрбум төгрөгийн валют нөөцлөөд зохиомлоор үнийн**

**хөөрөгдөл бий болгож дундаас нь ашиг олоод байна гэж хардах хүн бас байна аа?**

-Монголбанк Монгол эдийн засагт мөнгө их байгаа учраас эдийн засгаас мөнгийг нь татаж авлаа. Ингэхийн тулд бодлогын хүүгээ өсгөлөө. Ингэхээр арилжааны банкууд бизнес эрхлэгчдэд зээл өгөхгүй. Бизнес эрхлэгчид чинь үйлдвэрлэлээ мөнгөөр явуулдаг юм байгаа биз дээ. Бас зээлийнх нь нөхцөл хатуурчихна. Тэгсэн ч гэсэн тэр хатуу зээлийг нь бизнес эрхлэгчид авахаас өөр аргагүй болно. Тухайлбал, энэ бүх үнийн өсөлтийг дагаад арьс шир, махных нь үнэ нэмэгдчихсэн. Төр бас дунд нь сонин юм хийж байна л даа. “Та яг энэ үнээр зар. Танд мөнгө өгье” гэхэр Монголын мах үйлдвэрлэгчдийн холбоо “Үгүй ээ. Өөрийнхөө замаар өөрөө л явъя” гэсэн ч төр “Та үүгээр нөөцийн мах бэлдчих” гэсээр байгаад өнөө нөөцийн мах гэгчийг гаргаад ирсэн. Нөөцийн махыг ард иргэдийн гар дээр авчирч буй энэ үнэ малчдын зардаг ханшаас өсчихсөн үед малчдад хохиролтой. Инфляцийн хөөрөгдөлтөд нийлүүлэлтийн хүчин зүйлүүдээс гадна шатахууны үнэ маш их нөлөөлж байна.

**-Шатахууны үнэ яагаад нэмэгдэв?**

-Валютын ханш өнгөрсөн есдүгээр сараас хөдөлгөөнд орж эхэлсэн. Гэтэл шатахуун импортоор оруулж ирдэг компаниуд бушуухан ханш гайгүй дээр нь шатахуун нөөцөлж авъя гээд шаардсан. “Нэмэгдчих юм бол яах аргагүй үнээ нэмэхээс өөр аргагүй болох юм байна” гэдгийг ярьсаар ирсэн. Арилжааны банкууд тухайн үеийн валютын ханшаар тооцож мөнгөө өгч байв. Тэр мөнгөөр авсан шатахууныг өнөөдөр бид хэрэглэж байна. Үүнийг эдийн засгийн ухааныг нэвтэрхий мэддэг хүн битгий хэл дөрвөн аргын тоо мэддэг хүн ч бодоод үзэхэд инфляцид хамгийн их нөлөөлсөн нь валютын ханш. Эдийн засгаа үнийн галзууралд оруулахгүй, тогтвортой байлгая гэвэл валютын нөөц гэж жил, улирал болгон “тэд боллоо” гэж нээлттэй зарлан тэр ханшаар нь шаардлагатай валютыг нь шатахууны компаниудад нийлүүлж байя. Тэгвэл өнөөдрийн буруутныг хайх үйл ажиллагаанд хялбар болно. Гэтэл одоо хоёр тал бие бие рүүгээ дайраад л байгаа. Хоёрдугаарт шатахууны үнийг шууд нэмдэггүй юм. Нэмбэл тусгай хяналтад нэмдэг. Харамсалтай нь өнөөдөр дарга нь нэг юм хэлэнгүүт нэмсэн. Яриад үгсэн хуйвалдсан гээд байна. Цаад жинхэнэ шалтгааныг нь ярихгүй байна шүү дээ.

**-Шалтгаан нь юу юм бэ. Яагаад ийм болчихов?**

-Монголын эдийн засгийн үзэгдлийн фон нь чүдэнз зурах төдийд л гал авалцахад ойрхон инфляцийн бодит хүлээлт бий болчихсон байсан. Эндээс бид шийдлээ олж гаргалгаагаа гаргая. Дөрвөн даргыг халах нь зөв үү. Монголбанкийг болохоор өөр газар харьяалагддаг учраас бид юм хэлж болохгүй гэдэг зүйлийг ярьж байна. 2011онд буюу хоёрхон сарын өмнө улсын төсөв баталж байхад УИХ-ын гишүүд юу гэж ярьж байлаа. Дэлхийн банк юу гэж анхааруулга өгч байсан бэ. Үүнийг санаж байгаа байх. Дэлхийн банк “Он гараад инфляци 20-30 хувь хүрнэ шүү” гэж анхааруулж байсан. “Та нар их цамаан загнаж байна шүү” гэсэн. Үүнийг хэн ч сонсоогүй. Сонссон ч анхаарахыг хүсээгүй. Сонгуулийн өмнөх улс төрийн бизнесийн цикль эхэллээ шүү. Энэ үед инфляци гэгч зүйл гаардаг юм.

**-Монгол Улсад үйлчилж буй валютын зохицуулалтын тухай хуулийн валютын чөлөөтэй өгөх дэглэм ажиллаж байна уу, үгүй юу?**

-Монгол Улсад ажиллаж буй дөрөв тавхан банк л валютын зохицуулалтад оролцож байна. Бизнесмений валютын эрэлтийг хэн ч тооцож үзэхгүй. Дээр нь цагаан сарынхаа юмыг авах гэж байгаа ард иргэдийн валютын хэрэгцээг тооцоогүй. Үүнийг чинь хангадаг ББС байгууллага, экспортлогчид, импортлогчид үүнд чинь оролцохгүй байна. Гэтэл тавхан банк нь иргэдээс бизнес эрхлэгчдээс асуусан юм уу, үгүй юу. Үгүй, зөвхөн өөрийнхөө ашгийн төлөөх эрэлтийг зах зээлийн эрэлт гэхэд учир дутагдалтай. Тиймээс Монгол Улс валютын ханшийн чөлөөт гэж нэрлэж буй дэглэмийн зохицуулалтад орох ёстой. Энэ нь зөвхөн интервенц хий гэсэн үг биш.

**-Саяхан ханш өсч дагаад юмны үнэ нэмэгдэхэд Монголбанк интервенцийг оройтуулж хийлээ?**

-Уг нь валютын эрэлтийн эрсэдлээс хамгаалах үндэсний механизмыг бүрдүүлэх хэрэгтэй. Харамсалтай нь Монголбанк өнгөрсөн жилийн турш энэ чиглэлээр сургалт явуулсан гэж байгаа юм. Тэд сургалт явуулахын оронд бодлого гаргаж, үйл ажиллагааг нь хянах буюу тодорхой алхам хийх ёстой. Танайх яагаад “Интервенц хийхгүй байна”, “Валютын ханшийг тогтвортой байлгахгүй байна” гэдгийг нь судлан, хариултыг нь авах хэрэгтэй. Доллар, юань хөдөлгөөнтэй байна шүү гэх зэргээр үйл ажиллагаагаа хийх ёстой байтал сургалт явуулсан. “Нөөцөлж

аваарай” гэдэг ч юм уу энгийнээр бол анхааруулах хэрэгтэй. Хоёр жилийн өмнө гурилын үнэн дээр яаж байсныг санаж байгаа биз дээ. Үнэ нь нэмэгдэхээр нь сэтгүүлчид ард түмэн бүгд Засгийн газар луу дайрсан. Тэгэхээр мөнгөний бодлого болохгүй байгаа биз. Нөгөө талаас инфляци.

**-Инфляци гайгүй болоод ирэхээр гавьяаг нь Монголбанк өөртөө авдаг шүү дээ. Энэ удаа тэдэнд аз дайрсангүй. Тэгээр одоо яах ёстой вэ?**

-Монголбанк инфляцийг алдчихаар гайг нь хэнд тохдог вэ, Засгийг газарт. Хоёр жилийн өмнө гурилын үнэн дээр яасныг мэдэж байгаа. Бүгд зах зээл рүү дайрцгааж байсан. Сэтгүүлчид хүртэл. Тэгэхээр нь бид зах зээл рүү битгий дайрцгаа. Зах зээлийг ойлгож, итгэцгээ гэсэн мэдэгдлийг гаргаж байсан. Яг энэ үйл явдал ахиад давтагдаж байна. Манай танхимд салбар салбарын хүмүүс байдаг. Төр хамаагүй эдийн засагт хутгалдаж ор. Өөрийнхөө ажлыг л хий. Төр бизнес хийх нөхцөлийг нь тусгай мөнгөний бодлогоороо сайжруулах хэрэгтэй. Дээрээс нь бизнесийн зээлийг хүүгээр нь боомилдгоо зогсоох цаг нь ирсэн. 2006 оноос хойш Монголбанк инфляцийг онилно гэж худлаа ярьсаар ирсэн. Хэзээ ч байгаа онож байсангүй. Тэрний оронд эдийн засгийн өсөлтийг онил гэж хэлмээр байна. Тэр юуг хэлж байна гэхээр арилжааныхаа банкуудын дунд өрсөлдөөн өрнүүлэх болон бусад арга хэрэгслээр бодлогын хүүг дээш доош нь хөдөлгөлгүйгээр валютын ханшийн эрсэдлийн механизм тэгш шударга болж байна уу гэдэг дээр хяналт тавих хэрэгтэй. Арилжааны банкууд аль болохоор жижиг, дунд бизнесийг зээлжүүлэх зэрэг мөнгөө аль болохоор хурдан эргэлдүүлэх бодлого барих хэрэгтэй. Монголын инфляцийн мөн чанар нь бидний баттай хийсэн судалгаанаас авч үзвэл нийлүүлэлтийн талын хүчин зүйлүүдээр түүний нийлүүлэлтээс үүдэлтэй өртөг зардал нь нэмэгдээд байна аа. Тиймээс эрэлтийн талын буюу эдийн засагт мөнгө их байгаа гээд цалин хоёр дахин нэмэгдүүлж, халамжийг хавтгайруулах буруу. Эдгээр нь инфляцийн тодорхой нэг шалтгаан болохоос нийт шалтгаан болж чадахгүй. Уг мөн чанарыг танхимаас эргэн сануулах нь гээд зургаан хуудас юм гаргасан. Бид “Их наяд төгрөгийг биш их бүтээн байгуулалтыг амлая” гэж улс төрийн хоёр том намуудад хэлж байсан. Анх хүүхдийн мөнгийг орж ирэхэд хүүхдэд хайргүй танхим гэсэн цол авч байсан. Дараа нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмье гэж байхад бид “Сайн хүмүүст илгээх захидал” гэж

бичсэн. Түүний дараагаар төсөв асар их тэлэлттэй явж байхад “Дөрвөн аргын тоог нэмж хасч, сурцгаая” гэж. Гэтэл энэ бүхнийг анхаарахгүй явсны улмаас юмны үнэ хөөрөгдсөн. Нийгэм эдийн засгийн фонтой нь хамт дүгнэхэд чүдэнз зурахын төдийд л инфляци болохуйц бэлэн байдалд эдийн засаг байсан. 2008 оноос хойш нефть импортлогчдын хилийн үнэ ямар байв, жижиглэнгийн үнэ ямар байсан юм. Дээр нь жижиглэнгийн үнэ, валютын ханш, инфляци хэр түвшинд байсан юм гэдгийг тоон зүүлэлтээр гаргаж тавьсан ийм л мэдэгдэл. Үүнийг хаана ч гаргаагүй. Үүгээрээ аливаа юмны эцсийн цэгийг хатгана гэдэг шиг УИХ-д сануулга өгч байгаа юм. Мөн бодлогын алдаануудыг нь гаргаж тавьсан. Зөвхөн өнгөц хэлээд байх биш цаашид яах ёстой гэдгийг нь хэлээд өгчихсөн.

**-Монголбанкны бие даасан байдал гэдгийг дэлхий дахинд юу гэж авч үздэг юм бэ. Тодорхой жишээгээр тайлбарлах боломж байна уу?**

-Төв банкны бие даасан байдал гэдгийг өнөөдөр дэлхий дахинд УИХ, Засгийн газарт харьяалагдахыг хэлдэггүй. Шийдвэр гаргах процессод хамтын шийдвэр буюу хэнээс ч үл хамаарах хэсэг нөхдүүд, дээр нь төв банкны удирдлагууд зөвлөл байгуулаад Л.Пүрэвдорж гэдэг хүн биш хамтын шийдвэр гаргаж, үүнийхээ төлөө хариуцлага хүлээдэг механизмыг дэлхий даяар Төв банкны бие даасан байдал гэж авч үздэг. Үүний хамгийн тод жишээ нь АНУ. Гэтэл манайд энэ чиглэлийн үйл ажиллагааг хийлгүй, Пүрэвдорж гуай суучихаад хэдэн захирлууд сууж ярилцаж байгаад шийдвэр гаргачихна. Үүнийгээ бид бие даасан байдлаар шийдвэр гаргалаа гэдэг. Гэтэл бие даасан байдлаараа ийм тэнэг шийдвэр гаргаснаараа эдийн засагт хор учруулж байна гэдгийг хэлэх ёстой шүү дээ. Валютын энэ ханш бол буруу ханш. Тав, зургаахан банк оролцогчид нь. Үүнийгээ банк хоорондын зах зээл гэж нэрлэдэг. Гэтэл тэд харилцагчдынхаа валютын нийт эрэлт хэрэгцээг судалдаггүй. Хэн нэгэн хүн хэрэгцээтэй үедээ л “Тэдий хэмжээний валют авъя” гэж ханддаг биз дээ. Дээр нь банкнаас гадуурх валютын эрэлтийг хэн хангах юм. Жишээ нь чи гадаад руу яаралтай явахаар боллоо гэвэл Найман шарга л орно. Ард түмний валютын эрэлт буюу жижиг энэ мэт жижиг бизнесийг буюу жижиг секторын Эрээн рүү явдаг, Бээжин рүү явдаг, Орос руу явдаг эрэлт хэрэгцээг хэн судалдаг юм. Энэ нь Монголбанкны банк хоорондын гүйлгээнд тусгагдаж чадаж байна уу гэвэл тийм биш. Дээр нь дотоодын импортлогчид, “Наран трейд” ч гэдэг юм уу “Номин” ч

гэдэг юм уу эд нар яагаад валютын зах зээлд оролцож болдоггүй юм. Жишээ нь би зэсийн экспортлогч “Эрдэнэт” гэж бодъё. Тэгвэл би зэсийн баяжмалаа зараад олсон валютаа хэрэгцээтэй байгаа хүмүүст ханшаар нь зарж байж валютын зах зээл ажилладаг. Гэтэл тэр нь ажиллахгүй байна. Тиймээс хуулиндаа өөрчлөлт оруул. Ингээд ард түмэндээ ойлгогдох хэлээр нь ярьж хэлж өгөх хэрэгтэй.

**- Энэ инфляцид ер нь эерэг тал байна уу ?**

- Инфляци бол нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангах түвшинд буюу аядуу зөөлөн түвшинд бизнес эрхлэлтэд дэм болдог. Үүнийг би шоргоолжны үүртэй зүйрлэдэг. Үүрийг нь харахаар олуулаа орж гарсан юм шиг харагдаж байгаа ч цаанаа эмх замбараатай шүү дээ. Үүнтэй адилаар бодит сектор байнга бужигнаж байдаг.

**-Танай танхимаас саяхан аж ахуйн нэгжүүдийг үнээ хямдруулахыг уриалж долоо хоногийн аян зарласан байна лээ. Энэ ажил хэр үр дүнгээ өгөх юм бэ. Явцтай гэж үү?**

-Энэ бол ердөө акц.Үнэ гэгч байнга өсч буурч байдаг. Шууд хүчээр бүгдийг нь буулгаж болохгүй. Эрэлт нийлүүлэлт гэж нэг юм бий. Нийлүүлэлтийн сувгийг чөлөөтэй болгож өгөх хэрэгтэй. Түрүүн би хэлсэн дээ. Ямар нэгэн бараа бүтээгдэхүүн хилээр орж ирэхдээ ямар их хугацаа зарцуулж, ямар их хөрөнгө мөнгө зарцуулдаг болох нь нийлүүлэлт дээр саад болж буйн нэг жишээ. Дээр нь банкууд зээл олгох нөхцөлөө сайжруул. Дээр нь малчдаа үнэхээр бодож байвал тэр хөдөөд нь махны үйлдвэрийг нь байгуул.

**-Инфляцийг үгүй хийхийн тулд долларын интервенц хийе гэж. Саяхан үүнд зориулж тавхан сая доллар гаргалаа. Энэ бол жижиг компанийн дансанд байх мөнгө. Тэгэхээр манайд тоглоомын эдийн засаг явж байгаа юм биш үү. Монголд доллар байгаа юм бол таван саяыг гаргаад ингэж унагааж байгаа юм бол өшөө 50 саяыг гаргаж ирээд долларын ханшийг нам унагах хэрэгтэй ш дээ?**

-Өнөөдөр 2,5 их наяд АНУ-д нэг хэсэг нь доллараар нөгөө хэсэг нь еврогоор байршиж байна. Гэтэл валютын нөөцийг яах гэж байршуулдаг юм. Тэгэхээр импортын таван долоо хоногийн нөөцтэй тэнцэх валютын нөөцтэй байх ёстой юм. Үүнээс доогуур орчихвол улс орны төгрөгийн ханшийн тогтвортой байдал нь алдагдана гэсэн үг. Гэтэл манайх чинь импортын таван долоо хоногийн нөөцөөс хамаагүй илүү гараад явчихсан.

**-Тийм их нөөцтэй байж тэгээд юунд зориулж яах гэж тэр их долларыг хадгалаад байгаа юм?**

- Зорилго нь тодорхой цаг үед тодорхой агшинд улс оронд гэнэтийн шок буюу гадаад валютын эрэлт огцом нэмэгдэх, дотоодод зах зээлийн ороо бусгаа байдал үүсэх зэрэгт хэрэглэхээр валютын нөөцийг бүрдүүлдэг. Гэтэл энэ удаа Монголбанк дээрх зорилгоор валют нөөцлөөгүй нь тодорхой. Өнөөгийн иймэрхүү валютын ханшийн хэлбэлзэлтэй үед нэг хэсэг нь хождог. Харин импортлогчид болон дотоодын үйлдвэрлэгчид алддаг. Жилийн эцэст баланс дээр нь валютын ханшийн өөрчлөлт гээд дандаа хасах гардаг. Үүнээс сэргийлэх маш олон арга бий. Банк бүр дээрээ валютын ханшийн эрсэдлийг бууруулъя гэвэл харилцагчидтайгаа доллараар зээл авахад нь гэрээ хийхдээ валютын ханшийн зөрүү гарвал ингэж тооцно шүү гэдгээ тохирох ёстой.

**-Энэ доллар гэдэг чинь хүний биеэр цус гүйхтэй адил үргэлж хөдөлгөөнд орших ёстой. Гэтэл Монголбанк ингэж гүйж байсан урсгалыг царцаагаад хаячихсан. Ингээд долларын эрэлт хэрэгцээ нэмэгдээд ирэхээр долларын ханш өсөөд, төгрөгийн ханш унаад инфляц гээч гараад ирсэн. Монголбанкны гол зорилго бол өөрийн актив буюу хайрцганд байгаа мөнгөө зузаатгаж байх нь тэдний гол зорилго. Цаана ард түмний амьдрал яах нь хамаагүй. Түүгээрээ ажлаа дүгнүүлдэг юм биш үү?**

-Монголбанк зузаан доллартай гэдгээрээ ажлаа дүгнүүлдэг. Ганцхан юм хэлье. Монголбанкны хяналтын зөвлөлийн мэдээлэл гарсан. Монголбанк 2010 онд 145 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан. Энэ алдагдлаа сая нөхөөд авлаа шүү дээ.

*Өдрийн сонин 2012 он*

## **БИЗНЕСИЙН ОРЧИНД ЯАРАЛТАЙ ШИНЭЧЛЭЛ ХИЙХ ХЭРЭГТЭЙ**

**-Улирч буй он үйлдвэржилтийн жил байлаа. Засгийн газар үйлдвэрлэгчдээ дэмжиж чадсан болов уу Таны бодлоор?**

-Шууд хэлэхэд чадаагүй. Танхимаас үйлдвэржилтийн бүтэц болон газрын зураг, чиглэл хийгээд Монгол Улс дунд, урт хугацаанд долоон төрлийн үйлдвэрлэлийг дэмжиж болох юм байна гэдгийг тодорхойлоод өгсөн. Гэтэл үйлдвэржилтийн хөтөлбөр өчнөөн сар

болж байж нэг муу юм гарсан. За тэгээд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгогдох хөнгөлттэй нөхцөлийн зээл нь оны сүүлийн хагас жилээс эхлэн олгогдож эхэлсэн байх жишээтэй. Зээлээ хурдан авч ашиглахгүй бол буцааж хураана шүү гэж айлган байж хам хум үрэн таран хиймээр аядлаа.

Цөөн хэдэн компани тодорхой үр ашигтай төсөл хэрэгжүүлж байгааг үгүйсгэхгүй. Аливаа зүйл үр дүнгээр хэмжигддэг. Саяхан гаргасан статистикийн үзүүлэлтээр үйлдвэрлэл уналтын байдалтай хэвээрээ л байна.

Бизнес эрхлэгчдийг дэмжихээр олгосон тэр 30 тэрбум бол хангалттай мөнгө биш. Жинхэнэ эздэдээ хүрэхгүй байгаа зүйл ч байгаа. Тэгэхлээр ирэх жил үйлдвэрлэгчдэд олгох зээлийн хуваарилалтын механизмыг сайжруулах шаардлагатай.

**-Ингэхэд манай улсад хөгжлийн бодлого гэж байдаг л байх даа?**

-Өнгөн талаас нь харвал хөгжлийн бодлого байгаа юм шиг харагддаг. Өөрөөр хэлбэл, 2020 он хүртэл Монгол Улсыг ингэж хөгжүүлнэ гээд л мастер төлөвлөгөө, хэтийн бодлого гээд цаасан дээр бичээстэй байгаа. Харамсалтай нь эдгээр зүйлд Монгол Улсын болон дэлхийн нийтийн чиг хандлагыг тусгаагүй. Зарим нь хэтэрхий мөрөөдлийн шинжтэй, нэг хэсэг нь дутуу тооцоолсон нь харагддаг. Бидэнд алсад баримжаалах, зөв чигт заах луужин алга. Тийм учраас хөгжлийн бодлого гэдгийг хийлгэх гэж Үндэсний хөгжил шинэтгэлийн хороог байгууллаа. Саяхан 26 том төсөл оруулсан байсан. Гэвч түүнийг нь харахаар нөгөө хуучин хандлагаасаа салаагүй л хэвээрээ байна лээ.

Хөгжил гэдгийг зөв ойлгох ёстой. Эдийн засгийн өсөлтүүдийг хангах нөхцөлүүдийг орчны хувьд яаж бүрдүүлэх вэ гэдгийг хөгжлийн бодлогод онцгой анхаарах хэрэгтэй. Хөгжил гэдэг эцсийн эцэст та бидний маргаашдаа итгэх итгэл, амьжиргааны түвшин, бизнес хийх, ажиллах өөдрөг орчныг л бүрдүүлэхийг хэлээд байгаа.

Энд нэг зүйлийг нэмж хэлэхэд Ерөнхий сайд С.Батболд хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу шилжих түүхэн цаг үе ирлээ гэсэн мэдэгдэл нь улс төрийн бодлогын хувьд чухал мэдэгдэл. Гагцхүү үүнийг бодит амьдрал дээр л хэрэгжүүлэх нь чухал.

НҮБ-ын хүний хөгжлийн индексээр Монгол Улс ухарсан. Манай улсын өрсөлдөх чадвар, бизнесийн орчин, авлигын түвшин, Монгол Улс дахь эдийн засгийн эрх чөлөөг тодорхойлдог



олон улсын төсөөлөл, индекс зэрэглэл зэрэгцээд муудаад л байна. Энэ нь юу хэлээд байна гэхээр хүн рүү чиглэсэн хөгжлийн бодлогодоо анхаарах, бизнесийнхээ орчныг сайжруулах, эдийн засгийнхаа өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, зөвхөн уул уурхайд түшиглэхгүй, голланд өвчнөөс зайлсхийх, баялгийн хараал гэдэг зүйлд орохгүйн тулд салбаруудаа тэнцвэртэй хөгжүүлэх, хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэлийг сайн дэмжих, санхүү, эдийн засгийн орчныг бий болгох, банкны салбарыг өрсөлдөх чадвартай болгох шаардлагатай байна гэсэн үг.

**-Бизнесийн орчин муудаад байна гэдэг нь эдийн засгийн өсөлтийг чөдөрлөнө. Тэгэхлээр төр тодорхой юу хийх хэрэгтэй байна?**

-Хувийн хэвшилдээ эрх чөлөөг нь өгөн, бизнесийн болон эрх зүй санхүүгийн орчныг сайжруулсан орнуудын өрсөлдөх чадвар дээшлээд хөгжиж байна. Бичил дунд гээд бүх төрлийн бизнес эрхлэгчдэдээ мөнгөөр тусалж чаддаггүй юм гэхэд бизнес хийх орчныг нь сайжруулж, хүнд суртлыг арилгаж, ийм ч зөвшөөрөл энэ тэр гээд хэрэгтэй хэрэггүй баахан зүйл бүрдүүлэхийг шаарддаг, элдэв шалгалт, хяналт нэрийн дор дарамталдаг, сүрдүүлдэг байдлыг өөрчилбөл ахиц гарна.

Эхлээд бизнесийн орчны шинэчлэлийг хийх хэрэгтэй. Монголын бизнесийн орчин нь бохирдоод, хогийн өвс ургамал ургаад эцсийн дүндээ Монгол гэдэг улсын нүүр царайг халтар болгон харагдуулж байна. Тиймээс яаралтай шинэчлэл хийх хэрэгтэй.

Гадаад дотоодын хөрөнгө оруулагчид эдийн засгийн өсөлтийг бий болгодог. Эдийн засгийн өсөлт гэдэг нийгмийн төрөл бүрийн зүйлийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бий болгодог.

Манай улсын төр засаг энэ эх үүсвэрээ бий болгодог, баялгийг бүтээж байгаа хэсгийнхээ амьдрах, ажиллах орчныг ерөөсөө анхаарахгүй байна. Ямар сайндаа л Монголбанк нь хувийн хэвшлийг золиосонд гаргах бодлого хэрэгжүүлж байхав дээ.

**-Та үүнийгээ тодотгохгүй юу?**

-Монголбанк мөнгөний хатуу бодлого барьж зээлийг зогсоож байсан. Үүний үр дүнд аж ахуйн нэгжүүд нь хүнээр бол сульдаатай хүүхэд шиг унжийсан байдалтай болсон. Хувийн хэвшлийнхэн уналтад орохоор дагаад банкууд чирэгдсэн. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн гол судсыг нь тасалсан. Энгийнээр тайлбарлавал Төв банк иргэдэд битгий зээл, надаас үнэт цаас худалдаж ав гэсэн бодлого

барьсан хэрэг. Засгийн газраас боловсруулж оруулсан хямралын эсрэг хэрэгжүүлэх төлөвлөгөө гэгчийг УИХ-аар хэлэлцүүлээд, үүнийг хэрэгжүүлэхэд 1.5 их наяд төгрөг шаардлагатай гээд батлуулсан. Хямралын үед бусад улс орнуудын адил эдийн засаг руугаа хувийн хэвшил рүү, банк руу, ард иргэд рүүгээ мөнгө хаяж байж, эдийн засгаа нийтэд нь босгох юм байна гэж тооцоо судалгаа муу хийсэн ч зөв харж шийдвэр гаргасан. Гэтэл энэ төлөвлөгөөг баталсны дараа хоёр, гуравхан хоноод л ОУВС-тай Тогтворжуулалтын хөтөлбөр хэрэгжүүлэхээр гарын үсэг зурж 200 гаруй сая ам. доллараас их хэмжээний арилжааны зээл авч болохгүй гэж ам тангаргаа өгсөн юм. Энэ нь эдийн засгаас мөнгийг татаж авах зүйл байв. Нэг нь эдийн засагтаа мөнгө оруулах, нөгөө нь татаж авах хоёр шийдвэр хоорондоо зөрчилдөн саармагжсан учраас эдийн засгийн байдал хүндхэн байна.

Энэ оны эцэст инфляци нэг оронтой тоонд хүрсэн мөртлөө ард иргэдийн амьжиргаа дордсоор л байна. Үнэ буурсан уу гэж захын хүнээс л асуухад махны ханш л бага зэрэг унасныг эс тооцвол ихэнх бараа бүтээгдэхүүний үнэ өсөөд амьдрахад хэцүү болоод байна гэж хариулна. Энэ чинь инфляцийн дарамт. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшлийнхнийг золиослон инфляцийг хүчээр барьж ганц оронтой тоонд оруулсан Төв банкны бодлого буруу байжээ гэдгийг харуулж байгаа хэрэг. Үүний үр дүнд банкуудын байдал хүндэрч, аж ахуйн нэгжүүд сөхөрч, иргэдийн амьжиргаа улам л муудсаар. Цаасан дээрээс харахад инфляци нэг оронтой болсон ч бодит амьдрал дээр үнийн өсөлтийн дарамт өнгөрсөн жилийнхээс нэмэгдсээр байна.

**-Танхимаас Монголбанкинд нэг бичиг илгээсэн байдаг. Хариу юу гэж ирснийг сонирхох байна?**

-Монголбанкинд арилжааны банк болон компаниудын хооронд хийж байгаа зээлийн гэрээ эрх тэгш биш байна. Иргэний тухай хуулийн гэрээний эрх тэгш байх зарчмыг алдагдуулж байгаа. Тиймээс энэ чиглэлд зөвлөмж гаргаж арилжааны банкуудад хүргүүлнэ үү гэсэн утгатай захиа бичсэн юм. Гэтэл Монголбанкнаас бидний оролцдог ажил биш гэж хэлж байна лээ. Ийм сурах бичгийн хүрээнд Төв банкны бодлогыг зангидаж болохгүй шүү дээ. Нүдний шил зүүсэн, тэнгэр дээр сууж байгаа төв банкны бодлого байж болохгүй. Газар дээр буусан, хувийн хэвшлийнхний цусны лугшилтыг мэддэг байх хэрэгтэй. Ингэж л тэдний бодол санааг мэдэж байж зөв бодлого хэрэгжүүлж чадна. Иргэд, аж ахуйн

нэгжүүд урт хугацаатай, хүү багатай, өөрийг нь шатаадаггүй, бизнес нь урагшилдаг зээлийн орчныг л бий болгохыг хүсч байна. Ийм зээлийн орчныг бий болгох, өрсөлдөөнийг өрнүүлэхийн оронд зүгээр хөгжилтэй орны төв банкны хэрэгжүүлдэг бодлогыг хуулаад сууж байж болохгүй. Үүнд ч УИХ-ын гишүүд үнэмшээд, хэвлэлийнхэн итгээд тэдний гаргасан томъёоллоор дуугардаг болоод удаж байна даа.

**-Ер нь арилжааны банкууд цаашид яах бол Таны бодлоор?**

-Банкны салбарын хямрал ингэсхийгээд зогсох байх. Улс юм хойно бонд энэ тэр гаргаж аргацаагаад энэ салбарыг аваад гарах байлгүй дээ. Энэ үед өрсөлдөөний суурийг тавьж цаашид эрүүл гольдролоор замнах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал.

**-Валютын ханш нэг хэсэг хэт савласан, одоо дахиад өсөх хандлага ажиглагдаад байна уу?**

-Өнгөрсөн оны арваннэгдүгээр сараас 2009 оны дөрөвдүгээр сар хүртэл валютын асар их нөөцийг Монголбанк гаргаж байсан. Түүнийхээ хүчээр ханшийг тодорхой хэмжээнд тогтоон барьсан юм. Гэхдээ манай улсад валютын ханшийн зах зээл нь зөв хөгжөөгүй. Валютын ханшийн оролцогч нь цөөн хэдхэн банкаар л хязгаарлагддаг. Монгол Улсын валютын ханшийн дэглэм нь өөрөө валютыг гадагшаа урсгах, долларжилт эдийн засагт хүчтэй болохыг өөгшүүлдэг. Интервенц хийж байж зохиомлоор хэдэн сар валютын ханшийг тогтоон барьсан. Гэтэл эдийн засаг хүчээр барьснаар биш эрэлт, нийлүүлэлтээр тэнцвэржиж байдаг. Валютын зохицуулалттай хөвөх ханш гэсэн дэглэм Монгол Улсад алга. Валютын ханшийн удирдлага менежмент гэдэг зүйл ерөөсөө төлөвшиж чадаагүй байна.

Саяхнаас л Монголбанк валютын бирж ярьж байна. Энэ юуг харуулж байна гэхээр Төв банк ажлаа хийхгүй байж байгаад 2008 оны эцэс 2009 оны эхэнд ханш гэнэт өсч баахан сандарч арайхийн тогтоож авсан. Одоо үүнийг хийхгүй бол болохгүй нь гэдгийг мэдрээд 2010 оны үндсэн чиглэлдээ тусгаж батлууллаа. Өөрөөр хэлбэл, ажлаа хийхгүй байж байгаад одоо л хийх гэж байгаа хэрэг.

**-Эрхэм гишүүд тойрогтоо 76 тэрбум төгрөг хуваариллаа. Таны бодлоор энэ мөнгийг үр өгөөжтэй ямар зүйлд зарцуулах нь илүү бодитой бол?**

-Болдогсон бол “Ногоон сан” гэж байгуулаад төвлөрүүлж байгаль орчин, утаа, цөлжилт, бэлчээргүйдэл зэрэг тулгамдсан асуудалд зарцуулбал сайн сайн. Түүнээс биш талаар нэг цацах

нь эдийн засгийн талаасаа ч үр ашиг муутай. Тойрогт мөнгө хуваарилдаг тогтолцоог өөрчлөх хэрэгтэй. Төсвийн хуваарилалтын механизм өөрөө учир дутагдалтай, хэт төвлөрсөн нь ч нөлөөлж байгаа.

Зөвхөн гишүүдийн тойрогтоо хуваарилсан мөнгөнөөс гадна маш их хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна. “Эрдэнэт”-ийн дэргэд зэс хайлуулах үйлдвэр баригдахгүй байгаа нь хоёр улсын хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа удирдлага болон улс төрийн шийдэл хоёр орны хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа удирдлага болон улс төрийн шийдэл хоорондоо холилдсон учраас л өнөөг хүрч байгаа юм. Хэдэн жилийн өмнө энэ асуудлыг тавиад үйлдвэрийг барьж байгуулах улс төрийн хүсэл эрмэлзэл гаргасан бол барьчих л байсан. 76 тэрбум ч 7.6 тэрбум ч бай үр ашгаар нь эрэмбэлж төсвийн хөрөнгийг хуваарилдаггүй. Хувийн хэвшил болон иргэний нийгэм, иргэдийн санал бодол дээр тулгуурладаггүй, зах зээлээ олигтой олж хардаггүй, улс орны тэргүүлэх чиглэлээ зөв тодорхойлж чаддаггүйн улмаас асар их хөрөнгийг зам, дэд бүтэц рүү цацаад л байдаг. Дээрээс нь нийгмийн халамждаа л анхаараад байна. Эдийн засгийн зохистой байдал, эдийн засгийн үр ашиг гэдэг зах зээлийн эдийн засгийн хоёр гол зүйл, шалгуурыг авч үзэлгүй л төсвийн хөрөнгө оруулалтыг хуваарилаад байгаа юм. Тиймээс миний хувьд зөвхөн 76 гишүүнийг ч биш яам, агентлагийн түшмэдийг ч гэсэн буруутгах хэрэгтэй гэж боддог. Төсвийн хөрөнгийг эрх зүй, институци, эдийн засгийн үр ашгийн хувьд зөв зохистой байршуулахад өөрчлөлт хийхгүй бол бахь байдгаараа л байна.

**-Хөгжлийн банк байгуулна гээд байгаа. Та үүнийг дэмждэг үү?**

-Бусад улсын муу туршлагыг харахаар дэмжмээргүй санагддаг. Гэхдээ гадаадад ийм байсан юм чинь Монголд хөгжлийн банк байгуулж болохгүй гэж үзвэл хэтэрхий өрөөсгөл асуудал. Муу суурин дээр хөгжлийн банк байгуулах биш суурийг сайжруулах, банкуудын дунд өрсөлдөөн бий болгох л хэрэгтэй. Маш том төслүүд хэрэгжих гэж байгаа энэ үед нэр хүндтэй, олон улсын том банкны салбарыг Монголд байгуулах нь чухал. Ийм банк жилийн 5-7 хувийн хүүтэй зээлийг олгоод эхэлбэл бизнес эрхлэгчид хошуурна. Тэгэхээр дотоодын банкуудын өрсөлдөх чадвар ч дээшилнэ. Мөн банкнаас гадна мөнгө босгох боломжийг олгодог хөрөнгийн биржийг хөгжүүлэх хэрэгтэй байна. Монголд ганцхан

хөрөнгийн бирж байх ёстой юм шиг хандаад байдаг сэтгэлгээгээ ч өөрчлөх цаг болсон гэж боддог. Хөрөнгийн бирж байгуулъя гэж хөөцөлдөөд байгаа залуус байна. Тэднийг дэмжиж өрсөлдөөн бий болговол байдал аяндаа өөрчлөгдөнө.

#### **-Бид хямралаас гарсан уу?**

-Гараагүй. Эдийн засгийн хямралт байдал 2010 оны эхний улиралд үргэлжлэх шинжтэй байна. 2010 оноос эхлээд эдийн засаг руу мөнгө гаргаад, Төв банк мөнгөний бодлогоо өөрчлөөд, банкуудыг идэвхижүүлэх юм бол барилга ч баригдаад бусад бизнес ч цэцэглэнэ. Гадаадын орнууд аль хэдийнэ хямралаас гараад байна. Экспортод бараагаа гаргая гэвэл зах зээл байж л байна. Мал нядлаад гаргая гэхэд л мөнгө нь байхгүй байна шүү дээ.

**-Ирэх жил “Хүний хөгжил” гэсэн сангаас бэлэн мөнгө иргэдэд тараах гэж байна. Энэ нь эдийн засагт ямар нөлөө үзүүлэх бол?**

-Заяагдмал нөөцийн олдмол хам шинж илрээд байна. Түүний нэг шинж нь алаагүй баавгайн арьсыг ард иргэддээ хуваарилах гэж оролддог явдал. Энэ нь эдийн засгийн дархлааг сулруулж, хүмүүс тэгш боломжийг эдэлж өөрсдийгөө хөгжүүлэхийн оронд төрөөс авах гээд хараад суудаг бэлэнчлэх сэтгэлгээнд л сургана.

**-Танхимаас 2009 онд хийж бүтээсэн ажил, шинэ оны төлөвлөгөөнөөс сонирхуулахгүй юу?**

-Танхимын хувьд бизнесийн бодлогын өмгөөллийн чиглэлээр нэлээд олон зүйл хийлээ, өнгөрч буй онд. Танхимын хэлсэн ярьсан, бичсэн зүйлүүд төрийн бодлого, шийдвэрт тодорхой хэмжээгээр тусгалаа олж байгаа ч банк санхүүгийн талаар 2-3 жилийн өмнөөс хэлсэн зүйлүүд хэрэгжээгүй л байна. Гэхдээ зарим асуудлыг 2010 оны мөнгөний бодлогод тусгаж байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, манай төрийн бодлогын хурд яст мэлхийн хурдаар урагшилдаг юм бол дотоодын үйл явц, улам бүр хурдтай урагшилж яваа дэлхийн хөгжлийн хурдыг хүлээхгүй. Тиймээс манай улс хоцронгүй, гадна талдаа ямар ч амжилтгүй мөртлөө дотроо нэг л амбицтай улс болж хоцрох нь.

2010 онд бид эдийн засгийн хямрал, бодит салбарын зогсонги хөшүүн байдлыг үл харгалзаад урьд нь явуулж байсан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхээс гадна “Ногоон эдийн засаг, ногоон бизнесийг дэмжих жил” хэмээн зарлаж байна. Монгол Улсын хувьд хүрэн эдийн засгийн үйл явцыг эрчимжүүлэх буюу байгалийн нөөц

баялгаа эргэлтэд оруулж эхэлсэн. Үүний хажуугаар түүхэн зорилт буюу ногоон эдийн засгийн талаар бодож эхлэх, дэлхий нийтийн хандлагыг цаг алдалгүй дагах шаардлагатай. Тиймээс Танхим аливаа бодлогын үйл явцад байнга санаачлагч байсны хувьд ирэх оныг “Ногоон эдийн засаг, ногоон бизнесийн жил” хэмээн зарлаж байгаа юм.

Энэ хүрээнд Танхим шинэ Засгийн газартай хамтран ажиллана. Саяхан Ерөнхий сайд С.Батболд эрдэс баялаг, эрчим хүчний яамныхантай манай Танхим дээр уулзахдаа “Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу шилжих түүхэн сорилт ирлээ. Ярих бус, хийх цаг ирлээ” гэж мэдэгдсэн. Энэ талаар ч цаашдаа хамтарч ажиллах болно.

Ер нь Монгол Улс хөгжлийн салаа замын уулзвар дээр зогсож байна. Бид нийгмээрээ ерөнхийдөө хүрэн эдийн засгийг сонгоод байгаа. Ийм эдийн засгийн нөөц баялгийг зөв бодлогоор эргэлтэд хурдан оруулахын зэрэгцээ ногоон эдийн засгийн элементүүдийг завсраар нь хавчуулж өгөхгүй бол бид дэлхийн хөгжлийн цоо шинэ хандлагаас хоцрох нь. Дэлхийн улс орнуудын төрийн тэргүүнүүдийн уулзсан Копенгагены уулзалт зөвхөн уур амьсгалын өөрчлөлт бус дэлхийн эдийн засгийн шинэ хандлагын талаар ярилцлаа. Тэгэхээр Танхим ирэх онд ногоон эдийн засгийн чиглэлээр олон зүйл хийнэ. Танхим гурван Ц буюу цэвэр үйлдвэрлэл, цэвэр хүнс, цэвэр технологи, ногоон зээлийн баталгааны сан, жижиг, дунд бизнесийн хөгжлийг дэмжих зэргээр олон салбарт хийж буй ажлуудаа үргэлжлүүлнэ.

Дээр нь бидний хувьд 2010 он бол онцгой жил. Танхим байгуулагдсаны 50 жилийн ойгоо тэмдэглэнэ. Уламжлалт ёсоор 50 шинэ ажил хийнэ. Мөн мэдээллийн технологийн ололтыг, мэдээллийн технологийн бизнесийг компаниудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд Танхим түлхүү анхаарч ажиллана. Түүнчлэн банк санхүүгийн үйл ажиллагаа манай анхаарлын төвд байсаар байх болно. Энэ салбарт өнгөрсөн онуудад гарсан алдааг засахаас гадна 2010 оны мөнгөний бодлогод туссан чиглэлүүдийг бодитойгоор хэрэгжүүлэхэд бид дуу хоолойгоо хүргэнэ. Ганцхан жишээ хэлэхэд Танхим жил хагасын өмнө одоо яриад байгаа цөөн хэдэн компаниас хамаардаг банкны бүтцийг үлэмж дотночлон үзэх зарчмаар зарим банк ажиллаж байна. Үүнийг цаашид онцгой анхаарч ажиллах ёстой гэж хэлж байсан.

Олон улсын дипломатын хэллэгт байдаг үлэмж дотночлон үзэх зарчим гэдэг үгийг сануулж байсан. Дээр нь банкны салбарт өмчлөлийн асуудал чухал шүү гэдгийг мөн олонтаа ярьсан.

Цаашдаа Монгол Улс том том стратегийн төслүүдийг хэрэгжүүлж эхлэх учраас банк санхүүгийн салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, сайжруулах, өрсөлдөх орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллана. Мөн хөдөөгийн, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, төрөөс өгч буй 30 миллиардыг, төсвийн тодотголоор 100 миллиардад хүргэх, Танхимын хэдийнэ санаачилсан жижиг, дунд зээлийн баталгааны сан, олон жил ярьсан төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх зэрэгт голлон анхаарна. Өөрөөр хэлбэл, шинэ Засгийн газрыг бизнест ээлтэй болгоход бүх талын арга хэмжээг авч ажиллана. Учир нь өнөөгийн Засгийн газрын тэргүүн бол манай салбараас гарсан хүн. Ерөнхий сайдтай тохиролцсон байгаа. Бизнесийнхэн энэ Засгийн газрыг байгаа дээр их ажил амжуулах, бизнесийн орчныг шинэчлэхийн төлөөх жил болгож ажиллана.

2010 он

## **МУХАҮТ-ЫН ДАРГА С.ДЭМБЭРЭЛ: МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ ЗӨВХӨН ЦӨӨН ХЭДЭН ХҮН ШҮҮМЖЛЭЭД БАЙГАА ЮМ БИШ**

-Мөнгөний бодлого эдийн засагтай уялдаж чадахгүй байгааг зөвхөн би хэлээд байгаа юм биш. Үүнийг зээл авч чадахгүй байгаа хүмүүс, төсөл бариад санхүүгийн асуудалдаа түүртээд яваа хүмүүсээс бэлхэн харж болно. Ерөөсөө бизнесийнхэн ч, банкныхан ч энэ зээлийн систем, мөнгөний бодлогод шүүмжлэлтэй хандаж байна. Одоо инфляци гэдэг зүйлийг төв банкнаас аль 2006 онд онилоод онилоод бодит эдийн засагт үр дүн авчрахгүй байна. Бас инфляцийг нэг оронтой тоонд оруулна гэж яриад нөгөөх нь азаар орчихвол бидний гавьяа гэж яриад байдаг. Энэ бол цэвэр мөнгөний бодлоготой холбоотой асуудал.

Уулзалтад мөнгөний бодлогын нөлөөгөөр тулгардаг асуудлаа хэлэлцэхээр бизнесийн байгууллагын төлөөллүүд хүрэлцэн ирсэн юм. Тэдний хэлж буйгаар төрөөс баримталж буй мөнгөний

бодлого, төсвийн тэлэлт ихэвчлэн бизнесийн орчинд тээг болох үр дүнг авчирдаг аж. Тухайлбал, өнгөрсөн онд жижиг дунд бизнесийг дэмжихээр төсөвлөсөн хөрөнгийн 80 хувь нь найман нэрийн барааны дэлгүүр болж хувирсан байна. Энэ нь төрөөс олон жил баримталж байгаа үйлдвэрлэлийн салбарт ахиц авчрахгүй байгаа аж.

*Т.Есөн-Эрдэнэ, 2010 он*

## **НЭГ САЯ ТӨГРӨГ ТАРААЛАА ГЭЭД ЭДИЙН ЗАСАГ ХӨРӨХГҮЙ, ХАЛАХГҮЙ**

**МУХАҮТ-ЫН ДАРГА С.ДЭМБЭРЭЛТЭЙ ҮҮЛЗЭЖ ЯРИЛЦЛАА.**

**-2012 оны Монгол Улсын төсвийн төслийг та олж харсан л биз дээ. Цалин тэтгэврийн нэмэгдэл, сая саяын өглөг, буян үйлдэх үрэлгэн төсвийн хар гайгаар эдийн засаг хэрхэн хямрах бол гэсэн эмзэглэл олон нийтэд байгаа?**

-Үрэлгэн, өглөг хишиг нь хэтэрсэн төсөв болчихлоо гэсэн янз бүрийн шүүмжлэл сонсогдож л байна. Би харин үүний эсрэг байгаа. Тэтгэвэр, тэтгэмжийг 53 хувиар, тэгэхдээ ялгавартайгаар, бага тэтгэвэр авдаг хүмүүст арай илүү, их тэтгэвэр авдаг хүмүүст нь арай бага гэх зэргээр тэнцвэржүүлэх маягаар асуудалд хандаж байгааг би зөв гэж үнэлж байна. Тэтгэвэр, тэтгэмж нэмлээ гээд инфляци өсөхгүй. Үүнд би 100 хувь итгэлтэй байгаа. Харин төрийн албан хаагчдын цалинг компаничилж нэмэхийг эсэргүүцэж байгаа. Үүнээс болж инфляци өсч магадгүй. Ийм асуудлаас болж өссөн инфляцийг үйлдвэрчний эвлэлийн инфляци гэж нэрлэдэг юм. Би С.Ганбаатарыг шоглож байгаа юм биш шүү. Цалинг нэмэх асуудалд мань хүний оролцоо байсан байх. Засгийн газар гурван талын хэлэлцээрийн дагуу цалин нэмлээ гэж яриад байна лээ. Манай танхим цалин нэмээч гэж Засгийн газартай ямар ч хэлэлцээр өрнүүлээгүй шүү дээ. Үйлдвэрчний эвлэлийн инфляцийн горьг хэн мэдэрдэг вэ гэхээр жижиг дунд үйлдвэрүүд. Цалингийн өсөлтөөс болоод жижиг дунд үйлдвэрүүд хэцүүхэн байдалд ордог. Цалингаа нэмье гэхээр ажилтнуудаасаа халах хэрэгтэй болно. Нэг ажилтнаа халаад нөгөө ажилтныхаа цалинг нэмлээ гэхэд

үйлдвэрийнх нь хэвийн үйл ажиллагаа доголдож эхэлдэг. Үүнээс болоод нийт эдийн засгийн идэвх ерөнхийлдөө сулардаг юм. Үрэлгэн төсөв болсон уу гэвэл болсон. Үүнийг хэрхэн зохицуулах нь Монголбанкны мөнгөний бодлогоос хамаарах учиртай. Манай Монголбанкны мөнгөний бодлого дэндүү явцуу. Төв банк нь Засгийн газраа эдийн засаг тэллээ гээд буруутгаад байдаг, эдийн засгаа тэлэлтээс хамгаалж, инфляцийг тогтворжуулж байна гээд авч байгаа арга хэмжээ нь үнэндээ эдийн засгийг сайжруулах биш саармагжуулах тал руугаа оруулж байна.

**-Хөгшид болоод хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нэг сая төгрөгийг бэлнээр олгохыг та зөв гэж бодож байна. Бэлэн мөнгө тарааснаар эдийн засаг сульдаж магадгүй юм биш үү?**

-Яадгийм, зөв. Хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нэг сая төгрөг тараалаа гээд Монгол Улсын эдийн засаг хоосорчихгүй. Нэг хэсэг нэг сая төгрөгийнхөө талыг ходоодондоо хийнэ биз. Нөгөө хэсэг нь өр зээлээ дарна биз. Үлдсэн нь нийлүүлж байгаад нэг юм авна биз. Зарим нь хагас хугасыг нь хадгаламж болгоно байх. Хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мөнгө өглөө гээд буруудах зүйл байхгүй. Нэг хэсэг эрэлт л нэмэгдэнэ биз. Ингэлээ гээд эдийн засаг сульдаж муудаад байх явдалгүй гэж дүгнэж байгаа. Хөгшдөд нэг сая төгрөг тараалаа гээд эдийн засаг хөрөхгүй бас халахгүй. ОУВС-гийнхан эдийн засаг халалттай байна гэдэг. Хаана халж байгаа юм бэ. Харин хөрөлттэй байгаа юм биш үү. Иргэдийн халаас хоосон, ажилгүйдэл, ядуурал их, жижиг дунд үйлдвэрүүд нь чагтан баланстай байхад яагаад эдийн засаг халчихсан байх билээ дээ.

**- Эдийн засгийн өсөлт 17 хувьд хүрлээ гэж эрх баригчид зарлаад байгаа. Ирэх жил нэг монгол хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5000 ам.доллар болно гэсэн тооцоо гаргасан. Гэтэлд бодит амьдралд дээр иргэдийн амьдралд төдийлөн өөрчлөлт ороогүй л байна шүү дээ. Иргэд мөнгөгүй, ажилгүй ядуу хэвээрээ л байна?**

-Яг үнэн. Энэ асуудалд эрх баригчид арай өөрөөр хандах хэрэгтэй байгаа юм. Дотоодын нийт бүтээгдэхүүн 17 хувьд хүрлээ гээд иргэдийн амьдралд юу наалдсан юм бэ? Юу ч наалдаагүй шүү дээ. Ажилгүйдэл, ядуурал байсаар л байна. Уг нь дотоодын нийт бүтээгдэхүүн 5000 ам.долларт хүрлээ гэхэд иргэд үүнийг эхлээд мэдэрсэн байх ёстой. Миний амьдралд ийм өөрчлөлт орсон юм чинь, улсын эдийн засаг ийм хувьтай байх нь аргагүй гэсэн

бодлыг төрүүлэх хэрэгтэй. Бид тоон үзүүлэлт биш чанарыг хөндөх ёстой болж. Эдийн засгийн энэхүү 17 хувийн өсөлт хэр чанартай юм, үнэхээр иргэдэд наалдацтай байж чадах уу гэдгийг бодолцох шаардлагатай болж. Хятадын эдийн засаг асар хурдацтай хөгжиж байгаа. Гэтэл тус улс өнөөдөр тоон үзүүлэлтээсээ илүү чанарт анхаардаг болжээ. Эдийн засгийн өсөлтийн үр ашгийн хүрээнд иргэдийн амьдрал хэр сайжрав гэдгээ чухалчлах болсон байна лээ. Монголчууд бол уул уурхайн баялагтаа хэт их найдаж байна л даа. Нэг үгээр хэлбэл, манайхан уул уурхайн дэмийрэлд орчихсон. Нөгөө Голланд өвчнийх нь шинж тэмдэг аль хэдийнэ илрээд эхэлчихсэн байна шүү дээ. Уул уурхайгаас бусад баялаг бүтээх салбарууд нь ямар ч үнэ цэнгүй болчихсон. Баялаг бүтээх салбарын ажилчдын цалин бага. Гэтэл баялаг бүтээх салбарт ажлын байр байгаад байдаг, ажиллах хүн олддоггүй. Энэ эдийн засгийн бодит өсөлтийн үр дүн мөн үү гэдгийг ч бодох ёстой. Түүнээс биш, алт, зэс нүүрсээ зараад олсон мөнгөө эдийн засгийн өсөлт хэмээн тоон ухагдахуунаар тооцоолж эндүүрэх хэрэггүй байх. Манайхны толгой бүр эргэчихсэн байгаа нь надад анзаарагддаг. Бүгд л том, том тоо ярьсан хүмүүс. Тэр тоо нь амьдралд очоод наалдсан юм байхгүй. Дундаж давхрагийнхан нь бүх ачааг нуруундаа үүрчихсэн. Нэг л эвгүй гишгэвэл ядуусыг эгнээ рүү хөл алдчихаж магадгүй л дүр зураг харагдаж байна. Тэгэхээр эдийн засгийн өсөлт 17 хувьд хүрлээ гэхээсээ илүү иргэдийн амьдрал хэр сайжирсан юм бэ гэдгээр л эдийн засгийн бодит өсөлтийг дүгнэх болов уу. Би Ерөнхий сайдад хэлээд байгаа л даа. Битгий өсөлт гэж яриад байгаач ээ. Битгий эдийн засаг өсөөд байна гэж иргэдийн хуураад бай гэж.

**-Таныг, өөрөөр хэлбэл Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим /МҮХАҮТ/-ыг Хан-Уул дүүргийн шүүхээс хууль зөрсөн гэдэг үндэслэлээр буруутгасан. Та үнэхээр өөрийнхөө эрх ашигт нийцсэн хууль, дүрэм гаргачихсан юм уу?**

-МҮХАҮТ -ын дүрмийг баталж байхад тэр хүн өөрөө хараад сууж байсан шүү дээ. Их инээдтэй. Үндсэн хуулиар дулдуйдаад МҮХАТ төрийн бус байгууллагын хуулийг зөрчсөн гээд 13 зүйлээр шүүхэд хандсан. Шүүх нь ч шүүх. Нөгөө 13 зүйлийг наймыг нь Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хууль зөрчөөгүй гэсэн мөртлөө тавыг нь хууль зөрчсөн байна гэж үзсэн. Миний хувьд ямар жижигхэн хүн надтай Монголын үндэсний

худалдаа үйлдвэрийн танхимын төлөө өрсөлдсөн юм бэ гэж бодогдсон. Бид мэдээж дүрэм зөрчөөгүй. Тиймээс Нийслэлийн шүүхэд хандаад байгаа. Тэр хүн С.Дэмбэрэл гэдэг хүнд ялагдчихаад тахимаа өгөхгүй янз бүрийн юм яриад, сэдээд байгаа юм билээ. Баас хатавч өмхийгөө тавьдаггүй гэж нэг үг байдаг даа. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дүрмийг би ганцаараа баталчихдаггүй юм. Танхимын гишүүд хамт суугаад баталдаг. Эр хүн ялагдвал тахимаа өгчихдөг байх хэрэгтэй гэж би боддог. Намайг дэндүү олон хүн мэднэ дээ.

**-Тэр хүн гэж хэн юм бэ?**

-Зарим хүн карьераа өсгөхийн тулд намайг ашиглах гээд байх шиг байна. Би хэзээ ч тэгүүлэхгүй. Иргэн Лхагважав гэж болох гээд л байгаа юм байгаа биз. Өөрийнхөө аргаар л өөрийгөө тэгж таниулдаг юм байгаа биз. Тэр хүн надад хувийн өш хонзон санаагүй гэж бодож байна. Гэхдээ тэр хүний дэргэд намайг хэн бэ гэдгийг хэлүүлэлтгүй ойлгох хүмүүс олон бий.

**-МҮХАҮТ -ын зүгээс УИХ-ын 39 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулахаа мэдэгдсэн Ардчилсан намын эсрэг байгаагаа зарласан. Ингэхэд аж ахуйн нэгжүүд “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааны 10 хувийг нэрлэсэн үнээр нь худалдаж авах гээд яагаад улайраад байна вэ?**

-39 дүгээр тогтоолыг аж ахуйн нэгжүүд баталчихсан юм биш шүү дээ. УИХ-аас баталсан тогтоол. УИХ-аас баталсан тогтоолыг хэрэгжүүлэх нь Засгийн газрын үүрэг. 39 дүгээр тогтоолд дурдсанаар “Эрдэнэс Тавантолгой” компанийн нийт хувьцааны 10 хувийг аж ахуйн нэгжүүддээ өгье гэсэн байгаа. Зүгээр ч өгчих юм биш. Нэрлэсэн үнээр нь худалдан авах юм. УИХ өөрсдөө хуулиа баталчихаад дараа нь популизм хийгээд хуулиндаа өөрчлөлт оруулья гээд байгаа нь шударга биш гэж үзсэн учраас л эсэргүүцлээ илэрхийлсэн.

**- Аж ахуйн нэгжүүдэд “Эрдэнэс Тавантолгой” компанийн нийт хувьцааны 10 хувийг нь нэрлэсэн үнээр нь зарахаас илүү 20 хувийг нь иргэдэд үнэгүй тараах асуудлыг дэмжигчид олон байгаа. Монгол Улсад 50 гаруй мянган аж ахуйн нэгж бүртгэлтэйгээс дөнгөж 27 мянга орчим нь л татвараа төлдөг. Тэдгээр нь цөөхөн бизнесийнхний халаасанд байдаг гэсэн бас нэг үндэслэл гаргаж ирээд байгаа?**

-Нийт иргэддээ 10 хувийг тараана тэгээд тэгш хуваарилалт хийж байгаа юм. Харин нэрлэсэн үнээр нь аж ахуйн нэгжүүдэд

зарна гэдэг тэгш боломж олгож байгаа хэрэг. Тэгш боломж, тэгш хуваарилалт хоёр чинь хоёр өөр асуудал. Таны хэлдгээр 50 гаруй мянган аж ахуйн нэгжийн тал нь татвараа төлдөг, бусад нь чагтан тамгатай байгаа. Чагтан баланстэй компаниудынхаа тоог нэмэхгүйн тулд татвараа төлөөд явж байгаа баялаг бүтээгчдэдээ боломж олгох нь төрийн үүрэг. Баялаг бүтээгчдэдээ олгож байгаа тэгш боломжоо яагаад тэгш хуваарилалт болгох гээд зүтгээд байгааг ойлгоход ядах юмгүй л байна лээ. Сонгууль ойртсон, тэгээд л популист амлалтууд ар араасаа өрнөөд байна л даа. Ард түмэнд таалагдах гэсэн УИХ-ынхны ээлжит шоу эдийн засгийг авч яваа баялаг бүтээгчдэдээ гомдоох ёсгүй юм шүү дээ.

**- Иргэд ч гэсэн “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг нэрлэсэн үнээр нь авмаар л байгаа шүү дээ?**

- Та мэдэх үү. Нийт хадгаламжийн маш бага хувь иргэдийнх байдаг. Энгийн иргэд дотор “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг нэрлэсэн үнээр нь авах хүн тийм ч олон биш шүү дээ. Байлаа гэхэд тэр хүн ардаа компанитай л байгаа. Монголчуудын нэг атаархуу зан байдаг юм байна л даа. Тамын тогооны үлгэр шиг. Нэг нь жаахан ахих гэхээр араас нь чаргууцалдаад, барьцалдаад байдаг. 100 хувь ард түмэний хувьцаат компани гэж дэлхий дээр байсан уу, та мэдэх үү. Тийм юм байдаггүй л байхгүй юу.

**-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Тавантолгой төслийг буцаасан. Өнөөдөр уг төсөл хаана ямар шатандаа яваа нь тодорхой бус болчихлоо шүү дээ?**

-Би энэ төслийг хэрэгжүүлэх ажлын хэсэгт багтаагүй болохоор төсөл хаана явааг хэлж мэдэхгүй. Гэхдээ ямар ч байсан Тавантолгойн ордыг очиж үзэх санаатай байгаа. Байгаль экологийн асуудалтай нь бүтээн байгуулалт нь хэр хосолж байгаа сонирхох гэсэн юм. Миний бодлоор Тавантолгойн төсөлд төр оролцох нь буруу. 100 хувь хувийн хэвшлийнхний мэдэл өгөх хэрэгтэй шүү дээ. Төр өөрөө хувь эзэмшээд, хувиа барьцаалж мөнгө зээлээд байх нь зохимжгүй. Түүнийхээ оронд тоглоомынхоо дүрмийг ил болгоод, татвар, хураамжаа сайн хураах хэрэгтэй. Усаа үнэтэй болгох хэрэгтэй. Хөрсний элэгдлийг тооцдог байх ёстой. Алт, зэс, нүүрснээс илүү үнэтэй капитал ус болоод байгааг манай дарга нар тоохгүй л байна. Уул уурхайн компанийн хэрэглэдэг усны үнэ Долоон буудлын Должин эмээгийн литр уснаас хамаагүй хямдхан байна шүү дээ. Усаа өндөр үнээр зарах ёстой.



**-Төр хувиа яаж хүртэх юм бэ. Байгалийн баялгаасаа орж ирсэн мөнгөө ард түмэндээ ижил тэгш хэмжээгээр хүртээнэ гээд заачихсан байгаа шүү дээ?**

-Татвар, хураамжаараа хүртэнэ. Төр стратегиа барьж байх ёстой болохоос биш хувийн хэвшлийнхэнтэй хамт хутгалдаад ажилд нь оролцоод явах нь утгагүй. Тэгвэл их будилаан үүснэ. Араасаа маш их авлига, хээл хахууль дагуулна.

Төр тооны машин бариад бүгд тоо бодоод эхэлнэ гэдэг чинь нөгөө уул уурхайн дэмийрэлд өртөж байгаа нэг хэлбэр шүү дээ. Хэлбэр ч гэж дээ, өвчнөөр бол шинж тэмдэг нь илэрч байгаа хэрэг. Уг нь говийн эко системд ямар өөрчлөлт орж байна, усныхаа асуудлыг уул уурхайн компаниуд яаж шийдвэрлэж байна гээд том бодлого яриад, том асуудлыг шийдээд явах ёстой юм. Би бол 51 ч юм уу, 34 хувийг төр эзэмшинэ гэдэгтэй анхнаасаа санал нийлээгүй. Нийлэх ч үгүй юм билээ.

**-Аль хоёр жилийн өмнөөс гэрээг нь үзэглэхсэн Оюутолгойн ордоос эзэмших төрийн хувийг 51 болгох асуудал өнөөдөр яригдаад эхэлчихсэн байгаа шүү дээ. Энэ асуудлаар Засгийн газрыг ороож эхэлсэн?**

-Би хувьдаа улстөрчдийн тоглоом хэтэрлээ гэж дүгнэж байгаа. Тоглоом тоотой нь дээр гэдэг биш үү. Тийм л мундаг байсан юм бол төр өөрөө ордоо илрүүлээд 100 хувь асуудлаа үүрээд явахгүй юугаа хийгээд гэрээ хэлэлцээр байгуулсан юм.

*Ж.Нямсүрэн  
«Ардын эрх» 2011 он*

## **ХУВЬЦААНААС ҮҮДЭН ХАМГИЙН МУУ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ БИЙ БОЛНО ГЭДГИЙГ БАТТАЙ ХЭЛЬЕ**

**МУХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлтэй ярилцлаа**

**-Сүүлийн үед төрөөс иргэддээ хувьцаа олгоно гэх асуудлыг эрчимтэй ярьж эхэллээ. Энэ хэр зохистой зөв шийдэл вэ?**

-Иргэдэд хувьцаа тараана гэдэг оновчгүй шийдвэр. Энэ их хуваарилалт юм шиг харагдаж байгаа биз. Байгалийн баялаг ард түмний өмч. Үүнийг хэрхэхийг мэд гээд эрх мэдлийг нь УИХ-д өгсөн.

Гэтэл тэндээс бидэнд бүгдэд өгөх гэж байна. Үүнийг компанийн засаглал талаас нь авч үзвэл их буруу хэлбэр. Энэ бол цаашдаа авлига, хээл хахуулийг үүсгэх, хяналтгүй байдал үүсгэх их эвгүй хэлбэр. Ийм учраас манайхтай адил нөхцөлд байгаа, тархи толгой нь ажилладаг улсууд иймэрхүү зүйл хийдэггүй. Компанийн их муу засаглал үүсгэж, ил тод байдал үүсгэж, цөөхөн хэдэн хүний мэдэлд нийт эдийн засаг хамааралтай болох байдал үүснэ. Гаднаа шударга мэт харагдаж байгаа энэ хуваарилалт шударга биш хуваарилалт.

**-Явал шударга хуваарилалт болох юм?**

-Нийгмийн бүх бүлгүүдийн хүсэл эрмэлзэл, сонирхол, боломжид таарсан нөхцлийг төрийн зүгээс бүрдүүлж өгөхийг шударга боломж гэнэ. Бид өнөөдөр дээр хэлснээр тэгш хуваарилалт хийснээрээ шударга ёсыг үгүйсгэж байна. 140 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмэгтэйчүүд, жижиг бизнес эрхлэгчид өөр өөр зүйл хүсч байж болно. Тэр бүхэнд зориулсан эдийн засаг, улс төрийн орчинг бий болгохыг тэгш боломж олгож байгаа хэлбэр гэж ойлгож болох юм. Тэгш хуваарилалт гэдэг зүйл социализмын үед байсан. Эцэг маягийн төр социалист маягаар ард түмэнд ийм байдлаар цонхны цаанаас чихэр долоолгох үйл явц явагдаж байна гэж би байнга хэлдэг.

**-Аж ахуйн нэгжид нэрлэсэн үнээр Тавантолгойн нийт хувьцааны 10 хувийг олгох асуудал яригдсан. Үүнийг танхимийн тэргүүн хэрхэн хүлээн авч байв?**

-Манайх үүнийг дэмжиж байсан. Бид хувьцааг худалдан авч, хөрөнгө оруулалт хийе гэсэн. Монголын компаниудад гадны компаниудаас арай илүү боломж олгох асуудал байсан. Ийм асуудал ярьж байгаад зогсоочих шиг боллоо. Гэхдээ бүгдийг нь нийлүүлээд ерөнхийд нь тэгшитгэн хуваарилах асуудал яригдаж байна. Энэ асуудал хэдэн жилийн дараа хамгийн муу компанийн засаглалыг бий болгоно. Үүнийг баталгаатай хэлье. Энэ бол шударга ёсны шалгуур биш. Тэгш боломж, тэгш хуваарилалт хоёрын ялгааг бид огт олж харахгүй байна. Харин сүүлийн үед МАН зарим бичиг баримтандаа тэгш боломж олгох гэж ярьдаг болсон байна. Бүх нам ингэж ярих ёстой. Учир нь нийгэм тэр чигтээ нэг ижил цамц, өмд, гуталтай хүмүүсээс бүрддэггүй. Нэг хэмжээний хувцасыг хүн бүр өмсдөггүй шиг хүн бүр өөр өөрийн сонирхол боломжийг хүсдэг. Энэ боломжийг бүрдүүлэх ерөнхий зүйлийг тэгш боломж гэнэ.

**- Монголбанкнаас мөнгөний бодлогыг 2012 онд хатууруулна гэдгээ хэлсэн. Гэтэл он гараагүй байхад л арилжааны банкууд хүүгээ нэмэж, зээл олголтоо багасгаад эхэллээ. Ирэх оны төсөв, мөнгөний бодлогыг та хэрхэн харж байна вэ?**

-Үүнийг бид байнга шүүмжилдэг. Монгол Улсад мөнгөний бодлогыг шүүмжилдэг МҮХАҮТ гэдэг ганцхан байгууллага байдаг. Монголбанк инфляцийг онилдог. Тэд эдийн засагт хэтэрхий их мөнгө бий болж, халчихлаа гэдэг. Тиймээс мөнгийг татаж авах буюу мөнгөний бодлогыг хатууруулах гэдэг. Бидний үзэж байгаагаар эдийн засаг халаагүй байна. Зөвхөн уул уурхайн салбарт хэрэгтэй тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт нэмэгдсэн учраас гадаад худалдааны баланс ихэссэн байна. Энэ бол эдийн засаг энд тэндгүй буцлаад компани болгон мундаг болж, өнгөтэй явж байгаагийн үр дүнд үүсээд байгаа зүйл биш. Тиймээс тэдний хамгийн гол нотолгоо нь буруу болж байгаа юм. Манай дээр “Монголын бизнесийн замын зураг” гэдэг ном гарсан байгаа. Үүн дээр цагаан будаа, ноолуур, мах эдийн засагт нийлүүлэгдэхдээ хэчнээн хэмжээний зам туулж, ямар ямар зардал гардаг, хэчнээн хугацаа зарцуулдагийг гаргасан. Энэ бүх замын зургийг хялбаршуулбал, хэрэглэгчид очихдоо илүү хямдаар хүрч, ингэж л инфляцид нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, нийлүүлэлтийн талын хүчин зүйлүүд манай инфляцид хамгийн ихээр нөлөөлдөг. Сүүлийн үед Монголбанк өөрөө махны судалгаа энэ тэр хийдэг болсон. Энэ бол сурч эхлэж байгаа хэрэг. Гэхдээ болоогүй байна. Эдийн засгаа яах гэж байгааг ч мэдэхгүй байж, мөнгөний бодлогоо хатууруулна гэдэг. Нөгөө талаас мэдээж, валютын ханш нөлөөлж байгаа. Энэ талын хууль, бодлого нь байгаа. Үүний дагуу 2008, 2009 онд Монголбанк баахан интервинц хийсэн. Эдийн засгийг идэвхжүүлж байж валютын ханш тогтвортой байх ёстой. Эдийн засаг гэнэтийн шокинд орсон үед савалгаанд ордог. Жижиг, дунд бизнес гэлтгүй бүгд бужигнаж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байх хэрэгтэй. Монголбанкнаас төрийн бодлогоор дамжуулан бодит секторыг дэмжих, үйл ажиллагааг нь идэвхжүүлснээр нийт эдийн засаг идэвхжинэ. Тэр тусмаа уул уурхайн бус хэсэг нь буюу мөнгө хамгийн их дутдаг хэсэгт нь мөнгө олгох хэрэгтэй. Банкууд хоорондоо, банк бус санхүүгийн байгууллагууд хоорондоо өрсөлдөж, үйлчлүүлэгчээ хэвлэлээр дамжуулж дууддаг, гуйдаг байх нөхцлийг бий болгох хэрэгтэй. Одоо төр нь 60, 200 миллиард

төгрөгийг иргэддээ банкуудаар дамжуулан өгөөд байна. Үүнд нь гуравхан банк сонгогдож байна. Гэтэл банк бус санхүүгийн байгууллагуудын дунд уралдаант тендер маягийн зүйл зарлаж, шалгаруулалт явуулж болдоггүй юм бэ. Бидэнд жижиг дунд үйлдвэрийг дэмжих 100 тэрбум төгрөг байна. Үүний 30 тэрбумыг нь та нар дундаа өрсөлдөж, хамгийн сайн нөхцөлтэй нь дамжуул гэж өрсөлдүүлэх хэрэгтэй. Ингэвэл зээлийн нөхцөл сайжирна.

**-Одоо манай арилжааны банкууд ямар байдалтай байна вэ?**

-Төв банкныхаа үнэт цаасыг худалдаж авчихаад, төрийн мөнгөний нөөцөөр болон олон жилийн турш харилцсан итгэлтэй компаниудад зээл олгох байдлаар үйл ажиллагаа явуулж байна. Мөнгөний бодлого хатуураад ирэхээр хадгаламжаа татаж эхэлдэг. Энэ үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр банкууд хадгаламжийн таатай нөхцөл амалсан сурталчилгаа цацдаг. Хадгаламжийг захиргааны аргаар бууруулж болохгүй. Гэхдээ өрсөлдөөний аргаар бууруулж болно. Дараа жилийн болон дараа дараагийн Засгийн газрууд ийм зүйл хийх хэрэгтэй. Монголын улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт мөнгөний бодлогыг эдийн засагт чиглүүлнэ, инфляцийг ингэнэ тэгнэ гээд л дандаа хэвшмэл зүйлүүд байдаг. Одоо үүнийгээ бодитойгоор хэрэгжүүлэх цаг болсон. Өнөөдөр дурын бизнесмэнээс монголд бизнес эрхлэх таатай орчин байна уу гэхээр байхгүй гэж хариулдаг шүү дээ.

**-2012 оны төсөв, мөнгөний бодлого батлагдсан. Үүнээс үүдэн түрүүлж гарах эрсдэлийг та юу гэж харж байна вэ?**

-Энэ жилийн төсөвт бодит сектор руу жаахан мөнгө оруулахаар тусгасан. Гэхдээ энэ хангалттай биш. Өөрөөр хэлбэл, 2012 онд монголын бизнест илүү их мөнгө хэрэгтэй байна. Бүтцийг нь авч үзвэл, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчидэд илүү хэрэгтэй байна. Одоо л дөнгөж зээлийн баталгааны сангийн асуудал яригдаж байна. Өнөөдөр зээлийн баталгааны санд гурван миллиард биш, 30 миллиард байх ёстой. Ингэж байж олон хүн бизнес эрхлэх боломжтой болно. Ийм үед мөнгөний бодлогын хатууруулна гэж яриад явж байна гэдэг бизнесийн идэвхийг бууруулж, хямралыг даллан дуудах болно. Инфляци 13 хувьтай байж болно. Гэхдээ үүнийг зөөлөлдөг арга бий. Бизнес нь маш идэвхтэй явагдаж, барааны эргэлт ихэсч, гаднаас ирэх замын зургийг багасгавал ард түмэнд хэрэгтэй арван төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнэнд нөлөөлж байгаа зүйлийг үгүй хийвэл инфляци хөөрөгдөх нь

гайгүй. Өөрөөр хэлбэл, инфляцийг удирдаж болох төвшинд барьж болох боломжтой. Үүнийг би заавал нэг оронтой тоо гэж хэлээгүй. Инфляцийг нийгэм, эдийн засгийн байдлыг хүндрүүлэхгүй, тогтворгүй болгохгүй менежмент хийж болох төвшинд барьж болох мөнгөний бодлог байх хэрэгтэй. Мөнгөний бодлогын хамгийн гол зорилт нь эдийн засгийн өсөлтийн тэр дундаа хүмүүсийн оролцоотой, уул уурхайн хөөсний өсөлтийн биш хэлбэрийг бий болгох ёстой. Үүнийг энэ мөнгөний бодлогоор бий болгож чадахгүй. Төсвийн бодлого жаахан тэлсэн, төсвийн бодлого нь татсан энэ бодлого явахгүй. Энэ жил хэтэрхий үрэлгэн хөрөнгө оруулалтын төслүүдээ зогсоож, шууд хүмүүс дээр очих хөрөнгө оруулалтуудыг хийх хэрэгтэй. Монголбанк өөрөө хүмүүсийн оролцоотой, тэдэнд хүртээмжтэй өсөлтийг хангах чиглэлийн эсрэг үйл ажиллагаа явуулж байна. Тэд эдийн засаг хэт халчихлаа. Тиймээс одоо хөргөнө гэдэг.

**-Энэ тохиолдолд арилжааны банкууд яах ёстой юм бэ?**

-Арилжааны банкууд үг дуугүй боол биш. Тэд олон жил харилцаж тогтсон харилцагчдынхаа бааз, суурийг алдахыг хүсэхгүй байгаа. Тиймээс тэдэнтэй харьцах даа тусгайлсан байдлаар зээлийн хүүгээ багасгах байдлаар явж байна. Нэг хэсэг байгууллага нь гадны компаниудтай харьцаж байна. Удахгүй ирэх хоёрдугаар сараас Японы хоёр шаттай зээлээр 60 миллиард төгрөг орж ирнэ. Мөн одоогийн 30-40 миллиард, дээрээс нь ноос ноолуурын 100 орчим төгрөгийн бонд орж ирнэ. Энэ бүхэн нийлээд эдийн засагт нөлөөлнө. Гэхдээ эдийн засгийн ихэнхийг бүрдүүлж байгаа бичил, жижиг бизнест нөлөөлөхгүй. Тиймээс энэ үйл явцад бичил санхүүгийг байгууллагуудыг татаж оруулбал, тэд илүү түргэн хурдан шуурхай ажил болгоно. Мөн хэсгийг дэмжихийн тулд Хөгжлийн банк томоохон төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхийн зэрэгцээ бизнесийг дэмжих зээл гаргах хэрэгтэй.

**-Засгийн газраас УИХ-д Төсвийн төслийг анх өргөн барих үед нүүрсэн дээр таван хувийн экспортын татвар тавих санал тусгасан байсан. Энэ саналыг танай харъяа аж ахуйн нэгжүүд татуулсан гэсэн. Манай улс нүүрсээ хэдий болтол татваргүй гаргах юм бэ?**

-Энэ татварын асуудлыг манайх эсэргүүцсэн. Бид өртөг нэмэх процессыг хийж байна. Энэ талаас нь илүү санаачлагыг нь төрүүлэхийн оронд шууд орлого талаас нь төлөвлөж, мөнгө авах гээд байна. Гэтэл энэ өртөг нэмэх процессууд, татварын хөнгөлөлт

үзүүлэх зэргээр нөгөө талаас нь урамшуулбал, илүү үр дүнтэй. Өнөөдрийн нөхцөлд манай улсын экспортын хэмжээ, нэр төрөл хэтэрхий бага байна. Экспортын стратегитай үүнийг зэрэгцүүлж авч үзэх ёстой. Өөрөөр хэлбэл, мах, ноос ноолуур зэрэг хэдхэн төрлийн бүтээгдэхүүнийг бид гадагш гаргаж байгаа. Экспорт маань хүв хүрэн өнгөтэй боллоо. Энэ тохиолдолд экспортын солонгорсон олон өнгийг бий болгох ёстой. Тэр стратегийг батлаж байгаад энэ хүрээнд асуудлаа цогц хэлбэрээр нь ярих хэрэгтэй. Түүнээс ганц нэгээр нь ингэж сугалж, ярих нь эцсийн үр дүнг нь алдагдуулж байна.

*Shuud.mn, 2012 он*

## **СЭТГЭЛГЭЭ, ХӨГЖЛИЙН ЗАГВАРАА ӨӨРЧЛӨХ АСУУДЛЫГ УЛС ТӨРИЙН НАМУУД ЭХЛЭХ ЁСТОЙ**

*Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дарга С.Дэмбэрэлтэй ярилцлаа.*

**-Та өчигдөр твиттертээ Хятадын арилжааны банкууд зээлээ хааж эхэлж байгаа талаар бичсэн байна билээ. Мөн энэ нь манай улсад алсдаа сөрөг үр дагавар авчирч мэдэхийг хэлээд байсан?**

-Ш.Үнэнтөгс гэдэг залуу банкууд зээлээ хааж байгааг бичсэн. Би яг тэгж бичээгүй л дээ.

**-Тэгвэл та тэр асуудалд нэлээд анхаарлаа хандуулж байсан шүү дээ?**

-Ер нь бол ирэх жилийн Монголын эдийн засгийн байдлын талаар ярьсан л даа. Мөнгөний бодлого хатуурсан байгаа энэ нөхцөлд бодит сектор буюу бизнесийнхэн цаашаа яаж явах юм бэ, төсөв гэхэд л сонгуулийн жилд зориулагдаж тэлэлтэйгээр батлагдлаа. Гэхдээ тэлэлт гэдэг бол зөвхөн хэрэглээг тэлэх тухай юм гэж бодож болохгүй. Үйлдвэрлэлийг тэлэх асуудлыг яримаар байгаа юм. Өөрөөр хэлбэл бизнесийн идэвхжлийг хангах тодорхой санхүүжилт орж ирж байна уу гэдгийг ярьсан. Өнөөдөр төсөв, мөнгөний бодлого хоёр уялдаж чадаж байна уу. Чадахгүй байна. Одоо инфляцийн талаар нэлээд ярих боллоо. Инфляцийн өсөлтөд мөнгө их байгаа нь нөлөөлж байна уу эсвэл үйлдвэрлэж

байгаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ тэр дундаа ард түмэнд хэрэгтэй 10 төрлийн хүнсний зүйлийн замын зургийг нь хийгээд үзэхэд нийлүүлэлтийн А цэгээс Я цэг хүртэлх энэ замд ямар садаа учирч байна гэдгийг гаргасан.

**-Энэ нь юу гэсэн үг билээ?**

-Энэ нь инфляцид илүү нөлөөлж байна гэсэн дүгнэлтийг манай танхим гаргаад байна. Бизнесийн замын зураг гэсэн судалгаа хийлээ. Энэ судалгаа байхад хүн жишээ нь цагаан будаа, элсэн чихэр импортоор оруулж ирэхээс авхуулаад, хил, мэргэжлийн хяналт, лабораторийн дээжийн түвшин гээд дамжлагуудыг дамжаар эцсийн хэрэглээнд очиход үнэ дээр нь зардал хэр нөлөөлж байна, хүнд суртал яаж нөлөөлж байна гээд энэ бүхнийг гаргана. Ингэснээр Монголын инфляци нийлүүлэлтийн талын хүчин зүйлүүдээс ихээхэн хамаарч байна. Тэр дундаа хүнд суртлын инфляциас нэлээд хамаарч байна гэдгийг гаргах юм. Түүнээс биш учир зүггүй цалин нэмэхэд инфляци тэнгэрт цойлчихно гэж бодохгүй байгаа.

**-Цалин нэмэх тал дээр та ингэхэд ямар байр суурьтай байна?**

-Багш нарын цалинг нэмэх хэрэгтэй. Тэтгэврийн хөгшдөд мөнгийг нь өгөх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мөнгө өгөх хэрэгтэй гэж бодож байна. Харин халамжийн хавтгайруулсан байдлыг зогсоох шаардлагатай гэж бодож байна. Өөрөөр хэлбэл нийтэд нь 21 мянган төгрөг тарааж өгснөөр болохгүй нь ээ гэдгийг манайхан хэлээд байгаа. Дээр нь бас нийтэд нь хувьцаа эзэмшүүлнэ гэдэг компанийн засаглал талаасаа буруу. Бүр загвар талаасаа ч зүйтэй биш. Хүнд нөлөөлж байгаа сэтгэлзүйн эффект талаасаа залхуурал, бэлэнчлэх сэтгэлгээнд сургаад байна шүү дээ. Хүн хөдөлмөрлөж байж л хөрөнгө оруулалт хийдэг. Түүнээс биш газрын доорхи баялаг бол ард түмний өмч. Тийм учраас бүгдэд нь хувьцаа эзэмшүүлье гэж байгаа нь үнэндээ явуургүй. Тэгш боломж гэдгийг шударга ёсны хамгийн гол шалгуур гэж би үзэж байна. Тэгш боломж бол бүгдэд нь тэгш хуваарилах хэрэгтэй гэсэн үг биш. Нийгэм гэдэг маш олон сонирхолтой, чадвартай, хүсэл эрмэлзэлтэй нийгмийн амьтдын бөөгнөрөл. Жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрөө хөгжих сонирхолтой байна. Багш, эмч, бичил бизнес эрхлэгчид өөрийн сонирхолтой. Энэ бүхэнд нь таарсан боломжийг нь олгооч л гэж хэлмээр байна. Түүнээс биш бүгдэд нь өгмөөргүй байна. Бүх хүнд 21 мянган төгрөг өгөх нь шударга ёс биш. Энэ бол социализмын шударга ёс. Хувьцаа өгч байгаа нь ч ялгаагүй. Харин хувьцаа эзэмших эсэх нь сайн

дурын асуудал байж яагаад болохгүй гэж. Жишээ нь бичил бизнес эрхлэгчдэд юу хэрэгтэй вэ. Мөнгө хэрэгтэй. Гэхдээ зээлийн хүү нь бага, эргүүлж төлөх хугацаа нь урт тийм бизнесийн орчин хэрэгтэй байгаа. Бичил, томгүй бүгдэд нь бизнэсээ чөлөөтэй эрхлэх эдийн засгийн эрх чөлөөг нь олгох ёстой. Ийм мэтээр л эдийн засгийн ойлголтын зөрүү байна. Танхим гэхэд л зах зээлийн эдийн засгийн хэлээр ярьж байхад төр халамжит төрийн буюу эцгийн байдлаар хандаад байна.

**- Ингэж харж байгаа нь асуудал гэж үү?**

-Чамайг болон намайг зүгээр л биологийн амьтан гэж үзээд байна шүү дээ. Гэтэл бид хоёр хоёулаа нийгмийн амьтан байхгүй юу. Өөр өөрийн хүсэл эрмэлзэлтэй. Өөр өөрийг хөгжүүлэх, амьдралаа авч явах, өөрийн бодолтой хүмүүс. Ийм хүмүүст зориулж бодол хүслээ амжилттай биелүүлэхэд нь туслан эрхзүй, санхүүгийн хувьд бүрдүүлж өгмөөр байна. Үүнийг л би тэгш боломж гэж хэлнэ. Нөгөө талаас ерөөсөө Монгол Улсын хөгжих гээд байгаа зам зөв үү. Өөрөөр хэлбэл бүх төрлийн нөөц буюу газрын доорхи болон дээрх баялгаа дээд хэмжээгээр, маш эрчимтэйгээр, эргэж нөхөгдөх хугацааг нь үл харгалзан ийм хүрэн эдийн засгийн байдлаар яваад байна. Өнөөх орлогоо ногоон эдийн засаг руугаа хийе гэсэн концепци явах юм уу. Эсвэл уул уурхайгаа зохистой ашиглаж хажуугаар нь бусад салбараа анхаарах уу. Мал аж ахуй, жижиг дунд бизнесээ анхааръя. Мэдээж ингэж анхаарахад мөнгө хэрэгтэй. Ингэхдээ нэгийг хохироож мөнгө олно гэсэн үг биш. Нөгөө талдаа урам өгөх ёстой. Механизмыг нь уул уурхайн бус секторуудад боломж болгон гаргах хэрэгтэй. Ингэж байж л нийт эдийн засаг маань тогтвортой, хүмүүст мэдрэгдэхээр болно. Хэрвээ ийм бодлого явахгүй бол өнөөдөр Монголын эдийн засгийг ямар ч үнээр хамаагүй өндөр өсөлтөд хүргэх, нэг хүн оногдох ДНБ-ээрээ бахархах, хүн амын 50 хувь нь ДНБ-ий өсөлтийг мэдрэхгүй явах замдаа орно. Харамсалтай биз дээ.

**Тэгвэл яах ёстой вэ?**

-Хүн эдийн засгийн 17, 20 хувийн өсөлтийг мэдрэхийн тулд үүнд оролцох ёстой. Тиймээс л түрүүний миний хэлдэг тэгш боломж, оролцоог нь хангах хэрэгтэй байгаа юм. Бичил бизнес эрхлэгч бизнесээ жижиг дунд бизнес болгох бодолтойгоор цааш явах хэрэгтэй байна. Улмаар жижиг дунд бизнесээ том болгох боломж хэрэгтэй. Ингээд бизнесийн талбарт ажиллаж байгаа нь бүтээмжээ дээшлүүлэхэд анхаарч, юм хүлээхээ больж эхэлнэ. Зүгээр л нийгмийн ядуу хэсэг нь зүгээр суугаад зуух авдаггүй, мөнгө авдаггүй, архи уудаггүй байх, өөрийнхөөрөө хөдлөх

эрмэлзлийг нь төрийн бодлогоор суулгаж өгөх ёстой. “Та хэрвээ 21 мянган төгрөг авах гэж байгаа бол хашаандаа мод тарь” гэж болно биз дээ.

**- Ойрын хоёр жилийн эдийн засгийн өсөлтөд баясаж, дэвээд яваа нь улс төрийн халамж буюу эдийн засгаа халааж, ёстой өнөөх хөөс гэдэг нь болоод байгаа гэдэг биз дээ. Ийм үед юу хийх ёстой юм бол?**

-Гэхдээ үүний цаана бид ямар төртэй байна вэ гэдгээ харах ёстой. Бид халамжит эцгийн төртэй яваад байна. Чиний эсвэл миний өмнөөс чи бид хоёрын сайхан амьдрах эрхийг төр гаргаад байна шүү дээ. Энэ зөв юм уу. Гэтэл чи сэтгүүлчээ хийгээд, энэ камераараа улам сайн зураг аваад явах, түүнийгээ өөрийн карьер болгох бүрэн боломж байна. Тиймээс л дээр хэлснээр чиний энэ сурах, тэмүүлэх эрмэлзлийг чинь дэмжих орчинг шаардаад байгаа хэрэг. Олон залуу бий. Тэр залуу зураг дарахыг хүсээд дуртай газраа очоод фото камер авахад л лизинг гэдэг орчин бүрдсэн байх ёстой. Ингээд чи дуртай ажлаараа бизнес хийгээд явдаг орчин хэрэгтэй биз. Эсвэл чи энэ ажлаа бизнес болгож өргөжүүлээд компани байгуулж банк, санхүүгийн байгууллагад очиход чамайг инээмсэглэж угтдаг тийм орчин чухал биш гэж үү. Тиймээс та Тавантолгойн хувьцаагаа хүлээж бай гэдэг орчин хэрэгтэй байна. Бидний сонголтын асуудал болчихлоо. Ийм орчныг бидэнд бий болгож өгөх ёстой.

**- Ирэх жилийн сонгуулийн дараа иргэдэд хандсан их амлалтууд алга болно гэж байгаа. Ингэхээр таны хэлээд байгаа шиг тийм бүтээлч орчинг бий болгох боломж бүрдэж эхлэх болов уу. Та хэр хүлээлттэй байна?**

-Энэ сонгуулийн хувьд би хэлж мэдэхгүй байна. Зүгээр л бид сайн төрийг л хүсдэг. Харин ямар төрийг хүсдэггүй вэ гэхээр хүнд сурталтай, гол нь миний зөвшөөрөлгүйгээр дансанд минь мөнгө хийдэг төрийг хүсдэггүй. Зүгээр сууж байхад мөнгө өгөөд байгаа нь амар юм шиг мөртлөө миний өөрийн хөгжих боломжийг, эрмэлзлийг сэтгэлзүйн хувьд унагааж байна. Үүнд дургүйцдэг хүмүүс иргэдийн 50 хувийг эзэлж байгаа. Тэгвэл үлдсэн 50 хувь буюу мөнгийг дуртайяа аваад байгаа хүмүүсийг бид ойлгоно. Гэхдээ тэр хүмүүст хүртэл үр хүүхэдтэй учраас мөнгийг тэгж тэжээлгэх сэтгэлгээгээр авч, түүндээ дасаж амьдрах ёсгүй гэсэн бодол төрнө. Улстөрчид одоо бэлэн болон бэлэн бус амлалтаас татгалзчихлаа. Тодорхой хэлбэл, цалингуурав дахин өсгөнө гэж хэлэхгүй. Энэ зөв. Цалин бол бүтээмжтэйгээ уялдах ёстой гэдгийг бид мэднэ. Төр харин ажил олгогчийнхоо хувьд төрийнхөө

менежментийг хийгээд явах хэрэгтэй. Үр дүн, гүйцэтгэл чанараар нь ажлыг үнэлдэг, хүнд сурталгүйгээр нь хэмждэг цалингийн системийг төсөв захиран зарцуулагчид нь өгөх ёстой. Түүнээс биш Засгийн газар нь 3-3.5 дахин гэх мэтээр ярьдагаа болих хэрэгтэй. Ийм социализмын сэтгэхүйн үлдэгдлээсээ салах болсон. Сэтгэлгээ, хөгжлийн загвараа өөрчлөх асуудлыг улс төрийн намууд эхлэх ёстой гэж би боддог. Монгол Улсад бодит байдал дээр нам нь төрийнхээ дээр гарчихсан явж байна шүү дээ. Тиймээс орон нутгийн түвшинд л гэхэд намаа больё гэх байр сууриуд гарч байна. Хүмүүс ойлгоод “Энэ нам гэдэг чинь дэмий юм” гэх боллоо. Ерөөсөө орон нутгийн түвшний сонгууль байлаа гэхэд намаас нэр дэвшүүлэхээ больё гэж байна. Энэ бол хамгийн зөв. Хотынхоо даргыг иргэд өөрсдөө сонгодог больё гэж байна. Иймэрхүү олон асуудлыг өөрчлөх шаардлага гарч байна л даа. Мэдээж дараагийн сонгуулиас эхэлнэ. Яг 2012 оны сонгуулиас иймэрхүү суурь өөрчлөлтийг, сэтгэлгээний бодлогын шинэчлэлийг намууд нь мөрийн хөтөлбөртөө тусгаад, сонгогчид нь энэ чиглэлээр мөнгөний биш үзэл бодлын сонголтыг хийж чадвал болно. Дараа дараагийн жилдээ бүр ч зүгширнэ. Харин үүнийг хэвшүүлж эхлэхгүй бол 2016 оны сонгууль болоход асуудал бүр хурцдана.

## **МОНГОЛЧУУД ӨӨРИЙНХӨӨ ГАРААР ӨӨРСДИЙГӨӨ ХОРЛОЖ БАЙНА**

**МУХАҮТ-ЫН ДАРГА С.ДЭМБЭРЭЛТЭЙ ЦАГ ҮЕИЙН АСУУДЛААР  
ЯРИЛЦЛАА.**

**- Өнгөрсөн долоо хоногт Монголбанкнаас бодлогын хүүгээ өсгөлөө. Үүнийгээ тэд цаг үед тохируулж авсан арга хэмжээ гэж тайлбарласан. Таны байр суурь тэднээс эсрэг байгаа юм байна. Энэ талаар?**

- Үүнийг би монголчууд өөрийнхөө гараар өөрсдийгөө хорлож байгаа хэрэг гэж үзэж байгаа. Дээрээс нь энэ бол манай өнөөгийн бодит амьдралд зохицоогүй арга хэмжээ. Гэхдээ би, минийх буруу, засгийн хийж байгаа зүйл нь зөв байгаасай гэж хүссэн. Гэтэл бодит амьдрал дээр миний хэлсэн зүйл зөв болох нь өдөр тутмын амьдралд батлагдаад байна. Бодлогын хүү гэдэг зүйлийг би өмнө нь ч бас шүүмжилж байсан. Монголын нөхцөлд бодлогын хүүг ингэж барина гэж байхгүй. Ийм нөхцөлд зардлаа л танах хэрэгтэй.

**- Сая чамлахааргүй хэмжээнд зардлаа таналаа шүү дээ?**

- Танасан. Ер нь мөнгө гэдэг бол эргэлтэд орж байж үнэ цэнэ нь хадгалагдаж үлдэнэ. Эргэлтэд орохгүй бол үнэ цэнэ хадгалагдахгүй. Тэгэхээр банк гэдэг сектороос мөнгө тасраад гарахгүй нь л дээ. Өөрөөр хэлбэл банк бизнесийн секторын хооронд арилжаа наймаа шилжүүлэг явагдахгүй гэсэн үг. Банкууд зөвхөн төв банкны үнэт цаасыг аваад л сууж байна. Амар ч юм шиг. Энэ бол дунд хугацаан дахь хамгийн аюултай зүйл. Тэгэхээр дунд хугацаанд Монголын эдийн засгийн инфляци нь ч гэсэн багасаад валютын ханш нь тогтворжино гэж тооцоолсон бол үүн шиг том алдаа байхгүй. Урьд өмнө нь ингэж ирсэнгүй шүү дээ. Инфляци хамаагүй бага байхад л явуулсаар байгаад 30 гаргасан. Тэр үед ч бодлогын хүү өсгөсөөр, валютын ханшийг тогтоон барих оролдлого хийж тодорхой хэмжээгээр барьж байсан. Гэхдээ одоо түүнийг тогтоон барих нөөц нь байхгүй болсон. Үүнийг юу гэж хэлж байна гэхээр манайхтай адилхан Австрали, Орос, Чили мэтийн түүхий эдийн экспортоос хамааралтай улс орнууд ийм үед валютын ханшаа сул тавьсан. Өөрөөр хэлбэл тодорхойлоод байгаа валютын ханшийн уян хатан чанарыг хангах гэдгийг л олон улсын валютын сангийнхан хэлээд байна шүү дээ. Энэ маань сул хаячих л гэсэн үг. Сул хаялаа гээд өчигдрийн байдлаар 1760 байна. Өөрөөр хэлбэл психологийн төвшин гэж байгаа. Жишээлбэл 1600, 1700 хүрэх болов уу гэсэн төвшин маань маш хурдан эвдэгдэж байна.

**- Тэгэхээр ийм тогтворгүйжилтээс болж нэлээд олон сөрөг үр дагавар гарах нь тодорхой. Үүнийг тогтоон барих арга байгаа болов уу?**

- Валют нь албан бусаар оролцогч жижиг аж ахуйн нэгж бүх иргэдэд л хэрэгцээтэй байна. Яагаад гэвэл манай эдийн засаг Хятадаас, импортоос хамааралтай. Хүмүүс идэх, уух, хувцаслах, байшин барих ёстой. Одоо бизнесийн улирал эхэлж байна. Идэвхгүй мөнгөгүй улирал эхэлж байна шүү дээ. Энэ мэт нь улам цаашдаа юмны үнийг өсгөнө, өсгөөд ч байгаа. Ийм үед хүмүүс нөөцөлж эхэлдэг. Угаалгын нунтгийг нэгээр авдаг байсан бол 10-ыг авна. Энэ мэт хүмүүсийн авир төрх өөрчлөгдөж эхэлнэ. Энэ нь улам бүр инфляцийг хөөрөгдөөд буруу хүлээлт бий болгодог. Тэгэхээр энэ бүх амьдралын зүйлүүдийг хардаг нэг нүд байна. Энэ бол бизнес эрхлэгч бидний нүд. Нөгөө нүд маань гадаад орнууд. Тийм учраас мөнгөний хатуу бодлого явуулъя гэсэн Монголбанкны нэг нүд байна. Энэ хоёр нүдний аль нь бодитой байхыг цаг хугацаа харуулах байх гэж бодож байна.

**- Засгийн газраас хямралаас гарах төлөвлөгөөг батлан гаргалаа. Төлөвлөгөөнд үйлдвэржилтэд чамгүй хөрөнгө оруулж өгсөн байсан. Энэ хэр үндэслэлтэй төлөвлөгөө байх бол?**

- Мэдэхгүй байна. Тэр бол их хэцүү.. Жишээлбэл, банкаар дамжуулна гэвэл банкны зээлийн хүү өндөр болсон. Банкны зээлийн хүүгийн зөрөөг нөхсөн ч гэсэн их хэцүү л болно. Дээрээс нь өртөгтэй болж эхэлнэ. Одоо найдах зүйл бол гадаадын зээл тусламж. Хувийн хэвшилд зориулсан Японы хоёр шаттай, Европын сэргээн босголт хөгжлийн банкны гэх мэт зээлд найдах л үлдсэн. Гэхдээ энэ бол бизнесийн цөөхөн хэсгийг хамарч чадна. Ингэхээр бизнесийн нөхцөл маань улам хэцүү болж өртөг нэмэгдэнэ. Хүмүүс мэдээж төрөл бүрийн хэмнэлт хийнэ. Хувийн хэвшлийнхэн чинь уян хатан дасан зохицох чадвар сайтай. Энэ чадвар нь мэдээж ажиллана. Гэхдээ эдийн засгийн өсөлт цаашид гурван хувь хүрэх үү, үгүй юу. Тэгээд уул уурхайн салбараа яриад байдаг. Тэнд чинь цөөхөн хүн ажилладаг. Гэтэл олонх хүнийг ажиллуулдаг бусад секторууд хэцүү байна. Ингээд харахаар ажилгүйдэл ядуурал нэмэгдэх гэх мэтийн бараан юмнууд харагдаад байна. Үүн дотор жаахан гэрэл өгөх зүйл нь бол бизнесийн идэвхжлийг нэмэгдүүлэх бодит секторыг дэмжих л асуудал байсан.

**- Танай танхимаас хямралын эсрэг төлөвлөгөө боловсруулсан ч энэ төдийлөн ямар нэг зүйлд нөлөөлөл үзүүлсэнгүй. Энэ талаар?**

- Тэрийг ч онцгой юм хийгээгүй. Иргэдийн бодож байгаа зүйлийг эдийн засгийн онол, номтой нь тохируулж байгаад бидний үзэж байгаагаар бодлого ийм байх ёстой гэж зээл хийсэн. Явуулж байгаа бодлогуудын эсрэг л юм хийсэн. Жишээлбэл, валютын ханшийг чөлөөтэй хаяж болохгүй Монголын эдийн засаг даахгүй. Түүний дотор жижиг дунд бизнес эрхлэгчид албан бус секторынхон даахгүй, ингэснээрээ инфляцийг улам хөөрөгдөнө. Ийм учраас валютын ханшийг тодорхой хугацаанд зургаан сарын хугацаанд тогтоон барих өөр арга хэрэгслийг хэрэглэе. Тухайлбал долларын хадгаламжийн дээд хүүг тогтооё. Үүнтэйгээ уялдуулаад долларын зээлийн хүүг зохицуулдаг болъё. Дээрээс нь гаднаас авдаг зээлийн гадагшаа гаргаж байгаа болон оруулж ирсэн шилжүүлэг дээрээ ялгаатай хүүг тогтооё. Долларыг 1300 байхад валютын арилжаанд оролцогчдын хүрээг нэмэгдүүлэе, валютын ханшаа нэгжид уяхаа больё олон улсын нэгжид “сагс” гэсэнд уяа гэх мэт зүйлүүдийг хийе гэсэн санааг л хэлж байсан. Энэ бүхнийг уншсан л байх. Монголбанкныхан бол зөвшөөрөхгүй,

Сангийн яамныхан үүнд хамаагүй учраас орхиж байна. Үүнийг эрх баригчид уншаад тодорхой хэмжээнд хэлэлцүүлэг хийх байсан. Валютын зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулахаасаа өмнө заавал хууль өөрчилнө гэлгүйгээр эрдэмтэн мэргэд, бизнес эрхлэгчид Монголбанкны мөнгөний болон сангийн бодлогынхон сууж байгаад хэлэлцүүлсэн бол энэ нь бас нэг хувилбар байсан. Гэхдээ өнгөрсөн. Байдал хэцүү л байна.

*П.Нансалмаа*

*Монголын мэдээ сонин, 2009 он, №53/2626*

## УЛС ТӨРИЙН СОНГОЛТ ХИЙХ ЦАГ НЬ БОЛСОН

**МУХАУТанхимын дарга С.Дэмбэрэлтэй уулзаж ярилцлаа**

**- Монголын бизнес эрхлэгчдийн хамгийн том, хүчирхэг нэгдлийг толгойлж байгаа хүний хувьд танаас манай улсад бизнес эрхлэх таатай нөхцөл бүрдэж чадсан уу гэж асуумаар байна. Засгийн газар бизнесийн орчинг шинэтгэхэд өнгөрсөн жилээс нэлээд анхаарах болсон шүү дээ?**

- Төр хувийн хэвшлийн түншлэл, бизнесийн орчны шинэчлэлийн талаар МУХАУТанхимаас олон жил ярьсан даа. Төр, хувийн хэвшлэл түншилж, хамтрахгүйгээр, бизнес эрхлэгчдэдээ боломж олгож, дэмжиж туслахгүйгээр хол явахгүй гэдгийг олон ч жил үглэсэн. Тухайн цаг үед танхимын санаачлагыг ямар ч дарга, сайд нь сонсоогүй байхгүй юу. 2005 оноос эхлээд ярьсаар байгаад 2010 онд ашгүй нэг Ерөнхий сайд нь бизнес эрхэлж байсан хүн таараад нэг юм дэмжигдсэн. Тэр ажил өнөөдрийн байдлаар 30, 40 хувьтай л явна. Түүнээс биш бизнес эрхлэх таатай боломжийг бүрдүүлчихлээ, бизнесийн орчинг шинэчиллээ гэж хэлж чадахгүй. Урьд өмнө нь хүмүүс төрийн сайд, дарга болонгуутаа хамраа сөхөөд, нүднийхээ шилэн дээгүүр хараад эхэлдэг байсан бол одоо төрд зүтгэх нь иргэдэд үйлчлэх гэж, зарцлагдах гэсэн утгатайг бага сага ойлгодог болсон байна лээ. Монголд бизнес эрхлэх таатай нөхцөл бүрэлдэж чадсан гэж итгэлтэйгээр хэлж чадахгүй. Сая л гэхэд тэмдэгтийн хураамжийг яв. Баахан өөрчлөлт оруулж бөөн бантан хутгасныхаа дараа эргээд засаад л сууж байна шүү дээ. Энэ талаар бизнес эрхлэгчдийнхээ үгийг сонсоод, ядаж л ийм

хууль гарлаа та нар юу гэж бодож байна гээд танхимаас асуучихаж болно шүү дээ. Ямар ч судалгаа, нотолгоогүйгээр амьдралаас тасархай хууль гаргадгийн нэг илрэл энэ. Гэхдээ бизнесийн орчинг шинэтгэхэд Засгийн газраас анхаарч байна, ажил болгохын төлөө зүтгэж байна гэдэг сайн тал. Үүнийг түргэн хугацаанд хэрэгжүүлэх хэрэгтэй. Ирэх он гэхэд Монголын бизнесийн орчинд шинэчлэл гарсан байх ёстой юм. Засгийн газраас 2011, 2012 онд их юм хийж байж л сонгуулийн жил бизнес эрхлэгчдээс онц үнэлгээ авна шүү гэдгийг сануулчихъя.

**- Засгийн газраас гаргаж буй шийдвэрүүдээс харахад бизнес эрхлэгчдийг дэмжих талаар нэлээд анхаарах болсон шиг. Бизнес эрхлэгчид юм л бол Засгийн газраас мөнгө гүйдаг болсон байна?**

- Монголын банк санхүү салбар олигтойхон хөгжөөгүй байгаа учраас Засгийн газар Японоос нэг гуйгаад, өөрсдөө ч нэг хэсгийг нь ар өврөө нөхөж, аргалж гаргахаас өөр аргагүй байдалд орчихоод байгаа юм. Хэвийн банкны системтэй улс оронд бол компаниуд Засгийн газраа царайчлах ямар ч шаардлагагүй. Монгол Улсын зээлийн орчин нөхцөл өнөөдөр хүлээн зөвшөөрөх боломжгүй. Компаниудын үйл ажиллагааг өргөжүүлэх аргагүй давжаа алим шиг жижигхэн байдалтай бариад байдаг. Тэгээд төөрөгдөл нь үнийн өсөлтийг төрөөс зохицуулчихаж болно гэсэн ийм худлаа мөнгөний тогтолцоогоо л өөрчлөх хэрэгтэй байна. Олон жил бодит секторыг хорлож байгаа мөнгөний бодлогоо л өөрчлөх цаг нь болсон. Төр шаардлагатай, хэрэгтэй үед эдийн засагт интервенц хийх үүрэгтэй. Гэхдээ нийгэмд аль болохоор хор уршиг болохгүйгээр шүү дээ.

**- Таны хэлснээр бол Монголбанкнаас баримталж байгаа мөнгөний бодлого бизнес эрхлэгчдийг боомлоод байгаа юм аа даа, янз нь?**

- Монголбанкинд ч шууд бурууг тохох хаашаа юм. УИХ-д үүнийг өөрчлөх эрх нь байдаг. Тэгэхээр Монголбанкнаас оруулж ирсэн зузаан, зузаан хавтаст материалтай УИХ-ын гишүүд сайн танилцах ёстой. Монгол Улсад бизнес эрхлэгчид юу хүсч байна. Тэднийг өргөжиж боломж нь юу байх вэ гэдгийг нь судлах хэрэгтэй. Түүнээс инфляцийг тэдэн хувьд барь гээд Монголбанкинд боломжгүй үүрэг өгчихдөг. Нөгөөдүүл нь боломжгүй юманд үнэмшээд бодлогын хүүгээ нэг өсгөөд, нэг бууруулаад байдаг. Бодлогын хүүг зүгээр сул тавьчих хэрэгтэй шүү дээ. Энэ талаар зарим гишүүд нь ярих гэхээр чи хувьдаа компанитай, олигархи, сонирхлын зөрчилтэй нөхөр гэж хардаж эхэлдэг. Тэгэхээр нөгөөдүүл нь буруу гэдгийг нь мэдсээр байж сонирхлын зөрчилгүй нөхөр болох гээд

дуугүй суухаас өөрцгүй. Би хэрвээ УИХ-ын гишүүн бол чөлөөтэй ярина. Нийт бизнес эрхлэгчдээ төлөөлж байгаа болохоор надад сонирхлын зөрчил нэрээр амаа үдүүлэх шаардлагагүй.

**- Монгол Улсын Засгийн газраас нэлээд хэдэн томоохон бүтээн байгуулалтын ажил хийхээр төлөвлөөд байгаа. Түүний нэг нь Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор. Энэ цогцолборыг байгуулснаар Монгол Улсад хөгжлийн шинэ боломж нээгдэнэ хэмээн албаны хүмүүс ярьдаг. Та энэ талаар ямар бодолтой байна?**

- Сайншандын цогцолборт би итгэдэггүй. Монгол Улс том, том бүтээн байгуулалт хийнэ гэж их гоё юм мөрөөдөцгөөж байна л даа. Сайншандын цогцолборыг цэвэр эдийн засгийн талаас харж чадсан уу, улс төр, бүлгийн сонирхол орсон уу гэдэг бас эргэлзээтэй. Монголчууд их сонин хүмүүс л дээ. Тийм ч шав тавилаа, тууз хайчиллаа гээд л рекламдаад байдаг. Шав тавьж, тууз хайчиллаа гээд улс орон хөгжихдөг юм биш. Тууз хайчилснаараа бол Монголд өнөөдөр үсрэнгүй хөгжилтэй орны тоонд орчихсон цохиж яваа байлгүй. Сайншандаас өмнө эхлээд Замын Үүдээ хөгжүүлчих. Замын Үүдийг хөгжүүлэх нь Сайншандаас илүү Монголын ард түмэнд эдийн засгийн онцгой ач холбогдолтой. Энэ сувгаар дамжиж бараа бүтээгдэхүүн Монголд орж ирж байна. Энэ боомтоор бараа бүтээгдэхүүн яаж орж ирснээрээ Монголын зах зээл, худалдан авалтад нөлөөлж байна шүү дээ. Тэгэхээр эхний ээлжинд Замын Үүдээр орж ирэх бараа бүтээгдэхүүний саатал үүсгэхгүй нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Үүнийг маш хурдан хугацаанд шийдвэрлэх шаардлагатай. Замын Үүдийн байгаль экологи, эрчим хүч, дэд бүтэц, усан хангамжийг яаралтай шийдвэрлэмээр байна. Хажууханд нь байгаа Эрээн хот яаж хөгжиж байгаа хар л даа. Хятадуудаас суралцах хэрэгтэй шүү дээ. Асуу, зөвлө, юундаа ичсэн юм. Улс орноо хөгжүүлэх гэсэн хүн байгаа биз. Том, том бүтээн байгуулалт гэж томрохоосоо илүү хүмүүсийн оролцоотой, тогтвортой эдийн засгийг хөгжүүлэх цаг болсон байна. Эхлээд Замын-Үүдээ хэнд ч гологдохгүйгээр янзалчих. Энд ч чөлөөт бүс, тэнд ч аж үйлдвэрийн парк барина гэж үсчиж гүйгээд амжилт олохгүй ээ, дарга нараа. Замын Үүдийг сум, аймгийн хэмжээнд ч авч үзэж болохгүй. Монголын эдийн засгийн стратегийн чухал төв шүү дээ. Хөгжлийн гарц гэдэг утгаараа эдийн засгийн талаас нь экологийн талаас нь хөгжүүлэх ёстой.

**- Замын -Үүд, Алтанбулагийн чөлөөт бүс байгуулна хэмээн бараг арваад жил ярилаа даа. Хөрөнгө мөнгөний бололцоо нь болдоггүй юм байлгүй?**

- Яагаад хөрөнгө, мөнгө байхгүй гэж. Иргэдэд тарааж байгаа энэ 805 тэрбумаар нэг биш, хоёр ч биш нэлээд хэдэн чөлөөт бүс барьчихна шүү дээ. Алтанбулагийн чөлөөт бүсэд жилд өгдөг дөрвөн тэрбумыгаа 40 тэрбум төгрөг болго. Замын Үүдэд 200 тэрбумыг зарцуулчих. Нэг л их мундаг бүтээн байгуулалт ярьсан хүмүүс. Түүнд нь ард түмэн үнэмших хэцүү байх хэцүү байдалд ороод л.

**- Уул уурхайн салбар Монголын хөгжлийн гарц юм биш үү. Тиймээс ч төрөөс уул уурхайн салбарт илүү анхаарал хандуулаад байх шиг?**

- Монгол яах аргагүй уул уурхайн дэмийрэл тусчихсан байна. Нүд нь гөлөлзөөд галзуурсан хүнтэй адилхан ч юм шиг. Хүн болгон өнөөдөр уул уурхайн дэмийрэлд автагдаад байна шүү дээ. Өнөөдөр сэтгүүлчид ирээд нэг асуулт тавина. Тэр нь Тавантолгойг ашиглах нь зөв үү, энэ тэр гэсэн утгатай. Монголд энэ дэмийрэл хөгжил авчрахгүй ээ. Монголын экспортын ихэнхийг нь уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Яагаад Монгол Улс өөр зүйл экспортолж болохгүй гэж. Хятадын Жилид “Эрдэнэт” хивсийг булаацалдаад авч байна шүү дээ. Эрээнд “Өгөөж”-ийн боов шиг эрэлттэй гурилан бүтээгдэхүүн байдаггүй гэсэн. Ийм боловсруулсан, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнээ экспортлоход анхаар л даа. Манай монгол малын мах шиг цэвэр экологийн, органик мах хаана ч байхгүй. Гэтэл яагаад гадаад зах зээлд эрэлт бага байна. Тэгэхээр Монголынхоо үйлдвэрүүдийг гадаадын зах зээлд гаргах боломжийг нь бүрдүүлэх хэрэгтэй байгаа юм. Түүнээс бус нүүрсээ, алтаа, зэсээ ухаад түүхийгээр нь гаргаснаа Монголын аврал гэж ойлгож болохгүй. Эдийн засгийг төрөлжүүлбэ гээд байдаг. Яаж төрөлжүүлэхээ харамсалтай нь мэддэггүй юм шиг байна лээ.

**- Тавантолгойтой холбоотой асуудлыг уг нь танд тавих гэсэн юм. Нөгөө л нэг улиг болсон асуултыг тавих нь гэж таны дургүйг хүргэчих вий гэж бодоод?**

- Тавантолгойтой холбоотой нэг л хариултыг хэлье. Тавантолгойн орд газраас ард түмэн, аж ахуйн нэгжүүдэд хувь хүртээнэ хувьцаа тараана гэдэг ёстой үлгэр. Уул уурхайн дэмийрлийн нэг “симптом”. Хариуцлагатай, байгаль орчинд ээлтэй уул уурхайг эдийн засгийн бусад салбартай уялдуулан хөгжүүлэх талаар л анхаар. Ард түмэнд 10 хувь, аж ахуйн нэгжид 10 хувь, энэ тэр гэдгээ боль. Энэ бол үлгэр. Энэ бол тэнэглэл. Дэлхий дээр нийгмээрээ аз жаргалтай хувьцаат улс гэж хэзээ ч байгаагүй юм. Байх ч үгүй.



**- Монгол Улсаас 100 мянган айлын орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон. Энэ хөтөлбөр барилгын салбарын хөгжилд түлхэц болох байх, тийм үү. Засгийн газраас дээрх хөтөлбөрийн хүрээнд 300 тэрбум төгрөгийг гаргахаар шийдвэрлэсэн?**

-100 мянган айлын орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зөв. Иргэдэд өнөөдөр амьдрах орчин үеийн байр хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Монголчууд өөрсдөө барилгын материал үйлдвэрлэх нь зөв. Хамгийн гол нь Засгийн газар өөрсдөө бизнес хийхээс илүү хувийн хэвшлийнхэнд бизнес хийх боломжийг нь олгоод өгчих. Санхүүгийн механизмыг шийдээд өг. Хүмүүсийн орон сууц худалдан авах чадварыг нэмэгдүүл. Энэ хөтөлбөрийн хүрээнд гарч ирж буй олон асуудлыг цогцоор нь шийдэхгүйгээр зүгээр л нэг байшин бариад 100 мянган тоонд хүргэх нь чухал биш шүү дээ. Хөтөлбөрийн хүрээнд хичнээн үйлдвэр аж ахуйн нэгж шинээр бий болов, жилд Монгол Улс хичнээн хэмжээний барилгын материал дотооддоо үйлдвэрлэж байна, хичнээн иргэд байртай болж чадав гэдэг л хамгийн чухал асуудал юм.

**- Ноолуурын салбарт 110 тэрбумын бондыг Засгийн газраас гаргах болсон. Гэтэл дээрх 110 тэрбумыг 12-хон компани хувааж идээд, бусад нь хоосон үлдэх нь гэсэн хардлага байгаа?**

- Засгийн газраас ноос ноолуурын салбарыг дэмжиж 110 тэрбумын бонд гаргаж байгааг зөв алхам гэж бодож байгаа. Малчид нь мөнгөө бодоод хятад ченжүүдэд өндөр үнээр ноолуураа зарчихдаг, хятадууд ямар ч татваргүйгээр ноолуурыг урд хилээр гаргадаг. Гэтэл үндэсний үйлдвэрүүд нь хөрөнгө мөнгөний бололцоогүйгээс хүчин чадлаараа ажиллаж чадахгүйд хүрсэн нь худлаа биш. Засгийн газар тэр бонд гаргах ажлаа л яаравчлах хэрэгтэй. 12-хон компани хуваагаад үлдсэн нь хоосон хоцорно гэдэг дэмий хардлага. Монголын ноос ноолуурын салбарт 12 томоохон компани, 18 жижиг дунд үйлдвэр байдаг. Тэр 18 жижиг дунд үйлдвэрт 10 тэрбум төгрөг хэрэгтэй гэсэн тооцоо бий. Тэгэхээр хувааж авахыг нь үйлдвэрлэгчид өөрсдөө мэдэг. Хоорондоо учраа ололцчихно биз. Олсон шар тосоо булаацалдаад нэгийгээ хөнөөчихдөг оготнын үлгэр шиг болохгүй нь ойлгомжтой. Засаг бондоо гаргаж өгчих. Буцааж төлөх асуудалд танхим хяналт тавиад өгье.

**- Монголын бизнесийн бодлого монополиудад чиглэгддэг юм биш үү. Шатахуун импортлогчдын толгойг төрөөс илээд,**

**нөгөөдүүл нь шалтаггүйгээр үнийг нэмээд л. Нэг иймэрхүү л дүр зураг ажиглагдах болж?**

- Монголын газрын тосны стратегийн бодлогыг би мэдэхгүй. Сая намайг Дорнодод явж байхад Тамсагийн ордын нөөц нефть байгуулах үйлдвэр байгуулах хэмжээний биш гэсэн. Гэтэл уг ордоос хэдхэн километрын цаана Хайлаарт нөөц багатай газрын тосны орд байдаг юм байна л даа. Энэ хоёрын дунд нэг боловсруулах үйлдвэр барьчихмаар байна гээд Дорнодын бизнесменүүд ярьж байна лээ. Бизнесийнхэн чинь бодитоо боломжтой зүйлийг нь ярина шүү дээ. Улстөрчид шиг таамгаар хусахгүй.

**- Таныг УИХ-д Иргэний Зориг Ногоон намаас нэр дэвшинэ гэсэн яриа байна. Таны яриаг сонсоод байхад улс төрд хүч үзэхээр шийдсэн бололтой?**

- Миний хувьд улс төрийн сонголтоо хийх цаг нь болсон. Харин хаанаас нэр дэвшихээ шийдээгүй байна. Миний дэмждэг ногоон үзлийг гаргаж ирдэг улс төрийн хүчин бол Иргэний Зориг Ногоон нам. 20 жилийн турш бизнесийн гал тогоотой зууралдлаа. Тэдэнтэйгээ зөвлөлдөж байж би сонголтоо хийнэ.

**- Ардаа улс төрийн хүчний хамгаалалтгүйгээр улс төрд хол явахгүй гэдэг. Тэгэхээр та аль нэг намд элсэх нь тодорхой гэсэн үг үү?**

- Ямар хамгаалалт гэж. Аливаа намын хатуу гишүүнчлэлийг би ерөөсөө ойлгодоггүй, дэмждэггүй. Төрийн бодлогоос илүү намын бодлого дээгүүрт тавигддаг өнөөгийн тогтолцоог өөрчлөхийг хүсч байна. Тиймээс хайрцагласан улс төрийн намын бодлого нийгэмд хамгийн хортой. Албан тушаалын гишгүүр болсон намын энэ хайрцаглагдсан бодлогыг л өөрчлөх хэрэгтэй байна. Нам бус тэгсэн мөртлөө нийгэмд тодорхой хэмжээний байр суурьтай хэсэг хүмүүс нийлж нэг клуб байгуулахаар болсон. Энэ клубын талаар дараа та нарт тодорхой мэдээлэл өгнө.

**- Та С.Батболдын Засгийн газар урьд өмнө ямар ч Засгийн газар хийж байгаагүй ажлыг эхлүүлсэнд талархаж байгаагаа нэг бус удаа хэлж байсан?**

- С.Батболдын Засгийн газраас өөр ямарч Засгийн газар өнгөрсөн хорин жилд хийгээгүй ажлыг эхлүүлсэнд Ерөнхий сайдад монголчууд талархах ёстой. Утга агуулгын хувьд асар том далайцтай бизнесийн орчинг хөгжүүлэхийн төлөө С.Батболдыг ганцаардаж байна гэж би хэлмээр байна.

**- Ингэхэд Монгол үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хэр сайн ажиллаж байна вэ. Та өөртөө дүн тавиач?**

- Танхим сайн ажиллаж байгаа. Би бүр танхимын ажилд онц дүн тавимаар байна.

**- Зарим хүмүүс таны хэлсэнтэй санал нийлэх болов уу?**

- Санал нийлэхгүйгээсээ нийлэх нь олон. Ямар нэгэн зорилго агуулсан хүмүүс янз бүрийн юм ярьдаг. Гэхдээ танхим ажлаа хэр хийж байгаад бизнесийнхэн дүн тавина шүү дээ.

*Ж.Эрхэс “Эрхэс” сэтгүүл*

***МУХАУТ-ын дарга С.Дэмбэрэл төсвийн менежментийг шинэчлэх зайлшгүй шаардлагын талаар ярьж байна.***

## **ЭДИЙН ЗАСГИЙН ГЭХЭЭСЭЭ ИЛҮҮ УЛС ТӨРИЙН ШАЛГУУРААР ТӨСВИЙГ ҮНЭЛЖ ДҮГНЭДЭГ БОЛЧИХ ГЭЭД БАЙНА**

**- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн ач холбогдлыг Та хэрхэн харж байна вэ?**

- Төсвийн орлого, зарлага аль аль талд нь байгаа зөрчил, тодорхой бус зүйлүүдийг засаж сайжруулах ёстой гэж олон жил ярьж байгаа. Ерөнхийдөө төсөв мэргэжлийн байгууллагуудаар ороод гарч ирэхдээ 180 градус эргэчихсэн, танигдахгүй болоод гарч ирдэг. Энэ нь төсвийг боловсруулахаас эхлээд батлах үйл явцад хэтэрхий их субъектив нөлөөлөл байгааг харуулдаг. Улс орны эдийн засгийн зохистой байдал, үр ашиг, орлого зарлагыг төлөвлөх үйл явц нь өөрөө эдийн засгийн суурь үндэстэй байх ёстой. Улс төрийн ямар нэг суурь үндэстэй байх ёсгүй. Төсөв бол тухайн үеийнхээ эдийн засгийн бодлогын толь нь болох ёстой. Гэтэл сонгуулийн амлалт биелүүлэхийн тулд төсвийг өөрчлөх зэрэг тогтворгүй болгодог олон хүчин зүйл байна. Нэгдүгээрт, төсвөө тогтвортой байлгах ёстой. Тэгэхгүй бол улс төрчдийн амлалт, гадаад зах зээлийн коннектурын нөлөө хоёроос болоод төсөв тогтвортой байж чадахгүй нь. Төсөв тогтворгүй болсноор эдийн засгийн бодлогууд тогтворгүй болдог. Сүүлдээ эдийн засгийн гэхээсээ улс төрийн шалгуураар төсвийг үнэлж дүгнэдэг явдал бий болчих гээд байна. Энэ үүднээс л төсвийн реформ зайлшгүй. Төсвийн зарцуулалтын хяналтыг яаж бий болгох юм. Яаж хөндлөнгийн шинж чанартай болгох вэ. Засгийн газрын хөрөнгө

оруулалтын үр ашиг нь хэрхэн дээшилж байх юм. Төсөв өөрөө яаж төрийн авлигыг өөгшүүлдэггүй механизм байх ёстой юм. Тендер болон бусад эдийн засгийн процесстой хэрхэн уялдах вэ гэх мэт олон асуудлыг агуулсан хууль тусдаа гарна байх. Ерөнхийдөө энэ нь төсвийн ил тод байдал, зарлагын хяналт, орлогын бүрдэлтийг бодитойгоор эдийн засгийн агентуудад хүндрэл учруулахгүйгээр, тодорхой бодлогыг дэмжих чиглэлээр хийгдэх байх.

Төсөвт татвар төлөгчдөөс өгч байгаа мөнгөний зарцуулалт маш зохистой байх ёстой. Тэрхүү зохистой байдал нь алдагдчихсан учраас ийм асуудлууд гарч байгаа. Төсвийн “тогтвортой” гэдэг ойлголт нь stable буюу хөдөлшгүй гэсэн ойлголт биш. Бид яриад байгаа sustainable буюу тогтвортой хөгжил гэдэг нь хөдөлгөөнгүй хөгжил гэсэн үг шүү дээ. Манайд л буруу орчуулгаар яваад байгаа юм. Sustainable буюу тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд хөгжил маань тогтвортой байна гэвэл эдийн засгийн хязгаарлагдмал нөөц баялгийг төрийн төсөв гэдэг багаж хэрэгслэлээр нь дамжуулан хуваарилах, байршуулах, дахин байршуулах ажлыг л хийнэ. Энэ нь өөрөө дунд болон урт хугацаанд тогтвортой байж, эдийн засагт үйл ажиллагаа явуулж байгаа агентууд буюу хувийн хэвшлийнхэнд зөв сигнал өгөх, тийм орчныг бүрдүүлэхийг л Төсвийн тогтвортой байдлын хууль гэж яриад байгаа. Би тогтвортой гэдгийг нь sustainable гэдэг үгтэй холбож ойлгоно.

**- Тогтвортой байна гээд төсвийн уян хатан байдлыг, хөрөнгө оруулалтыг хааж боож болохгүй гэсэн байр суурь ч байгаа?**

- Юуны өмнө орлогынхоо төлөвлөлтийг их зөв хийдэг байх ёстой. Татвар төлөгчдөөс дээд зэргээр аваад бай гэсэн зарчмаасаа илүүтэй хэдий хэмжээгээр авбал эдийн засгийн өсөлтийг бий болгох мотиваци буюу сэдэл санаа бий болгох вэ гэдэгт анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл төсвийн орлогыг бүрдүүлэхдээ татварын дарамт учруулахгүй байх, төсвөөрөө эдийн засгийн үйл явцыг урамшуулагч байх ёстой.

Эцсийн дүндээ төсөвт орлогын хэлбэрээр өгч байгаа татвар төлөгчдийн мөнгийг хамгийн үр ашигтай зарцуулах, эдийн засгийн харилцааны нийт оролцогчдыг төсвийн орлогын бодлогоор бүхэлд нь хамрах, тэдний үйл ажиллагаанд түлхэц өгөх зорилготой байх учиртай. Зарлагын хувьд хамгийн үр ашигтай нийгмийн халамжийн системийг яаж бүрдүүлэх вэ. Хамгийн үр ашигтай байж болох нийтийн хөрөнгө оруулалтыг яаж үүгээр хангах вэ. Цугларсан мөнгийг нийгмийн олон сувгуудаар дахин байршуулах орлогын хуваарилалтыг яаж шударга хийдэг болох вэ гэхчлэн тодорхой

асуудлууд гарна. Өөрөөр хэлбэл нэгээс аваад нөгөөд нь тэгшитгэн хуваарилах зарчмаар явах нь төсвийн эцсийн үр дүнг эдийн засгийн үр ашиггүй болгож байна. Төсвөөр дамжуулж нийгмийн хүрэх гэж байгаа зорилтот санхүүжилт нь үр ашиг өгдөггүй. Эдийн засаг, нийгмийн нийлмэл үр ашиг нь эцсийн дүндээ тааруу байдаг ийм бүтэцтэй, ийм менежменттэй байх юм уу гэдэг талаас нь л ярилцах ёстой.

Тухайлбал, бид өнөөдөр зэс, алтаар баримжаалаад төсвөө хийж байгаа. Гэхдээ энэ чинь болохгүй юм байна гэдгийг сүүлийн хэдэн жилд үзлээ. Манайх цикл гэдэгтэй нэг зүйлийг бас андуурч ойлгодог. Монголбанк цикл гэдгийг Монголын эдийн засаг бол мөчлөгт эдийн засаг гэж ойлгодог. Түүндээ тааруулсан бодлого хэрэгжүүлээд буруудаад байгаа. Манай эдийн засаг мөчлөгт эдийн засаг биш. Гэхдээ гадаад зах зээлийн мөчлөгийг хүлээж авдаг. Өөрөөр хэлбэл бараа түүхий эдийн үнийн хэлбэлзэл, соппесше ийн хэлбэлзлээр дамжуулж Монгол улс өөрөө тодорхой хэмжээний эрсдэлийг хүлээдэг. Яагаад гэвэл Монголын эдийн засгийн бүтэц нь өрөөсгөл. Цөөхөн хэдэн экспорт дээр тогтдог. Тиймээс гадаад нөлөөллийг өөрийн эрхгүй авдаг. Энэ нь төсвийн бүрдэлтэд нөлөөлдөг. Зарлагад хүртэл нөлөөлдөг. Ингэснээрээ менежментийг үр ашиггүй болгодог ийм бүтэцтэй л яваад ирчихсэн.

Цаашид эдийн засгийн үр ашгийг хамгийн түрүүнд тавих асуудал гарч ирж байна. Тиймээс нийтийн хөрөнгө оруулалт буюу төсвийн хөрөнгө оруулалтад үр ашгийн шалгуурыг тэргүүн зэрэгт тавих учиртай. Зарцуулалт, тухайлбал тендерээр дамжуулж дахин байршуулж байгаа нь нийгэмд том асуудлыг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл манай нийгмийн нэг эд эс мэт болоод хавдар шиг ургачихсан, буглачихаад байгаа хээл хахууль, авлигыг үүсгэдэггүй байх тийм л зохистой механизмыг гаргаж ирэх ёстой. Сонгогчдын захиас гэдэг зүйлээр дулдуйдсан улстөрчдийн хүсэл төсөвт орж ирдэггүй байх ёстой. Ерөөсөө төсөв бол “хуурай” эдийн засгийн “хуурай” хэрэгсэл байх ёстой. Цаашид эдийн засгийн улстөржөөгүй арга хэрэгсэл бий болгох хэрэгтэй.

**- Ийм “хуурай харилцааг” зөвхөн хууль гаргаснаар хэвшүүлж чадах уу?**

- Хууль гаргах нэг хэрэг. Хуулиа зөв ашиглаж, яг таг мөрддөг байх ёстой. Жишээлбэл, Сангийн яамнаас оруулж ирж байгаа төсвийн төлөвлөлтийн үндсэн баримт бичиг, дээр нь Монголын эдийн засгийг тухайн жилд болон дараа дараагийн жилүүдэд, дунд хугацаанд хөгжүүлэх үндсэн баримт бичиг, мөн банк санхүүгийн талаар энэ улсын эдийн засгийг хэрхэн авч явах вэ

гэдэг энэ гурван баримт бичиг дээд зэргээр уялддаг байх ёстой. Манайд бол нэг их уялдахгүй байгаа. Уялдуулж байна гээд том том объектуудыг зарна гээд л тавьчихаж байгаа шүү дээ. Тиймээс энэ чиглэлийн ажил цаашдаа зарчмын хувьд өөрчлөгдөх байх.

Тогтвортой хөгжлийг хангаж байгаа нэг гол хэрэгсэл нь төсөв. Дээр нь төсвөөр дамжиж эдийн засагт оролцож байгаа оролцоогоо эргэж харах том асуудал байна. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ их өндөр байгаа. Үүнийгээ манай улсын онцлог гэж тайлбарладаг. Энэ бол худлаа тайлбар. Тиймээс төрөөс эдийн засагт оролцох зүйлдээ л оролцох ёстой. Төсвийн хөрөнгө оруулалтыг бүх тийш цацахын оронд эдийн засгийн тэргүүлэх секторуудыг хөрөнгө мөнгөөр хангаж өгөх шаардлагатай. Америкт хүртэл жижиг бизнесийг дэмжээд төчнөөн миллиардыг хуваарилъя гэж Б.Обама ярьж байна. Үүнтэй адил манайд жижиг, дунд бизнесийг дэмжих гээд төсвөөс 30 тэрбум төгрөг хуваарилъя гэж байгаа. Дээр нь тодорхой секторуудад тэтгэлэг татаас өгч байна. Үр дүнд нь тодорхой сектор хөл дээрээ босож байна. Тухайлбал, Атрын III аян байна. Төрийн зүгээс тодорхой хэмжээгээр оролцох шаардлагатай салбар гэж бий. Монголын эдийн засагт албан бус секторын хувь хэмжээ их. Байгаа албан секторуудын ихэнх нь жижиг дунд бизнес. Банкны сектор нь тэдгээрийн хэрэгцээг хангаж чадахгүй тохиолдолд оролцоо зайлшгүй шаардлагатай.

**- МҮЭХ төсөвт иргэдийн хяналтыг бий болгохоор Төсвийн байнгын хороотой Санамж бичиг байгууллаа. Энэ хамтын ажиллагаа хэр хэрэгжих боломжтой бол?**

- Үйлдвэрчний эвлэлийн холбоо хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг л ярьдаг байгууллага шүү дээ. Нэг их улсын төсөвт оролцоод байдгийг нь мэдэхгүй юм. Татвар төлөгчдийн төлөөллийн байгууллагууд тодорхой хэмжээгээр хөндлөнгийн хяналт хийж байх ёстой. Манайд төсвийн хяналт гэхээр Аудитын газар үнэлгээ хийгээд л “төсвийн байгууллага тэдийг илүү үрчихэж, тийм боломж байсан” гэж дараа нь хэлдэг биз дээ. “Ниргэсэн хойно нь хашгирна” гэдэг шиг юм ярьж байхын оронд төсвийг боловсруулах шатанд нь л “ийм байвал зохистой болно” гэж хэлдэг байгууллагууд хэрэгтэй. Мэдээж явцын дунд нь мониторинг хийх байгууллагууд хэрэгтэй.

Төсвийн гүйцэтгэлийг УИХ-аар авч хэлэлцээд хянаж байна гэдэг. Энэ бүхнийг хянадаг иргэний байгууллагууд зайлшгүй чухал. Үйлдвэрчний эвлэл татвар төлөгч хүмүүсийн нэгдэл гэдэг үүднээс тодорхой хэмжээгээр оролцож болно. Тэгэхээр татвар төлөгч иргэн бүр хянадаг байхын тулд төсвийн процесс ил тод

л байх ёстой. Ил тод гэдэг нь вэб сайтдаа байршуулахыг хэлж байгаа биш шүү дээ. Гол нь төсвийг бүрдүүлж байгаа эх үүсвэрүүд ил тод байх хэрэгтэй.

Мөн гадны хамаарал, коннектурын хэлбэлзлээс хамаардаггүй эдийн засгийн бодлогуудыг гаргаж ирэх шаардлагатай. Тэгснээрээ төсвөөр дамжуулж баялгийн хараал хүрэхгүй байх механизмыг сайн суулгаж өгөх ёстой. Тийм ч учраас бусад улс оронд Тогтворжилтийн сан байгуулдаг.

#### **- Тогтворжилтийн сангийн ач холбогдол нь юу вэ?**

- Тогтворжилтийн сан гэдэг нь тодорхой эрсдэл, гадаад орчны коннектурын хэлбэлзлийн хамаарлыг багасгах арга зам. Тухайн үед улс орны эдийн засгийг тогтвортой авч явахын тулд өмнө нь орж ирсэн хөрөнгийг зохистой байршуулах зорилгоор хуримтлуулж байгаа хэсэг шүү дээ. Нэг хэсэг нь ийм хар өдөрт зориулсан хөрөнгө. Нөгөө нь ямар ч нам хүчин гарч ирсэн байж байдаг. Эдийн засагт баланс алдагдах үед хэрэглэдэг. Мөн хөгжлийг санхүүжүүлэх нэг хэсэг хөрөнгө байна. Энэ нь үйл ажиллагааны шуурхай зарчим дээр тулгуурлан явагддаг. Ямар ч тохиолдолд хэт улстөржилтийн субъектив хүчин зүйл рүү ордоггүй тийм л зарчим байх ёстой.

#### **- Хяналтыг хэрхэн тавих вэ?**

- Хяналтыг хуулиараа л хэрэгжүүлнэ. Тухайлбал, Норвегийн сангийн хуулийг Монголынхоо нөхцөлд маш сайн тохируулж буулгаад гаргачихвал, түүнийгээ мөрддөг бол хардлага үүсэхгүй. Ер нь хуулийн заалтуудын маш сайн жишээнээс авах хэрэгтэй. Судалгаагаар хамгийн сайн жишээ Норвегийн сан л байгаа шүү дээ.

#### **- Хүний хөгжлийн сангийн тухай хуулийн эх загварыг Аляскийн сангаас хуулсан гээд байгаа шүү дээ?**

- Ямар ч байсан гурав, дөрвөн жилийн өмнө Германы том институтээс нөөцөөр баян улс орнуудын дунд хийсэн судалгаагаар хамгийн сайн жишээтэй улс Норвеги л байсан. Аляскийн сан гэж тэнд дурдаа ч үгүй. Манайхан Норвеги руу явж туршлага сайн судалмаар байгаа юм. “Баялгийн хараалаас яаж зайлах вэ” гэх зэрэг Ж.Штиглиц болон бусад хүмүүсийн бичсэн номнууд байна. Дэлхий даяар энэ чиглэлээр судалгаа хийгдчихсэн. Улс орнуудын тодорхой жишээнүүд бий. Бид “Голланд өвчин” гэж ганц юм цээжилчихээд яриад байж болохгүй шүү дээ. Монгол бол заяагдмал нөөцтэй улс Тиймээс ч бид “Заяагдмал нөөцийн олдмол хам шинж” гэсэн томъёоллыг гаргаж ирсэн. Ийм симптомууд манайд байна аа. Яагаа ч үгүй байхад алаагүй баавгайн арьсыг хуваачихдаг. Улс төс хэтэрхий их оролцохоороо эдийн засгийн зохистой байдал, үр

ашгийг дарчихаад гаргаж ирдэггүй юм байна. Зөвхөн улс төрийн амлалт гэдэг юм дээр эдийн засаг яваад байгаа нь л хамгийн том эмгэнэл.

Манай улсын төсөв цаашдаа эрдэс баялгийн салбарын хөгжлөөс ихээхэн хамаарна. Гэхдээ энэ нь манай эдийн засаг хэдхэн жилийн дараа 20, 30 хувийн өсөлттэй болно гэж худлаа ярихын нэр биш шүү. Одоо бол бид төөрчихсөн, хэдэн тоонууд, хандлагаа хардаг. Өсөлтийн хэдэн шинжилгээ хийгээд, тэрэндээ л итгэдэг. Түүнийгээ хөгжил гэж ойлгодог. Гэтэл уул уурхайгаас орж ирж байгаа орлогыг төсөв болон бусад арга хэрэгслээр дамжуулан шударгаар хуваарилах ёстой. Тэгснээр зөвхөн уул уурхай бус бусад сектор тэгш хөгжиж эдийн засаг өөрөө баланслагдана.

Зөвхөн уул уурхайн салбарт ажилладаг хүмүүс 5000 долларын цалин авч байна гэж бахархаж ярих ёсгүй юм. Хөдөлмөрийн багтаамж ихтэй бусад салбарыг хөгжүүлэх нь чухал. Хоёрдугаарт, эрдсийн бус экспортыг онцгой анхаарах хэрэгтэй. Дээр нь эрдэм мэдлэг шингэсэн секторуудыг онцгой анхаарах ёстой. Хөдөө аж ахуйн салбарынхаа цаг уураас хараат байдлыг яаж бага болгох вэ. Тодорхой хугацааны дараа эрдэс баялгийн хэмжээ багасаад, уул геологийнх нь нөхцөл хүндрээд ирэхэд “Энэ улс Голланд өвчин тусчихаж, Монгол өвчин болоод хувирчихаж, баялгийн хараалд орчихож, улс төрийнх нь систем хахуульд идэгдээд цөөхөн хүн нь баяжчихаж, тэд нар нь гадагшаа гараад явчихаж, улс оронд нь цөлжилт нүүрлээд байгаль орчин нь сөнөчихөж” гэж дэлхийд жишээ болоод байж болохгүй. Тийм гашуун үр дүнд хүргэхээргүй л төсвийн бодлогыг явуулах хэрэгтэй.

Өнөөдөр нөөцийг дээд зэргээр хайр гамгүй ашиглаж байгаа. Орчин үеийн уул уурхайн хөгжлийн гол зарчмуудыг шингээж чадаагүй байна. Ер нь ямар ч үнээр хамаагүй нөөцийг аваад, эдийн засгийн үнэлэмжүүдийг бий болгоод байж болохгүй. Угаасаа эдийн засгийн онолоор бол байгаль гэдэг гадаад хүчин зүйл маань дотоод хүчин зүйл болчихож. Байгаль орчин өөрөө үйлдвэрлэлийн хүчин зүйл болоод хувирчихсан. Байгаль орчны зөв, ногоон үйлдвэрлэлийн хөрсөн дээр хүрэн өнгөтэй байгаа тэр орлого, зарлагуудыг жил жилээр тодорхой бодлоготойгоор, эдийн засгийн үр ашигтай зөв хөгжил рүү хөтлөх сэжим түлхэц өгдөг санхүүгийн арга хэрэгсэл байх талаас төрийн бодлого явах ёстой. Төсвийн тогтвортой байдлын хууль гэдэг маань нөгөө талаас ийм л үүрэг биелүүлэх учиртай юм.

*Ярилцсан Э.Болорхажид  
Mongolian Mining Journal, 2010 он, №002/016*

## ТАВАНТОЛГОЙД МОНГОЛ КОМПАНИУДЫГ ҮНДСЭН ТОГЛОГЧ БОЛГОХ ЭРХ НЬ УИХ-ЫН МЭДЭЛД БАЙНА

“Таван толгой”-г Монгол өөрөө эзэмшинэ гэсэн асуудал яригдаж “Монгол Үндэсний нэгдэл 999” гэсэн компани байгуулагдаж байгаа, мөн нөгөө талаас МҮХАҮТ-ын гишүүн компаниуд буюу үндэсний томоохон компаниуд нэгдэн “Тавантолгой”-д үндсэн тоглогч болох саналаа, ажиллах зарчмаа ерөнхий сайдад өргөн бариад байгаа. Сүүлийн үед зарим хэвлэлээр энэ МҮХАҮТ-ын гишүүн компаниуд, “Монгол үндэсний нэгдэл 999”-ийн хооронд маргаан дэгдэж байгаа тухай яригдаад байгаа. Энэ талаар МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлээс тодрууллаа.

**- Таныг “Таван толгой”-г авах гэж улайрч зүтгээд байгаа гэж яригдах боллоо. Манайхан томоохон ордоо авах тухай асуудал дээр та ямар байр суурьтай байгаа вэ?**

- Намайг үндэсний 20-н томоохон компанийг удирдан таван толгойг авах гэж байна, “Монгол Үндэсний нэгдэл 999”-тэй ерсөлдөөд байгаа мэтээр ярих нь буруу, ташаа ойлголт. Манай танхимын зүгээс барьж байгаа бодлого бол Монголчууд өөрсдөө “Тавантолгой”-нхоо ордыг эзэмшсэн нь зүйтэй гэдэгтэй санал нэг байгаа. Тиймч учраас манай танхимын гишүүн компаниуд өөрсдийн хүсэлтээ тавьсан байгаа. Танхимын хувьд аль нэг талд нь орох эрх ч байхгүй. Үүргийнхээ хувьд. “Монгол үндэсний нэгдэл 999”-ийн үндсэн санааг бид дэмжиж байгаа. Өнөөдөр манай улсад томоохон компаниуд үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлээд 20 жил боллоо. Хүнээр бол 20 настай эрийн цээнд хүрсэн залуу болж тиймээс итгэл хүлээлгээд үзэхэд буруутах зүйл байхгүй болов уу. Гэхдээ Тавантолгойд Монгол үндэсний компаниуд үндсэн тоглогч байх уу, гадаадынхан байх уу гэдгийг УИХ шийдэх болчихоод байна.

**- “Тавантолгой”-д маш их хэмжээний хөрөнгө оруулалт хэрэгтэй байгаа. Манайхан гаргаж чадах уу?**

- Чадахгүй. Тийм учраас төртэйгээ хорших хэрэгтэй. Төрийн дэмжлэг байх хэрэгтэй. Гэхдээ төр нь өөрөө бизнесмэн болчих ёсгүй л дээ. Манайхан 80 жил нүүрс ухсан болохоор нүүрсээ ухаж чадах л байх л даа. Гэхдээ бидэнд гадаадынхаас сурах хамтрах

зүйл их байгаа. Хамгийн гол нь бид өөрсдөө л Тавантолгойгоо мэдэлдээ авах хэрэгтэй тэгээд дараа нь дараагийнхаа асуудлуудыг ярилцах хэрэггүй. Тэгэхгүй бол өнөөдөр хүн болгон жаргалтай амьдрал мөрөөдөөд урдаа байгаа ажлаа мартчихаад байна. Энэ бол аз жаргалыг мөрөөдөх сэтгэцийн өвчин.

**- Манайхан аль нэг нэр хүндтэй бирж дээр мөнгө босгох боломж бий юу?**

- Байхгүй. Манай орон ямар зэрэглэлд багтдаг билээ. Компаниуд нь хөрөнгө босгох боломжгүй. Ядаж хөрөнгийн бирж нь ч олигтойхон биш. Тэгэхээр болохгүй л дээ.

**- Нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр унах тухай бас яригдаад байна. Гэтэл бид 200 жил энэ уурхайгаар тэжээлгэж болно гэсэн ойлголттой байгаа?**

- Эрчим хүч байгаа цагт нүүрс үнэгүйдэнэ гэж байхгүй байх аа. 200 жил гэдгийг бол би хэлж мэдэхгүй байна. 200 байтугай 20 жилийн дараа ч яах юм билээ. Нөөц нь бол байгаа байх аа.

Л.Оюу  
Shuud.mn, 2010 он

## С.Дэмбэрэл: ТӨРИЙН ӨМЧИЙГ ШҮТЭХ ДУРШИЛ БҮХИЙ БОДЛОГО НЬ ЭЦЭГ - ТӨРИЙН ЗАРЧМААР ЯВЖ БАЙГАА ХЭРЭГ

**- Хувийн хэвшил манай эдийн засгийн 70-80 хувийг бүрдүүлж, бүтээж байна гэдэг. Зах зээл хөгжсөн оронд үүнийг “нормаль” үзэгдэл гэх байх. Гэтэл сүүлийн үед төр өмчтэй болох сонирхол давамгайлаад байх шиг. Ер нь бизнес эрхлэгчид хэлдэг дээ, төр бидний орон зайг булаагаад байна, зах зээл хумигдаад байна гэж?**

- Өнөөдөр бид өмч хувьчлалын 20 жилийн ойг тэмдэглэх гэж байна. Гэтэл нөгөө талаар өмчийг шилжүүлснээ мартаж шахаж байна. Ер нь манайд төрийн өмчийг шүтсэн эдийн засгийн хөгжлийн загвар бий болгох хандлага хүчтэй цухалзаж энэ нь эцэстээ нийтээрээ хувьцаа эзэмшдэг аз жаргалтай нийгэм байгуулах тийшээ хандчихаад байна. Төрийн өмч давамгайлсан газар үйл ажиллагаа доголдож, үр ашиг, бүтээмж муудаж, нөгөө авлига, хээл хахууль цэцэглэдэг нь түгээмэл фактууд ш дээ. Тиймээс хүн төрөлхтний олж мэдсэн өмчийн хамгийн сайн хэлбэр

нь хувийн өмч. Өнөөдөр төрийн өмчөөр учиргүй сайхан хөгжиж дэвжсэн улс орон хаана ч байхгүй. Ялангуяа нөөц дээр суурилсан, түүнд дулдуйдсан эдийн засагтай улс орны хувьд төрийн өмчийн тухай ойлголтыг маш болгоомжлох хэрэгтэй.

**- Манайхан Чили зэрэг орны туршлагыг судлаад байна. Хөгжлийн ийм сайн загвар байдаг юм биш үү?**

- Тэр яриад байгааг нь хэн баталсан юм. Хаана хувийн өмч, хөрөнгө оруулалт байна, тэнд хариуцлага, ил тод байдал давамгайлж байдаг. Манайд болохоор төрийн болон нийтийн өмчийг хольж хутгаад хаячихсан. Үндсэн хуульд газар, баялаг ард түмний мэдэлд байна гэсэн тэр “төрийн хамгаалалт” гэх хоржоонтой үгийг төрийн өмч юм шиг тайлбарлаад, нөгөөх ард түмний мэдэлд гэдгийг нь нормаль байдлаар ойлгоод сурчихсан. Тэгээд бүх иргэддээ хувьцаа тарааж өгөөд баяжуулаад суух юм яриад байгаа. Ийм хандлага сүүлийн үед посткоммунист орнуудад ажиглагдах болсон. Казахстан гэх мэтээр. Энэ нь хэр тогтвортой, зөв зам бэ. Гэтэл үүнээс нь өмнө манайд ч гэсэн хувийн компаниуд IPO хийгээд, хөрөнгө мөнгө босгоод хариуцлагаа хүлээгээд, олон улсын тоглогч болоод явж байна ш дээ.

**- Манайхан зах зээлийн системд хөл тавиад бас чиг 20 орчим жил болчихлоо. Нийгмийнхээ ая эвийг олох ухаанд хурдан суралцаж байгаа бус уу?**

- Тиймээ. 1990-ээд онд монголчууд бид бүгдийг хувьчилчихвал бүх юм ид шидийн саваагаар дохисон мэт сайн сайхан болчихно гэж гэнэн төсөөлдөг байж. Тэр үеэс хойш бусад улс оронд өмч, менежмент хоёр салж эхэлсэн. Гэтэл бид төрийн өмчит компани байгуулах дуршилтай болчихсон буруу загвар руу яваад байдаг. Жишээ нь, яагаад сонгуульд ялсан намууд Засгийн газраа байгуулмагц “Эрдэнэт” үйлдвэрийн захирлыг сольдог вэ. Тус үйлдвэр корпорацийн зарчимд шилжихгүй, арилжааны дэглэмд орохгүй байгаа нь улс төрийн бялуу хуваах, хэн нэгийг урамшуулах арга хэрэгсэл болсныг харуулаад байгаа юм. Тиймээс бид дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байгаагаас зөрөөд, өөр загвар хувилбар хайгаад яах юм бэ. Ийм болохоор бүх нийтээрээ хувьцаа эзэмшиж, аз жаргалтай нийгэм байгуулна гэсэн үзэл баримтлалд би хувьдаа итгэдэггүй. Тиймээс төрийн болон нийтийн өмчийг ялгаж салгаад түүний менежментийг боловсронгуй болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, бодлогоо тодорхойлох ёстой. Уг нь нийтийн өмчийн эдийн засаг гэдэг тусдаа шинжлэх ухаан байх юм. Гэтэл энэ талаар манайд төрийн бодлого ч алга. Ер нь тэгээд төрийн өмчийг шүтэх дуршил, бодлого нь патерналист буюу эцэгтөрийн зарчмаар явж

байгаа хэрэг. Манайд жишээ нь, авлигатай тэмцэх гээд чадахгүй л байна ш дээ.

**- Ер нь төрийн болон хувийн өмч төдий харьцаатай байвал зохимжтой гэсэн жишиг байна уу. Хувийн өмч өндөр хөгжсөн оронд бол өөр байдаг байх?**

- Манайд бол үүнийг тоогоор илэрхийлбэл төрийн өмч 10 хувиас илүү баймааргүй. Баялгийн нөөц ихтэй, ганц хүний удирдлагаар бүх юм нь хөдөлж байгаа орон байна. Гэхдээ хөгжил гэдгийг том том барилга байгууламж, олон гоё сайхан машинаар хэмжихгүй байх. Нийгэмд шударга ёс тогтож, иргэд нь маргаашдаа итгэлтэй, хүн бүр хүсэл сонирхол, авьяас чадвараараа ажиллаж амьдрах, эрүүл мэнд, боловсрол гээд нийгмийн бүхий л боломжоор хангагдсан байх учиртай. Ийм орны тод жишээ нь Норвеги юм. Тэнд жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж чадсан.

**- Ийм байдлыг ойртуулахын тулд манайд юу хийх ёстой вэ?**

- Бүх хүн нийгмийн харилцаанд орохоороо өөр давхаргад хамрагддаг. Тиймээс давхаргын хүн бүрт хувьцааг тэгш хуваарилах биш, хүн бүрт ажиллах тэгш боломжийг л олгох нь чухал. Түүнийг нь иргэн бүр тэгш, шударга ашиглах хэрэгтэй. Ердөө л энэ.

**- Тэгвэл өнөөдөр манайд монголчууд бид эх орондоо ийм боломж эдлэх нь байтугай байгаа шүү дээ. Жишээ нь, манайд ямар ч нөхцөл тавьсан гадаадын хөрөнгө оруулагчид ороод л ирдэг, “эзлээд” л авдаг?**

- Гадаадын хөрөнгө оруулалт манайд хэрэгтэй, ялангуяа бидний чадахгүй нано технологи ч юм уу, орчин үеийн мэдлэгийн багтаамж ихтэй секторуудад. Энэ мэтээр манайд хөрөнгө оруулалт шаардлагатай салбар зөндөө байна. Гадаадын хөрөнгө оруулалтаас тэргүүний технологи, сайн менежмент, бизнесийн сайн практик үлддэг. Түүнийг сурч, өөрийн болгоод авах хэрэгтэй юм. Ер нь татварын тааламжтай орчин гадаад, дотоодын гэлтгүй хэнд ч тэр хамгаас чухал. Бид өнгөрсөн хугацаанд гадаадынханд хаалгаа цэлийтэл нээсэн. Өнөөдөр харин хөрөнгө оруулалтын бодлогоо эргэж харах хэрэгтэй, цаг нь болсон. Тиймээс гадныхан орж ирэхэд хөрөнгө оруулалтын босгыг 500 мянгаас 12 сая ам.доллар гэж өндөрсгөмөөр байгаа юм.

**- Ноос, ноолуурын салбарт овоохон хөрөнгө оруулалт хийх гэж байна. Гэх мэтээр манай төр, засгаас сүүлийн үед үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжих гээд байх шиг. Гэхдээ үүнийг нийтээр нь авч үзвэл төр, засгийн дэмжлэг ямар байгаа вэ?**

- Монголын зах зээл бага болохоор импортыг орлох үйл явц явагдаж байгаа нь сайн хэрэг. Гэтэл экспортыг яах вэ. Манай экспорт ноолуур юм уу, алт, зэс гэхчлэн хар, шар өнгөнөөс бүрдэж байна. Уг нь хоёр том зах зээл байгаад байдаг. Үүний хэрэгцээг сайтар судалж, өөр юу экспортолж болох вэ гэдэг гарцыг хайх хэрэгтэй. “Өгөөж”-ийн бүтээгдэхүүнд Эрээнийхэн дуртай байдаг. Жилин мужийнхан “Улаанбаатар” хивсийг дор нь худалдаад авчихдаг. Энэ мэтээр экспорт хийх боломжийг судалж, бодлогоо боловсруулах нь үр дүнтэй. Танхим өөрийн боловсруулсан Экспортын Үндэсний хөтөлбөр стратегийг саяхан Г.Занданшатар сайдаар уламжлаад саяхан төр.засагт хүлээлгээд өгчихсөн. Үүнийг нэмж сайжруулаад санхүүгийн ресурсээр дэмжээд баталчихвал ойрын ирээдүйд монголчууд бид асар их экспорт хийж чадна. Бидний судалгаагаар уламжлалт экспортоос гадна 2030 бүтээгдэхүүн нэмж гаргах боломж байгаа нь харагдсан.

**- Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 110 тэрбум төгрөгийн бонд гаргахтай зэрэгцээд ноос бэлтгэн нийлүүлэгч малчдыгурамшуулах хөрөнгө ч босгохоор боллоо. Гэтэл кг нь 500 төгрөгийн үнэтэй ноос авчирч өгчихөөд 2000 төгрөгийн урамшуулал хүртэх нь хэр шударга вэ?**

- Монгол Улсын ноос, ноолуурын салбарт өөрт нь тохирсон санхүүгийн орчин алга. Тиймээс төр өөрийн хөрөнгөөс хувийн секторт хөрөнгө оруулалт хийж байгаа хэрэг. Урамшууллын тухайд малчдыг тусгайлан авч үзэж байгаа нь буруу. Энэ нь нөгөөх тэжээлгэдэг сэтгэлгээг л дэврээж байгаа хэрэг. Тэр ноос, ноолуур бэлтгэж нийлүүлэх ажил чинь тодорхой гинжин хэлхээгээр явж байгаа. Тэр дотор нь л авч үзэх ёстой.

**- Ноолуурын дотоодын хэрэгцээг хангахын тулд экспортод татвар ногдуулж болдоггүй юм уу. Өмнө нь 30 хувийн татвартай байхад тухайн үеийнхээ ханшаар овоо л үнэтэй байсан санагдах юм?**

- Олон улсын худалдааны байгууллага экспортын бүтээгдэхүүнд татвар ногдуулахыг төдий л таашаадаггүй юм. Гэхдээ квот тогтоох зэрэг хязгаарлалтын аргууд бий. Гол нь ноолуурт татвар ногдуулахгүй байгаа нь улс төрийн учир шалтгаантай гэж хэлбэл үнэнд ойртоно. Хэрвээ татвартай болгочихвол малчид болон үүний дундаас орлого олж байгаа хэсэг бүлэг хүнд очих ашигт нөлөөлнө. Ер нь манай бага зах зээл дээр ноолуурын асуудлаа шийдэж чадаагүй нь эмгэнэлтэй явдал. Би хувьдаа үйлдвэрлэгчидтэй санал нэг байдаг. Татвар тогтоочих хэрэгтэй. Тэр нь малчдын

ашиг орлогод нөлөөлөх эффектийг урамшуулал олгох зэргээр саармагжуулах нь чухал.

**- Сая монголчууд шатахуунаар суусан. Ганц шатахуун ч биш, талхны үнэ нэмэгдэхээр Танхимын гишүүн компаниудыг зориудаар ингэж байна хэмээн харддаг?**

- Өдий олон жил түүхий эд нь байсаар байтал дотооддоо боловсруулах үйлдвэр барих талаар нэг ч алхам хийгээгүй төр засгийг хохь нь гэж хэлэхээр байна. Шатахуун дээр бол ийм байгаа. Улс төрийн шийдлээ олоогүйнх нь төлөө ингэж хэлж байгаа юм. Импорт, нийлүүлэлт, үнэд төрийн оролцоо их байх тусам компаниуд эсрэг үйлдэл хийж байна. Гэхдээ би нуун дарагдуулж, хомсдол үүсгээд үүнийг далимдуулж үнээ нэмж байна гэж хэлж байгаа юм биш. Үүнийг бол Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар тогтоох ёстой. Нөгөө талаар бид нефтийн бүтээгдэхүүний хувьд үнэ тогтоогч биш, үнийг хүлээн авагч гэдгийг мартаж болохгүй. Чингисийн агуу Монгол Улс одоо Оросын “Роснефть” гэдэг монополь компаниас хамааралтай байна шүү дээ, харамсалтай юм.

**- Ерөнхийлөгч саяхан ОХУ-д айлчлахдаа энэ асуудлыг нэлээд чухалчлан тавьсан. Хариулт нь харин төдий л хангалттай санагдаагүй шүү.**

- ОХУ-ын Ерөнхий сайд энэ асуудлыг авч хэлэлцэх болно гэж хэлсэн. Их танил үг. Минийхээр бол лав таван удаа хэлж байна, Тэгэхээр бид энэ талаасаа л бодмоор байна. Түүнээс биш импортлогчид руу дайрах хэрэггүй. Тэд ч бас хараат бизнес хийж байгаа улсууд. Нефть боловсруулах үйлдвэр барихдаа зөвлөгөө, тусламж авах нь зөв. Тэд нефтийн бүтээгдэхүүнийг мэднэ. Бас аливаа хомсдолын үед дамлан тоглогчид, хялбар аргаар мөнгө олохыг эрмэлзэгчид гарч ирдгийг санах хэрэгтэй.

**- Манайд ОХУ-аас нийлүүлэх шатахууны хэмжээ багасч, дотооддоо янз бүрийн шалтгаанаар хомсдолтой байсан нь Ерөнхийлөгчийн айлчлал, тэнд яригдсан асуудлуудад хийсэн шангааж гэж хэлж болох уу. Ийм боломж байна уу?**

- Байж болох л юм. Бид дэлхийн гол хоёр тоглогч, томоохон гүрнүүдийн дунд амьдарч байгаа. Тэд жижигхэн Монголд байгаа энэ их баялаг, үүцийг “сүхдээд” авахыг л бодож байгаа. Дахин хэлэхэд төр стратегийн бодлогоо тодорхойлоод, ялангуяа олны “нүдний хор” орж байгаа уул уурхайн салбарт хувийн хэвшлийг сайн ажиллуулах нь чухал. Нэг жишээ хэлэхэд, Швейцарьт Кантоны систем үйлчилж, компани, холбоод нь салбарын бодлогын асуудлаа шийддэг. Засгийн газар ерөнхийд нь

чиглүүлдэг, стратегийг нь тодорхойлдог явдаг юм байна. Энэ алхам манайд хийгдэж эхэллээ. Одоо “Энержи ресурс” компани нүүрсээ хэнтэй, яаж ашиглаж олборлохоо өөрсдөө мэдэхээр болсон. Засгийн газраас асуугаад байх шаардлагагүй, зөвхөн бодлогыг нь баримтлаад явж болно. “Хоёр толгой”-г ч ийм байдлаар шийдчихсэн бол Монголын Засгийн газар Путин гуайд ч, Ху Жинтао гуайд ч загнуулж дарамтлуулахгүй амар байх байлаа.

*Бизнес таймс сонин,  
2011 он, №16/654*

## ХОЁРДАХЬ “ЭРДЭНЭТ” БОЛЖ МЭДЭХ ТАВАНТОЛГОЙД БҮГД ОЧИЖ БАЯСААД Л... ЯМАР ХЭРЭГТЭЙ ЮМ БЭ

МУХАУТ-ЫН ДАРГА, ГАВЪЯАТ ЭДИЙН ЗАСАГЧ С.ДЭМБЭРЭЛТЭЙ  
МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ТУХАЙ  
ЯРИЛЦЛАА.

**- Манай улсын хөгжлийн хөдөлгөх хүч, эдийн засгийн үндэс суурь нь уул уурхай гэдэгтэй та санал нэг байна уу. Сүүлийн 23 жил бид уул уурхайгаар, дэлхий ертөнц Монголоор амьсгалж байх шиг?**

- Бид хөгжлийн бодлогоо цоо шинээр гаргаж ирэх шаардлагатай болсон байна. Олон жилийн “хур хог” гэдэгтэй адил манай нийгэмд хуримтлагдсан, шийдвэрлэвэл зохих асуудал маш их байгаа. Монголын нийгмийг өнөөдөр хүн талаас нь авч үзвэл олонхи нь өвчин хуучтай, амьдарч байгаа орчин нь өдрөөс өдөрт улам муудсан ийм л дүр зураг харагдаад байна. Дээр нь нийгмийн “амьтан” талаасаа ажил хийх сонирхолгүй, бэлэн мөнгө тосоод сууж байдаг хүн дэндүү гэмээр олон болж, хөдөлмөрийн насны 40 мянган залуу Солонгост очиж, хөлс хүчээ мөлжүүлэхээр бүртгүүлж байна. Ийм хачин нийгэм бүрэлдчихээд байхад манай Засгийн газрын болон УИХ-ын гишүүд Тавантолгойд бөөнөөрөө очоод тууз хайчилж, томоохон ёслол үйлдээд байгааг би ер ойлгоогүй. Улсын нэг үйлдвэр хэдэн тонн нүүр экспортод гаргаа л биз. Анх удаа нүүрс гаргаж үзэж байгаа юм уу, хаашаа юм бэ. “Энержи ресурс”, бага Тавантолгой гээд олон газраас өчнөөн тонноор нь зөөж л байсан шүү дээ.

**- Та үүнд тэгтэл их ач холбогдол өгөхгүй байгаа юм байна. Өмнө нь хувийн хэвшлийн компаниудын зөөж байсан нүүрсийг бодвол төрийн өмчит аж ахуйн нэгжийн экспортолж эхэлсэн нүүрс илүү үр өгөөж өгөх юм биш үү. Олон нийтийн хувьд?**

- Зарчмын ямар ч ялгаагүй. Цаашид ил тод биш, улстөржсөн байдлаараа хоёрдахь “Эрдэнэт” ч болж мэдэх “Эрдэнэс Тавантолгой” дээр бүгд очиж баясаад л, сайхан үг хэлээд л... Ямар хэрэгтэй юм бэ. Уул уурхай төдийгүй эдийн засгийн аль ч салбарт төрийн оролцоотой байх, энэ хувь хэмжээ нэмэгдэх нь аюултай гэж бид ч, гадна дотнын хүмүүс ч хэлээд байгаа. Намууд амлалтаа биелүүлэх, бүх нийтээрээ жаргалтай хувьцаат нийгэм байгуулах мөнгийг олж эхэлсэндээ баясч байгаа юм байх. Энэ “Эрдэнэс Тавантолгой”-гоос өмнө нүүрс болон бусад эрдэс баялаг олборлож, экспортолдог компаниуд татвараар хангалттай мөнгийг улсын төсөвт төвлөрүүлдэг байсан, одоо ч өгч байгаа. Ер нь энэ бүхнээс хараад байхад манайхны хөгжлийн тухай сэтгэлгээ маш хуучинсаг, социализмын үеийн тэгшитгэн хуваарилах зарчим руу хандаад байна. Уг нь ардчилсан нийгэмд хүн бүрийн хүсэл эрмэлзэл, боловсрол мэдлэг, сонирхолд тохирсон төрийн бодлоготой байх ёстой юм. Төмөр зам, уул уурхай, тэр алт, зэс яахав, маргаашийн асуудал. Гэтэл өнөөдөр хүний эрүүл мэнд, боловсролд оруулдаг бүтээн байгуулалт маш чухал болжээ. Өнөөдөр иргэн, хувь хүний эрүүл мэнд илт муудаж, нийгмээс хүртдэг суурь үйлчилгээ маш их хоцрогдчихож. Түүнийгээ гаднын байгууллагын хандив, тусламжаар чадан ядан нөхөж байна. Одоо нийт хүн амын 40 хувь нь ядуурлын төвшинд амьдарч, аргаа барсан залуус Солонгосыг зорих гэж өдөр шөнөгүй бүртгэлд нь дугаарлаж байх юм. Бид эрдэмтэн мэргэдийг гадаад руу дүрвэхийг “оюун ухаан дайжих” гэж тодорхойлдог байсан. Гэтэл монгол хүн яагаад эх нутгаасаа дайжиж байна вэ. Иймэрхүү байдлын учир шалтгааныг тодорхойлж, мэдэж байж хөгжлийн ирээдүйн бодлогоо боловсруулахгүй бол байгаль экологи, монгол хүний амьдрах орчин, эрүүл мэнд, амьдрах хүсэл эрмэлзэл “будaa” боллоо. Гэтэл уул уурхайн салбар дахь Голланд өвчин, эрдэс баялгийн халуурал манайд бодит зүйл болчихоод байна.

**- Та их бухимдалтай байх шиг. Наадмаар олигтой амарч чадаагүй юмаа даа?**

- Харин ч наадмын тэр олон хоногийн амралт надад сайхан боломж олгосон. Би баахан тоотой “ноцолдож” амарлаа. Энэ статистик тоонуудаас их юмыг олж харсан. Одоо энэ уул



уурхайтай холбогдоод усны тухай том асуудал гарч ирэх нь. Өнөөдөр явуулж байгаа манай төрийн бодлого дэлхий дахин аль эрт татгалзаж эхэлсэн “хүрэн эдийн засаг”-ийн арга замаар яваад байна. Тавантолгой, Оюутолгойгоос багагүй мөнгө хөрөнгө орж ирж байгаа ч тэр Ханбогд, Цогтцэций сум нэг хувийг нь ч ашиглах эрхгүй Сангийн яамыг хараад сууж байна. Гэтэл экологийн сүйрэл говийн бүсийг нэлэнхүйд нь хамарч, харагдаж мэдрэгдэж эхэллээ. Улаанбаатарт утаагүй зуух, ямар түлш ч гэнэ вэ. Баахан юм ярьдаг. Түүнийг нь авах хүн ховор шүү дээ. Нийслэлийн газрын хөрсний бохирдол л гэнэ. 140 мянган жорлон, муу усны нүх байна. Түүнийг багасгах санаатай “био 00” энэ тэр гээд санал санаачилга гаргаад юм хийх гээд үзээд байдаг. Нийслэл үүнийг чинь дангаараа шийдэж хийж чадахгүй ээ. Өдөр тутамд тулгамдсан жижиг гэмээргүй ийм ажил зөндөө байна. Гэтэл төр, засгийн томчууд нь тэнд нүүрсний тортогт булагдаад тууз хайчлаад явж байж таарах уу. Хүний хөгжлийн асуудал маань төмөр зам, уул уурхайн хөгжлөөс дор байх ёсгүй л санагдах юм.

**- Банк, санхүүгийн асуудал улс орны эдийн засгийн нэг гол тулгуур болох нь зайлшгүй. Сүүлийн үед Төв банкнаас арилжааны банкуудын дүрмийн санг хоёр дахин нэмэгдүүлэх чиглэл өгсөн. Үүнийг та хэрхэн үнэлж дүгнэж байгаа вэ?**

- Тэгж болно. Нэг хэсэгт нь зээл авахад амар болох биз. Ерөнхийдөө гаднаас эрчимтэй орж ирж байгаа томоохон төслүүдийн хөрөнгийг шингээх чадварыг нэмэгдүүлэхийн тулд банкуудыг томруулах талаар ярьж байсан санагдана. Түүгээрээ болсон нь тэр байх. Гэтэл Төв банк бодлогын хүү, заавал байлгах нөөцийн доод хэмжээг нэмэгдүүлэхээр шахаж шаардаж байснаас биш арилжааны банкуудыг томруулах талаар ямар ажил хийсэн юм бол. Тэднийг ингэж хүчээр нэгдэхээс өөр байдалд оруулахгүй байж болохгүй байсан юмуу гээд олон асуулт гарна. Үүнд хариулт өгч чадах УИХ-ын гишүүн олон бий. Ганцхан энэ асуудлаас харахад манай эдийн засгийн ерөнхий болон хөгжил рүү хандах макро бодлого маш буруу явж байна. Үүнийг 2012 оны сонгуулиар өөрчлөхгүй бол цаашдаа улс орны хувьд үүний дотор байгаль экологи, хүний эрүүл мэнд, хөгжлийн хувьд маш түгшүүртэй он жилүүд байх болно. Энэ талаар “Монголын хүний хөгжлийн илтгэл”-д тодорхой дурдсан байна билээ.

**- Хүний хөгжлийн сангаас иргэн бүрт олгож байгаа 21 мянган төгрөгийн тэтгэмжийн талаар олон нийт янз бүрийн л санаа бодолтой байдаг. Та бас л сөрөг байр суурьтай явна уу?**

- Уг нь энэ сангийн байгуулагдсан анхны санаа нь Аляскийн сангийн адилаар хүний хөгжлийг дэмжихэд чиглэж байсан юм. Үүнийг одоо зээлийн хөрөнгөөр санхүүжүүлээд иргэдийг тэжээхэд зориулж байна. Бүр цаад утгаараа олон нийтийг дуугүй байлгах, бэлэнчлэх сэтгэлгээнд сургах улс төрийн сонгуулийн зорилготой мөнгө болчихож. Үүнийг зарим нь хэрэгтэй мөнгө гэж хэлдэг. Гэтэл би хэд хэдэн аймагт Хүний хөгжлийн сангийн мөнгө тараасны дараахь байдалтай тааралдаж байсан. Тийм өдөр архи, согтууруулах ундааны борлуулалт нэмэгддэг гэж бизнес эрхлэгчид хэлдэг.

Одоо энэ оюутанд олгох тэтгэлэг үүний нэг хувилбар болох байх. Их, дээд сургуульд суралцагчдын 15 хувийнх нь ар гэр сургалтын төлбөрийг нь төлөхөд хэцүү, амьдрал ядуу өрх байдаг гэсэн судалгаа үзлээ. Тэдэнд энэ тэтгэлгээ олгох хэрэгтэй. Бусдад нь сурлагын чанарыг харгалзан олгодог байхад болохгүй нь юу байхав.

**- Монгол Улсыг нэг айл гэж бодвол өрхийн дотор уул уурхай дангаар ноёлох байр суурьтай болж байна. Нөгөөх эдийн засаг олон тулгууртай байх ёстой гэдэг онол сургаалын эсрэг бид ганц хөлтэй, тэр нь хаа хамаагүй дураараа туучдаг л болох гээд байх шиг?**

- Уул уурхай гэдэг “хүүхдийнхээ” барааг борлогдож байгаа юм гээд хамаагүй зараад байж болохгүй. Манай гэрийг тэжээж байгаа нь энэ гээд тахин шүтэж бүр ч хэрэггүй. Яагаад гэхээр эдгээр томоохон төслүүдийг хэрэгжүүлж, маш их мөнгөтэй болох байлаа ч цаана нь нийгмийн амьдрал, байгаль экологи, ядуурал хүлээж чадахгүй. Тэдэнд тийм цаг хугацаа байхгүй бүр мөсөн сүйрчих гээд байна. Иймд үлдсэн “хүүхдүүдээ” ч адилхан авч явах ёстой. Та нар тэсч бай, уул уурхайгаар хэдэн цаас олоодхоё гээд бусдад нь амь зогоох төдий чимх юм өгч байгаатай л адилхан бодлого бариад байна шүү дээ. Үлдсэн “хүүхдүүд” нь тахир дутуу ч юмуу өвчин хуучтай болчихвол энэ айллыг “эрүүл бус өрх бүл” гэж нэрлэхээс аргагүй. Бид ийм ил болчихгүйн тулд ганц “хүүхдээ” харах, шүтэх биш нөгөөдүүлтэйгээ санал бодлоо хуваалцдаг, нэгнийгээ дэмжиж тэтгэдэг, ил тод байдаг ийм л зарчмаар ажиллах ёстой. Манайд ийм л бодлого дутаад байна гэж боддог. Уг нь хүүхдээ алагчилдаг айл байдаггүй л байхгүй юу. Уул уурхайн томоохон төслүүдийн хувьд төр оролцохгүйгээр дотоодын компаниудын консерциум, мэргэжлийн холбоодод эрхийг нь өгч тендерийн шалгаруулалтыг явуулж, төр бодлогоо танилцуулаад гаднаас нь хараад сууж байх хувилбар байсан. Одоо ч бий. Харин тэд хүсэхгүй байна.

- Та ногоон хөгжил гэж нэлээд хэдэн жил ярьж байна. Үүнийг товчооноор тодорхойлбол юу гэж ойлгож болох вэ?

- Энэ бол айх аюулгүй, тоос шороогүй, элдэв харшилгүй, үр хүүхдэд маань хүссэн, чадах хэмжээний нь боловсролыг олгочихдог, хүмүүст би хичээвэл маргааш гайгүй болно гэсэн амьдрах итгэл, эрмэлзэл төрүүлсэн тийм л орчинг бүрдүүлэхийг хэлээд байгаа юм. Үүнд төр засаг нь бодлогоо чиглүүлж, энэ орчинг бүрдүүлэхэд хувь хүн, аж ахуйн нэгж, төрийн болон ТББ-ууд нь “мах цусны тасархай” мэт санаа сэтгэлтэйгээр оролцох учиртай. Ер нь Монголын эдийн засаг “ногоон эдийн засаг”-руу замнах цаг нь эрт болчихсон байна.

*Д.Мөнхжаргал, Үндэсний шуудан сонин,  
2011 он, №183,1207*

## ТӨР БИЗНЕСМЭН БОЛЧИХООД КОМПАНИУДАЙ ӨРСӨЛДӨӨД БАЙДГАА БОЛИХ ХЭРЭГТЭЙ

Улс орныг эдийн засгийн хямралаас гаргах, цаашлаад эдийн засгийг эрчтэй хөгжүүлэх, Оюутолгой гээд цаг үеийн асуудлыг шийдэхэд төр засгаас ямар бодлого баримтлах нь илүү оновчтой байх талаар саналыг нь сонсохоор МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлтэй ярилцлаа.

- Засгийн газар энэ оныг “Үйлдвэржилтийг дэмжих жил” болгон зарласан. Энэ ажил хэр бодит ажил болж, хэр үр дүн гарч байна вэ? Бизнес эрхлэгчид зарим талаар ялангуяа банкны зээлийн талаар нэлээд шүүмжлэлтэй хандаад байх шиг байна?

- “Үйлдвэржилтийг дэмжих жил” гэдгийг ярихын өмнө манай танхим үйлдвэржилтийн газрын зураг гэж гаргасан. Монгол Улсын аль бүс нутагт ямар ямар үйлдвэр шаардлагатай байна гэдгийг санал асуулга авч байгаад анх удаа газрын зураг хэлбэрээр гаргасан. Үүнийг санхүүжүүлэхийн тулд зөвхөн банкны санхүүжилт төдийгүй альтернатив буюу зэрэгцээ хувилбар хэрэгтэй гэсэн санал дэвшүүлсэн. Ингээд засаг төр дуншиж дуншиж үйлдвэржилтийн жил гэж зарлаж, 30 тэрбум төгрөгийг энэ ажилд зарцуулахаар боллоо. Ингэхдээ 50 хүртэл сая төгрөгийг

жижиг дунд үйлдвэрүүдэд олгохдоо бидний таашаахгүй байсан санхүүжилт буюу банкуудаар дамжуулах хувилбарыг сонгосон. Бизнес эрхлэгчид гомдоллох нь аргагүй.

Нэгдүгээрт аль 2008 онд ярьсан юм 2009 оны эхний хагас жил дуусч байхад нэг юм тодорхой болж байна. Хоёрдугаарт мөнгөний хатуу бодлогоос болоод зээл өгөхөө больсон банкуудад дахиад нэмэлт эх үүсвэр санхүүжүүл гэхэд банкууд нэг их сонирхолгүй л байгаа болов уу. Яагаад гэвэл эрсдэл өндөр болсон, эх үүсвэр дутмаг байгаа. Тийм учраас банкууд шалгарсан төслүүдийг ямарваа нэг шалтгаанаар буцаах сонирхолтой байна. Угаасаа банк тэгдэг л байсан. Дээрээс нь дээрх нөхцөлд арилжааны чанартай банкууд хөгжлийн шинж чанартай санхүүжилтийг аль болох өөр дээр байлгах гэхээс нэмж зээл гаргах гэсэн хүсэл төрөхгүй л байх. Гуравдугаарт ерөөсөө Монгол Улсын жижиг дунд үйлдвэрт байдаг барьцаа хөрөнгөний дутагдал. Барьцаа хөрөнгийг үнэлэхдээ бодит үнээс хоёр дахин доогуур үнэлдэг. Барьцаа хөрөнгө нь ч дутагдалтай байдаг. Зээлийн баталгаа гаргадаг систем танхимаас өөр газар хаана ч байхгүй. Танхим баталгаагаа гаргаад 400 сая төгрөгийн эх үүсвэрээ тараачихсан. Тэрний эргэн төлөлт арай болоогүй байна. Иймэрхүү шалтгаанаас болоод 2009 оны наймдугаар сараас эхэлж байгаа үйлдвэржилтийн жил ерөнхийдөө жилийн эцэст нэг их сайн олигтой үр дүн гарахгүй байх.

**- Санхүүжилтийг ямар хэлбэрээр хийвэл оновчтой байсан бэ?**

- Бид альтернатив санхүүжилт хийе гэсэн. Нэг хэсгийг нь танхимаар дамжуулж, нөгөө хэсгийг нь мөнгөний бодлогоо зөөллөх замаар хийх. Мөнгө их байгаа учраас инфляци өсч, хямрал болоод байсан юм биш. Мөнгө угаасаа л байнга хэрэгтэй. Одоо бол бүр их хэрэгтэй байна. Банкны салбарт өрсөлдөөн бий болгох замаар энэ төрд байгаа мөнгөний нөөцийг арилжааны банкуудад байршуулаад, бодит сектор буюу жижиг дунд үйлдвэрийг зээлжүүлэх, ингэхдээ заавал хууль энээ тэрээ гээд байлгүй зээлийн баталгааг манай танхимын баталгаан дээр тулгуурлаад хийсэн бол өдийд бодит сектор шоргоолжны үүр шиг бужигнаж байх байсан. 2009 оны нэгдүгээр сард танхим хямралын эсрэг эдийн засгийг идэвхжүүлэх төлөвлөгөө гаргаж УИХ, Засгийн газарт өгсөн. Энд нийлүүлэлт, эрэлтийн талд ямар ямар арга хэмжээ авах талаар маш тодорхой дугаарлаж байгаад тусгасан байгаа. Энэ бүхнийг харгалзаж үзсэнгүй, харгалзаж үзэх соёл ч байсангүй.

Ажлын хэсэгтээ оруулсан болоод л явж байгаа нь энэ. Гэхдээ цаг оройтоогүй байна. Энэ үлдэж байгаа саруудад мөнгөний бодлогод өөрчлөлт оруулаад, ээлжит бус чуулганаар зөвхөн Оюултолгой биш, Монголын эдийн засгийн хямрал ямар байна, бодлогын ямар засвар хийвэл эдийн засаг идэвхжих нь вэ? барилгын салбарт хуримтлагдсан өр зээлийн хямралыг яаж давах вэ? гэсэн асуудлыг ярих хэрэгтэй гэж бодож байна. Танхимаас “Заяагдмал нөөцийн олдмол хам шинж ба хөгжилд хүрэх зөв замын тухай” 10-аад зүйлтэй маш тодорхой санал гаргасан. Монголын нийгэмд сүүлийн үед бий болсон ашигт малтмалын нөөцийг тойрсон нийгмийн хийрхэл гэж болох гаж үзэгдэлд дүгнэлт өгөөд ийм нэртэй Дийгмийн өвчин байна гэж дүгнэж байгаа юм.

**- Мөнгөний хатуу бодлого бариагүй бол инфляцийг барьж чадахгүй байсан гэсэн тайлбар хэлж байгаа шүү дээ?**

- Яст мэлхий шиг засаглалын удаан технологи, дээр нь банкны секторт банкуудын буруугаас биш, мөнгөний бодлогын буруугаас болоод банкууд зээл өгөх сонирхол багасчихсан байгаа. Нөгөө талаар бид хэдийгээр шүүмжилдэг байсан ч банкууд рекламдаж байгаад жижиг дунд үйлдвэрийн бизнест зориулсан зээлийн багц гээд л овоо өрсөлдөөд, зээлийн хүү нь ч зах зээлийн журмаар бас овоо багасч байсан. Гэтэл энэ бүх процессийг таслаад мөнгөний хатуу бодлого нэр дор банк ба бизнесийн хооронд байдаг амьд орчлыг тасалчихсан. Үүнийгээ юу гэж зөвтгөдөг вэ гэвэл “хэрэв бид мөнгөний хатуу бодлого бариагүй бол Монгол Улс сүйрэх байсан. Бид валютын ханшийг тогтворжуулж байж, инфляцийг барьж чадлаа” гэсэн юм хэлдэг.

Энэ тухай 2009 оны гуравдугаар сард сонины бүтэн нүүр материал бүх сонинд нийтлүүлж, тэрэн дээрээ “тэртэй тэргүй унаж байгаа хувийн хэвшил” гээд албан ёсоор биччихсэн байгаа. Төв банк нь хувийн хэвшлийг унаж байгаа гээд зөнд нь орхисон улс орон хаана ч байхгүй. Тэр тусмаа хямралтай энэ үед Төвбанк харин ч хувийн хэвшлээ хамгийн идэвхтэй дэмжиж, хамтран ажиллаж, хямралыг боломж болгохоор ажиллах хэрэгтэй. Гэтэл үүнийг нь Засгийн газар нь ч, УИХ нь ч тоохгүй юм. Тэгсхийж яваад гайхамшигтай наадмууд эхэллээ. Тэр наадмууд хэзээ нэгэн цагт дуусна биз. Эдийн засгийн байдал нэлээн тааруу болоод байна. Бизнесийн сектор бартерийн харилцаанд орчихсон, бартерт авч өгөлцөг зүйл нь ч багасаад ирлээ. Барилгын салбарт гэхэд 380-аад орон сууц зогсчихлоо. Барилгын салбарынхан аргаа тасраад Монголын түүхэнд байгаагүй жагсаал анх удаа хийлээ. Иймэрхүү

байдалтай эдийн засгийн хүндрэлтэй үед УИХ-ын гишүүд нь ч, ерөнхий сайд нь ч амардаг юм байна.

**- Танай танхим эдийн засаг, бизнестэй холбоотой хууль тогтоомжуудад дүн шинжилгээ хийж байгаа гэсэн?**

- ХЗДХЯ, Германы техник туслалцааны хамтын ажиллагааны нийгэмлэг, МҮХАҮТ, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо хамтран Монгол Улсад мөрдөж байгаа бизнес эдийн засгийн хууль тогтоомжуудад дүгнэлт хийхээр “Их цэвэрлэгээ” кампанит ажил өрнүүлж байна. Гол нь эдийн засаг дахь тоглоомын дүрмийг өөрчилье, хуулиар далимдуулж бизнест ордог төрийн хэт их оролцоог багасгах гэсэн зорилготой. Эдийн засаг, бизнесийн чиглэлийн 80-аад хуульд анализ хийгээд, багасгах, өөрчлөх, хүчингүй болгох зэрэг саналаа УИХ-д хүргүүлнэ.

**- Үл хөдлөх хөрөнгийн барьцаатай холбоотой хуулиуд батлагдаж байгаа? Энэ хуулийг элдвээр шүүмжилж байна. Таны хувьд ямар бодолтой байгаа вэ?**

- Манайх энэ хуульд тодорхой саналаа өгсөн. Барьцаалагч, барьцаалуулагчийн хоорондын тэгш, шударга харилцааг бий болгох хэрэгтэй. Энэ намрын чуулганаар батлагдах байх. Хуультай болсноор ипотекийн орчин гайхалтай хөгжөөд байна гэж байхгүй. Ямар ч байсан хууль эрх зүйн орчин нь бүрдэнэ. Банкууд бизнес эрхлэгчидтэй хийж байгаа зээлийн гэрээ олон улсын эрх зүйн нэг зарчмаар бол талуудын тэгш байдлыг хангаж өгөх ёстой байдаг. Жишээ нь: Үер усны гамшиг болсон ч мөнгөө төлнө шүү гэсэн заалт гэрээндээ заачихсан. Зээл авах хүмүүс нь мөнгөө авахын тулд зөвшөөрч таардаг.

Ипотекийн талын хууль дээр ч зарим банканд барьцаалагч этгээдийн эрх мэдлийг дэндүү товойлгоод тавьсан зүйл байсан. Энэ бүхэнд саналаа өгсөн. Гэхдээ батлагдаад хэрэгжээд ирэхээр харагдах байх. Ер нь аливаа хууль хэрэгжээд ирэхээрээ л харагддаг шүү дээ.

**Тухайлбал:** татварын реформ хийсэн гэдэг. Гэтэл эцсийн дүндээ Татварын ерөнхий хууль дээр нэг зүйл орхигдуулчихсан байгаа. Процессын талыг реформын чиглэлтэй оруулсан. Татварын ерөнхий хуульд татвар төлөгч ба татварын байгууллага хоорондын эрх тэгш байдлыг хангаж чадаж байна уу? дэндүү субъектив хүчин зүйл, татварын байцаагчаас дэндүү хамаарч байна уу гэдгийг бид судалж шинжилж байна.

**- Намуудын амлаад байгаа 1.5, нэг сая амлалтыг ямар хэлбэрээр өгвөл зүгээр вэ?**

- Ерөөсөө огт өгөх хэрэггүй гэж бодож байна. “Заяагдмал нөөцийн олдмол хам шинж” гэж би яриад байгаа. Энэ нэг юм сануулж байгаа биз. Дархлал дутагдлын олдмол хам шинж гэдэг дээ. Тэгэхээр Монголын нийгэмд бий болсон “Заяагдмал нөөцийн олдмол хам шинж өвчин”ий нэг шинж тэмдэг нь алаагүй баавгайн арьсыг аль хэдийн социалист байдлаар тэгш хуваарилах зарчмаар ард түмнийг системтэйгээр дээрээс нь сатааруулж, ингэсний үр дүнд ард түмэн нь төр лүү харах, төрөөс хүсэн хүлээх, хишиг горьдох ийм психологийн орчинд орж байна. Нийгмийг ийм байдалтай болгож байгаа нь ард түмнийг идэвхгүй болгож, гүйх хүсэх, дээшээ харах байдалд хүргэж байна.

**- Оюутолгойн гэрээг хэлэлцэх явцад 68 хувийн татвар гол гацаа болчих шиг боллоо. Үүнээс болж УИХ-ын ээлжит бус чуулган хуралдуулах төлөвтэй байгаа? 34-51 гэсэн хувь, 68 хувийн татвар гэдэг дээр таны санал ямар байгаа вэ?**

- Ээлжит бус хурлыг хуралдуулах ганц л шалтгаан бий. Нэгд, эдийн засгийн хямралын эсрэг цаашид ямар арга хэмжээ авах вэ? Хоёрт эдийн засгийн хямралын эсрэг цаашид ямар арга хэмжээ авах вэ? Гуравт эдийн засгийн хямралын эсрэг цаашид ямар арга хэмжээ авах вэ? Нэг шалтгааныг би зориуд гурав дахин хэлж байна. Түүний дараа барилгын секторын асуудлыг яаж шийдэх вэ? Оюутолгойг яах вэ гээд ярих. Түүнээс биш өвчтэй юм шиг 4-5 жил гацаачихаж болохгүй ш дээ. Ард түмэндээ 51 хувийг нь ч гэсэн аваад өгчих юмсан, тэгээд л үхэх юмсан, тэгэхгүй бол хохирчих гээд байна гээд байдаг. Тэгсэн мөртөө цаанаа улс төрийн бүлэглэлүүдийн тэмцэл явагдаж байна. Тэр тусмаа хариуцлагаа хүлээж байгаа Засгийн газар байх үед нь гэрээг яаралтай байгуулах ёстой. Гэхдээ Оюутолгойг эзэмших “Айвонхоу майнз” компанид ч үг хэлэх хэрэгтэй.

“Өнөөдөр Монголд хандах та бүхний хандлага буруу байна. Та бүхэн захиа бичээд, эсвэл нэг суманд хэдэн Жийп авч өгөөд байгаа чинь буруу байна. Орчин үеийн хөрөнгийн биржид бүртгэлтэй сайн компани, сайн засаглалыг хэрэгжүүлэх компани байх ёстой. Тухайн хөрөнгө оруулж байгаа улс орондоо сайн засаглалын шинжүүд болон компанийн нийгмийн хариуцлагын шинжийг улс орон даяар харуулсан тийм компани байх ёстой”. “Айвонхоу майнз” гэдэг компанийн “Компаний нийгмийн хариуцлагын илтгэл”ийг би интернэтээс хайгаад олоогүй. Хийдэггүй юм шиг байна. Нөгөө талаас “Айвенхоу майнз” гэсэн нэртэй Виржина аралд бүртгэлтэй тийм компани байдаг юм байна. Гэх мэт эргэлзээтэй зүйл олон байна. Хамгийн гол нь энэ компанийг удирддаг Роберт Фрийдланд

гэдэг хүн Нью-Йоркт ч юм уу, Торонтод ч юм уу хөрөнгө босгохын тулд хөрөнгө оруулагчидтай Монголын тухай ярьж байгаа, Монголд хандаж байгаа байдлыг нь харахад үнэхээр бизнесийн соёлгүй, хөгжиж байгаа Африкийн хаа нэг газар авлига хээл хахуультай Засгийн газартай яриад сурчихсан тийм байдалтай хандаж байна. “Монгол бол амархан орон” ч гэх шиг. Юу юу ч гэлээ.

Хэрэв Монгол улсад хөрөнгө оруулах гэж байгаа бол удаан хугацаанд оршин тогтнож, энэ улс нийгмийн нэг эд эс нь болоод явах учраас энэ нийгэмд тулгарч байгаа сорилтууд, нийгмийн асуудлыг шийдэхэд оройлон оролцож, ингэсний дүнд Монголын ард түмний итгэлийг авах юм бол энэ компанийн хамгийн зөв бодлого болно. Энэ талаар энэ компани үнэхээр ажиллаагүй. Зүгээр нэг Ханбогд суманд хэдэн Жийп авч өгсөн, нэг сургууль засч өгсөн гэдэг нь сонин биш.

Нөгөө талаасаа 34, 51, 68 гэсэн гурван тоо л ярьж байна. 34, 51 гэдэг бол утга муутай зүйл. Үндсэн хуульд газрын доорх баялаг бол Монголын ард мэдэлд байна гэж маш тодорхой заасан. Хууль эрх зүйн тапаас ард түмний мэдэлд байна гэсэн чинь ард түмний өмч гэсэн үг. Үүнийг аль ч улсын хөрөнгө оруулагч ойлгож байгаа. Ард түмний мэдэлд байгаа хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах гэсэн хэлбэрүүдэд хувийн хэвшил Засгийн газрын түншлэлийн арга, концессийн арга гэх мэт төрөл бүрийн хөрөнгө оруулалтын арга бий. Үүн дээр суурилан нөгөө компани чинь хөрөнгийн бирж дээр хөрөнгө босгоно. “Та миний пиджакийг түр авчээ. Гэхдээ миний хэвээрээ л байгаа учраас өөр хүнд өгч болохгүй шүү. Та түр хугацаагаар ашиглаж бай”. Яг тэрэнтэй адилхан. Ард түмний өмчлөлийн эрхийг УИХ, Засгийн газар хадгалж явна. “Би энд ажилтай, завгүй байна. Ногоо тарьж байна гээд” иргэд гараа өргөөд сонгочихсон.

Өмчлөх эрх мэдлээ дамжуулаад өгсөн болохоос өмчлөх эрх нь хэвээрээ байгаа. Тэгэхээр Засгийн газар цаашаа хөрөнгө оруулагчидтай яриад явах ёстой. Энэ тохиолдолд 34, 51 хувийг авна гэж байгаа. Үүнийгээ “Ийм жишээ байна шүү дээ. 51, 49 хувьтай Эрдэнэт гэдэг” гэж их гоёор зөвтгөдөг л дөө. Хэрэв үнэхээр сайн жишээ юм бол яагаад засаг солигдох болгонд Эрдэнэтийн даргыг солихын төлөө, энэ суудлын төлөө, эдний импортоор оруулж ирдэг юмны төлөө бүгд тэмцэлдэж, гүйдэг юм бэ. Сайн жишээ мөн үү. Биш л байгаа байхгүй юу? Ийм тохиолдолд 34, 51 гэлгүй орчин үеийн эрдэс баялгийн ил тод сайн засаглалтай, компанийн нийгмийн хариуцлагыг сайн өрнүүлсэн энэ компаниуд дотоодын болон гадаадын компаниудад хөрөнгө оруулах орчныг

бүрдүүлж өгөх, энэ орчныг бүрдүүлэх явцдаа бүх төрлийн татварыг сунайтал авах хэрэгтэй.

Манай танхимын байр суурь эрдэс баялгийн салбарт төрийн авторитор дэглэм тогтож болохгүй. Зөвхөн Ерөнхийлөгч нь бүх юмаа мэддэг зарим нэг орон байдаг. Нэрийг нь хэлэхээ больё. Тийм орон шиг болох гээд байгаа юм уу, эсвэл эрдэс баялгаа хөгжлийн төлөө зориулах гээд байгаа юм уу гэдэг талаасаа сайн бодох хэрэгтэй. Нөгөө талаар яг одоо Оюутолгойн хувьд нэг асуулт өөрсдөөсөө асуух хэрэгтэй. Говийн дор байгаа гүний ус энэ аймгийг хэдэн жил тэжээх вэ? Оюутолгой ашиглалтад ороод секундэд хэдэн шоо метр ус ашиглах вэ? гээд. Асар их ус ашиглахтай төсөл явж байгаа. Экосистемийг тэр чигээр нь гэмтээн говьд хүн амьдрахын аргагүй, цаашлаад Монголын нийт экосистемд гүний усны дутагдал бий болгож, Монголыг усны гачаалд оруулах түгшүүрийн харанга 2020 биш 2030 биш, 2010 оноос хойш гарах гээд байна. Би заримдаа Өмнөговийн ард түмнийг азгүй гэж боддог. Үүнийг бодож байгаа юу?

Гол мөрөн ширгээд эхнээсээ усны асуудал тулгараад ирлээ. Ийм юм болно гэдгийг чинь манай наймдугаар Жавзандамба гээд хутагтууд хэлчихсэн. Пүрэвбат бурханч лам “Ирээдүйд иш үзүүлэгч бошготууд” гэсэн номондоо биччихэж. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга сая Монголд айлчлахдаа цаг агаарын дулаарлын талаар онцгой анхаарах тухай тодорхой юм хэллээ. НҮБ өөрөө “Ногоон эдийн засгийн санаачилга” гуравдугаар сард гаргасан. Иймэрхүү байхад ганцхан ашигт малтмал, эрдэс баялгийн салбар манай хөгжлийн эх үүсвэр гэж байгаа нь утгагүй санагдаж байна. Улс орны нөөц байгаа юм бол Оюутолгой, Тавантолгойг ашиглаж эхлэх хэрэгтэй. Магадгүй 2015 оноос, 2020 оноос хойш дэлхий дээр нөөц баялаг дээр суурилсан хөгжлийн загвар арилсан байж болно. Маш олон шинэ хувилбар гарч ирж байна. Экологи, дулаарлын асуудлаа бодож байхгүй бол зөвхөн энэ хоёр тал руугаа хөлжөөд сайхан амьдралаа гэдэг бол хамгийн гэнэн бөгөөд хортой асуудал.

**- Компанийн нийгмийн хариуцлага гэж нэлээн ярих болсон. Үүнийг хуульчилчихвал яасан юм бэ?**

- Үүнийг хуульчлах ямар ч шаардлагагүй. Ёс суртахууны ч асуудал биш. Зүгээр компани хөгжих шинэ философи л гарч ирж байна. Урьд компанид байгаль орчин, нийгмийн тулгамдсан асуудлыг огт хайхардаггүй, зөвхөн ашгийг максимум зорилтоо болгож тавьдаг байсан бол одоо байгаль орчноо хордуулдаггүй, ээлтэй технологи бий болгох, нийгмийн тодорхой асуудлыг

шийдэн зах зээлээ улам тэлэх замаар хөгжиж болох юм гэсэн шинэ философи гарч ирж байгаа юм. Тэрнээс биш аль нэг дүүрэгт юм хандивладаггүй компанийг “Компанийн нийгмийн хариуцлага”-гүй компани гэж хэлж болохгүй. Сүүлийн үед “Алив чи нэг юм хандивлаач. Компанийн нийгмийн хариуцлага шүү” гэх юмуу эсвэл нэг спортын аливаа үйл явдлыг ивээн тэтгээч гэх гээд байдаг болсон. Ингэснээрээ компанийн нийгмийн хариуцлага бий болж байгаа юм биш. Хүн, гараг ертөнц, ашиг гэсэн энэ гурван зүйлийн /гурван Пигийн/ нэгдэл юм. Дэлхий дээр энэ талаар компаниуд бүр тусдаа илтгэл бичдэг болсон. Би түрүүн хэлсэн дээ. “Айвенхоу майнз”-д ийм илтгэл байдаггүй юм байна билээ. Цаашдаа гарах байх гэж найдаж байна.

**- Засгийн газар төрөл бүрийн хөтөлбөр гаргадаг. Зарим нь хэрэгжихгүй, зарим нь бүр сураг тасарчихдаг. Хөтөлбөрөө цагаа олохгүй гаргаад байна уу? Хэрэгжүүлэх аргаа олохгүй байна уу?**

- Тулгамдсан асуудалд нийгмийн болон бизнес эрхлэгчдийн анхаарлыг илүү хандуулахын тулд төрөл бүрийн хөтөлбөр гаргаж байгаа юм. Аливаа юм хийхэд оролцоон дээр суурилах ёстой. Тэр хөтөлбөрүүдэд бүгдэд нь байдаг нэг үндсэн дутагдал гэвэл маш гоё зорилго тавьсан хэрнээ сонирхол нь хөндөгдөж байгаа тэр хэсгээ татаж оруулах, санал бодлыг авах, өөрөөр хэлбэл “Итгэлт”-ийн хэлээр хүнээр ажил хийлгэх талаар манай засаглалын технологи нь хоцрогдсон. Социализмын үеийн дээрээс бүхнийг төлөвлөөд өөрснөө хийх гэж зүтгэдэг, төр өөрөө бизнесмэн болчихсон, төр өөрөө компаниудтай өрсөлдөөд байдаг ийм гажиг системээ солиод төр нь орчноо бүрдүүлж өгдөг, үгийг нь сонсоод, хамтарч ажилладаг засаглалын технологитой болохгүй байгаагаас олон хөтөлбөр, санаа цаасан дээр үлдэж байна. Тэрнээс биш хөтөлбөр дотроо зорилтоо буруу тавиад байгаа юм биш. Компани бүтээмж нь буураад байвал машинаа солих хэрэгтэй, ажилчдынхаа мэргэшлийг нь дээшлүүлэх хэрэгтэй. Ингээд бүтээмжээ дээшлүүлдэг. Тэрэнтэй адил засаг машинаа солих, ажил хийх технологио солих хэрэгтэй. Тэр технологи нь нь маш энгийн хүмүүсийг сонс, хүмүүсийн оролцоотой хүмүүсийн төлөө хүмүүстэй хамтраад юм хий.

**- Манайд ялангуяа банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэлээд их байх шиг байна? Гадаадын хөрөнгө оруулалт дээр бодох зүйл их байх шиг санагдаад байдаг юм?**

- Банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалт оруулахад болгоомжтой хандах хэрэгтэй. ОХУ гэхэд банкны секторт 50-аас

дээш хувь гадны хөрөнгө оруулалт ороод ирэхэд болгоомжлоод тодорхой арга хэмжээ авч байна. Монгол жижиг эмзэг эдийн засагтай орон. Гэхдээ л банкны сектор гадны хөрөнгө оруулалт хэрэгтэй. Ингэхдээ дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт хөрөнгө оруулалтыг баланслах ёстой. Унгар улс асар их реформ хийж байна гээд баахан хувьчлал явуулж, бүгдийг нь гадныханд өгөөд эцэст нь тэд нь орхиод л гараад явчихсан. Ер нь гадны хөрөнгө оруулалтыг тооны хувьд биш чанарт анхаарах цаг болсон. Өнгөрсөн 18 жил бид үүдээ цэлийтэл нээгээд гадаадын хөрөнгө оруулалтыг урьсан. Эргээд харсан чинь эмх замбараагүй болсон байна. Энэ гэрийн үндэсний шинж тэмдэг алдагдах гэж байна.

Нэг хэсэг оёдлын салбарт дурын хүн ирээд л хуучирсан машин авчраад юм оёод л байсан. Тухайн үед би шүүмжилж байлаа. Одоо өдөр нь 2, 3 алхаад л нэг шанаган тогоо, шөнө нь караоке ажиллаж, 14-16 насны охид ажиллаж байна. Гадаадын хөрөнгө оруулалтаар зарим тохиолдолд шинэ технологи орж ирэхгүй, технологийн түвшин доогуур юм орж ирж байна. Өнөөдөр 10 мянган доллартай бол орж ирээд л нэг юм түрээслээд, эсвэл Солонгосын комиссын бараа зарж байна шүү дээ. Бид Солонгост хуучин дээлний дэлгүүр ажиллуулж чадах уу? Тэгэхээр аль ч салбарт хөрөнгө оруулахад ямар босго байх вэ гэдэг ялгавартай бодлого бий байх ёстой. Тухайлбал, жижиглэнгийн салбарт гэхэд 500 мянган доллартай байвал хөрөнгө оруулж болно гэх мэт. Цаашдаа чанарыг дээшлүүлэх зорилгоор Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй. Бид 2009 оны эхээр энэ талаар саналаа өгсөн.

**- Барилгын салбарыг сэргээх ямар боломж байна вэ?**

- 60-аас дээш хувьтай барилгаа тоолох хэрэгтэй. Дараа нь ард иргэдийн худалдан авах чадвар хүрэх нэг, хоёр өрөө байрыг тоолох хэрэгтэй. Эдгээрийг барихад материал дутагдаж байгаа учраас мөнгө хүсээд байгаа. Тэгвэл Засгийн газар санаачлаад бартерийн харилцаагаар барилгуудыг дуусгах хэрэгтэй. Зарж борлуулах бол хоёрдугаар асуудал. Дууссан юмыг зарж болно. Өөр ямар ч арга байхгүй. Тэгэхгүй өнөөдөр бид мөргөж гэж нэг юм яриад, хууль батлаад ч хэрэггүй. Эсвэл банк хөрөнгө босгоно гэж хүлээгээд ч хэрэггүй. Банкууд зээл өгөхгүй. Юу гэж өгөх вэ дээ. Өөрсдөө хэцүү байгаа юм чинь. Яагаад хэцүү болсон гэхээр Төвбанк хэцүү болгочихсон. Тиймээс Ерөнхий сайд толгойлоод барилгын компаниуд, татвар, гааль, шүүх бүхтөрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл орсон ажлын хэсэг байгуулаад зөвхөн энэ цаг үед хэрэгжих онцгой схемээр ажиллахгүй бол

болохгүй. Үүний нэг тод жишээ байна. “Атрын III аян”, Засгийн газарт баталгаа гаргаж пад пад трактор авч өгөөгүй бол хүмүүс авч чадахгүй байсан.

Сүүний үйлдвэр ч гэсэн засаг авч өгөөгүй бол сэргэхгүй л байсан. Энэ бол төрийн зүгээс эдийн засагт орж байгаа интервэнц буюу хөндлөнгийн оролцоо. Энэнтэй адил арга л барилгын салбарыг сэргээнэ. Барилгын салбар уначихаад байхад банк хүү бодоод л байна. Гэтэл одоо бол хүү бодох эрх зүйн үндэслэл байхгүй. Буруу бодлогын улмаас барилгын компаниудаас өөрөөс нь болоогүй шалтгааны улмаас бий болсон нөхцөл байдал. Үүнийг олон улсад хүнд хэцүү нөхцөл гэж тодорхойлдог. Энэ хүнд хэцүү нөхцлийн тодорхойлолтыг танхим гаргаж өгнө. Барилгын компаниудад гаргаж өгч байгаа. Ингэснээр тэр компаниудыг зээлийн хүүгийн өрнөөс чөлөөлнө. Сая үер усны гамшиг болоход ногоо тарьсан хүмүүс өртсөн. Тэр хүмүүс “одоо яахав дээ, зээлээ төлдөг л байх даа” гэж ярьж байна лээ. Төлөх шаардлага байхгүй. Хүмүүс мэдэхгүй байна шүү дээ. Тэр хариуцлагаас чөлөөлөгдөнө. Яагаад гэвэл байгалийн гэнэтийн гамшиг болсон. Үүнийг хуулийн дагуу танхим гэрчилгээг нь гаргаж өгч байна. Өөр нэг жишээ. МАХН-ын байр шатсан. Тэгэхэд тэнд байсан компаниуд өртсөн. Энэ бол мөн л гэнэтийн гамшиг. Газар хөдлөлт, гал усны аюул ч гэх мэт. Энэ бүхнийг дэлхий дээр хөндлөнгийн байгууллага олгодог. Тэрэнтэй адил барилгын салбарынх гэнэтийн гамшиг биш ч гэсэн хүнд хэцүү нөхцөл буюу бодлогын өөрчлөлтөөс болж үүссэн хохирол. Банк үхчихгүй байх, барилгын компани үхчихгүй байх амь тариа хийх хэрэгтэй. Амь тариаг амь нь тасарсан хойно хийх хэрэггүй. Амьтай байхад нь хийх хэрэгтэй. Амь тариаг “-доктор” Ерөнхий сайд ажлын хэсэг байгуулаад хийх хэрэгтэй байна даа.

**- Чөлөөт бүс байгуулна гээд хууль журам нь гарчихаад нэлээн хэдэн жил боллоо. Бас л нэг их ахицгүй байх шиг байх юм?**

- Энэ тухай 19 жил, миний санаж байгаагаар бараг 30 жил ярьж байна. Тэгээд чөлөөтэй бүс байхгүй байна. Бямбасүрэн гуай Ерөнхий сайд байхдаа улс орноо чөлөөтэй бүс болгож, эдийн засгаа либеральчлая гэж байсан. Гэхдээ ийм жижиг эмзэг эдийн засагтай орон асар хурдан либералчлах хэцүү. Гадны нөлөө даадаггүй. Тухайн үед Энхсайхан импортыг тэглээд хэцүү байдалд орж байсан. Дараа нь Жасрай гуай 1994 онд чөлөөт бүсийн үзэл баримтлал гаргаж байсан. Тэрнээс хойш түүх үргэлжлээд л явж байна. Одоо яахав Алтанбулаг, Замын-Үүдэд тохирсон зам, Транзит Монгол хөтөлбөр гэх мэт юм ярьж л байна.

Дан ганц төр чадахгүй ээ. Манайх чөлөөт бүсэд 40 га газар авсан. Түүнийгээ компаниудад хуваарилж байгаа. Орос, Хятад гэсэн мөнхийн хоёр хөршийг холбосон, монголчуудад ашигтай тийм л зүйл хэрэгтэй. Чөлөөт бүс удаан боловч явж л байна. Чөлөөт бүс нэг ихтулгамдсан асуудал биш, эдийн засгийн хямралаас яаж гарах вэ л гэдэг чухал байна. Тийм ч учраас би “эдийн засгийн хямралын эсрэг цаашид ямар арга хэмжээ авах вэ? гэдгийг ярих хэрэгтэй” гэж албаар гурван удаа давтаж эхлэсэн шүү дээ.

**- Цөмийн энергийн тухай хууль батлагдсан. Манайх уранаа ямар замаар хэнтэй хамтарч ашиглавал зүгээр вэ?**

- Би мэргэжлийн хүн биш учраас мэдэхгүй байна. Ажиглаад байхад улс орнууд их зөв бодлого явуулдаг юм билээ. Тайширын усан цахилгаан станцыг хар л даа. 1500-2000 өрхтэй жижиг газар асар их хөрөнгө гаргах шаардлага байсан юм уу. Буруу шийдэл, буруу хөрөнгө оруулалтын том жишээ. Одоо тэрийг хөшөө болгон үлдээх хэрэгтэй. Хойч үе шоолог. Үүнтэй адил ураны чиглэлээр маш болгоомжтой хандахгүй бол Монгол бол жижиг эдийн засагтай орон. Тэр талаас нь бодож байгаа байх аа.

*www.news.gogo.mn, 2009 он*

## НАМУУД ХОЦРОГДСОН АРГА БАРИЛТАЙ БАЙНА

МУХАУТанхимын дарга С.Дэмбэрэл өнөөгийн бизнесийн орчин болоод улс төрийн сонгуульд оролцож байгаа намуудын мөрийн хөтөлбөрт энэ талаар хэрхэн туссан тухай манай порталын асуултад харцуулж байна.

**- Манай өнөөгийн нөхцөлд бизнесийн орчин тааламжтай бус, эдийн засгийн өсөлт удаан, татварын дарамт ихтэй болохоор бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлтэй гэдэг. Та үүнтэй санал нийлэх үү?**

- Мэдээж хэрэг бизнесийн орчин төгс төгөлдөр сайхан байна гэж байхгүй шүү дээ. Хамгийн гол нь бизнесийг хэвийн явуулахад саад болж байгаа янз бүрийн зохицуулалт, хүнд сурталууд бизнест сөрөг нөлөө үзүүлдэг. Үе үеийн Засгийн газар энэ чиглэлээр сайн анхаарч ирээгүй л дээ. Ер нь өнгөрсөн хугацаанд төр эдийн засагт нэлээн оролцох хандлагатай явж ирлээ. Бизнесийн орчин нь

төрийн бодлого, Засгийн газрын зохицуулалт, макро эдийн засгийн бодлогоор бий болж байдаг. Эдийн засгийн орчинг сайжруулна гээд дан Засгийн газар явдаггүй.

Өнөөдөр бизнес хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн өсөлт, ядуурал гэх гурван ойлголтыг их холбож ярьж байна. Бүх улс эдийн засгийн өсөлтийг хүсч байгаа. Эдийн засгийн өсөлтийг яаж бий болгох вэ гэвэл хөрөнгө оруулах бизнесийн тааламжтай орчинг бүрдүүлэх ёстой. Ингэж хөрөнгө оруулах бизнесийн тааламжтай орчинг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг бий болгосноор ядуурлыг бууруулна. Харин бизнесийн орчинг сайжруулахад Засгийн газар, хувийн хэвшлийн түншлэлийн механизм хэрэгтэй юм.

Энэ талаар Монголд ажил хийгдэж эхлээд байна. Саяхан бизнесийн таатай орчинг бүрдүүлэх чиглэлээр “Нэг цэгийн үйлчилгээний зарчим”-д шилжих тухай Засгийн газрын тогтоол гарсан. Энэ бол Засгийн газар нь бидэнд сонгосон болоод л явдаг өнгөрсөн үеийн механизм биш, бид дуу хоолойгоо оруулж үүнийг хянаж байх хоёр талын хариуцлагыг тодорхойлж өгсөн шинэлэг механизм юм. Цаашдаа зөв хэрэгжүүлбэл бусад шилжилт хийж байгаа орнуудад үлгэр жишээ болж ч магадгүй. Саяхан болтол их хүндрэлтэй бизнесийн орчинд амьдарч ирлээ.

**- Бизнесийг хүндрэлтэй байдалд оруулж буй шалтгааныг тухайн Засгийн газрын бодлоготой холбож ойлгож болох уу?**

- Аль ч Засгийн газар хүнд суртлыг бий болгож байдаг. Реформын Засгийн газар ч адилхан. Тийм учраас орчин үед сайн засаглал гэж ярьдаг боллоо шүү дээ.

**- Тэгвэл бизнесийн орчинг сайжруулах талаар улс төрийн намууд мөрийн хөтөлбөртөө яаж тусгасан байна?**

- Би мөрийн хөтөлбөрүүдийг нь нарийвчилж уншаагүй. Ер нь ямархуу баримт бичиг гарна гэдгийг нь төсөөлж байсан. Арван хэдэн жил намуудын мөрийн хөтөлбөрийг уншаар байгаад мэддэг болчихож. МАХН-ын мөрийн хөтөлбөрт “Татварын орчин, бизнесийн орчинг сайжруулна, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд учруулж байгаа захиргааны хүнд суртлыг хална, хувийн хэвшил, иргэний нийгэмтэй ажиллах механизмыг зүгшрүүлж өгнө” гэж тусгаж өгсөн нь сайшаалтай. “Эх орон-Ардчилал” эвслийнх ч гэсэн “Бизнес дэх төрийн дарамтыг арилгана” гэж тусгасан байна.

Намууд мөрийн хөтөлбөртөө тусгана гэдэг ард түмнээс дохио авчихсан байна гэсэн үг. Түүнээс биш тэнгэрээс шүүрч хийхгүй шүү дээ. Өөрөөр хэлбэл, манай намууд ухаан сууж байгаа хэрэг.

**- Харьцуулалт хийж болох уу?**

- Тэр утгагүй л дээ. Нэг нь гоё бичсэн байна, нөгөөх нь муухай бичсэн байна гэж харьцуулж болохгүй биз дээ.

**- Татварыг бууруулна, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлнэ гэсэн ерөнхий заалт л байгаа болохоос тодорхой зүйлийг заагаагүй юм шиг санагдаж байна. Сонгогчид илүү бодит зүйлийг хүсч байна?**

- Монголчууд чинь ерөнхийгөөр ярьдаг хүмүүс шүү дээ. Тэгнэ ээ л гэж. Уг нь тэгнэ, ингэнэ гэхээсээ илүү яаж хийх вэ гэдэг механизмаа суулгаад өгчихвөл илүү тодорхой болох юм. Гэхдээ 145 мянган ажлын байр бий болгоно гээд тийм замаар шийднэ гэсэн зарим нэг тодорхой зүйл анзаарагдсан.

Манайд хамгийн түрүүнд шийдэх том асуудал нь ажлын байр, ядуурал, эдийн засгийн өсөлт байна. Эдийн засгийн өсөлтийг бизнесүүд хангана. Яаж хийх вэ гэвэл хөрөнгө оруулалт, бизнесийн тааламжтай орчинд хийнэ.

**- Татварын хувьд 100 сая төгрөгөөс доош орлоготой аж ахуйн нэгж 15 хувь, түүнээс дээш орлоготой нь 30 хувийн татвар төлж байна. Энэ нь өндөр татвартай орны тоонд багтдаг гэсэн. Татварыг бууруулна гэдэг хэр бодитой зүйл вэ?**

- Өнөөдөр хүмүүс татварын нэг системтэй болох хэрэгтэй гэдэг. Энэ бол прагматик биш л дээ. Үүнийг эдийн засгийн талаас нь сайтар судалж үзэх хэрэгтэй. Наад зах нь татварын байцаагчдыг бизнест яаж найрсаг ханддаг болгох вэ, татварын байгууллагуудын үзүүлж байгаа үйлчилгээнд бизнесменүүд яаж хамтран ажиллавал үр дүнд хүрэх вэ гэдгийг бодох ёстой. Татвараа төлдөг байя, татварынхаа тайланг авдаг байя гэсэн зарчимд шилжих цаг болсон.

Татварын дээд хэмжээ 45 байсныг 35 хувь болгож бууруулсан. Мэдээж төсвөө бодолгүй яахав. Нэг талдаа төрөө үр ашигтай ажилладаг болгох (хүнд сурталгүй байх, илүү дутуу орон тоог халах, төрийн үйлчилгээг найрсаг болгох гэх мэт), нөгөө талдаа эдийн засгийн өсөлтийг татвараар яаж урамшуулах вэ гэдэг асуудал байна.

Ядуу хүмүүс их байна. Ногоо тарих юм уу, жижиг худалдаа эрхлэхээр дээрээс нь дүрэм журам гэдэг лантуугаар толгой руу нь цохичихдог. Нөгөө хүнд чинь буцаад ядуурал руугаа орох, эсвэл энэ бүхнийг давж гарах гэсэн хоёр л зам байна. Үүнээс харахад ямар бодлого баримтлах вэ гэдэг нь ойлгомжтой байгаа биз дээ.

Ядуурлаас гарахын тулд жижиг бизнесээ дэмжиж, жижиг бизнест эрх чөлөө өгье.

**- Зарчмын асуудлууд мөрийн хөтөлбөрт туссан нь биелэгдэж хэрэгжих боломжтой болж байна гэсэн үг үү?**

- Мөрийн хөтөлбөрийг би сайхан завшаан гэж боддог. Ялсан нам нь мөрийн хөтөлбөр дээрээ суурилж Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх болно. Хэрэгжүүлэхгүй бол худлаа ярьсан болно. Худал хэлсэн бол дөрвөн жилийн дараа сонгогчид өөр талд нь саналаа өгнө. Ард түмэн сурч байна. Харин намууд бие биеэ муулдаг, ерөнхий зорилт тавьдаг, худлаа хэлдэг, боломжгүй зүйлийг амладаг хоцрогдсон арга барилтай байна.

Бид намуудад ямар нэг санал өгөөгүй. Зарим холбоо ийм зүйлийг тусгачих, тэгвэл бид дэмжье гэж хандаж байна. МҮХАҮТанхимд тийм эрх байхгүй. Мянгаад хүний саналыг би мэдэхгүй. Хэн нэгнийг дэмжинэ гэдэг тэдний улс төрийн сонголтын асуудал.

Харин сонгуулийн дараа Засгийн газар бий болж мөрийн хөтөлбөрөө гаргах үед нь бид зөвлөмж өгнө. Ингэвэл эдийн засгийн өсөлт бий болно, хувийн хэвшил хөгжинө, ядуурал багасна гэсэн тодорхой зүйлийг тусгаж өгнө.

Ярилцсан Г. Өлзийсайхан  
www.forum.mn, 2009 он

## 630 ТӨГРӨГӨӨР ӨӨРСДӨӨ ТАЛХАА АВЧ ИД

МҮХАҮТанхимын дарга С.Дэмбэрэлтэй цаг үеийн асуудлаар ярилцлаа. Та үнийн өсөлт, инфляцийн хөөрөгдөлтөд хэн буруутай вэ, үүнээс бид хэрхэн бэрхшээл багатайгаар гарах талаар түүний ярьсныг уншаарай. Тэрбээр үйлдвэрлэгчидтэй хамтран Засгийн газарт хэд хэдэн зөвлөмж, санамж гаргасан тухайгаа мөн үеэр ярьсан юм.

**- Засгийн газар, үйлдвэрлэгчид хоёрын хооронд үл ойлголцол үүсээд байна. Үүн дээр танай танхимын байр суурь ямар байгаа бол.**

- Засгийн газрын өнгөрсөн лхагва гаригийн хуралдаанаар инфляци хорин хувьд хүрсэн талаар авч хэлэлцээд цаашид ямар



арга хэмжээ авах тухайгаа ярьсан байна л даа. Мөн өнгөрсөн даваа гаригийн Үнийг тогтворжуулах Засгийн газрын зөвлөлийн хурлаар Ерөнхий сайд С.Баяр зурагтаар ярихдаа “өнөөдрийн хуралд үйлдвэрлэгчдийг урьсан боловч хэн нь ч ирсэнгүй” гэж байсан. Яг үүний маргааш манай танхим дээр 50 гаруй хүнсний үйлдвэрлэгчид цуглаж, санал бодлоо хуваалцсан. Би асуусан “та нарыг урьсан уу” гэж. Тэгэхэд нэгийг нь ч уриагүй гэсэн. Миний гар дээр үйлдвэрлэгчидтэй хийсэн уулзалтын протокол нь байж байна. Одоо энэ протоколоо Ерөнхий сайд руу явуулдаг юм бил үү гэж бодоод л сууж байна. За, энэ ч яахав. Ер нь МАХН-ын талх, мах, Ардчилсан намын талх, мах гэдэг зүйл сүүлийн үед их яригдах болж. Үйлдвэрүүдэд бараг захиргааны арга хэмжээ аваад л энэ үнэ гэдэг зүйлийг буулгачихдаг юм шиг л Үйлдвэрчний эвлэл яриад жагсах юм. Залуучуудын хэлдэгээр их л шог юм болж байна л даа. Ийм шог юм байж болохгүй байхгүй юу. Урт хугацааг нь больё. Богино болон дунд хугацаанд энэ инфляцийг бид яаж багасгах вэ гэдгээ Засгийн газар, үйлдвэрлэгчид, иргэний нийгмийн төлөөлөл нь сууж байгаад хэлэлцэх ёстой. Харамсалтай нь, 10 хоног тутам жишиг үнэ ард түмэнд зарлана ч гэх шиг юм ярьж байх юм. Үүний цаад санаа нь үйлдвэрлэгчдийн үнэ бүрдэлтийг хянах гэж байгаа хэрэг. Энэ арга замаар бол явахгүй ээ.

**- Тэгээд бид яах ёстой вэ?**

- Бид үйлдвэрлэгчидтэйгээ хамтраад богино болон дунд хугацаанд цаашдаа ямар аргаар энэ үнийн өсөлтийг давах вэ гэдэг санал, зөвлөмж боловсруулсан. Өнөөдөр дэлхий дахинд хүнсний хямрал болж байна. Хүнс импортолдог болон экспортолдог орнууд яаралтай арга хэмжээнүүдийг авч эхэллээ. Инфляци гэдэг энэ мангас чинь энэ үнийн өсөлтөөс, үйлдвэрлэлээс гадна буруу бодлогоос хамаараад хөөрөгдөөд байна. Яагаад гэхээр буруу бодлого гэдэг инфляцийн хүлээлтийг үүсгэдэг. Энэ хүлээлт чинь ард түмэнд дарамт болоод явдаг. Мөн энэ инфляци чинь мөнгөний бодлогоос ихээхэн хамаардаг. Одоо манай оронд эдийн засгийн яг эрчимтэй хөгжил явагдаж байна. Энэ хөгжлийн ачаар банкны зээлийн хүү бага зэргээр буух байдал ажиглагдаж байсан. Гэтэл Монгол банкнаас энэ үйл ажиллагааг зогсоож, үүнийгээ хатуу мөнгөний бодлого явуулж байна гэж тайлбарлаж байгаа. Гэтэл өнөөдрийн эдийн засагт хатуу мөнгөний бодлого хэрэгтэй юу.

Мөн энэ инфляцид хүнд суртлууд нөлөөлж байна. Гаалиар бараа бүтээгдэхүүн оруулж ирэх гэж маш их хүнд сурталтай тулгардаг гэж үйлдвэрлэгчид яриад байна. Жишээ нь талхны бүх орц бүтээгдэхүүнийг бүгдийг гаднаас оруулж ирдэг. Зөвхөн

усаа л дотоодоосоо гаргаж байна. Энэ орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнийг гааль дээр шалгаж байгаа нэртээ шинжилгээнд оруулна гэж олон хонуулна, за тэгээд алхам тутамд нь мөнгө хураана энэ бүгд чинь үнийг өсгөж байна. Дээр нь улс төрчид төрийн албаны ажилчны цалинг сая төгрөг болгоно, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300 мянга болгоно гэдэг. Гэх мэтийн үйл ажиллагаануудыг хараад байхад дандаа инфляцийг уруу татаж инфляцийн хүлээлтийг бий болгодог.

Мөн дээр нь энэ газар, газар хуваарилалт, барилга гээд бүгдээрээ “bubble” гэж ярьдгаар их хөөстэй байна. Савангийн хөөс гэж ярьдгаар.

Инфляци гэдэг нийгмийн маш олон зүйлээс хамаардаг, хүсүүштэй зүйл биш, өөрөөр хэлбэл мангас юм. Энэ мангастай тулалдахын тулд дан ганц Засгийн газар сэлэм бариад хувийн хэвшлийнхнийг үнэ нэмлээ гээд сэлэмдэх гээд эсвэл хий хоосон агаарт сэлэмдээд явдаггүй юм аа. Дэлхийн практикт.

Миний ширээн дээр Дэлхийн банкнаас гаргасан 57 хуудас бүхий энэ хүнсний хямрал, ядуурал, доогуур орлоготой иргэдэд хэрхэн тусч байгаа тухай судалгаа байж байна. Ийм жишээнүүдийг бид харж ажиллах ёстой ш дээ.

**- Инфляци, үнийн өсөлт олон зүйлсээс хамаарч байна. Бас нэг нь төгрөг, доллар хоёр салшгүй холбоотой байгаатай гэж ярьж байгаа.**

- Тэгэлгүй яахав. Монгол төгрөгийг доллартай уячихсан байгаа шүү дээ. Доллар глобаль түвшинд яаж хөдөлнө үү, манай төгрөг түүнийг дагаад, уягдаад яваад л байдаг.

Монгол өндөр долларжилттай орны тоонд орчихсон байна. Доллар биш юань, евро гээд бусад мөнгөн дэвсгэрттэй сагсанд Монгол төгрөгөө уяж байж зөв голдиролдоо орох ёстой. Манай хөрш Орос, Хятадад ч мөн инфляци өсч байна. Гэхдээ юань, рублийн хөдөлгөөнийг харахад манайх шиг биш байна. Харьцангуй төр засаг нь зохицуулалт хийж чадаж байна. Монголдоо зөвхөн Монгол төгрөгөөр гүйлгээ, арилжааг хийдэг болгомоор байна л даа. Тэгж төгрөгийн үнэ цэнийг жаахан ч гэсэн нэмэгдүүлэх хэрэгтэй.

Тийм учраас одоо байгаа улс төрийнхөн, УИХ-ын гишүүд нэн тэргүүнд инфляци, эдийн засаг, бизнесийн асуудлыг авч хэлэлцэх хэрэгтэй байна.

Үнийн өсөлтийн хувьд нэн тэргүүнд хүнсний бүх төрлийн барааны гаалийн татварыг тэглэх хэрэгтэй байна. Ялангуяа гурилан бүтээгдэхүүнд ордог орц бүтээгдэхүүний татварыг

чөлөөлөх хэрэгтэй. Элсэн чихэр гээд бүгдийнх нь үнэ нэмэгдчихлээ. Түүнээс биш үнэ бүрдэлтийг нь тоолоод хянаад, тэдэн хувийн ашиг олж ав гэдэг чинь социализмын үеийн арга барил ш дээ. Мөн борлуултанд буюу эцсийн бүтээгдэхүүнээс авч байгаа НӨАТ-ийн татварыг зургаагаас есөн сарын хугацаанд авахгүй байх хэрэгтэй. Татварын амралт гэдэг ойлголт бий ш дээ. Татварын амралт өгч болно.

Нефть бүтээгдэхүүний хувьд одоо байгаа нефть бүтээгдэхүүнүүдээ нөөцлөж авах, нөөц бүрдүүлэхийг богино хугацаанд хийх хэрэгтэй. Дунд хугацаанд дотоодын эхний шатны үйлдвэрлэл зэрэг нь ороод явна. Гэх мэтийн арга замуудыг бид зөвлөмжөө оруулсан.

**- Олон улсын валютын сангийн төлөөлөгчид манай оронд ажиллаад хэд хэдэн зөвлөмжийг бас гаргаж байсан. Түүнийг манай төр засгийнхан нэг их тоосонгүй ш дээ.**

- Түүнээс өмнө манай танхимаас 2006 оноос эхлээд энэ талаар ярьж, хэлж, бичиж байсан. “Хүүхдэд хайргүй Худалдаа аж үйлдвэрийн танхим” гэж хүртэл сонин хэвлэлээр бичиж байлаа. Дараа нь төр засгаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг төвлөрүүлсэн байдлаар тогтоож байгаа нь мөн энэ инфляцийг хөөрөгдөж байна гэж бичсэн. Хамгийн сүүлд цалин нэмэхээ битгий зарлаж бай гээд бичлээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300 мянга болгоно гэж яриад байгаа хүнд хандаж бичсэн ш дээ.

Эдийн засгийн амьдрал дотор байгаа, мэргэжлийн хүмүүсийнхээ үгийг сонсохгүй тэрүүхэн хавьдаа эсвэл үйлдвэрчний эвлэл жагсахаар нь айгаад ингэж байж болохгүй ээ. Одоо бидний гаргах гэж байгаа зөвлөмжинд 20, 30 санал байж байна. Үүнийг хүлээж аваад хэрэгжүүлээд явах юм бол инфляцийг нэг хэсэгтээ дээшээ гаргахгүй байж болно. Түүнээс биш 10 хоног тутамд тэр жишиг үнэ гэдгийг зарлаад байх явдал биш ээ. Жишиг үнэ гэдэг чинь өөрөө бизнесийнхний хамгийн ихээр бухимдуулдаг зүйл байхгүй юу. “Үйлдвэрлэгчдийг үнээ нэмээд байна” гэсэн хардлагаар явахгүй шүү.

**- Яг одоо УИХ-ын түвшинд яригдаж эхэлж байна л даа. “Эх орны хишиг” гээд. Үүнийг ОУВС-гийнхан инфляцийг нэлээд хөөрөгдөх магадлалтай гэж байсан. Таны байр суурь ямар байна вэ?**

- Үүнийг чинь бид нар хэлж л байсан. Дээр хэлсэнчлэн “Хүүхдэд хайргүй МҮХАҮТ гэж бичиж байсан гээд. Хүүхдийн мөнгөнөөс авахуулаад иймэрхүү халамжийн мөнгө инфляцийг

хөөрөгдөнө. Үүний оронд бүтээлч капитал бий болгох хэрэгтэй байна. Өнгөрсөн долоо хоногт УИХ-ын гишүүн Н.Батбаяр, “Монгол шуудан” банкны захирал Д.Зоригт нарын санаачилсан Монголд оронд шаардлагатай байгаа 100 үйлдвэрийг зарласан. Энэ бол маш зөв санаа. Ийм бодитой зүйлийг бид ярих ёстой. Манай оронд яг өнөөдөр 200 үйлдвэр байгуулах боломж байна ш дээ. Аймаг, орон нутгийнхантай бид ярьж хэлж байгаа зүйлүүд байна. Ингээд зориглоод хөдлөх юм бол бид хоёроос гурван жилийн дотор 200 үйлдвэртэй болох боломж байна. Хүмүүс тэгэхээр яаж өрсөлдөх юм гэж асуудаг. Тэр чинь маш их өрсөлдөөнийг үүсгэнэ. Үйлдвэр эхлээд өөрийнхөө хэрэгцээг, тэгээд импортыг, дараа нь экспортыг нэмэгдүүлнэ тэгэхээр өрсөлдөөн үүсгэнэ.

**- Манай зарим түшээд, иргэний хөдөлгөөд, үйлдвэрчний эвлэлийн ярьж буйгаар эдийн засгийн энэ хямралын үед үйлдвэрлэгчид, хувийн хэвшлийнхэн таваас зургаан хувийн ашиг олоход хангалттай. Одоо манай үйлдвэрлэгчид, үнийг хөөрөгдөөд 2030 хувийн ашиг олоод байна гэж ярьж байсан. Тэгэхээр яг өнөөдрийнх шиг эдийн засгийн хүнд үед ийм төр засгийн зохицуулалт ер нь олон улсын практикт байдаг юм болов уу?**

- Урьд өмнө нэлээд хэдэн оронд ийм оролдлогууд хийж байсан. Огт явуургүй гэдгийг Дэлхийн банк хүртэл хэлж байгаа. Ийм зохицуулалт зөвхөн зах зээлийн гажуудлыг авчирна. Засгийн газар дээр миний хэлсэнчлэн маш олон хүнд суртлыг дамжсан татварыг үйлдвэрлэгчдээс хурааж аваад нөгөө гараараа энэ инфляц гэдэг зүйлтэй тэмцэх гээд зүтгээд байх юм. Эдийн засаг гэдэг чинь их хуурай зүйл. Тийм сэтгэлийн хөдлөл, хайр сэтгэлээр бүтдэг зүйл биш юм. Ийм ийм хүндрэл учирдаг гээд үйлдвэрлэгчид яриад байна. Миний гар дээр үйлдвэрлэгчдийн ярьсан арваад хуудас материал байж байна. Тэр байтугай энэ үйлдвэрчний эвлэлийн жагсаал чинь инфляцийг бас хөөрөгдөж байдаг юм ш дээ. Тэгэхээр инфляцийг хэн хөөрөгдөж байна вэ гэхээр, нэгдүгээрт Засгийн газар, хоёрдугаарт сайн санааны үүднээс жагсаад байгаа гэж би хаалтанд хэлье. Монголын үйлдвэрчний эвлэл энэ инфляцийг хөөрөгдөж байна. Түүнээс биш үйлдвэрүүдийг монополь гэж зарласнаар энэ зүйлүүд чинь зохицуулагддаггүй юм. Жишээ нь “Талх чихэр” ХХК гэхэд ямар юмных нь монополь байдаг юм. Хүнсний үйлдвэрүүдийн томоохон төлөөлөгчид гээд байгаа “Өгөөж”, “Атар өргөө” энэ тэр чинь нийт үйлдвэрлэлийн 30-аад хувийг л эзэлдэг ш дээ. Бусад нь дандаа жижиг үйлдвэрүүд

байдаг байхгүй юу. Энэ үйлдвэрүүдэд гурил, хүнсний орцууд хэрэгтэй байна. Гурил, хүнсний орцууд нь бүгд татвартай. Тэгээд орцуудынх нь үнэ нь өсчихсөн байна.

**- Нэг өдрийн дотор гэнэт 200 төгрөгөөр нэг талхны үнэ нэмэгдэнэ гэдэг бас их хүнд тусч байгаа зүйл шүү дээ.**

- Талхны үйлдвэрүүд дээр миний хэлсэн хүчин зүйлүүдийг тэвчиж, барьсаар байгаад тэсэхгүй дэлбэрч байгаа нь тэр шүү дээ. Тэгэхгүй бол дампуурчих гээд байна.

2007 оноос авахуулаад тодорхой компаниуд энэ үнийн өсөлтийг мэдрээд төр засаг руу бичээд байж. Гэтэл засаг нь шуурхай арга хэмжээ авахын оронд “за бид нар буудай оруулж ирнэ ээ” гээд баахан хүлээлгээд л. Буудай нь орж ирэх гэж хэдэн сар болно. Тэр хооронд нь үйлдвэрүүд нь оруулж ирэх гэж байсан буудайгаа болиод хүлээнэ. Оруулаад ирэхээр шатчих гээд байдаг. Бизнесийнхэн гэдэг чинь аль болох шатчихгүй байхыг бодно. Түүнээс биш нэг их хатуу сэтгэлтэй, Монголынхоо ард түмнийг боддоггүй улсууд биш шүү дээ. Яг үйлдвэр дээр нь газар дээр нь очоод үзэхээр тэр үйлдвэрт чинь хүн ажиллаж байгаа. За тэгээд бүх төрлийн үнэ нь өссөн орц материалуудаар эцсийн бүтээгдэхүүнээ гаргах гээд ажиллаж байгаа. Тэр үйлдвэрт чинь адилхан хүн л ажиллаж байна. Тэр хүмүүст зориулсан талхыг үйлдвэрлэж байна ш дээ. Өчигдөр талх 400 байж байгаад өнөөдөр 600 төгрөг боллоо. “За үйлдвэрүүд нэг ширхэг талхнаас 200 төгрөгний ашиг олох гэж байна” гэсэн хөгийн арифметик үйлдэл хийчихээд суугаад байх юм. Үйлдвэрлэгчдэдээ энэ төрөл бүрийн хүнд суртлаа, татвараа багасгаж туслахынхаа оронд үйлдвэрчний эвлэл гэдэг зүйлээс айгаад, сонгууль болохоос өмнө гээд л янз янзын юм бодоод байх юм. Харин төр засаг зөв алхам хийхгүй бол юун үйлдвэрчний эвлэлээс чинь мянга дахин илүү хүчтэй энэ үйлдвэрлэгчид босоод ирнэ шүү. Хамгийн гол нь бизнесийнхэн тэгдэггүй байхгүй юу. Даруудаа биш энэ эдийн засгийг ойлгодог учраас. Үйлдвэрчний эвлэлийн дарга С.Ганбаатар өөрөө эдийн засагч гээд байж ингэж явж болохгүй ээ. Тийм л сүрхий юм бол үйлдвэрлэгчидтэй, манай танхим дээр ирээд мэтгэлц л дээ. Бизнесийн тодорхой компанийн захирал дээр очоод уулзах хэрэгтэй ш дээ. Бүтээгдэхүүний үнэ бүрдэлтийг харах хэрэгтэй. Гааль дээр очоод харах хэрэгтэй. Төмөр зам, Алтанбулаг дээр очоод харах хэрэгтэй байхгүй юу. Худлаа энд жагсаад яах юм бэ. Машины хөдөлгөөн үймүүлээд. Иймэрхүү л юм болоод байна ш дээ.

**- Засгийн газрын өнгөрсөн хуралдаанаар нэг ширхэг талхны эцсийн буюу борлуултын үнийг 630 төгрөг байх жишиг үнэ гаргасан байна лээ.**

- 630 төгрөгөөр өөрсдөө тэр талхаа авч ид гэж хэлнэ.

**- Үйлдвэрлэгчид энэ үнийг зөвшөөрч байгаа юу гэхэд “зөвшөөрч байгаа” гэсэн.**

- Үйлдвэрлэгчидтэй нэг нэгээр нь уулзаад шахаанд оруулаагүй л юм бол. Тийм зүйл огт болоогүй. Надад байгаа үйлдвэрлэгчдийн ярьсан бэрхшээлээс би зарим хэсгийг уншиж өгье л дөө.

**-Таныхаар татвар, НӨАТ-ийг чөлөөснөөр энэхүү үнийн өсөлтийг манай иргэд бэрхшээл багатайгаар давж чадна гэсэн үг үү?**

- Минийхээр биш, зах зээлийн жамаар миний дээр хэлсэн аргуудыг авч байж инфляц буурна. Тэгээд л боллоо.

**- Үнийн өсөлтийн асуудал ийм байдаг байж. Танай танхимаас өөр хэрэгжүүлж байгаа ажлынхаа тухай танилцуулаач. Туул голоо аврах их сайхан уриа гаргаж, үйл ажиллагаа зарласан байсан.**

- Туул гол чинь сөнөлөө. Дунд гол, Сэлбэ гол чинь байхгүй болчихсон. Ийм чухал нийгмийн асуудалд нийтийн хүчин чармайлтыг төвлөрүүлэх шаардлагатай байна. Манайд нэлээн хэдэн компаниас Туул голоо аврах хөдөлгөөн өрнүүлье гэсэн санаа ирсэн. Үүн дээр мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд маш сайн сурталчилж ажиллаж өгмөөр байгаа юм.

Ирэх сарын 17-нд бүх нийтийн цэвэрлэгээ, мод тарих үйл ажиллагаа буюу субботникийг зохион байгуулах гэж байна. Өчигдөр нэг телевизээр гарч байсан. Маш хурдан ургадаг модны тухай. Энэ компанитай бид холбоо бариад хамтарч ажиллах гэж байна. Гэх мэтчилэн бид байгуулагынхаа нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх ажил хийх гэж байна.

Хоёрдугаарт, ирэх сарын 7-нд Эдийн засаг, бизнесийнхний үндэсний чуулганыг Төрийн ордонд хийх гэж байна. Саяын миний ярьдаг энэ инфляцийн хөөрөгдлийн эсрэг авах арга хэмжээ зэргийг хэлэлцэх гэж байна. Энэ хурал дээр бид бас төр засгийн хүмүүсийг урьж байгаа. Эдийн засагчид, эрдэмтэд, бизнесийнхэн юу гэж боддог вэ гэдгийг сонсох хэрэгтэй ш дээ. Тийм учраас Эдийн засаг, бизнесийнхний чуулга уулзалт гэж нэрлэж байгаа.

Дээр нь манай танхимаас үйлдвэржилтийг хөгжүүлэхийн тулд манайд шаардлагатай байгаа 200 үйлдвэрийн жагсаалтыг гаргачихсан. Орон нутаг, аймгуудаас санал хүсэлтийг авч байна.

Танай аймгийн аль суманд ямар үйлдвэр баривал зохилтой вэ гэхчилэн. Ажиллах хүчийг яаж бэлдэх вэ гэдгийг судалсан. Ингээд үйл ажиллагаа явуулъя гэхээр бидэнд мөнгө хэрэгтэй болж байгаа юм. Тэгэхээр бид төр засгаас мөнгө зээлье гэж байгаа. Компаниудтайгаа хамтраад өөрсдөө энэ бүгдийг хийх хэрэгтэй болж байна. Энэ ажил хэрэгжээд эхэлвэл жилийн дараагаар үйлдвэрүүд ашиглалтад ороод эхэлнэ. Үйлдвэр гэхээр бид социализмын үеийнх шиг тийм том үйлдвэрүүд яриад байгаа юм биш шүү дээ.

**- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих талаар бид олон жил л ярьлаа л даа. Энэ бүх үйл ажиллагааны бодитой хөгжил хаана явна вэ?**

- Бид одоо 15 аймагт 40-өөд төслийг амжилттай хэрэгжүүлээд байна л даа. Бодигой жишээнүүд бидэнд байна.

**- Иргэдэд үйлдвэрлэл эрхлэх хүсэл, эрмэлзлэл байдаг ч ядаж төслөө хэрхэн бичих вэ гэдгээс авахуулаад бэрхшээлтэй тал их байдаг юм шиг.**

- Тийм талууд бий. Бид мөдхөн “Хас” банкттай хамтраад 100 сая төгрөгний төсөвтэй нэгэн үйл ажиллагаа явуулах гэж байна. Телевизийн реалити шоу гээд их яваад байгаа ш дээ. Энэ хэлбэрээр үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй, төслөө биччихсэн, гэтэл мөнгө байхгүй, барьцаа хөрөнгө байхгүй хүмүүсийг шалгаруулаад санхүүжилт хийдэг, зээл олгох үйл ажиллагаа явуулах гэж байна. Өөрөөр хэлбэл бизнесийн реалити шоу зохион байгуулах гэж байна.

*Ярилцсан: Ч.Болортуяа  
www.news.gogo.mn, 2008 он*

## **С.Дэмбэрэл: УИХ-ЫН ГИШҮҮД МОНГОЛБАНКНЫ ОЛОН ХУУДАС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МАТЕРИАЛД ХУУРТАГДАЖ БОЛОХГҮЙ**

**- УИХ ирэх оны Төсвийн төслийн талаар хэлэлцэж эхлээд байна. Таны хувьд 2010 оны төсвийн төслийн тухайд ямар бодолтой байна вэ?**

- Төсвөөс илүүтэй мөнгөний бодлогын талд хэлэх зүйл байна л даа. Гэхдээ төсвийн талаар асуусан болохоор санал бодлоо

хэлье. Ирэх оны Төсвийн бодлогыг ерөнхийд нь харсан. Төсвийн орлого, зарлага гээд нэлээд олон зүйл дээр реформ, төсвийн зохистой хөрөнгө оруулалт хийнэ, төсвийн хариуцлагын тухай хууль батална гэх мэтээр ирээдуй цагт чиглэсэн олон концепцийн шинж чанартай зүйлүүд бичсэн байна лээ. Харин төсвийн орлого, зарлагын чиглэлээр нарийн уншаад судлаад үзвэл бүх юм хуучнаараа байна. Өөрөөр хэлбэл, 2010 оны Төсвийн төсөлд Монгол Улсын 2010 оны эдийн засаг буюу 2009 онд ургэлжилсээр байгаа хямралын эсрэг авах арга хэмжээний талд төсвийн ямар бодлого явуулах вэ гэдэг нь тодорхой биш байна.

Ямар ч гэсэн орлого тал дээр зарлагын реформ хийгээгүй учраас жишээлбэл, зарим төрлийн орлогыг нэмэхээр тусгасан байсан. Жишээлбэл, зэсийн үнийг 5500 гэж тооцоод, орлогоо тооцсон байх жишээтэй байна. Мөн нийгмийн зарим хавтгайрсан халамжаа үргэлжлүүлэхийн тулд зэсэнд найдаж, бизнесийн татварыг нэмэх замаар өөрөөр хэлбэл, нийгмийн даатгалын шимтгэлийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх бодлогоор төсвийн орлогыг нэмэгдүүлэхээр тусгаж. Бодит секторын идэвхжилийг дээшлүүлэх чиглэлээр төсвийн талаас яг ямар арга хэмжээ авах тухайд тодорхой юм байхгүй байна.

2008 онд зогсоосон бүх объект болон 2009 онд ийм ийм зүйл барьж байгуулна, ийм зүйлд хөрөнгө оруулалт хийнэ гэж төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдуулсан байсан л даа. Гэхдээ ерөнхийдөө орлого тал дээр мөнөөх хуучин хандлага хэвээрээ. Уг нь ОУВС-тай тохирсон ёсоор бол нийгмийн халамжийн хавтгайрсан байдлыг цэгцэлж, хамгийн зорилтот шаардлагатай хэсэгт нь нийгмийн халамжийг төвлөрүүлэх, тэр байтугай мөнгийг нь нэмэх хандлага байсан. Үүнийг Танхим дэмжиж байгаа. Гэтэл зэсийн үнийг өссөн байгаа өнөөгийн зах зээлийн конъюнктурт итгэх, дээр нь компаниудаас тодорхой хэмжээгээр компинсаци хийж аваад төсвийнхөө орлогын дутууг нөхчихнө. За тэгээд мэдээж зээл, тусламж гэсэн энэ гурван зүйлд найдсан, тийм учраас зарлага талаа ювээр нь үлдээчихсэн. Үүний аргумент нь юу юм гэхээр ард түмэн тэртээ тэргүй зовж байна, тийм учраас яарсны хэрэггүй ээ гэж. Ард түмэн зовж байна гэдэг нь өөрөө их утгагүй ойлголт. Ард түмний хэн нь зовж байна, хэн нь хамгийн их зовж байгаа юм гэдгийг судлаад тэр хэсэгт л төсвийн халамжийн мөнгийг өгөх ёстой.

Дээр нь 2010 онд эх орны хишиг, эрдэнийн хувь гэсэн амлалтуудыг нэгтгээд нэг хууль болгож батлах нь. Энэ нь цаашдаа

Монгол Улсын төсөв гэдэг зүйл, түүнийг хариуцаж боловсруулж, бэлтгэдэг Сангийн яамыг зүгээр л ерөнхий тоо бүртгэгчийн хэмжээнд аваачиж байна. Өөрөөр юлбэл, Сангийн яам ерөнхий тоо бүртгэгч болж хувирлаа. Энэ нь Сангийн яамны муугийнх биш. Хамгийн гол нь улс төрийн зорилт, амлалтыг биелүүлэх, дээр нь сонгуулийн үеэр иргэдэд амалсан амлалтуудыг гүйцэлдүүлэх үүднээс өмнө нь өгч байсан халамжийн бух бодлогыг хэвээр үлдээж, хүүхдийн мөнгөний эх үүсвэрийг төсөвт найдчихсан учраас Сангийн яамны зүгээс ямар нэгэн реформ хийх боломжгүй болчихож байгаа юм.

Ирэх оны төсвийн төслийг уншаад үзэхэд Сангийн яам Засгийн газрын хуралдаанд нэг тодорхой асуудалд реформ хийе гэж санал тавиад оруулсан боловч Засгийн газрын хуралдаанаар зөвшөөрөөгүй байна. Энэ нь нэг яам төсвийн төсөл дээр реформ хийе, хариуцлагатай төсөвтэй больё, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлбэ, эдийн засгийн үр ашигт голчлон анхаарч ажиллая гээд анхны оролдлого хийнгүүт нь таслан зогсоож байна. Эндээс нэгдүгээрт, Сангийн яам ерөнхий тоо бүртгэгч болж байна гэсэн гэсэн тодорхойлолт гарч ирж байгаа юм.

Хоёрдугаарт, Сангийн яамны маневарлах боломжийг хаагаад өгчихсөн. Тийм учраас Сангийн яам өнөөдөр зөвхөн дээрээс ямар захиалга орж ирнэ, түүнд тааруулж төсвийн орлого, зарлагыг боловсруулж хийдэг практик амь бөхтэйгөөр тогтох шинжтэй болоод байна. Энэ нь төсөв өөрөө эдийн засгийн тооцоо, зохистой, үр ашигтай байдал гэсэн зүйлүүдэд хувиарлагддаг төсвийн үндсэн зарчмууд алдагдаад, төсвийг зохиох боловсруулах, нөөцийг хуваарилах, дахин хуваарилах асуудалд улс төрийн шалгуурууд голлоод ирэхээр ерөнхийдөө төсвийг хэлэлцсэн ч, хэлэлцээгүй ч яалаа гэсэн байдалд оруулчихаж байгаа юм. Эндээс 2010 оны төсвийн төслийг хуучин хэвээр нь хийжээ гэсэн дүгнэлт урган гарна. Хуучин хэвээрээ гэдэг нь нэгдүгээрт, зэс, алтанд, хоёрдугаарт, олон улсын тусламжид, гуравдугаарт, хувийн хэвшлийнхнийг урьдын адил зулгаана, бүр ч илүү их зулгаана гэсэн ийм л гурван зүйлд найдсан нь харагдлаа.

Зохистой байдал, үр ашиг гэсэн үгнүүд манай эдийн засгийн үгсийн сангаас хасагдаж байх шиг байна. Түүний оронд тэгш хуваарилах гэсэн хуучны тогтолцоо нэлээд зонхилоод ороод ирчихжээ. Ийм тохиолдолд төсвийн талаас сайн боллоо, ийм боллоо гэсэн зүйл байхгүй. Нөгөө талаас баримт бичгүүдийг харж байхад бас л урьдын адил мөнгөний болон төсвийн бодлого хоёрын хооронд ямар ч уялдаа холбоо алга.

**- Мөнгөний бодлогод эрс өөрчлөлт хийх шаардлагатай талаар эдийн засагчид дуугардаг. Ирэх оны мөнгөний бодлогод өөрчлөлт харагдана уу?**

- Мөнгөний бодлого дээр Монголбанк зальтай юм бичсэн байна л даа. Бид энэ жилдээ инфляцийг найман хувьд барьчихна аа гэж. Тэгээд энэ хугацаанд мөнгө орчих юм бол банкуудаа жаахан сайжруулъя, харин энэ хоорондох төсвийн идэвхитэй бодлогыг Сангийн яам явуулмаар байна гээд Сангийн яам руу түлчихсэн байгаа юм. С.Баярцогт сайд үүнийг нь анзаарч уншсан уу, үгүй юу. УИХ-ын гишүүд анзаарсан болов уу.

Монголбанк өөрөөсөө бүх юмыг бултуулж байна. Төв банкнаас хамаардаггүй инфляци гэдэг зүйлийг удирдана гэсэн хуурамч төсөөллөөр мөнгөний бодлогыг боловсруулаад энэ бүх зүйлээ далдлахын тулд Мөнгөний бодлого гэсэн сурах бичих шиг олон хуудас номору материалыг УИХ-ын гишүүдэд тараасан.

Ирэх оны мөнгөний бодлогын гол мөн чанар нь Монголбанк инфляцийг хариуцъя гэжээ. Тэд хэзээ ч хариуцаж байгаагүй. Монголын инфляцийг Монголбанк доошоо тогтоогоод барьчихсан гэдэг ч худлаа. Ийм дутагдал харагдаад байна. Жишээлбэл, 2009 оны гуравдугаар сард Монголбанкнаас гаргасан мэдэгдэлд Засгийн газрыг цалин хаамгүй нэмэгдүүлсэн энэ тэрээ гээд хэлсэн байдаг. Үнэн л дээ. Гэхдээ энэ хоёр байгууллага тэгвэл яах гэж хамтарч ажилладаг юм бол, яагаад нэг улсын сангийн болон мөнгөний бодлогыг хослуулж явуулах ёстой гэж ярьдаг юм бол, яагаад тухайн үед хамтарч ажиллаагүй юм бол гэсэн асуултууд гарна. 2010 оны төсвийн төслийн бодлогод энэ чиглэлээр бас л тусгаагүй байна лээ.

Мөнгөний бодлогын хувьд муу болсон байна лээ. Бас л урьдынхаараа. Мөнгөний бодлого гэсэн олон хуудас материалыг гол агуулгыг товчлоод хар угээр тайлбарлавал, Монголбанк эдийн засгийн өсөлт мэдрэгдэхүйц аятайхан боломж гарвал л оролцоно. Харин одоохондоо бол инфляцийг найман хувьдаа баръя. Мөнгөний бодлогыг нөхцөл байдалтай уялдуулан зөөллөнө, болохгүй бол хатууруулчихна гэж айлгасан байх жишээтэй. Монголбанкнаас барьдаг тийм инфляци гэж байхгүй ээ. Үүнийг их л сайн ойлгох ёстой. Үүнд нь их хурлын гишүүд хууртагдахгүй байх ёстой.

**- Мөнгөний бодлогыг сайжруулах талд ямар арга хэмжээ авч, хэрхэн ажиллах талаар Танхим ихэд дуугарсан шүү дээ?**

- Олон зөвлөмж юлсэн. Тухайлбал, манай эдийн засгийн мөнгөний нийлүүлэлт их байх тусам инфляци нь дагаад өсчихдөг

эдийн засаг бишээ. Яагаад гэвэл, Монголын эдийн засаг, санхуугийн зах зээл буюу бусад зах зээл хөгжих ганцхан альтернативтай. Өөр альтернатив байхгүй. Өөрөөр юлбэл, мөнгөтэй болох ганц зах зээл нь банк.

Иргэд, аж ахуйн нэгж мөнгөтэй болох гэж банк руу очно. Гэтэл өнөөдөр ард түмэн санхүүгийн чадваргүй болчихсон байна. Жижиг, дунд бизнес нь урагш явахаа байлаа, зээл юрэгтэй байдаг ч банкууд өгөхгүй. Ийм байдалд яагаад оров гэдгийг эруул ухаантай хүмүүс ойлгож байгаа. Жижиг, дунд бизнесийн хэн яагаад 30 тэрбум төгрөгийн хойноос цуцалтгүй гүйгээд байна. Яахав ирэх оны төсөвт 30 тэрбум төгрөгийг суулгаж өгсөн байсан. Уг нь энэ мөнгийг 60 тэрбумд хургэсэн бол сайн байх сан.

Дээр нь банкуудын байдал муудсан. Банкуудыг тэжээгддэг зүйлээс нь салгачихаар муудахаас яахав дээ. Шилэн саванд байдаг загасыг тэжээдэг зүйлээс нь салгачихаар мөнөөх загаснууд тох аюулд ордог шүү дээ. Усыг нь байнга сэлбэж шинэчилдэг биз дээ. Банкуудыг шинэ мөнгөөр сэлбэж шинэчлэхгүй, харин ч тэжээдэг зүйлсийг нь салгаад хаяхаар банкны үйл ажиллагаа муудна. Банкууд өнөөдөр үхсэн ч биш, сэхмэл ч биш байдалтай л байна. Банкны байдал бодит сектор сайжрахаар л банкны эргэлт үүсч, үйл ажиллагаа нь дээрдэж ирдэг. Түүнээс банкны тусгай бодлого гэж юм байхгүй шүү дээ.

Монголбанк төрийн мөнгөний бодлогыг бодит сектор луу чиглүүлэхгүй л юм бол энэ 15 банкны байдал ердөө сайжрахгүй. Зээл авагчид муу байна аа гэж ярих. Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, үйлдвэр үйлчилгээг нэмэгдүүлэх зэрэг бодитой арга юмжээ авч байж л байдал сайжирна. Инфляцийг барьчихна гээд бусад зүйлсээ Сангийн яам уу чихчихээд суугаа өнөөгийн нөхцөлд Төвбанк байхын хэрэг байгаа юм уу. Эсвэл Төвбанкныхаа хуулийг өөрчилж, Засгийн газрын харьяалалд оруулах юрэгтэй. Уг нь Төвбанкны бие даасан байдлыг хангах үүднээс Төвбанк нь Парламентийнхаа харьяалалд байдаг. Ер нь Төвбанк, УИХ, Засгийн газрын аль альныхаа харьяалалд байвал төрийн мөнгөний болон сангийн бодлогын уялдаа гарч ирэх ёстой. Ийм хувилбар байж болно. Энэ бол ухралт биш реформ. Монголбанкныхан гэж өнөөдөр юунд ч захирагддаггүй, хоосон аргалдаг бүлэг хүмүүсийн нэгдэл болчихоод байна. Инфляцийг зогсоосон гэж худал ярина. үнэндээ бол, бодит байдал дээр эдийн засгийн уналт хамгийн доод цэгтээ тулаад, иргэдийн худалдан авах чадвар доод цэгт хуртэл унасан учраас инфляци зогсонги байдал орчихсон.

Инфляци зогсохоор бизнес хөдөлгөөнгүй болж, валютын ханшны хөдөлгөөн ч бас зогсоно. Аж ахуйн нэгжүүд л амьдрахын эрхэнд өөрсдийгөө аргалаад үлгэн салган ажиллаад байна. Тиймээс зах зээл дээр бараа бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж байгаа компаниуд инфляцийг тогтоон барьж байна. Тэгэхээр Төвбанк компаниудыг үхмэл байдалд оруулаад үүний золиосоор инфляцийг нэг оронтой тоонд барьж чадлаа гэж хэлбэл би тийм ээ гэж хэлнэ. Гэхдээ ийм бодлого удаан ургэлжилж болдоггүй юм аа. Яагаад гэвэл бугдийг нь үхүүлчихдэг учраас.

**- Танхимаас гаргасан “Эдийн засаг сэргэж байна уу” гэсэн мэдэгдэлд мөнгөний бодлогын алдаануудын талаар тодорхой хэлсэн байсан?**

- Танхимын “Эдийн засаг сэргэж байна уу” гэсэн мэдэгдэлд арван бодлогын алдааг хэлсэн байгаа. Жишээлбэл, нэг зүйлийг энд тодруулах байна. Мөчлөгт эдийн засаг гэж сүүлийн үед нэг юм бичээд байгаа. Мөчлөгт гэхээр капиталын, хөрөнгийн зах зээл маш сайн хөгжсөн, дээр нь банкны систем маш сайн төлөвшиж тогтсон эдийг засгийг юлнэ. Ийм эдийн засгийг мөнгөний агрегатууд удирдаад явдаг. Тэр байтугай ийм эдийн засагт инфляцид байдаг мөнгөний болон ялангуяа мөнгөний бус хүчин зүйлүүд нь хуртэл давамгайлдаг. Ийм эдийн засаг өөрөө бас мөчлөгтэй. Тийм учраас хөрөнгийн бирж өндөр түвшинд хөгжсөн улс орнуудад мөчлөгийн уе шатууд ургэлжилж байдаг. Дээр нь тэр улс орнуудад бизнесийн авир төрх эдийн засгийн үйлдлүүдээрээ бух юманд нөлөөлдөг.

Хэрэглэгчдийн болон бизнесийн итгэл, хэрэглэгчдийн итгэлийг сэргээх гэж ярьдаг даа. Ийм улс орнуудын бизнес эрхлэгчид нь Засгийн газрынхаа юу хэлж байгаа болон юу хийх гэж байгаад нь итгэл үнэмшлээ өгөөд, хариуд нь эерэг хүлээлтийг бий болгодог. Инфляцийн хүртэл эерэг хүлээлт үүсгэдэг. Ийм эерэг эдийн засаг дотор энэ бүх зүйл нь мөчлөгөөр яваад, эдийн засагт оролцогчдын хүлээлт өөрчлөгдөөд муудаад ирэх юм бол уналт болж солигддог.

Гэтэл манай улсад хөрөнгийн бирж байхгүй гэж хэлж болно. Капиталийн төрөл бүрийн зах зээл хөгжөөгүй, мөн банкны ганцхан дутуу хөгжсөн системтэй. Дээр нь инфляци, валютын ханш гээд бусад төрлийн бүх хүлээлт олон жилийн турш дандаа сөрөг байсан. Төвбанк болон төр, засагт итгэх итгэл ч сөрөг байдаг. Тийм учраас хэрэглэгч, бизнес эрхлэгчдийн аль нь ялгаагүй дараа жил инфляци өснө гэсэн дүлээлтэд дандаа орсон, ийм эдийн засагтай.

Капиталын зах зээл нь хөгжөөгүй. өөрөөр хэлбэл, инфляцийг, хүмүүсийн авир төрхийг мөнгөний бодлогын арга

хэрэгслүүдээр удирдаж болдоггүй. Ингэснээрээ эдийн засаг энэ бүх шалтгаануудын улмаас улирлын гэсэн нэг л циклтэй, бизнес нь улирлаа дагаж явдаг, цөөхөн хэдэн нэр төрлийн барааг экспортолдог. Эдгээр нь конъюнктурын циклээс хамаарч байдаг ийм улс оронд циклийн эсрэг, циклийг дагах гэсэн ойлголт байдаггүй. 2009 оныг Монголбанкны мөнгөний бодлогод цикл гэсэн үг их гарч ирсэн. Ойлгохгүй юмаа ярьдаг.

Тэр байтугай Монголынбанкны мөнгөний бодлогыг барьдаг хамгийн хариуцлагатай нэг хүнээс би “Монголын эдийн засаг циклтэй юмуу” гээд асуухад “Эдийн засаг чинь угаасаа л циклтэй байдаг” гэсэн юм ярьдаг хүмүүс Монголын мөнгөний бодлогыг атгаад дээр нь Улсын их хуралд биднийг төлөөлж байгаа хүмүүсийг зальдаад сууж байна. Сүүлийн жилүүдэд УИХ-д прагматик хүмүүс олон гарч ирж, нэг юмыг олж харсан.

Инфляцийг онилно энэ тэр гээд юм яриад байх юм. Нүдэн дээр ард түмний амьдрал дордоод, бизнесийн идэвхжил буурчихаад байхад мөнгөний бодлого гэж юу байна аа гээд энэ асуудалд анхаарал хандуулснаар 2009 оны мөнгөний бодлогыг шинэчлэх анхны оролдлого хийгдсэн. Эдийн засгийг онилдог болгоё, бодит сектор луу Төвбанкны бодлогыг чиглүүлье гэсэн анхны оролдлого байсан.

Гэхдээ туршлагагүй байсан учраас дахиад залилуулсан. Тэр нь энэ тодорхой зорилт бол мөнгөний бодлогын үндсэн зорилт гэж зөв томъёолох явдал байсан. Хоёрдугаарт, улирал болгон биелэлтийг шалгах ёстой байв. Ийм механизмаа хийгээгүй учраас мөнгөний бодлогын томъёолол нь зөв орсон ч гэсэн хэрэгжээгүй. Одоо 2010 онд мөнгөний бодлогыг маш буурь суурьтайгаар авч хэлэлцэхгүй бол эргээд л бахь байдгаараа байх болно.

**- УИХ-ын гишүүд Монголбанкныханд дахиад залилуулахгүйн тулд мөнгөний бодлогод хэрхэн хандах ёстой талаар?**

- Ер нь Монголын эдийн засаг найм, эсвэл арван хувийн инфляцитай байна уу зарчмын ялгаа байхгүй. Харин Их хурлын гишүүд мөнгөний бодлогыг эдийн засгийн өсөлтийг идэвхижүүлэх, Сангийн яамны төсвийн бодлоготой уялдуулан хэрэгжилтэд чиглүүлж, ур дунг голлоход л анхаарах ёстой. Харьялалдаа байгаа нэгжийнхээ бодлого үйл ажиллагааг идэвхжүүлмээр байна. Ажлын үр дүнг нь улирал болгон дүгнээд явах хэрэгтэй. Ажлаа хийж чадахгүй байгаа хүмүүсийг солих хэрэгтэй. Гишүүд олон хуудас бодлогод залилуулах хэрэггүй. Мөнгөний бодлого гэж гурван хуудас материал байхад л болно.

Ерөөсөө энэ эдийн засгийг мөнгөөр хөдөлгөхөд юу дутаад байна, яагаад банкны секторт өрсөлдөөн болохгүй байна, яагаад банкууд компаниудад зээл өгье гэж хоорондоо өрсөлдөхгүй байна, яагаад банк ч, компани ч өсдөг бодлогыг явуулахгүй байна, яагаад хүн болгон чөтгөрийн тойрогт тухайлбал, хөдөө орон нутагт 60 мянган малчин зээлийн өрөнд орчихсон ийм гажиг тогтолцоо байгаад байна, яагаад энэ зээлийн багцуудад нь үйлдвэрлэл үйлчилгээг дэмждэг, зорилтот түүний дотор байгаль орчин, эрчим хүч хэмнэдэг технологийг дэмждэг банкууд байхгүй байна гэдэгт дүгнэлт хийж ажиллах шаардлагатай. Энэ бүхний хариу өрсөлдөөн байхгүйд л байгаа юм. Тийм учраас УИХ-аас Төвбанкинд өрсөлдөөнийг бий болгоход анхаарч ажиллах тодорхой үүрэг даалгавар өгөх юрэгтэй. Бизнесийг авч явдаг гол хүч өрсөлдөөн. Банкны салбар ч бас бизнес. Тэгвэл банкинд яагаад өрсөлдөөн байхгүй байна. Энэ нь эрүүл бишийн шинж мөн биз дээ. Тэгвэл энэ эрүүл бус шинжийг илааршуулахад чиглэсэн бодлого, арга хэмжээ авах ёстой.

Дээр нь Монголын эдийн засаг мөнгө хэрэгтэй байна уу гэдгийг бодолцох. Би одоо нэг зүйлийг ярьж, хэлээд байгаа. Хүмүүс тэнэг гэж ч бодож магад. Эдийн засаг руу мөнгө гарга, хэрэв инфляци өсвөл миний толгойг аваарай гэж хэлээд байна. Инфляци өсөхгүй гэдгийг мэдэж байна. УИХ-ын гишүүн О.Чулуунбат бид хоёр мөнгө гарга аа, яах ч үгүй гээд нэг л зүйлийг өөр хэлбэрүүдээр яриад байгаа шүү дээ.

Тэгэхээр 2010 оны мөнгөний бодлого тодорхой зорилготой байх ёстой. Тэр зорилгодоо хурэх арга хэрэгсэл нь ямар ч байж болно. Заавал классик тийм юм байх хэрэггүй. Монголын эдийн засаг мөнгөжөөгүй эдийн засаг байна. Эдийн засагт мөнгө хэрэгтэй байна. Мөнгөний ямар ч бодлого байж болно, гол нь үр дүнд л хүрсэн байх ёстой.

**- Хөгжлийн банк байгуулах талаар та ямар бодолтой байна вэ?**

- Манай банкны систем нь хөгжлийн том том төслүүдийг хэрэгжүүлэх боломж ойлгохгүй байна. Өөрөөр хэлбэл, банк санхүүгийнх нь орчин муу байгаа учраас хүмүүст хөгжлийн банк байгуулах юмсан гэсэн санаа орж ирсэн. Гол ерөнхий санаа нь урт хугацааны төслийг, бага хувийн хүүгээр санхүүжилдэг банк л байх юм шүү дээ. Гэхдээ ийм банк байгуулсан олон орны туршлагаас харахад ихэнх нь дампуурсан байдаг юм билээ. Авлига, хээл хахууль, улс төрийн пракцуудын бүлэглэлийн сонирхлын зөрчилдөөнөөс болж, дампуурсан байдаг.

Манай улсын хувьд ил тод байдал дутмаг, нам нь төрийнхөө дээр гарсан, эдийн засгийн бүлэгүүд үүссэн өнөөгийн нөхцөлд том эрсдэл дагуулах асуудал гэж бодож байгаа. Гэхдээ гадаад менежменттэй, бие даасан, дотоодын санхүүгийн системийн дотор, бусад санхүүгийн нэгжүүдэд эерэг нөлөө үзүүлэх банк гараад ирвэл сайн. Харин банкны салбарт өрсөлдөөн бий болгохын оронд битүү цагираг үүсгэж ажиллах юм бол тогтвортой байдал талаасаа буруу. Сайн бодож хийх ёстой асуудал. Би Японы экспиртизүүдэд Хөгжлийн банк ерөнхий чиг үүргээсээ гадна Монгол Улс худалдааны орон гэдгийг бодолцож, экзим банкныг үүргийг гүйцэтгэх ёстой. Бизнесийг хөнгөвчлөх төрөл бүрийн зээлээс гадна, баталгаа, даатгалын системтэй холбож, олон бүтээгдэхүүн багцийг дотроо шингээсэн зээлийн багцууд гаргах замаар хэрэглэгчдийг татах, зөв санхүүжилт олгож ажиллавал сайн үлгэр жишээг авчирна гэж хэлсэн.

- **“Монгол шуудан”, “Хадгаламж” банкуудын нэгдлийг та юу гэж үзэж байна вэ?**

- Өмнө нэг зүйлийг хэлмээр байна. Танхим хоёр жилийн өмнө банкныг өмчлөлийн талаар ярьж, бичиж байсан. Одоо УИХ үндэсний банкуудын өмчлөлийн зохистой бодлогын талаар мөнгөний бодлогод суулгаж өгөх цаг болсон.

Банкууд томрох хэрэгтэй гэсэн зүйлийг сүүлийн үед хүмүүс их хэлэх болж. Өрсөлдөөн байхгүй нөхцөлд банкиг хүчээр томруулж болдоггүй юм аа. Өрсөлдөөн байгаа нөхцөлд томрох нь томроод, жижиг банкууд өөрсдийн зах зээлээ олоод явдаг. Хамгийн гол нь банкуудын ар талын сонирхлын зөрчил, хариуцлагатай, банкны ил тод бизнес чухал юм. Энэ асуудалд болгоомжтой хандах ёстой. Ер нь бол өрсөлдөөнгүй нөхцөлд томроод ч, жижигрээд ч яах вэ дээ.

Дээрх банкуудын хувьд нэгдэн нийлсэн явцыг банкууд сулраад байгаагийн шинж гэж л үзэж байна. Гэхдээ нэгдэн нийлснээрээ банкны салбарт өрсөлдөх хэмжээний бүтээгдэхүүний багц гаргаж, нийлүүлж чадвал энэ нэгдлийг сайн болжээ гэж үзнэ. Эцсийн эцэст банк бол бизнес, бизнес бол өрсөлдөөн шүү дээ.

*www.mongolchamber.mn,  
2009 он*

## **АЖЛЫН АРГА БАРИЛ ХУУЧНААРАА ЯВАХ ЮМ БОЛ БИЗНЕСИЙН ОРЧИН БАЙХ БАЙДГААРАА Л БАЙНА**

*Улиран одож буй 2008 он айлчлан ирж буй 2009 оны зааг дээр МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлтэй үулзаж, өнгөрч буй онд Танхимаас зохион байгуулсан ажлууд хэр үр дүнтэй явагдсан, ирэх жилд юуг хийхээр төлөвлөсөн болон улс орны эдийн засгийн байдлыг хэрхэн дүгнэж байгаа талаар нь сонирхлоо.*

- **Танхимаас 2008 оныг Компаний нийгмийн хариуцлагыг дэмжих жил болгон зарласан билээ. Энэ хүрээнд ямар бодит ажил хийснийг сонирхох байна?**

-2007 онд Танхимын дэргэд Компаний нийгмийн хариуцлагын зөвлөл байгуулагдсан. Энэ зөвлөлийн үйл ажиллагааны гол чиглэл нь Танхимын гишүүн байгууллагууд болон нийт бизнес эрхлэгчдэд Компаний нийгмийн хариуцлага /КНХ/ гэж юу болохыг сурталчлан таниулах, хамтран ажиллах зорилготой. Энэ жил КНХ-ын талаарх компаниудын ойлголт хэр байгаа, энэ чиглэлээр ямар ажлууд зохион байгуулж буй талаар тандалт хийх зорилгоор КНХ-ын тайланг авсан юм. Нийт 50 гаруй компаниас тайлан ирсэн бөгөөд энэ нь Монголд анхны КНХ-ын тайлан гаргасан ажил болсон гэж үзэж байна. КНХ хэрэгждэггүй бусад улс орнуудтай харьцуулах юм бол энэ нь нэлээн сайн үзүүлэлт. Саяхан болсон НҮБ-ын их хуралд манай төлөөгчид оролцоод КНХ-ын асуудал дээр гайгүй үнэлгээ авсан. КНХ-ыг сайн хэрэгжүүлсэн, идэвхтэй оролцсон манай компаниудыг НҮБ-ын вэб сайтад мэдээллээ тавих бодит урамшуулалыг олголоо.

Ажиглаад байхад зарим компаниуд КНХ гэдгийг ажилчдынхаа нийгмийн хамгаалалын чиглэлээр хийсэн цалин хөлс урамшуулалыг нэмсэн, спортын үйл ажиллагааг ивээн тэтгэсэн зэрэг ажлуудыг хийх гэсэн явцуу хүрээнд ойлгоод байх шиг. Гэтэл угтаа тухайн компанийн хөгжлийн загвар нь нийгмийнхээ нэг хэсэг, эд эс нь гэдгийг ухаарсан, аль ч компанид ашиг нэмэгдүүлэх гэсэн өөрийн зорилт байдгийн хажуугаар байгаль орчин, нийгмийн тулгамдсан асуудлуудад анхаарлаа тавьж, санаачлагатай ажиллаж чадах юм бол ашиг орлого нь нэмэгдэж байдаг гэсэн философи.



КНХ-ын Азийн зөвлөлд багтдаг орнуудтай харьцуулах юм бол Монгол Улсад энэ ажлын эхлэл гайгүй, сайн тавигдсан. Гэвч зарим нэгэн дутагдалтай зүйл ажиглагддаг. Бүтэн жилийн турш компаниудын дунд ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дунд энэ чиглэлээр тодорхой үр дүнтэй ажил зохиож чадсангүй. Тухайлбал, КНХ-ын Зөвлөлийн үзэсгэлэнг Мишээл Экспод хийсэн нь халтуурдсан ажил болсон. Тийм учраас өнөөдөр энэ зөвлөлийг хариуцсан нарийн бичгийн дарга муу гэсэн ажлын үнэлгээ аваад явж байна. КНХ-ын Зөвлөлийн даргыг энэ чиглэлээр Монголдоо санаачлагатай ажилладаг газар буюу Хас банкыг сонгож тус банкны ерөнхий захирал М.Болдыг тавьсан.

2008 онд КНХ-ын чиглэлээр хийгдсэн ажлуудыг дүгнэхэд, илгээх тал дээр сул ажилласан нь ажиглагдсан. Хэдхэн компанийн дунд л эргэлдсэн үйл ажиллагаа явуулжээ. Тодорхой үйл ажиллагаа явуулаад эхэлчихсэн том компаниудын үйл ажиллагааг сурталчлахад олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй хамтраад олон янзын шинэ арга хэлбэрээр, тухайн компаниудыг тодорхой нэг нийгмийн үйл ажиллагаанд дайчлан оролцуулах, урамшуулах зэрэг ажлууд дээр дутагдалтай ажилласан. Бид үүнд дүгнэлт хийж, ирэх жил тодорхой арга хэмжээ авах болно.

**- Орон нутгийн салбар Танхимууд энэ онд хэр ажилласан бэ?**

- Шулуухан хэлэхэд муу ажилласан. Мэдээж хэрэг бидний зүгээс дэмжлэг урамшуулал дутсан тал бий. Удирдлагын зүгээс, тэднийг хариуцсан хэлтсийн зүгээс ч гэсэн хамтран ажиллах, уялдаа байхгүй, сул үлбэгэр байдалтайгаар буюу цаасаар харьцдаг, тайлан нэхдэг. Өөрөөр хэлбэл, амьд бодит харьцаагүй болсон тал ч ажиглагдсан. Тухайн орон нутгийн танхимын дарга нар яагаад сайн ажиллаж чадахгүй байгаа, хөдөөгийн бизнесийнхэнд чиглэсэн үйл ажиллагаа явуулж чадаж байна уу гэсэн асуултад тухайн үед нь шуурхай онош тавиад, тодорхой арга хэмжээ авах асуудлыг төв Танхимаас гаргаж байх ёстой байлаа.

Нөгөө талаас орон нутгийн Танхим төлөвшин тогтох үйл явцад хувь хүний хүчин зүйл нэн чухал юм. Өөрөөр хэлбэл, танхимын дарга болон гүйцэтгэх захирал нь хэн байгаа болон бизнес эрхлэгчдийнхээ дунд хэр нэр хүндтэй, түүнийгээ хэрхэн ашиглаж чадаж байгаа, үндэсний танхимтайгаа хэр идэвхтэй холбоотой ажиллаж байгаагаас нөлөөлж байдаг. Хэдийгээр Танхимын зүгээс төрөл бүрийн сургалт, семинар зохиох, үйл ажиллагаанд нь бодит дэмжлэг үзүүлсээр байгаа хэдий ч бүхэлд нь аваад үзэхэд салбар танхимуудын үйл ажиллагааг муу гэж дүгнэж байна.

Орон нутагт Германы төслөөр олон жижиг төслүүдийг амжилттай хэрэгжүүллээ. Энэ төслүүд амжилттай хэрэгжсэн нь тухайн орон нутгийн танхимуудын үйл ажиллагааных нь сайных биш. Төсөлд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн идэвхтэй үйл ажиллагаанаас хамаарч амжилттай хэрэгжиж байна гэсэн үг. Түүнээс гадна салбар танхимуудын дунд бодлогын өмгөөлөлийн чиглэлээр буюу тухайн орон нутгийнхаа бизнес эрхлэгчдийн нийтлэг санал хүсэлтийг сайн судлаад, засаг захиргаандаа асуудлыг зөв, хүчтэй тавих гэсэн бодлогын чанартай үйл ажиллагааг сул явуулж байгаа нийтлэг дутагдал мөн ажиглагдаж байна. Эдгээр асуудлыг 2009 онд арилгах хэрэгтэй. Ирэх онд олон салбар танхимын үйл ажиллагаанд өөрчлөлт хийнэ.

Эцсийн дүнд Танхим бизнес эрхлэгчдээр өөрийгөө хүрээлүүлсэн, энэ юм хийдэг байгууллага шүү? гэж хэлүүлдэг, мэдрүүлдэг байгууллага байх ёстой. Хүн хичнээн сайн ажилладаг толгойтой байгаад хөл муутай бол хийж бүтээх ажлын үр дүн муу л байдагтай адил төв Танхим сайн ажиллаа ч орон нутгийн салбар Танхимын үйл ажиллагаа муу байвал ажил хэзээ ч жигд эрчтэй урагшилж чадахгүй. Тийм ч учраас 2009 онд салбар танхимуудын шл ажиллагаанд эрчимтэй өөрчлөлт хийнэ, мөн төв танхимаас хариуцан ажиллаж байгаа хүмүүсийн үйл ажиллагааг идэвхижүүлэх арга хэмжээг авч ажиллана.

**- Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бизнес эрхлэгчдийн дэвшүүлсэн саналуудын 70 гаруй хувь нь тусгагдсан гэсэн. Харин зарим нь үүнийг бизнесийнхний амыг дагуулсан аргацаах гэсэн юм биш биз гэсэн хардлага явж байна. Та энэ талаар юу хэлэх байна?**

- Шинэ засгийн газар өмнөх засгийн газруудаасаа онцгойдоо биш. Угаасаа Монгол Улсад урьд өмнө явуулж байсан засаглалуудын туршлага юуг өгүүлж байна гэхээр эцсийн дүндээ хүмүүсийн эрэлт хүсэлтийг хэр зэрэг судалсан, тэдэнд зориулсан үйлчилгээг өөрсдөөр нь хийлл/лэх буюу хамтарч ажиллавал илүү үр дүнтэй сайн засаглал болох юм байна гэдгийг баталсан л байхгүй юу.

Бизнесийн орчин хүнд суртал их байх тусмаа хээл хахуул газар авдаг. Ингэснээрээ орчин нь бохирдож, эдийн засгийнхаа өсөлтийг зөвхөн гадаад хүчин зүйлд найдаж, үүнийгээ бурханы хишиг хэмээн боддог. Гэтэл асар их ажлын байр бий болгосон, улсын төсөвт их татвар өгдөггүй хэдий ч олон ажилчид ажиллуулж үр дүнд хүрсэн, олонх хүмүүсийн санал бодол, ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан эдийн засгийн таатай орчин,

нөхцлийг бурдуулэх тал дээр урь урьдын засгийн газар дутуу ажилласан байна гэдгийг ойлгосон, ухаарсан байдал энэ засгийн газарт ажиглагдаж байна. Тийм учраас тэр 70 гаруй хувь гээд байгаа саналыг бид гаргасан юм. Өөрөөр хэлбэл, Танхимаас сонгуулиас өмнө хоёр намтай байгуулсан санамж бичиг болон бизнес эрхлэгчдийн өгсөн саналуудыг засгийн газрын мөрийн хөтөлбөртэй нэг бүрчлэн тулгаад шууд болон шууд бус утгаар тусгагдаж уу гээд үзэхэд ерөнхийдөө 70 гаруй хувь нь орчихсон байгаа. Засгийн газар мөрийн хөтөлбөрөө УИХ-д танилцуулахдаа энэ удаагийн мөрийн хөтөлбөрт бизнес эрхлэгчдийн нэгдсэн санал тэр дундаа Танхимын саналыг нэгтгэн тусгалаа гэсэн өгүүлбэрийг зориуд тусгайлан оруулсан байсан.

Үүнээс харах юм бол энэ засгийн газрыг дэвшилттэй шинэ санаа, бодлогоор ажлаа эхэлж байна гэж дүгнэж болно гэхдээ хэрэгжүүлэх арга нь ямар технологи, ямар хэлбэрээр явагдах гэдэг нь чухал. Зүгээр нэг хэдэн яамдууддаа тараагаад, тэд нар нь өөрсдийнхөө төлөвлөгөөг гаргаад биднээс нэг санал авсан болоод явах юм уу эсвэл бодитой ажлын хэсэг байгуулаад тодорхой асуудлаар хамтарч, харилцан зөвшилцөх байдлаар шийдвэрээ гаргадаг, эцсийн үр дүнгийн нь төлөө хамтран хариуцлага хүлээдэг механизмаар ажиллах уу гэдэг асуудал дээр анхаарах л хэрэгтэй.

**- Засгийн газраас 2009 оныг үйлдвэржилтийг дэмжих жил болгон зарлалаа. Таны хувьд Засгийн газар чухам юу хийгээсэй гэж бодож байна?**

- Танхим маш их дэмжиж байгаа. Яагаад гэвэл бидний хүсэн хүлээж байсан сэдэв. Хувийн хэвшлийн түншлэлийн механизмыг өрнүүлнэ, хөгжүүлнэ гэж Ерөнхий сайд, Шадар сайд ярьж байгаа тохиолдолд яг одоо л бидний саналыг авах хэрэгтэй. Гэтэл харамсалтай нь үйлдвэржилтийг дэмжих жилийн төлөвлөгөөг нь харахад хувийн хэвшлийнхний салбараас тусгасан зүйл байхгүй байна лээ. Хэрвээ ам ажил хоёр ингэж зерөөд байх юм бол нөгөө яриад байгаа түншлэл маань хөгжихгүй гэсэн шүүмжлэлийг саяхан болсон үйлдвэржилтийн чуулга уулзалтан дээр нэлээдгүй хүмүүс бухимдуу ярьж байсан.

Засгийн газар, хувийн хэвшлийн түншлэлийг хангана гэхихээд, засаглалын технологи буюу ажлын арга барил нь хуучнаараа байх юм бол энэ асуудал цаашдаа үр дүнтэй ажил болж чадахгүй. Танхим Засгийн газрыг хүлээгээд суухгүй тодорхой асуудал дэвшилүүлж санаачлагатай ажиллана.

**- Сүүлийн үед Засгийн газрын 100 хоног сэдвийн дор хувийн хэвшлийнхний дунд нэлээдгүй уулзалт, чуулган зохион**

**байгуулагдаж байна. Эдгээр арга хэмжээний үеэр Засгийн газарт тендэр, төсөл сонгон шалгаруулалт, зөвшөөрөл зэрэг төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудад өгөх нь зүйтэй гэсэн санал давамгайлж байсан. Харин Та энэ талаар ямар бодолтой байна?**

- Даахгүй нохой булуу хураана гэдгийн адилаар төр хийх ёсгүй зүйлээ, эсвэл өөрийнхөө явцуу сонирхлоор дэндүү их ажлыг өөртөө хураадаг. Төрийн оролцоо хэт ихэдсэнээс болж хүнд суртал, хээл хахуул газар авч, хувийн хэвшлийнхний тогтвортой үйл ажиллагаанд саад болдог.

Бид засгийн газар бүрэлдсэний дараахан төрийн ямар ямар чиг үүргийг төрийн бус байгууллагуудад шилжүүлж болох санал явуулсан. Үүний үр дүнд БОЯ, ХХААХҮЯ зэрэг яамдууд 10 гаруй байгууллага, мэргэжлийн холбоодуудтай гэрээ байгуулаад эхэллээ. Энэ нь хэдийгээр жижигхэн ч гэсэн үр дүн.

Тендэр гэсэн нэрийн дор маш олон булхайтай үйлдэл явагддаг. Тиймээс хөндлөнгийн хараат бус байгууллага тодорхой хэмжээгээр тендэрт хэрхэн хяналт тавих тухай хууль эрх зүйн актанд суулгаж өгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол жишээлбэл, Танхим сайн дураараа энэ асуудлыг аваад хийнэ гэдэг худлаа.

Тендэрийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийн тоо, хамрах хүрээг багасгах чиглэлээр 2009 онд нэлээд ажил санаачлах хэрэгтэй байна. Ирэх онд Засгийн газарт Танхимаас санаачлан Бизнес эрхлэлтийн индекс буюу бизнес эрхлэлтийн ерөнхий орчингоороо Монгол Улс Азидаа эхний аравт орох ёстой гэсэн том боловч бүрэн биелэх боломжтой асуудлыг дэвшүүлсэн. Үүнийг Ерөнхий сайд ч дэмжсэн. Хамтын ажиллагааны хүрээнд хамгийн түрүүнд хийж цэгцлэх асуудлуудын нэг бол тендэрийн асуудал байгаа.

**- Эдийн засагч хүнээс нэг асуулт асууя. Өнөөгийн манай эдийн засаг ямар түвшинд байна? Инфляцийн хэт өсөлт нь юунаас шалтгаалж байна вэ?**

- Инфляци аядуу буюу мөлхөө түвшинд байх ёстой. Тоогоор илэрхийлэх юм бол нэг оронтой тоо буюу 6-8 хувьтай байж болно. Гэтэл нөгөө инфляци аядуу түвшин буюу доод түвшингээсээ даваад бүр хоёр оронтой тоонд хүртлээ өсчихөөр энэ нь эдийн засагт маш хортой нөлөө үзүүлээд эхлэнэ.

Эрэлт, нийлүүлэлт, мөнгө болон мөнгөний бүс гэсэн инфляцид нөлөөлөх олон хүчин зүйлс байдаг. Инфляци өсч байгаа тохиолдолд Монгол банкнаас мөнгөний нийлүүлэлтэнд тодорхой хэмжээний хязгаарлалт хийж болно. Гэхдээ одоо Монгол банкны

удирдлагуудын тайлбарлаж байгаа шиг тухайн үед бид мөнгөний нийлүүлэлтийг багасгаагүй бол одоо хямрал яриад сууж байх байсан юм гэсэн үг нь шал худлаа. Тухайн үед инфляци бараг талхны үйлдвэрүүдийн үүнийг хянаад эхлэх тэр үед бид талхны үнийг хянахын оронд Засгийн газрынхаа зардлыг хяна, бизнесийн идэвхжилийг нэмэгдүүлэх тал дээр анхаараачээ гэсэн өөрсдийн зөвлөмжийг хүргүүлж байлаа. Арилжааны банкуудын эрүүл мэнд тэр үед гайгүй байсан. Харин Төв банкны эдийн засаг дахь валютын нөөцийг удирдах, бизнесийн бодит секторын идэвхжилийг хангах зэрэг үйл ажиллагаануудыг хамгийн идэвхгүй явуулсан.

Монгол банк УИХ-аас инфляцийг тодорхой түвшинд барих ёстой гэсэн үүрэг авчихсан тэр үед инфляци нь өөрөө аядуу түвшинд байсан. Гэнэт нөгөө дэлхийн эдийн засгийн хямрал үүсээд, инфляци нэмэгдэх мер, мөнгөний нийлүүлэлтийг багасгаж инфляцийн түвшинг барина гэсэн энгийн сурах бичгийн хүрээнд сэтгээд түүнийхээ дагуу арга хэмжээ авсан. Энэ нь эдийн засгийн бодит секторуудын цусыг боосон үйл ажиллагаа болсон.

Нөгөөтэйгүүр банкуудыг удирддаг зохистой харьцаа нь зөвхөн банкууддаа хандсан болохоос биш тэр банкуудын харилцагч нарын “эрүүл мэндэд” хандаагүй, амьдралд ойрхон биш, валютын нөөцийг тэр болгон удирдаж чадаагүй. Ялангуяа улсын үйлдвэрүүдийн валютын нөөцийг удирдаж чадсангүй.

Валютын зохицуулалтын тухай хууль нь ч иймэрхүү байдлыг өөгшүүлсэн хууль байдаг. Амьдрал мэддэг хэсэг эрхэм гишүүд инфляцийг барихын тулд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх шаардлагатай гэдгийг ухаараад 2009 оны Монгол банкны мөнгөний бодлогод эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх гэсэн зөв томъёололыг хэдийгээр оройтсон боловч оруулж өгсөн. Үүнтэй холбогдуулаад Засгийн газраас аймаг болгонд 1 миллиард төгрөг хувиарлаж байна. Энэ нь тийм ч хангалттай биш үйлдвэржилтийг хөгжүүлэх, дэмжихэд асар их санхүүжилт шаардлагатай. Хамгийн гол нь бизнесийг хаан боогдуулсан актуудыг багасгах, эрх зүйн орчныг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй.

*Ц.Оюунханд*

*Бизнес таймс сонин, 2008 он, №36/566/*

## ТУУЛЫГ БОХИРДУУЛСАН АРЬС ШИРНИЙ ҮЙЛДВЭР ШИГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЦААШДАА ОРЖ ИРЭХГҮЙ

*“Монгол, Хятадын бизнес форум”-д хоёр улсын 100 гаруй компанийн төлөөлөгч оролцлоо. Форумын үер МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлтэй үулзлаа.*

**- Бизнесийн ямар салбарт хамтран ажиллах санал солилцож байна вэ?**

- Хятадын томоохон компанийн төлөөлөгчид энэ форумд оролцож байна. Өөрөөр хэлбэл, дэлхийд нэртэй, Хятадаа ТОП 100-д ордог компанийн төлөөлөгчид Хятадын дэд даргыг дагалдан ирсэн. Манайхаас ч олон компани оролцож байгаа. Энэхүү форумар бид цаашдаа хоёр орны бизнесийн харилцаанд хамтран хэрэгжүүлэх томоохон төслүүдийн талаар тохиролцох юм. Ашигт малтмалын ордыг байгаль орчинд халгүй орчин уеийн техник, технологи ашиглах чиглэлээр Хятадад хэрэглэж байгаа дэвшилтэт арга, амжилтыг хуваалцах, Хөдөө аж ахуй, дэд бүтэц, зам тээвэр, логистикийн асуудлууд, усан цахилгаан станц, худалдаа гээд цаашид манайд байгуулагдах аж үйлдвэрийн паркуудад хамтарсан үйл ажиллагаа явуулах тухай санал солилцож байна. Бид дээрх хувилбаруудаас гадна байталь орчны аюулгүй байдлын асуудлыг дотоод, гадаадын бизнес эрхлэгчдэд онцгой анхааруулж байгаа. Өнөөдөр дэлхий даяар маш чухалд тавигдаад байгаа байгаль орчин, цаг агаарын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг Монгол, Хятадын компаниуд нийгмийн хариуцлагаа ухамсарлан хамтарч ажиллах болно.

**- Байгаль орчинд халтай үйлдвэрүүдийг яаж цэгцлэх вэ?**

- Аж үйлдвэрийг байгаль орчны асуудал байнга дагаж явдаг. Өнөөдөр эдийн засгийн хувьд өрсөлдөх чадвар гэдэг бол зөвхөн мөнгө хөрөнгө, ашиг олохоор хязгаарлагдахгүй. Байгаль орчинд халгүй технологи хэрэглэснээр аж үйлдвэрийн эдийн засгийн өрсөлдөх чадвар тодорхойлогдож байна. Иймээс байгаль орчинд хор хөнөөлтэй технологиор үйлдвэрлэл явуулахгүй. Жишээлбэл Туул голыг бохирдуулдаг арьс ширний үйлдвэрүүд шиг хөрөнгө оруулалт цаашдаа орж ирэхгүй гэсэн үг юм. Ийм үйлдвэрүүдийг

зах зээлээс шахаж гаргана. Гэхдээ хүчээр биш, тэд өрсөлдөөний явцад хуучин технологитойгоо аяндаа устана. Үүнээс гадна гадаадын хөрөнгө оруулалтын хуульд дэндүү либериаал маягийн заалт орсон байдаг. Хамгийн гол нь, бид гадаадын хөрөнгө оруулалтын чанарын асуудлыг анхаарч байна. Бас зарим салбаруудад хөрөнгө оруулалтын доод босго хэмжээг зааж өгөх ёстой гэж бодож байна.

**-Эндээс олборлосон нефть Хятадад боловсруулаад оруулж ирэх, нефть авах зэрэг асуудал яригдаж байсан. Энэ талаар тодруулж өгнө үү?**

- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, нефтийн бүтээгдэхүүн импортлогч компаниуд энэ чиглэлээр санал солилцож байна. Цаашдаа Монгол, Хятадын хамтран ажиллах нэг салбар бол газрын тос олборлолт, бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм. Жишээлбэл, газрын тосыг Хятадаас оруулж ирээд боловсруулах эсвэл урд хөршид үйлдвэрлэл явуулах боломжийн талаар ярьж байгаа. Одоо энэ яригдаад байгаа нефтийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн асуудал удахгүй биеллээ олно гэж үзэж болох юм.

**- Хэдэн жилийн дараа бид нефтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох вэ?**

- Ийм ажилд наад зах нь 4-10 жил шаардлагатай. Тэгэхээр ирэх дөрвөн жилд эхний үр дүн гарна байх гэж бодож байна. Газрын тос, нүүрс боловсруулж шингэн түлш гаргадаг болно гэсэн үг л дээ. Гэхдээ хамгийн гол нь газрын тос байгаа гэдэг ч олборлолт нь манайд үйлдвэрлэлийн хэмжээнд хүрч чадах уу, үгүй юу гэдгийг анхаарах ёстой. Хятад бол газрын тос олборлогч орон юм. Тиймээс ирэх дөрвөн жилд их тодорхой төслүүд хэрэгжээд эхлэнэ. Мөн бусад үйлдвэрлэлийн чиглэлээр олон төсөл хэрэгжүүлнэ. Жишээ нь, усан цахилгаан станц барих, хөдөө аж ахуйн аж үйлдвэржүүлэлтэд ч бас тодорхой үр дүн гарна.

**- Гадаадын хөрөнгө оруулалт хэр орж ирэх вэ?**

- Төд төчнөөн хөрөнгө оруулалт гэхээсээ илүү чанарыг анхаарах цаг болсон. Бид урд хөршийнхөө хөрөнгө оруулалтын хэмжээнээс илүү чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, олон улсын хэмжээнд танигдсан томоохон компаниудтай нь хамтарч ажиллахад онцгой анхаарч байна. Өнөөдөр бид байгаль орчныг хордуулдаг, эсвэл болсон болоогүй бүтээгдэхүүн гаргадаг төмрийн жижиг үйлдвэр оруулж ирэхийг бүр мөсөн зогсоогоод байгаа.

*Т.Эрдмаа*

## МАНАЙ НӨХЦӨЛД БОНД ГАРГАХ НЬ АРАЙ ЭРТЭДНЭ

*МУХАУТанхимын дарга, доктор С.Дэмбэрэлийг “Ярилцах танхим”-даа урьж ярилцлаа.*

**- Манай улсын санхүүгийн хямрал дуусах болж байна уу. Аль шатандаа явж байна вэ гэсэн асуултаар ярилцлагаа эхэлье.**

- Тоон үзүүлэлтээр ярих юм бол үйлдвэрлэлийн салбарын өсөлт буурсан, төр, засаг маань зэс, алтны үнэ, гадны зээл, тусламж зэрэг “бурхны хишиг” хардаг тэр л хэмжээндээ хэвээрээ байна. Банкны секторууд унасан гэх мэт үзүүлэлтүүдийг харвал хямрал маань бүр архагшиж, ужгирах үедээ орчихсон гэлтэй. Санхүү, банкны орчин сайжрахгүй байна. Хоёр банк бизнесийн салбараас гарлаа. Үүнээс болж бусад банк зээл өгөхөө болгоомжилж эхэлсэн.

**- Таны бодлоор үүнд хэн буруутай вэ?**

- Ерөөсөө мөнгөний бодлого нь буруу. Сангийн бодлого нь үүндээ нөлөөлж чадаагүй. Саяхан Монгол банкнаас судалгаа хийсэн байна. Гэтэл тэр нь бидний дөрөв, таван жилийн турш хэлээд, анхааруулаад байсан юмыг л гаргаж ирж. Хүмүүс банкинд бус өөрт нь тохирсон нөхцөлтэй санхүүжилтийг хүсч байна. Үүнийг төрөөс бодлогоор, санхүүгийн аргаар дэмжүүлэхийг хүсдэг. Дээр нь барьцаа хөрөнгө байхгүй учраас зээлийн баталгааны схемийг яаралтай хэрэгжүүлээсэй гэж хүсдэг. Жижиг бизнесийнхэн тоног төхөөрмжөө лизэнгээр авахыг хүсч байна. Хүмүүс ийм л юм хүсч байна. Үүнийг л Засгийн газар Төв банк, Сангийн яам холбогдох яам, байгууллагатай хамтраад хийх ёстой. Ийм л юмыг дээрх судалгаагаараа гаргаж ирсэн байна. Тиймээс манай танхимаас “Та бүхний гаргасан судалгааг бид 100 хувь дэмжиж байна. Одоо санхүү, зээлийн орчныг сайжруулах чиглэлээр Засгийн газрын хөтөлбөр боловсруулаад хамтран ажиллая” гэсэн санал явуулсан байгаа.

**- Та “Монгол банкны бодлогыг эсрэгээр нь хэрэгжүүлэх хэрэгтэй” гэж ярьдаг байсан. Үүнийгээ дэлгэрүүлээд тайлбарлаж өгөхгүй юу?**

- Засгийн газарт зөвлөмж өгөхдөө тэгж хэлсэн нь үнэн. Утга нь төрөөс инфляцийг “онилох” мөнгөний бодлого бодит амьдралаас тасархай байна. Амьдралд ойртуулахын тулд хувийн

хэвшлийнхний үгийг сонсч, тэдний хүсч байгаагаар л бодлогоо явуулбал энэ хямралаас чинь гарч чадна гэсэн л санаа. Монгол банкны Ерөнхийлөгч хэн байх нь хамаагүй. Гагцхүү УИХ-ын гишүүд төрийн мөнгөний бодлогод хандах хандлагаа өөрчлөх хэрэгтэй байна. Жил бүр л мөнгөний бодлого гэж нэг юм оруулж ирээд тал талаас нь хэлэлцдэг. Сүүлийн үед бүр загнадаг болжээ. Гэхдээ оруулж ирсэн чигээр нь баталчихдаг. Энэ л хандлагаас татгалзах хэрэгтэй байна. Оронд нь улирал бүр мөнгөний болон сангийн бодлого хэр зэрэг уялдаатай явж байна, мөнгөний бодлого эдийн засгийг өөгшүүлж чадаж байнауу гэдгийг судалж гаргах хэрэгтэй. Инфляцийг мөнгөөр удирдах гэсэн монетарист хандлагаас татгалз гэмээр байна. Түүнээс биш өөрт ганц байдаг бодлогын хүү гэдэг зүйлээ дээш, доош нь болгох замаар эдийн засгаа зохицуулж байна, инфляциас авраад байна гэж хэлдэг үг нь зөөлнөөр хэлбэл тэнэг эндүүрэл юм.

**-Төрийн банк байгуулсан нь зөв үү. Төр арилжааны банкны үүргийг гүйцэтгэж болдог юм уу?**

-Төр арилжааны банкны үүргийг гүйцэтгэж болохгүй. Гэхдээ төр бол санхүүгийн зах зээлийн нэг тоглогч нь юм. Харин өр хөгжлийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэх, тэргүүлэх ач холбогдолтой гэж үзсэн салбараа дэмжих, ажлын байр бий болгох, ядуурлаас сэргийлэх зэрэг зорилтуудыг биелүүлэхийн тулд өөрт байгаа хөрөнгөөрөө, арга хэрэгслээрээ хөгжлийн тодорхой төслүүдийг хэрэгжүүлж болно.

Түүнээс биш арилжааны чанартай үйл ажиллагаа эрхэлбэл явуургүй. Ийм төрлийн банк дампуурахгүй л оршиж байх ёстой. Арилжааны банкууд шиг хэт ашиг хөөж болохгүй. Өнөөдөр арилжааны банкууд зээл өгөхдөө тэртээ таван жилийн дараа ашиг гарах ажилд өгөлгүй жилийн дараа ашиг өгөх төсөлд л өгдөг. Энэ бол арилжааны банкны нэг онцлог. Бизнес нь учраас буруутгах аргагүй. Харин төр хөгжлийн банкаа өөрөө байгуулж аргагүй эрхэнд хөгжлийн чиглэлийн том, том төслүүдээ санхүүжүүлж эхэлж байна. Энэ нь зөв. Гэхдээ банк нь үр ашигтай ажиллах ёстой. Хулгайлдаггүй байх ёстой.

**- Гэтэл Төрийн банкныг улс төрчдийн “мөнгө угаах” газар болно гэсэн таамгийг дэвшүүлдэг л дээ.**

Цаад нарийн учрыг нь би мэдэхгүй байна. Гэхдээ эрүүл явах ёстой, хүмүүсийн итгэл дээр тогтдог салбар руу улс төр ороод ирэхээр бүх юм утгаа алддаг.

**- Хоёр банк дампуурсан шалтгааныг та хэрхэн дүгнэдэг вэ?**

- Арилжааны банкуудынхаа эрүүл өсөх орчныг нь бүрдүүлж чадаагүй. Хүүхдийг өсгөхийн тулд эрүүл орчин байх хэрэгтэй биз. Дээр нь төрөл бүрийн витамин өгч, эрүүл өсч байгаа эсэхийг нь шалгадаг шүү дээ. Үүнтэй л ижил хандаж “аав” эсвэл “ээжийнх” нь үүргийг гүйцэтгэх ёстой байсан. Гэтэл “эцэг, эх” нь үүргээ ухамсарлалгүй “За, аяндаа өснө биз дээ” гээд хаячихсан. Ингэснээс болж “хүүхдүүд” нь өвдөж, алдаж эхэлсэн. Тэр дотор сайн засаглалын алдаанууд байсан. Хоёр дугаарт, банкны системд тохиолддог “хөл алдах” явдал нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл, цөөн тооны харилцагчтай, тэднээсээ хамааралтай болчихсон байсан. Дээр нь банкны ил тод, тунгалаг байдал зэрэг нь Төв банкны энэ оны л мөнгөний бодлогод анх удаа тусгагдлаа шүү дээ. Үүнийг харж байхгүй яасан юм бэ, “ааваа”. Энэ бол хариуцлагын асуудал. Түүнээс бүх бурууг арилжааны банкируу нь чихэж болохгүй.

**- Гэтэл Төв банк “Арилжааны банкны дотоод асуудалд хөндлөнгөөс оролцож болохгүй гэсэн заалт байдаг” гэж ам тагласаар удаж байгаа шүү дээ.**

- Энгийн жишээ ярья л даа. Өнөөдөр банкны салбарт дөнгөж сургуулиа төгсчихсөн залуус арван хэдэн жил хамтарч ажилласан харилцагчийг нь танихгүй гомдоодог. Тэгэхээр энэ асуудлыг “Зоос”, “Анод” өөрсдөө хариуцах ёстой гэж орхиж болохгүй. Хүний хөгжлийн асуудал гэдэг чинь Төв банкны бас нэг чухал үүрэг байх ёстой. Энэ чиглэлээр юу ч хийгээгүй. Түүнчлэн тухайн үед бид арилжааны банкуудыг дипломат хэллэгээр хэлбэл “үлэмж дотночлон үзэх зарчим”-д орчихоод байна шүү гэдгийг хэлж л байсан. Өөрөөр хэлбэл, цөөн тооны оронтой дотно харилцаатай байна гэдгийг хэлж байсан. Үүнийг тухайн үед ойлгосон л байх ёстой. Учир нь Төв банк чинь дотоодын хяналтын системтэй. Тэд ч бас энэ асуудлыг гаргаж тавьж байсан юм билээ. Зарим банк ердөө 20 харилцагчаас хамаардаг байсан.

**- Инфляцийг нэг оронтой тоонд барина гэж ярьдаг. Үүний тулд ямар бодлого явуулах ёстой вэ?**

- Инфляцийг нэг оронтой тоонд барина, барихгүй гэдэг чинь “чепуха” байхгүй юу. Мэдээж хэрэг, 20 эсвэл 30 хувьтай байвал амьдралд хэцүү. Харин найм, ес, арвын хооронд нэг их ялгаа байхгүй. Инфляцийг удирдаж болох түвшинд нь бариад хамгийн гол нь банкуудын үйл ажиллагааг эрүүл байлгах нь чухал.

**- Засгийн газар бонд гаргах тухай их ярьж байна. Нэг хэсэг нь үүнийг буруу гэх. Нөгөө хэсэг нь зөв гэх. Таны бодлоор энэ хэр үр дүнтэй арга вэ?**

- Би Хөрөнгийн бирж, төрийн өмчийн компани зэрэгтэй холбоотой асуудалд жаахан итгэл муутай ханддаг. Цаашид эдийн засгийн ардчиллыг жинхэнэ утгаар нь бий болгох гэж байгаа бол төр янз бүрийн үйл ажиллагаа явуулах нь буруу. Төр өөрөө өмчлөгч, менежер, бизнес гээд хамаагүй юманд хутгалдаж болохгүй. Орчныг нь л бүрдүүлж өгөх ёстой. Харин өнөөдрийн нөхцөлд бондыг би бүтэхгүй асуудал гэж боддог оо нуугаад яах вэ. Баялаг дээрээ сууриалаад бонд гаргах гэж байгаа явдлыг арай эртэдсэн гэж хэлэх байна. Ерөнхий сайдад ч хүртэл би “Аль болох төрийн өмч гэж бага яриач ээ” гэсэн зөвлөгөө өгсөн.

**- Тэгвэл бонд гаргахын оронд ямар арга замыг та санал болгох вэ?**

- Аль болох цэвэрхэн, олон улсын хэмжээнд “сэтгэдэг” хувийн хэвшил, дунд ангийг бий болгох хэрэгтэй. Энэ дунд анги бий болохгүй зовоож байна. Учир нь хүн амын 40 хувь ядууралтай, 400-гаад мянган хүн албан бус, 60 орчим мянган хүн албан сектортой гэсэн судалгаа бий. Эднийг хоёрхон хүчин зүйл л нэгтгэж чадна. Нэг нь төрийн хүний зөв бодлого, урамшуулал, нөгөө нь сэтгэлгээ, авхаалж самбаа. Энэ бүхэн хэрэгжвэл гудамжинд наймаа хийж буй хүн “Компани байгуулвал зүгээр юм байна” гэсэн бодолтой болно. Цаашлаад “Компани байгуулбал зээл авч болох юм байна. Барьцаа хөрөнгөөрөө баталгаанд хамрагдаж болох юм байна” гэх мэт нөхцөлүүдийг нь бүрдүүлчих хэрэгтэй. Энэ арга л зөв юм.

**- Таны зөвлөж буй арга богино хугацаанд хэрэгжих боломжгүй юм даа?**

- Манайхан юмыг хурдан шийдэлтэй болгох гэж их яарах юм. Намайг зарим нь “Энэ нөхөр бондыг ойлгохгүй байна” гэж хэлэх л байх. Би муу, сайн ч олон улсын хөрөнгийн биржүүдийн үйл ажиллагааг судалж, хардаг. Гэхдээ өнөөдөр манай нөхцөлд бонд бол арай эртэдсэн асуудал. Наана нь хувийн хэвшлийнхнээ өөд нь татах гадны хөрөнгө босгох хэрэгтэй болохоос төрөөрөө хөрөнгө босгох гэж явсны хэрэггүй.

**- Оюу толгойн гэрээнд өөрийн саналаа оруулж байсан уу?**

- Хууль зүйн талаас нь мэргэжлийн хүмүүс саналаа боловсруулж байсан. Харин эдийн засаг талаасаа дүгнэх гэхээр тэр үед Техник, эдийн засгийн үзүүлэлт нь байхгүй байсан. Одоо л гарч ирж байна. Тэр үед эдийн засгийн дүгнэлт хийх гэсэн чинь ТЭЗҮ нь байхгүй байсан болохоор хийж чадаагүй. Сонин эсвэл хүний амаар судалгаа хийж болохгүй шүү дээ. Тиймээс тухайн үед Ц.Баярсайхан гишүүнд “ТЭЗҮ нь байгаа гэж сонслоо. Түүнийг нь бидэнд өгөөч. Хөндлөнгийн дүгнэлтийг бид хийж чадна” гэсэн

захидал би бичиж байсан ч хариу өгөөгүй. Тэгэхээр бодвол байхгүй байсан юм болов уу л гэж ойлгож байна. Одоо үүнийг нь авчихвал хөндлөнгийн хяналт, тооцоог нь хийхэд ядах юм алга. Аливаа ТЭЗҮ-гийн үнэлгээг 15 жилийн үр ашиг, хөрөнгө оруулалтыг нь тооцоолчихдог программ байдаг. Гэхдээ сүүлийн үед хүмүүс надад нэг зүйл хэлдэг боллоо.

**- Юу хэлж байна гэж?**

- “Говь бол цөл биш юм” гэж хэлдэг боллоо. Учир нь говьд заг ургадаг, зарим хүн улаан лооль ургуулж байна. Өөрөөр хэлбэл, эко систем нь байна. Харин цөлд бол юу ч байдаггүй, ургамал ургах арга ч үгүй газрыг хэлдэг. Тухайлбал, сахарын цөл байна. Харин говийг цөл болгочихвий гэсэн болгоомжлол их хэлдэг боллоо. Энэ бас бодох л асуудал. Оюу толгойн гэрээнд усны нөөцийг зөв үнэлж чадажуу, хэрэглээг нь зөв тооцоожуу, мөн экосистемд үзүүлэх нөлөөллийг тооцсонуу гэдгийг харах хэрэгтэй байна. Дээр нь манай улсад өнөөдөр экосистемийн үйлчилгээний төлбөр гэдэг юм алга. Мөн “PPP” буюу бохирдуулагч нь төлдөг зарчим Монгол Улсын хууль тогтоомжид байхгүй. Нөгөө талаар, хууль ч биш ч нэг л юман дээр их гайхдаг. Үндсэн хууль, түүнийг дагалдан гарсан хуулиуд гэж бий. Гэтэл эрх зүйн талаас хариултыг нь аль хууль өгөх вэ гэдэг нь тодорхойгүй. Өөрөөр хэлбэл, эцэг, өвгөдөөс өвлөгдөн ирсэн оюутай толгой (Оюутолгой), шараараа урсдаг гол (Шарынгол) гээд энэ их баялгийн экосистемд буюу ус, агаар, зэрэгт хохирол учруулбал аль хуулийг барих вэ. Үүнийг урьдчилан тооцож гэрээндээ тусгажуу гэдэг нь бас л асуулт. “Оюутолгой авралын үүд”, “Оюутолгой хөгжлийн гарц” гэж ярьдаг нь худлаа байхгүй юу. Энэ орд чинь хөгжлийн гарц биш шүү дээ.

**- Харин Таван толгойн асуудал дээрх таны байр суурь?**

- “Эхнээс нь шууд гарга” гэж хэлмээр байна. Гэхдээ байгаль орчны асуудлыг орхиж болохгүй. Түүнээс гадна өртөг бүтээх процесс гэж их яригдаж байгаа. Гэтэл энэ процесс тэртээ тэргүй явагдаж байгаа. Нөгөө талаар улс энэ асуудалд хэтэрхий оролцож байна. “2015 он хүртэлх Эрдэс баялгийн салбарын хөгжлийн үзэл баримтлал” хэмээх хуралдаанд оролцогчид “Эрдэс баялгийн салбарт авторитар дэглэм тогтоохоос болгоомжлох” гэсэн санааг дэвшүүлж байлаа. Ийм томъёолол байхгүй. Гэхдээ хэн ч сонссон утгыг нь шууд ойлгоно. Казахстаны хөгжлийн зам бол бидний сонгох зам биш гэдгийг л хэлмээр байна. “Норвегит очиж үз. Голландын өвчний учрыг сайн ол” л гэж би хэлдэг.

*Сэтгүүлч Б.Уянга*

*Улс төрийн тойм сонин, 2010 он, №024/0024*

## **ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ САЙЖРУУЛАХАД БИЗНЕСИЙНХЭНТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙГ ОНЦОЛЛОО**

*- Олон улсын худалдааг хамгийн бодитой болгодог  
зүйл чинь тээвэрлэлт шүү дээ -*

МҮХАУТанхимын санаачлагаар зохион байгуулж буй “Худалдаа, Эдийн засаг хамтын ажиллагааны Монгол - Орос - Хятадын гурван талт чуулга” уулзалт саяхан болж өнгөрлөө. Чуулга уулзалтад манай талаас МҮХАУТанхимын дарга С.Дэмбэрэл тэргүүтэй 10 гаруй төлөөлөгч, БНХАУ-аас Гадаад худалдааг дэмжих хорооны орлогч дарга Дун Сонгэн тэргүүтэй найман танхимын 23 төлөөлөгч, хойд хөршийн Хакасийн худалдаа аж, үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч С.Б.Адамянаар ахлуулсан таван төлөөлөгч оролцсон юм.

Чуулганаар улс хоорондын худалдааг хөнгөвчлөх, эрчим хүч, экологийн хүрээнд хамтран ажиллах хэтийн төлөв сэдвээр голлон ярилцаж, гурван улсын Худалдаа аж, үйлдвэрийн танхимын тэргүүлэгчид илтгэл тавьлаа. Чуулганы гол зорилт нь улс хоорондын эдийн засгийн эргэлт, өсөлтийг нэмэгдүүлж, гурван улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, эрхлэгчдийн үйл ажиллагаагаа явуулах хууль эрх, зүйн орчин, нөхцлийг сайжруулах тал дээр голлон ярилцлаа.

Ер нь гадаад худалдаа явуулахад тээвэрлэлтийн асуудал зүй ёсоор тавигддаг.

Иймд худалдааг тээвэрлэхэд шаардагдах бичиг баримт бүрдүүлэхэд нэг цэгийн үйлчилгээ өөрөөр хэлбэл, бизнесийн байгууллагууд тээвэрлэлт хийхдээ холбогдох баримтаа аль болох шуурхай бүрдүүлэх бололцоог бүрдүүлэхэд гурван улсын худалдаа аж үйлдвэрийн танхим эрчимтэй ажиллах шаардлагатай байгааг онцоллоо.

Мөн далайд гарцгүй манай орны хувьд ямар нэг байдлаар гарц үүсгэх, тээвэрлэлтийн энэ бололцоог ашиглах нь нэн тэргүүний асуудал болоод байгаа. Энэ асуудлыг манай болон чуулгад оролцож буй хоёр орны Худалдаа аж, үйлдвэрийн танхимынхан чухалчилж байсан юм.

*Энэ талаар МҮХАУТанхимын дарга С.Дэмбэрэлээс цөөн асуултад хариулт авлаа.*

**- Худалдаа тээврийн салбарт ямар хүндрэл бэрхшээл байна вэ?**

- Далайд гарцгүй манай улсын хувьд худалдааны тээвэрлэлт, үүнийг хөнгөвчлөх асуудал нэн тэргүүний асуудал шүү дээ. Харамсалтай нь бид энэ асуудлыг тэр бүр хөндөггүй. Ер нь бол энгийн иргэдээс эхлээд л бизнес эрхлэгчид үүнийг байнга л ярьж байдаг шүү дээ.

Асуудлыг манай ХАУТанхим анхааралдаа авчихаад байна. Бид саяхан “Транзит Монгол” хөтөлбөрийг санаачлан Засгийн газарт асуудлаа оруулаад, батлуулж амжсан.

Улсынхаа эдийн засгийн өсөлт, эргэлтийг сайжруулахад бараа бүтээгдэхүүнээ гадны зах зээлд гаргах шаардлага манай бизнесийнхэнд зүй ёсоор тулгарна. Үүнийг хэрэгжүүлэхэд тээвэрлэлт, хил гаалийн олон шат дамжлага, зөвшөөрлийн бичигсэлтийг цөөлж, гадаад худалдаа хийхэд хамгийн хямд, төсөр, хялбар аргаар хийж болох аргыг эрж хайх хэрэгтэй байгаа юм. Уг нь Засгийн газрын тогтоол байдаг л даа Монголд. Гадаад худалдааны цахим цогц цонхыг бий болгох тухай. Гэвч энэ салбарт тодорхой ахиц гарахгүй байгаа юм. Иймээс Худалдаа, аж үйлдвэрийн танхим энэ чиглэлд анхаарч, Засгийн газар болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах ёстой болоод байна. Өнөөдрийн болж буй чуулганд ч энэ асуудлыг нэлээд нухацтай хөндөн ярилцана.

**- “Транзит Монгол” хөтөлбөр хэрэгжлээгхэд Монгол Улсад тээвэрлэлтийн асуудалд ямар ахиц гарах юм бэ?**

- Олон улсын худалдааг хамгийн бодитой болгодог зүйл чинь тээвэрлэлт шүү дээ. Худалдааг хөнгөвчлөх гэдэг нь их том бодлогын чанартай асуудал болоод байна. Иймд “Транзит Монгол” хөтөлбөр худалдааны тээвэрлэлтийг хөнгөвчлөх, асуудлыг бүрэн шийдвэрлэх цогц бодлогыг хэрэгжүүлэх гээд байгаа юм. Үүний үндсэн дээр манай гурван улс, түүний дотор Оросын Сибирь, Хятадын зүүн хойд хэсгээр Монгол Улсын худалдааны бараа эргэлтийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үүд хаалга нээгдэх юм.

**- Өнөөдрийн чуулганаар дээрх асуудлаас гадна эрчим хүчний хэмнэлтийн талаар ярилцсан гэсэн?**

- Манай улс төдийгүй дэлхий нийтэд эрчим хүчний асуудал ялангуяа, хэмнэлтийг нэлээд дорвитой ярьж, ажил хэрэг болгох цаг иржээ. Иймд манайх хөрш хоёр улсынхаа худалдаа, аж

үйлдвэрийн танхимтай энэ асуудлыг хэлэлцэж байна. Мөн харилцан туршлага судлах, эрчим хүч болон ус хэмнэлтийн төрөл бүрийн технологийг солилцох, энэ салбарт хамтран ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх гэж байна.

**- Ер нь манайхан эдийн засаг болон бусад салбарын тулгамдаж буй асуудлыг Засгийн газар болон, яамд хоорондын хүрээнд шийдвэрлэх гээд байдаг. Асуудлыг Худалдаа аж, үйлдвэрийн танхимын хүрээнд шийдвэрлэх бололцоо хэр байдаг юм бэ?**

- Нэг их том шийдвэр гарахгүй мөртөө бодитой ажиллагаанууд нэлээд хийгддэг юм шүү. Ер нь улс хооронд яриа хэлэлцээрийн механизм зайлшгүй хийгдэх ёстой л доо. Гэвч энэ ажиллагааны сул тал нь дээгүүрээ яриа, хэлэлцээ хийгээд л байдаг доогуураа хэрэгжихгүй байх нь элбэг. Төр, захиргааны байгууллага, бизнес эрхлэгчтэйгээ хамтран ажиллавал энэ асуудлыг нэлээд хөнгөвчилж, ажил хэрэг болж, үр дүн нь харагдах бололцоо өндөр байдаг.

*Б.Уртнасан*

*“Ардын эрх” сонин, 2008 он, №114/902*

## **ЗАХ ЗЭЭЛ РҮҮГЭЭ БУРУУГ ТОХДОГ ХАНДЛАГА БИЙ БОЛЖ БАЙНА**

*Сүүлийн хэдэн өдрүүдэд иргэдийн ярианы гол сэдэв шатахууны үнэ тойрсон асуудал байлаа. Өнгөрсөн онд шатахууны үнэ бага багаар буюу жилийн туршид 240 орчим төгрөгөөр нэмэгдсэн гэсэн тоо бий. Гэтэл он гарангуут ганцхан хоногийн дотор 230-300 төгрөгөөр нэмэгдсэн нь олон нийтийг цочролд оруулсан. Үүнийг дагаж бусад бараа бутээгдэхүүний үнэ ч өсөх хандлагатай болж байна. Ард иргэдийн нуруун дээрх ачаа ийнхүү өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа энэ байдалд хэн буруутайг, хэн юу хийх ёстой байсныг, цаашид юу хийх хэрэгтэй байгааг эдийн засагчийн үнэнд ойр яриагаар уншигчдад хүргэхийг зорьсон юм. МҮХАҮТанхимын дарга, эдийн засагч Самбуугийн Дэмбэрэл манай сонинь ярилцлагын танхимд уригдлаа.*

Шатахууны үнэ 300 төгрөгөөр нэмэгдэхэд такси, хувийн хэвшлийн нийтийн тээврийнхэн үнэ хөлсөө мөн 200-300 төгрөгөөр үндэслэлгүй нэмж байгаа энэ давалгаанд ард иргэд хохирсоор байх уу? Хариуцлага алдсан дарга нарыг нь халж, үнэ нэмсэн компаниудыг торгосноор асуудлыг шийдлээ гэж яривал ерөөсгөл гэдэг нь хэнд ч ойлгомжтой хэрэг. Түүний байр суурь энгийн бөгөөд бодитой, ойлгомжтой байсныг нуух юун. Тэрбээр “Өнөөдрийн энэ байдал бол гэнэт бий болчихсон зүйл биш. Өнгөрсөн оны аравдугаар сараас эхлээд л улсын төсөв хийж байх үед ч гэсэн танхимын зүгээс, мөн компаниудын зүгээс ч гэсэн УИХ-ын гишүүд, Засгийн газар, улс төрийн гол намуудад хандаж, сануулж хэлж байсан” гэсээр яриагаа эхлэхэд нь энэ сэдвээр ярихаас өмнө маш олон зүйлийг дэлгэрүүл ярих юм байна гэдгийг ойлголоо. Үнэхээр аливаа улс орны эдийн засаг маш олон шалтгаанаар унаж босч байдаг. Манайд үүссэн энэ нөхцөл байдал ч зөвхөн нефть импортлогч компаниудын “тарьсан хэрэг” биш гэж тэр үзэж байгаа.

“Нефтийн компаниуд ийм нөхцөл байдал үүсэхийг эртнээс тооцоолоод вапютын ханш нэмэгдэж байна, үнэ өсөх гээд байна, хилийн үнэ, өртөгт ийм асуудал тулгарч, тээврийн зардал ингэж өсөх гээд байна, тийм болохоор бид асуудлыг хүндрүүлэхгүй байж болох боломжит олон эх үүсвэр хайж байна гэж өчнөөн сануулж байсан. Урьдчилан сэргийлэх боломж нь байсаар байтал нөгөөх л хөшингө механизм ийм байдалд хүргэлээ. Ер нь цаашдаа нефтийн үнийн талаар танхим дээр зөвлөл байгуулъя гэж бид төлөвлөж байна. Бид одоо бодитой мэдээллийг хүмүүст хүргэж байхгүй бол нэг юм болонгуут хувийн хэвшлийнхэн, компаниуд руу чичлэдэг уламжлал тогтоод байна. Хоёр жилийн өмнө гурилын үнэ өсөхөд гурилын компаниудруу дайрч байсан. Гэтэл тэр нь тухайн компаниудаас хамаараагүй зүйл байсан шүү дээ. Иймэрхүү зах зээлрүү бурууг чихдэг хандлага манайд газар авч ихлээд байна. Энэ бол маш буруу зүйл. Хэрэв бид зах зээлийн эдийн засагтай холбогдсон л юм бол зах зээлдээ итгэж сурах хэрэгтэй. Зах зээлээ ойлгодог байх ёстой. Онолоор явдаг засаг биш, ард түмэн, бизнес эрхлэгчдийн дуу хоолойг, саналыг нь сонсдог засаг байж гэмээнэ төр хувийн хэвшил хоёр хоорондоо жинхэнэ ёсоор түншилдэг юм” гэж С.Дэмбэрэл ярилаа.

Тэрбээр цааш нь: “Ерөөс эдийн засагт хувийн хэвшлийн үгийг сонсолгүйгээр, зах зээлийн дохиоллыг мэдрэлгүйгээр төсвийг хэт тэлж батлах, мөнгөний бодлогыг бизнесийг хохироох замаар хатууруулах, сонгуульд зориулсан төсөв хийх нь өөрөө эдийн



засагт буруу үр дагавар үзүүлнэ. Би 2012 оны төсвийг улс төрийн давтамжит бизнесийн төсөв болсон гэж үзэж байгаа. Аль ч улс оронд сонгуулийн өмнө улс төрийн нам ямар нэгэн юм амлах, сонгуулийн дараа хэцүү арга хэмжээнүүдийг гэнэт авах зэргийг улс төрийн бизнесийн давтамж гэж нэрлэдэг. Үүнээс урьдчилан сэргийлж бичил болон жижиг дунд бизнес, бодит сектор руугаа мөнгө их оруулах их чухал хэрэгтэй зүйл байсан. Инфляцийг тогтоон барина гэж мөнгөний бодлогыг хатуу барихынхаа оронд эдийн засгийн өсөлт рүү чиглэсэн, бүтээгч салбарлуу чиглэсэн хөрөнгө оруулалтуудыг илүү баталсан бол арай өөр байх байлаа шүү дээ” гэхэд нь “Таны бодлоор яг бодитой ямар зүйлүүд хийх ёстой байсан юм бэ” гэж сэтгүүлч миний бие сонирхлоо. Ярианыхаа эхэнд л бид тойрч төөрүүлэлгүйгээр тодорхой зүйл дээр тогтож ярихаар тохирсон юм. Хийх юмаа бид зөв сонгож хийж чадахгүй дэмий зүйлд хүч хөрөнгө их зарж байгааг С.Дэмбэрэл дарга сануулаад, “Төрийн яам, дүүрэг, аймаг сум болгонд бүртээ ордон барьж гаднаа хөшөө босгож байхын оронд жижиг дунд бизнестээ илүү мөнгө өгсөн нь дээр гэдгийг жаахан хүүхэд ч ялгаж салгаад хэлээд өгнө дөө. Өрхийн бизнесийг дэмжиж, тэдэнд хэрэгцээтэй, шаардлагатай тоног төхөөрөмжийг нь лийзингээр өгөх нь эргээд үр нөлөөгөө өгнө. Ийм ийм бодитой саначуудыг бид байнга тавьсаар ирсэн. Мөн валютын ханшны зах зээл дээр цөөхөн тоглогч байна. Тийм учраас тоглогчийг нь олон болгоё. Банк бус санхүүгийн байгууллагууд болон, импортлогч компаниудыг олноор татан оролцуулъя. Валютын бирж байгуулья гэдэг асуудлуудыг ч тавьж л байсан. Гэтэл манай төрийн механизм өөрөө маш их удаан байгаа нь асар том саад учруулдаг. Хувийн хэвшлийн хэлсэн үг нэг газар очоод гацдаг ийм хөшингө төртэй байна гэсэн үг л дээ. Төрийн машин нь 20-р зуун шиг, хувийн хэвшил нь 21-р зуун болчихоод энэ хоёр нь хоорондоо авцалдахгүй байгаа нь харагдаад байна” гэж тэр ярилаа. Түүний дахин дахин сануулан хэлж байсан зүйл бол засаглалын технологи удаан байгаа явдал. Үнэхээр биднийг хөгжлөөс хойш чангаагаад байгаа тэр удаан “хөдөлдөг” төрийн машиныг хурдтай болгох нь эн тэргүүний шаардлага болжээ гэдгийг би бодож суулаа.

“Аливаа компани технологгоо хуучирч муудаад ирэхээр нь сольдог. Шинэ технологийн үр дүнд бүтээмж нэмэгдэж, үр ашиг нь дээшилдэг, Яг үүнтэй адил төрийн засаглалын технологи нь хүнд суртал үүсгэсэн, хугацаа их алддаг, удаан технологи үүсчихээр үүнийг солих, хүнд суртлыг арилгах, бизнесийн орчныг цэвэрлэх, цэцэглүүлэх тааламжтай болгох зайлшгүй хэрэгтэй ийм бодлогыг

бид байнга санал болгосоор ирсэн. Яахав түүний үр дүнд 2010 оныг бизнесийн орчны шинэтгэлийн жил гэж зарласан. Гэхдээ дутуу хийсэн. Тэрний өмнө жил үйлдвэржилтийг дэмжих жил болгоё гэж бид санал болгосон. Бас л дутуу хийсэн. Өнгөрсөн жил ажлын байрыг нэмэгдүүлэх жил болгосон. Харин бид ногоон эдийн засаг ярьж эхэлсэн. Өөрөөр хэлбэл хувийн хэвшил нь түрүүлээд яваад байна. Хувийн хэвшлийн дууг сонсдог, судасных нь лугшилтыг мэдэрдэг, мэдрэмжтэй төрийн байгууллагууд дутаад байгаа учраас дээдсүүд улс төрийн зах зээл дээр оноо авах, хүмүүст таалагдах юм яриад ард иргэдийн толгойг эргүүлээд байгаа юм” гэснээр эдийн засагч С.Дэмбэрэл бид хоёрын яриа өндөрлөлөө. Тэрбээр цаашид манай сонины ярилцлагын танхимаар дахин дахин зочилж, эдийн засгийн чиглэлээр бодитой, амьдралд ойр олон сэдвээр ярилцах аяа амласан юм. Бидний энэ удаагийн ярилцах сэдэв өнгөрсөн өдрүүдийн дуулиан болоод байсан шатахууны үнийн өсөлт байсан боловч түүнийг тойрсон асуудал нь ямар өргөн хүрээнд байсныг ярианыхаа төгсгөлд анзаарлаа. Дараагийн удаад ч мөн халуун сэдвээр тодорхой ярилцахаа уншигч танаа амлая.

*Г.Урантуяа*

*Монцамэ мэдээ, 2012 он, № 10/2372*

## БИ ӨӨРТ БАЙГАА ЗҮЙЛДЭЭ СЭТГЭЛ ХАНАЧИХСАН ХҮН

*VIP булангийнхаа энэ удаагийн зочноор МҮХАҮТанхимын дарга С.Дэмбэрэлийг урилаа.*

**- Яг үнэнийг хэлэхэд Худалдаа, аж үйлдвэрийн танхим гэхээр С.Дэмбэрэл гэдэг нэр шууд санаанд ордог. Анх хэний томилгоогоор энэ албан тушаалд очиж байв. Яриагаа ингэж эхэлбэл ямар вэ?**

- Билльярд тоглож байгаад томилогдохсон гэвэл та нар үнэмших үү. Үнэнээ л хэлж байна. Зах зээл судлалын хүрээлэн Худалдаа аж үйлдвэрийн танхим хоёр Ялалтын хажуугийн өндөр байшинд нэг дор байсан юм. Өндрийн нэгдүгээр давхрын билльярдын газарт хоёр байгууллагын залуучууд ажил тарсны

дараа цугларч хааяа тоглоно. Тэгж тоглох үедээ манайхан Худалдаа аж үйлдвэрийн танхим ажил хийдэггүй энэ тэр гээд л шүүмжилнэ. Үнэндээ бол ХАҮТ-ын дэргэд Зах зээл судлалын хүрээлэн хүчтэй байсан. Үйл ажиллагааных нь цар хүрээ, явуулж буй бодлого, нэр төр гээд бүхий л талаараа. Гэтэл 1960 онд байгуулагдсан Худалдаа, аж үйлдвэрийн танхим үзэсгэлэн яармаг зохион байгуулахаас хэтэрдэггүй байх жишээтэй. Гишүүд нь гэхэд л улсын хэдхэн үйлдвэр. Нэг өдөр тоглож байгаад санаандгүй манай даргын сонгууль болох гэж байгаа гээд ярихаар нь би ямар ч бодлогогүйгээр тэр сонгуульд чинь оролцоно гээд хэлчихсэн. Тэгээд сонгон шалгаруулалтад миний нэрийг дэвшүүлсэн байсан. Тэр үед залуу ч байж. Сарын дараа дүн нь гарч, би танхимын даргын үүрэгт ажлыг хүлээж авсан. Энэ бол 1997 он.

**- Зах зээлийн нийгмийн тухай төсөөлөл танд хэр тод байв?**

- Энэ асуулттай чинь холбогдуулан тэр бүр хүнд ярьдаггүй түүх яримаар байна. Эдийн засагчдын клуб гэж байсан юм. Залуу эдийн засагчид тэнд цуглаад өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй солилцдог байв. Эдүгээ ч үнэ цэнээ алдаагүй Монгол Улсын зах зээлд баримтлах эдийн засгийн үзэл баримтлалыг би боловсруулалцсан юм. Гэхдээ хоёр хувилбар байдаг гэдгийг онцлох ёстой. Хоёуланд нь миний оролцоо буй. Тодруулж хэлбэл, Үндэсний дэвшлийн намын дэвшүүлсэн үзэл баримтлалын ажлын хэсэгт би орж ажилласан бол Ардчилсан намын одоо баримталж буй үзэл баримтлалыг хэдэн шил архиар л биччихсэн. Тэр үед социализмыг сайжруулах үзэл баримтлалаас салъя гээд олон эдийн засагч цугларсан. Энхсайхан, Монголбанкны ерөнхийлөгч байсан Жаргалсайхан, Төвбанкны Золоо нар ирснийг санаж байна. Би нэг найзтайгаа Ардчилсан намын одоо баримталж буй зах зээлийн үзэл баримтлалыг бичсэн юм. Энэ бүхэн надад 2010 оныг харчих боломж олгосон. Дэмбэрэл бол үзмэрч биш. Мөн тэр үед би эдийн засгийн асуудал либералчлал гэж юу вэ гэсэн нэрийн дор өмч хувьчлалын тухай анх бичсэн. Түүний дараа өмч хувьчлалыг явуулах аргуудын талаархи дэлхийн туршлагыг түмэн олонд хүргэсэн. Дээр нь нэмж хэлэхэд, өнгөрсөн жилээс яригдсан үйлдвэржилт байна. Тэр тухай бас л бичиж байлаа. Энэ бүхнийг өгүүлэхийн учир Дэмбэрэл гэдэг хүн яасан мундаг юм бэ гэж өөрийгөө магтах гээгүй. Улс орны хөгжлийн зам яасан удаан юм бэ гэдгийг л хэлэх гэсэн юм. Өөрөөр хэлбэл, 1990 онд миний бичиж байсан зүйл эдүгээ 2010 онд яригдаж, хэрэгжиж эхлэх жишээтэй. Тийм учраас би төрийн гурван өндөрлөгт хандаж нэг

юм хэлэх гээд бэлтгэхихээд сууж байна. Өнөөдөр маргаашийн тухай биш хөгжил яагаад ингэж удаж буй талаар. Эдийн засгийн чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк байгуулах тухай Жасрай агсны Засгийн газрын үеэс л ярьсан. Тэр үед эрх зүйн орчин байхгүй гээд өнгөрсөн. Одоо эрхзүйн үндэс нь тавигдаж, Аж үйлдвэрийн тухай, Чөлөөт бүсийн тухай гээд бүх хууль нь батлагдчихлаа. Тэгтэл одоо хөрөнгө оруулалт дээрээ гацчихдаг байгаа. Ядаргаатай байгаа биз дээ. Биднийг ингэж ээг мааг гэж мөлхөж байтал 30 жил өнгөрөх нь байна. Шулуухан хэлэхэд, Монголын төр аягүй удаан, ажиллаж байна.

**- Зүг чигийг нь гаргасан хүний хувьд араас нь түлхээд өгч болсотүй юу?**

- Монгол Улсын хөгжлийг хувийн хэвшлийнхэн л авч явж байна шүү дээ, үнэндээ. Түлхэц болох олон зүйлийг манай танхим санаачилж хэрэгжүүлсэн. “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”, Төр - хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих жил” гээд өөрсдийн зүгээс чадах бүхнээ хийсэн. Тодруулж хэлбэл, төр хувийн хэвшлийн үгийг сонсоод бодлогодоо дүгнэлт хийж байгаа нь хөгжлийг бодлогоор түлхэж байгаа хэрэг.

**-Таныг шаггүй менежер гэж ойлгож болох уу. Яагаад гэвэл ХАҮТ-ын үйл ажиллагааны цар хүрээ өргөжөөд нөлөө бүхий болоод зогсохгүй гишүүнийх нь тоо жилээс жилд нэмэгдэх юм?**

- Шаггүй гэхээсээ муугүй гэвэл онох байх. Яагаад гэвэл шинэ зүйлийг нийгэмд бий болгохын төлөө ажилладаг учраас. Тухайлбал, өмнө нь компанийн нийгмийн хариуцлага гэж ярьдаггүй байсан биз дээ. Бизнесийн орчин гэдэг чинь 10 жилийн өмнө гарсан нэр томъёо. Энэ мэтчилэнгээр улс орон шинэ зүйл рүү яваад ирэхээрээ хөгждөг. Түүнчлэн мөнгөний бодлогыг хэн шүүмжилж байсан юм. Яагаад мөнгө, санхүүтэй холбоотой бүхий л асуудал зөвхөн банкаар дамждаг байх ёстой гэж. Тэгвэл бид алтернатив арга зам байдгийг хэлж, хэрэгжүүлж чадсан. Нэг жишээ хэлье л дээ. ХАҮТ орон нутаг дахь салбараараа дамжуулан Ховд, Увс, Баян-Өлгий аймгаас тус бүр 10 ажилгүй эмэгтэйг сургалтад хамруулан голланд маягаар талх, нарийн боов хийлгэж сургалаа. Тэднийг буцахад талх хийх тоног төхөөрөмжийг нь лизингээр өгөөд амьдралынх нь асуудлыг шийдээд зогсохгүй тэр хэмжээгээр ажлын байр шинээр бий болгож байгаа юм. Энд банк ямар хамаа байна аа. Энэ мэт арга замыг хайж хэрэгжүүлэх нь чухал. “Баянмонгол” чуулгад бид гурван сая төгрөгийн хандив өргөлөө. Зүгээр л хамтарч ажилладаг түнш учраас тусалсан. Нөгөө утгаараа манай

хамт олон нийгмийн хариуцлагаа ухамсарлаж байгаа хэрэг. Бас манай байгууллага дээр гурван сая төгрөгийн буухиа зээлийн сан байгуулагдсан. Хуучнаар бол зээлдэн туслах касс. Мөнгөгүй үедээ манай залуучууд сангаасаа хүүтэй мөнгө зээлнэ гэсэн үг. Үүнийг нь би хянахгүй. Залуус өөрсдийгөө хянаана. Ийм зээл байж яагаад болохгүй гэж. Заавал яахаараа банкин дээр очоод баталгаагүй гэж гологдох ёстой юм бэ. Баталгааны сан байгуулах асуудлыг хөндөх цаг болжээ. Тийм сантай болчихвол банкнаас зээл авах гэхээр баталгаа нь гологддог иргэдийн амьдралд ихээхэн нэмэр болох учиртай. Энэ бүхнийг үндэсний хэмжээнд хийчихвэл энэ улс эрүүлжинэ.

**- Та энэ албан тушаал дээр ирээд арваад жил боллоо. Ингэхэд таныг хэн сонгодог юм бэ?**

- ХАҮТ бол төрийн бус байгууллага. Бизнесмэнүүд намайг сонгодог юм. Хэрэв би олигтой ажиллаж чадахгүй бол огцруулах эрх нь тэдэнд бий.

**- Та бид хоёрын ярлцпага ХАҮТ-ыг сурталчилсан тал руугаа хэлбийчихлээ. Тиймээс хувь хүн Дэмбэрэлтэй ярилцмаар байна. Та хувийн амьдралдаа хэр овсгоотой менежер вэ?**

- Үнэнээ хэлэхэд, надад гэр бүл үр хүүхдэдээ зарцуулах цаг тун хомс. Дэмбэрэл гэх аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа сайн байгаа нь ерөнхий менежерийн хичээл зүтгэл. Тэр хүн мэдээж миний гэргий. Би бол шөнийн бор хоногт орж унтаад бэлэн хоол идэж, угааж индүүдсэн хувцас өмсөөд гардаг нэг тийм амьтан. Зав гарвал зурагт үзнэ. Цалингаа аваачиж өгнө. Ингэж хэлснээр өөрийгөө бэлгэдэл төдий гэх гэсэнгүй. Гэрийн эзний хувьд том том асуудалд байр сууриа илэрхийлж, тамгаа дарна шүү дээ. Нөгөөтэйгүүр, Монголын нийгмийг эмэгтэйчүүд авч яваа. Эрчүүдийг би хувьдаа циркийн баавгай л гэж хэлнэ. Тиймээс би эмэгтэйчүүдэд хандаж хэлэхэд, эр нөхрөө циркийн баавгай гэж бодоод хааяа ётон өгч урамшуулаад хүссэн бүжгээ хийлгэ. Тэр утгаараа эхнэр нь нөхрөөсөө гэртээ ямар мебель тавилга авахаа асуух нь илүүц юм. Амьдрал дээр би Дэмбэрэл гэх компанийн ТУЗ-ийн дарга. Эхнэр маань гүйцэтгэх захирал. Гүйцэтгэх захирлын үүрэг компанид ямар байдаг билээ, түүнтэй л жишчих.

**- Таныг чөлөөт хувцастай явж байхыг хараагүй юм байна. Ямар тохиолдолд жинс, саравчтай малгайгаар гангардаг вэ?**

- Надад энгийн хувцас тоотой хэд бий. Эрхэлж буй ажлаас болдог байх л даа. Тэгээд ч энгийн хувцастай явахаар хүмүүс хачирхаж хараад байх юм билээ. Саяхан “Инээмсэглэл”

хамтлагийн тоглолт үзэх гээд жинсээр гангараад очтол найз нар маань сонжиж хараад байсан. Зарим нь зохиж байна, зохихгүй байна гээд л мэтгэлцээд амжсан шүү.

**- Ингэхэд та аль аймгийнх вэ. Дэмбэрэл гэх хувь хүний удам судрыг сонирхвол?**

- Манай эцэг өвгөд Архангайнх. Аав маань хөдөлмөрийн баатар, саятан жолооч Самбуу гэж хүн байлаа. Би өөрөө Улаанбаатарт төрж өссөн. Хүмүүс 40 мянгатынх, хүрээ соёлтой айлын хүүхэд гэж өөрийгөө тодорхойлдог юм билээ. Үүнийг би таашаадаггүй. Хүрээ соёл гэж юуг хэлээд байгаа юм. Тийм юм байхгүй шүү. Жинхэнэ соёл чинь хөдөө байсан юм, тэгж ярьвал.

**- Аавынхаа кабинд өссөн хүү юу гээд асуувал бүү эмзэглээрэй?**

- Аав биднийг дагуулаад алсын тээвэрт явдаггүй байсан. Одоо бодох нь ээ, их ухаантай хүн байж. Намайг дагаад ном эрдмээ орхино гэж боддог байсан хэрэг. Гэхдээ би хөдөөгийн амьдралд дуртай. Өдгөө би Архангай аймгийн нутгийн зөвлөлийн дарга.

Ээжийг минь Цанжид гэдэг байсан. Манж хэлний орчуулагч. Тухайн үедээ л зэгсэн боловсролтой эмэгтэй байв. Царай зүс сайтай сайхан эмэгтэй байсан гэж үеийнх нь хөгшчүүл хэлдэг юм.

**- Танайхнаас хамгийн сайн амьдарч яваа нь та юу?**

- Албан тушаалын хувьд өндөр алба хашиж яваа нь би байх. Ахуй амьдралын хувьд дор бүрнээ хэр таарсан амьдралтай. Тэгэхээр бүгд жигд сайн яваа гэж ойлгож болно. Бид эцэг эхээс арван хэдүүлээ. Би доороо хоёр дүүтэй. Ах дүү нартайгаа цагаан сар, наадмаар л уулзах юм даа. Аав ээж хоёр бурхан болсноос хойш манайхан том эгчдээ л захирагдаж байгаа. Том эгч дуудвал би хийж байсан ажлаа хойш тавиад гарна. Яагаад гэвэл эгч онц шаардлагатай үед л дуудаж таарна шүү дээ.

**- ХАҮТ-ын дарга ногоон хаш өргөөнд залардаг юм байна. Ногоон хаш ивээл чулуу тань юм аа даа?**

- Монголчууд хүнд хүрэн өнгөнд дуртай шиг байгаа юм. Энд тэнд ороход ажлын өрөө нь дандаа л хүрэн өнгөтэй мебельтэй. Би гайхдаг. Миний өрөөнд орж ирсэн хүмүүс тайвшраад гардаг. Би бурхан Будда, Исүс христ биш. Тэр ч байтугай албан ширээнийхээ араас бусадтай харилцдаггүй. Нөгөөтэйгүүр, амьдралынхаа ихэнхи цагийг энэ өрөөнд өнгөрүүлнэ гэх утгаараа ингэж тохижуулсан. Тэгээд ч чулуу энерги сайтай.

**- Таны шилэн хоргон дахь цуглуулга өөрийн эрхгүй анхаарал татаад байна. Бусдаас бас л өвөрмөц зүйл цуглуулжээ?**

- Үүний өмнө энэ шилэн хоргон дотор баахан цом, өргөмжлөл байсан юм. Тийм зүйл харж суух ямар уйтгартай гээч. Тэгээд нэг өдөр нарийн бичгийн даргаа дуудаад авахуулж коридорт гаргаад танхимын доор зарж байсан бэлэг дурсгалын зүйлээс энэ хэдийг бөөндөөд авчихсан. Орж ирсэн хүмүүс “Та рокн ролл сонирхдог юм уу” гээд байдаг юм. Хөөрхөн байна уу, миний цуглуулга.

**-Та ярилцлагын эхэнд билльярд тоглож байхад гээд дурдаад өнгөрсөн. Билльярд цохихоос өөр ямар нэгэн тоглоомд цаг зав гаргадаг уу?**

- Би билльярд тоглож сурах гэж ерөөсөө хичээгээгүй. Хаа хамаагүй цохиод л хүмүүсийг солиоруулж орхидог. Өнөө бөмбөг нь тэнэж тэнэж байгаад орчихдог. Шатрыг ч мөн адил. Шатарчид шиг өрөг бүрээ бодож, тооцоолж нүүдэггүй. Мастерыг хүртэл хожчихдог гээд бод доо. Тэд бас л намайг солиотой нөхөр гэнэ. Энэ нь л надад зугаа. Тархиа амраах зорилгоор л тоглоом эргүүлдэг байхгүй юу.

**- Тэгвэл танд өөрийгөө “эрхлүүлдэг” зүйл чинь юу вэ?**

- Хоол. Би шөнийн 02 цагт ч мах чануулаад иддэг. Надад биологийн цаг байхгүй учраас хүссэн цагтаа хооллодог. Би ямар ч тохиолдолд хоолыг халбагаар иддэг. Зав гарвал янз бүрийн хоолыг өөрийнхөөрөө зохиож хийх дуртай. Намайг хоол хийхээр хүүхдүүд гал тогооны өрөөний хаалга онголзуулаад л “Аав хоол болж байна уу” гээд байдаг юм.

**- Таны халаасаа тэмтэрч орхидог зүйлийг сонирхвод?**

- Би өөрт байгаа зүйлдээ сэтгэл ханачихсан хүн. Энэ ханан дахь уран зургууд бүгд бэлгийнх. Надад зураг худалдаж авах шаардлага байхгүй. Яагаад гэвэл дүү маань зураач. Гэхдээ би зурсан зургийг нь ойлгодоггүй юм. Тиймээс би дүүдээ үнэнээ хэлж, “Чи ХХII зууны хүн байна” гэдэг. Хүмүүс үнэ хаяад л, захиалаад л байдаг юм билээ.

**- Сүүлийн асуулт. Нөлөө бүхий албан тушаалд очсон хүмүүс яван явсаар улс төр рүү хэлтийх нь бий. Та улс төр сонирхдоггүй юм уу. УИХ-ын аль ч сонгуульд нэрээ дэвшүүлээгүй учраас ийн асуусан хэрэг?**

- Шаардлага гарвал улс төр бид хоёр бие биеэ сонирхох нь дамжиггүй.

*Ч.Чулуунцэцэг*

*Өдрийн шуудан, 2010 он, № 164/242*

## НИЙТЭЭРЭЭ ХУВЬЦАА ЭЗЭМШИЖ, АЗ ЖАРГАЛТАЙ НИЙГЭМ БАЙГУУЛНА ГЭДЭГТ БИ ИТГЭДЭГГҮЙ

*МУХАҮТ-ын дарга, гавьяат эдийн засагч С.Дэмбэрэлтэй  
ярилцлаа.*

**- Манай улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэн гэх боловч Сүүлийн үед төр өмчтэй болох сонирхол нь давамгайлаад байх шиг. Ийм байх нь аль хэр зөв бодлого байдаг юм бол. Та өөрийн байр суурь, санал бодлоо хуваалцана уу?**

- Үндсэн хуульд өмчийн бүх хэлбэр эрх тэгш хөгжих заалт байдаг. Одоо бид өмч хувьчлал эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэх гэж байна. Энэ өндөрлөгөөс харвал бид өмчийг хувьд шилжүүлснээ мартаж шахаж байна. Нөгөө талаар 2005 оноос хойш төрийн өмчийг шүтэх, үүнд суурилсан эдийн засгийн хөгжлийн загвар гаргах хандлага Хүчтэй цухалзаж эхэлсэн. Энэ нь эцэстээ нийтээрээ хувьцаа эзэмшдэг аз жаргалтай нийгэм байгуулах тийшээ хандчихаад байгаа. Сонгож аваад, хуульчлаад байгаа энэ зам хэр зөв хувилбар вэ гэдэг асуулт гарч байна. Гэтэл төрийн өмч давамгайлсан юм уу, түлхүү цугларсан газарт үйл ажиллагаа доголдож, үр ашиг, бүтээмж мууддаг, авлига, хээл хахууль цэцэглэдэг, тэр нь улам нуугдмал байдалтай болдог гэхчилэн дэлхий даяар ойлгомжтой, түгээмэл фактууд байна. Ер нь хүн төрөлхтний олж мэдсэн өмчийн хамгийн сайн хэлбэр нь хувийн өмч. Өнөөдөр төрийн өмчөөр учиртай сайхан хөгжиж дэвжсэн улс орон хаана ч байхгүй. Ялангуяа нөөц дээр суурилсан эдийн засгийн хөгжлийн загварыг сонгож авсан, түүнд дулдуйдсан улс орны хувьд төрийн өмчийн тухай ойлголтыг маш болгоомжтой хэрэглэх ёстой.

**- Манайхны туршлагыг нь судлаад олон хүн нүдээр харсан гэж ярих дуртай Чили мэтийн орон энэ хөгжлийн сайн загвар байдаг юм биш үү?**

- Түүнийг маш сайн, баталгаатай сайн загвар гэж хэн баталсан юм бэ. Эцсийн дүндээ өнөөдөр баялаг, түүний хуваарилалт, үүнд ямар өмчийн харилцаа давамгайлах вэ гэсэн асуултад нэгэн дуугаар хувийн хөрөнгөд суурилсан хувийн өмч, хөрөнгө оруулалт

гэж хариулж байна. Яагаад гэвэл ийм хөрөнгө оруулалт байхад тэнд хариуцлага, ил тод байдал давамгайлж байдаг. Манайд болохоор төрийн өмч далан жил ноёрхсон, түүнээс хагас хугас салаад хориодхон жил болж, хувийн өмчийн давуу тал нь дөнгөж цухас харагдаж, өсч бойжиж байгаа. Энэ үед төрийн болон нийтийн өмчийг хольж хутгаад хаячихсан байна. Үндсэн хуульд газар, түүний баялаг ард Түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна гээд биччихсэн байдаг. Тэр “төрийн хамгаалалт” гэх хоржоонтой үгийг төрийн өмч юм шиг тайлбарлаад, нөгөөх ард түмний мэдэлд гэдгийг нь формаль байдлаар явуулаад сурчихсан. Тэгээд Сүүлийн үед бүх хүнд хувьцаа тарааж, олон улсын зах зээлд гаргаж худалдаад баяжуулаад өгөх юм яриад байгаа дээ. Гэтэл үүнээс урьтаад хувийн хөрөнгө оруулалттай “Энержи ресурс” зэрэг компани IPO хийж, хөрөнгө босгоод хариуцлагаа хүлээж, олон улсын тоглогч болж байгааг харж байгаа биз дээ. Сүүлийн үед посткоммунист орнуудад ч ийм хандлага ажиглагдаж байна. Үүнд сайн жишээнд Казахстаныг хэлж болно. Гэхдээ энэ нь хэр тогтвортой, зөв зам бэ гэдэг нь бас л асуудалтай. Хятадад гэхэд төрийнхөө өмчийг хувьчлаад эхэллээ. Хятадын онцлогтой социализм гэж яригдаж байна.

**- Манай улс энэ талаар харин ч Хятадаас нэг алхмын өмнө яваад байгаа юм биш үү?**

- Манай өмч хувьчлалын яригдаж байсан хэдэн асуудал бий. Ер нь өмчийг хувьчлах олон арга хэлбэр байдаг. Гэхдээ юуны өмнө корпорацийн зарчимд шилжүүлэх ёстой. Дараа нь арилжааны дэглэмд оруулах, тэгээд хувьчлах учиртай юм. Гэтэл бид дандаа дутуу хийж байсан. Жишээлбэл, хэдэн жилийн өмнө эрчим хүчний салбарын үнийг чөлөөлөөгүй байж корпорацийн зарчимд оруулж, арилжааны дэглэмээр ажиллуулаад одоо төрийнх ч биш, хувийнх ч биш өмчийн хэлбэртэй болчихсон. Иймэрхүү байдлаас харахад Сүүлийн үед өмч хувьчлалыг мартаж, эсвэл мартагнуулах, хоёрдугаарт, төрийн өмчийн компани байгуулах дуршил нэмэгдээд байна. Түүнийгээ төрийн өмчийн компани эхэлж байгуулаад хувьцаа тарааж, нийтийн өмчийнх болгоно гэж тайлбарлаад байх юм. Энэ бол дэндүү төвөгтэй, хэцүү шилжилт л дээ.

**- Монголчууд, Монголын компаниуд зах зээлийн системд хөл тавиад хорь орчим жил боллоо. Бас ч энэ нийгмийн ая звийг олох ухаанд хурдтай суралцаж байна бус уу?**

- Тийм л дээ. 1990-ээд оны үед бид гэнэн байж, нийт массаараа. Бүгдийг хувьчилчихвал бүх юм ид шидийн саваагаар дохисон мэт сайн сайхан болчихно гэж төсөөлдөг байлаа. Тэр үеэс хойш

бусад улс оронд өмч, менежмент хоёр салж эхэлсэн. Гадаадаас менежментийн зөвлөх, тэр байтугай баг ирж хувийн компанийг удирдаж байна. Гэтэл бид төрийн өмчит компани байгуулах дуршилтай болж байгаа нь буруу загвар руу явж буйг харуулаад байгаа хэрэг. Үүнд цаашид онцгойлон анхаарах нь чухал санагддаг. Яагаад сонгуульд ялсан намууд Засгийн газраа байгуулмагц “Эрдэнэт” үйлдвэрийн захирлыг сольдог вэ гэсэн энгийн асуулт тавиад хариулж үзье л дээ. Тус үйлдвэр хэдийгээр Монгол Улсыг олон жил тэжээсэн ч корпорацийн зарчимд шилжихгүй, арилжааны дэглэмд орохгүй байгаа нь улс төрийн талбар, бялуу хуваах, хэн нэгнийг урамшуулах арга хэрэгсэл болсныг харуулаад байгаа юм биш Дээрх хоёр жишээг харахад л хувийн өмч, хувийн хөрөнгө оруулалт гэдэг аль ч талаараа давуу гэдгийг батлаад байгаа хэрэг. Дэлхий нийт ч үүнийг хүлээн зөвшөөрч байгаа юм чинь бид үүнээс зөрөөд, өөр загвар хувилбар хайгаад яах юм бэ. Ийм болохоор бүх нийтээрээ хувьцаа эзэмшиж, аз жаргалтай нийгэм байгуулах энэ үзэл баримтлалд би хувьдаа итгэдэггүй. Тиймээс төрийн болон нийтийн өмчийг ялгаж салгаад түүний менежментийг боловсронгуй болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, бодлогоо тодорхойлох ёстой. Нийтийн өмчийн эдийн засгийг жаахан газар, сум орон нутгийн зам гэхчилэн хэтэрхий жижгэрүүлж ойлгоод байх юм. Уг нь нийтийн өмчийн эдийн засаг гэдэг бараг тусдаа шинжлэх ухаан байх учиртай юм. Энэ талаар манай төрийн бодлого ч гэж алга. Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хууль зэрэг цөөн баримт бичгийг эс тооцвол. Тэр нь хүртэл төрийн гэдгээрээ эхэлчихсэн. Ийм байж таарахгүй ээ. Жижиглэнгийн худалдаа үйлчилгээг аваад харъя. УИД-ийг хувьчилсан. Одоо “Номин холдинг” яаж ашигтай ажиллуулж байна. Энэ салбар “улсын хоршооны хөөрхөн Бурмаа”-гүйгээр, төрийн өмчийн том нүсэр дэлгүүргүйгээр болж л байгаа биз дээ. Гэтэл төрийн өмчийг шимэх дуршилтай, бодлого нь патерналист буюу эцэг төрийн зарчмаар явж байгаа, сайн засаглалгүй улс оронд нуугдмал авлигыг улам хөгжөөж өгдөг. Манай орны хувьд ч авлигатай тэмцэх гээд чадахгүй л байна.

**-Төрийн өмч давамгайлсан улс оронд хэвлэлийн эрх чөлөө хаагдмал болчихдог гэдэг. Ялангуяа манайх шиг нэг салбарт хэт шүтсэн газарт. Яагаад тэр вэ?**

- Нөөцөөр баялаг улс оронд хэвлэл мэдээллийн эрх чөлөө хумигддаг нь дэлхийд батлагдчихсан нь үнэн. Яагаад гэвэл байгалийн баялгийн нөөц, хэвлэлийн эрх чөлөө хоёрыг шууд хамааралтай болгодог. Тухайн нөөцийнхөө ихэнх хувийг эзэмшдэг төр түүнийгээ буруу ашиглах тусам хэвлэл мэдээллийн хэрэгсэл

худалдагдаж, эрх чөлөө нь боогдож эхэлдэг. Манайд ч ийм үйл явц гарч болзошгүй элементүүд цухалзаад байна. Үүнийг танай сонин хөндөж байгаа нь сайн хэрэг. Өнөөдөр бид “төрийн өмч”, “ард түмэн” гэх бамбай үгүүдээс аль болох зайлсхийх нь чухал.

**-Тийм шүү. Одоо УИХ-ын гишүүдээс эхлээд амбицтай болгон “ард түмэн”, “олон нийт” гэж бүгдийг төлөөлж ярьдаг болчихож. Ер нь төрийн болон хувийн өмч төдий харьцаатай байвал зохимжтой гэх хэмжээ дамжаа олон улсын жишигт байдаг юм болов уу. Хувийн өмчийг дээдэлдэг хөгжчихсөн орнуудад бол өөр байх л даа?**

- Хаана ч тийм юм байхгүй. Миний өөрийн хатуу итгэл үнэмшлээр бол манайд хувийн сектор илт давамгайлах ёстой. Тоогоор илэрхийлбэл төрийн өмч арван хувиас илүү баймааргүй санагддаг. Баялгийн нөөц ихтэй Төв Азийн нэг улсад ганц хүний удирдлагаар бүх юм хөдөлж, улс орон хөгжиж байгаа загвар байна. Гэхдээ тэр хөгжил гэдэг юмыг том том барилга байгууламж, нүсэр үйлдвэр, олон мянган Жийп машинаар хэмждэг юм биш. Гагцхүү нийгэмд шударга ёс тогтож, иргэд нь маргаашдаа итгэл дүүрэн байж, хүн бүр өөрийн хүсэл сонирхол, авьяас чадварын дагуу нийгэмд ажиллаж амьдрах боломж, эрүүл мэнд, боловсрол гээд нийгмийн бүхий л боломжоор хангагдсан л байх учиртай.үүний тод жишээ нь Норвеги байдаг .Энд ЗР-ийн зарчим буюу хувийн болон нийтийн түншлэлийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж чадсан.

**- Ирээдүйд тийм болох байх гэж найдъя, манай улс ч гэсэн. Үүнийг ойртуулахын тулд төр засаг бид яах ёстой вэ?**

- Одоо энэ “хоёр толгой”-н хувьцааг иргэн бүрт тэгш хүртээнэ гээд ярьж байна. Бид биологийн амьтны хувьд адилхан идэж ууж, баярлаж гомдож, сэхэж доройтож явдаг ч гэсэн нийгмийн харилцаанд орохоороо өөр давхаргад хамрагддаг. Тэгвэл тэр давхаргын хүн бүрт хувьцааг тэгш хуваарилах биш өөрийгөө, эрхэлж байгаа ажил үйлчилгээ, бизнесээ хөгжүүлэх тэгш боломжийг л олгох нь чухал. Энэ боломжийг иргэн бүр тэгш, шударга ашиглах хэрэгтэй. Ердөө л энэ.

**- Гурван сая хүрэхгүй монголчууд ийм боломж эдлэх нь байтугай өөрийн нутаг орондоо гаднынхнаас дор нөхцөлд бизнес эрхэлж, амьдрах гэж ядаад яваа юм биш үү. Тийм ч учраас гадаадын хөрөнгө оруулагчдад янз бүрийн хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлдэгээ болиоч. Тэд ямар ч нөхцөл тавьсан ороод л ирнэ гэж ярьдаг болж. Энэ талаар та юу хэлэх вэ?**

- Энэ бол зөвхөн гадаадынх гэлтгүй дотоодын хөрөнгө оруулагчдад ч хамаатай асуудал. Үүнд татварын тааламжтай орчин

хамгаас чухал. Нөгөө талаар бидний чадахгүй нано технологи ч юм уу, орчин үеийн мэдлэгийн багтаамж ихтэй секторуудад гадаадын хөрөнгө оруулалт хэрэгтэй. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд бид гадаад ертөнцөд хаалгаа цэлийтэл нээсэн. Сайн нь саартайгаа орж ирсэн. Одоо хоолны газар, караокег солонгосууд эзэгнэж, вьетнамууд автомашин болон дугуй засварыг тэргүүлж байна. Бид тэднээс суралцсан, нуух юм байхгүй. 25 мянган доллартай байхад гаднын хөрөнгө оруулалтыг оруулаад ирдэг байлаа. Харин өнөөдөр хөрөнгө оруулалтын бодлогоо эргэж харах цаг болсон. Үйлчилгээний салбарт гэхэд дор хаяж 2-3 сая, аялал жуулчлалын бааз ажиллуулахад 500 мянган доллар гэхчилэн хөрөнгө оруулалтын босгыг өндөрсгөмөөр байгаа юм. Түүнээс биш цэлийтэл нээсэн хаалгаа тас хийтэл таг хаачих гэж байгаа юм биш. Манайд хөрөнгө оруулалт шаардлагатай салбар зөндөө байна. Гадаадын хөрөнгө оруулалтаас тэргүүний технологи, сайн менежмент, бизнесийн сайн практик үлддэг. Түүнийг сурч, өөрийн болгоод авах хэрэгтэй юм.

**- Манай төр, засгаас үндэсний үйлдвэрлэгчдээ хэр дэмжиж байна вэ. Сүүлийн үед ноос, ноолуурын салбарт овоохон хөрөнгө оруулалт хийхээр болж байна. Нийт массаар нь авч үзвэл?**

- Монголын зах зээл бага болохоор импортыг орлох үйл явц явагдаж байна, энэ сайн хэрэг. Гэтэл экспортыг яах вэ. Манай экспорт ноолуур юм уу, алт, зэс гэхчлэн хар, шар өнгөнөөс бүрдэж байна. Уг нь хоёр том зах зээл байгаад байдаг. үүний хэрэгцээг сайтар судалж, өөр юу экспортолж болох вэ гэдэг гарцыг хайх хэрэгтэй.”Өгөөж”-ийн бүтээгдэхүүнд Эрээнийхэн дуртайг би мэднэ. Жилин мужийн Чан чунь хотынхон “Улаанбаатар” хивсийг дор нь дуусгадаг. Энэ мэтээр экспорт хийх боломжийг судалж, бодлогоо боловсруулах нь үр дүнтэй. Бид экспортын стратегийг анхан шатны байдлаар боловсруулаад Г.Занданшатар сайдад хүлээлгээд өгчихсөн.үүнийг нэмж сайжруулаад санхүүгийн ресурсээр дэмжээд баталчихвал ойрын ирээдүйд монголчууд бид асар их экспорт хийж чадна. Бидний судалгаагаар уламжлалт экспортоос гадна 20-30 бүтээгдэхүүн нэмж гаргах боломж байгаа нь харагдсан.

**- Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 110 тэрбум төгрөгийн бонд гаргахтай зэрэгцээд ноос бэлтгэн нийлүүлэгч малчдыг урамшуулах хөрөнгө ч босгохоор боллоо. Гэтэл кг нь 500 төгрөгийн үнэтэй ноос авчирч өгчихөөд 2000 төгрөгийн урамшуулал хүртэх нь хэр шударга вэ?**

- Монгол Улсын ноос, ноолуурын салбарт өөрт нь тохирсон санхүүгийн орчин алга. Тиймээс төр өөрийн хөрөнгөөс хувийн секторт хөрөнгө оруулалт хийж байгаа хэрэг. Урамшууллын тухайд малчдыг тусгайлан авч үзэж байгаа нь буруу. Энэ нь нөгөөх тэжээлгэдэг сэтгэлгээг л дэврээж байгаа явдал. Тэр ноос, ноолуур бэлтгэж нийлүүлэх ажил чинь тодорхой гинжин хэлхээгээр явж байгаа. Энэ дотор нь л авч үзэх ёстой юм.

**- Ноолуурын дотоодын хэрэгцээг хангахын тулд экспортод татвар ногдуулж болдоггүй юм уу. Өмнө нь 30 хувийн татвартай байхад тухайн үеийнхээ ханшаар овоо л үнэтэй байсан санагдах юм?**

- Олон улсын худалдааны байгууллага экспортын бүтээгдэхүүнд татвар ногдуулахыг төдий л таашаадаггүй юм. Гэхдээ квот тогтоох зэрэг хязгаарлалтын аргууд бий. Гол нь ноолуурт татвар ногдуулахгүй байгаа нь улс төрийн учир шалтгаантай гэж хэлбэл үндэн ойртоно. Хэрвээ татвартай болгочихвол малчид болон үүний дундаас орлого олж байгаа хэсэг бүлэг хүнд очих ашигт нөлөөлнө. Ер нь манай бага зах зээл дээр ноолуурын асуудлаа шийдэж чадаагүй нь эмгэнэлтэй явдал. Би хувьдаа үйлдвэрлэгчидтэй санал нэг байдаг. Татвар тогтоочих хэрэгтэй. Тэр нь малчдын ашиг орлогод нөлөөлөх эффекийг урамшуулал олгох зэргээр саармагжуулах нь чухал.

**- Шатахуун импортлогч, танай танхимын гишүүн компаниуд зориудаар нийлүүлэлтийг хязгаарлаж, үнийг үгсэн хөөрөгдөж байна гэх хардлагад байнга өртдөг. Сүүлдээ бөөний үнэ нь өндөр, жижиглэн нь хямд болоод явчихлаа. Зах зээлийн үнэ ханшид үл үзэгдэх гар үйлчилж байдаг. Гэтэл импортлогчид ил харагдаад үнийг зохицуулаад байгаа юм биш үү?**

- Хоёр хариулт хэлье. Нэгдүгээрт, хохь чинь. Өдий олон жил түүхий эд нь байсаар байтал дотооддоо боловсруулах үйлдвэр барих талаар нэг ч алхам хийгээгүй төр засгийг хэлж байна. Улс төрийн шийдлээ олоогүйнх нь төлөө. Хоёрдугаарт, шатахууны импорт, нийлүүлэлт, үнийн асуудалд төрийн оролцоо их байх тусам компаниуд эсрэг шийдэл хийж байна. Гэхдээ би нуун дарагдуулж, хомсдол үүсгээд үүнийг далимдуулж үнэ нэмж байна гэж хэлж байгаа юм биш. Хэрэв ийм байдаг бол тэр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зэрэг байгууллага нь баталгаа нотолгоотой тогтоох ёстой. Нөгөө талаар бид нефтийн бүтээгдэхүүний хувьд үнэ тогтоогч биш үнийг хүлээн авагч гэдгийг мартаж болохгүй. Чингисийн агуу Монгол Улс одоо Оросын

“Роснефть” гэдэг монополь компаниас хамааралтай байна ийм дээ, харамсалтай юм.

**- Ерөнхийлөгч саяхан ОХУ-д айлчлахдаа энэ асуудлыг нэлээд чухалчлан тавьсан байсан. Хариулт нь харин төдий л хангалттай санагдаагүй шүү.**

- ОХУ-ын Ерөнхий сайд, бид энэ асуудлыг авч хэлэлцэх болно гэж хэлнэ лээ. Энэ яасан танил үг вэ. Миний олж уншсанаар лав таван удаа хэлж байна, манай томчуудад. Тэгэхээр бид энэ талаасаа л бодмоор байна. Түүнээс биш импортлогчид руу дайрах хэрэггүй. Тэд ч бас хараат бизнес хийж байгаа улсууд. Харин тэднийг чөлөөт өрсөлдөөнд оруулах, нефть боловсруулах үйлдвэр барихдаа зөвлөгөө, тусламж авах нь зөв. Тэд нефтийн бүтээгдэхүүнийг мэднэ. Бас аливаа хомсдолын үед дамлан тоглогчид, хялбар аргаар мөнгө олохыг эрмэлзэгчид гарч ирдгийг санах хэрэгтэй.

**- Манайд ОХУ-аас нийлүүлэх шатахууны хэмжээ багасч, дотооддоо янз бүрийн шалтгаанаар хомсдолтой байсан нь Ерөнхийлөгчийн айлчлал, тэнд яригдсан асуудлуудад хийсэн шантааж гэж хэлж болох уу. Ийм боломж байна уу?**

- Байж болох л юм. Бид дэлхийн гол хоёр тоглогч, томоохон гүрнүүдийн дунд амьдарч байна. Тэд жижигхэн Монголд байгаа энэ их баялаг, үүцийг “сүхдээд” авахыг л бодож байгаа. Дахин хэлэхэд төр стратегийн бодлогоо тодорхойлоод, ялангуяа олны “нүдний хор” орж байгаа уул уурхайн салбарт хувийн хэвшлийг сайн ажиллуулах нь чухал. Нэг жишээ хэлэхэд, Швейцарьт Кантоны систем үйлчилж, компани, холбоод нь салбарын бодлогын асуудлаа шийддэг. Засгийн газар ерөнхийд нь чиглүүлдэг, стратегийг нь тодорхойлдог юм байна. Энэ алхам манайд хийгдэж эхэллээ. Одоо “Энержи ресурс” компани нүүрсээ хэнтэй, яаж ашиглаж олборлохоо өөрсдөө мэдэхээр болсон. Засгийн газраас асуугаад байх шаардлагагүй, зөвхөн бодлогыг нь баримтлаад явж болно. “Хоёр толгой”-г ч ийм байдлаар шийдчихсэн бол Монголын Засгийн газар Путин гуайд ч, Ху Жин тао гуайд ч загнуулж дарамтлуулахгүй амар байх байлаа.

*Эх сурвалж:*

*Үндэсний Шуудан сонин, 2011 он*

## МОНГОЛ МӨНГӨ ХАДГАЛАХ МУНДАГ БАЯН ОРОН БОЛОХГҮЙ, БАТАЛГААТАЙ ХЭЛЧИХЬЕ

МУХАУТ-ын дарга С.Дэмбэрэлтэй ярилцлаа. Энэ сарын 27-нд тус танхимд Монголын компаниудын захирлуудын “Mongolian CEO summit 2010” чуулга уулзалт болсон юм. Бизнес эрхлэгчид, үндэсний үйлдвэрлэгчдийн дүү хоолойг уншигчидтайгаа хуваалцъя.

**- “Mongolian CEO summit 2010” чуулга уулзалтын дараахь сэтгэгдлээсээ эхлээд хуваалцахгүй юу?**

- Юуны өмнө “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-д манай бизнесмэнууд сэтгэл дундуур байгаагаа хэллээ. 140 гаруй гарын үсэг цуглуулдаг барилгын салбарт гэхэд хүнд суртал дөнгөж есөн гарын үсгээр багассан байна. Бусад хэрэгжилт нь хаана байна вэ гэдэг асуулт хариултгүй хэвээр. Өнөөдөр бид төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаар яриад байгаа. Гэтэл зөвхөн төртэй холбоотой асуудлаа яриад бусдыг нь орхиод байна.

### ЕРӨНХИЙ САЙДЫН ИТГЭЛ ҮНЭМШЛИЙГ БАТЛАХ ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО ХЭРЭГТЭЙ БАЙНА

**- 150 гаруй компанийн захирал оролцсон энэ чуулганы дараа үр дүнд хүрэх алхмаа хэрхэн тодорхойлов?**

- Компанийн засаглал бол хэдэн хувьцаат компанийн асуудал биш. Харин бүхэл бүтэн сууриар нь өөрчлөх ёстой. Хууль эрх зүй, удирдлагын хувьд ч тэр. 2010 ондоо багтаж, “Бизнесийн шинэтгэлийн жил”-тэй холбоотой ажлуудыг хийх сонголт нь үлдэж байна. Компаниуд Засгийн газрын “Бизнесийн орчныг шинэтгэх жил”-ийн хэрэгжилтэд “дунд” буюу “3” гэсэн дүн тавьсан.

**- “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-д “дунд” дүн тавьсан гэлээ. Засгийн газраас энэ аяны хэрэгжилтийг хаа очсон газраа л тайлагнаж байна шүү дээ, уг нь?**

- Энэ дүнг чинь арай гэж л тавьж байгаа юм шүү дээ. Тэгэхээр ойлгомжтой байгаа биз дээ.

**- Он дуусахад гуравхан сар үддлээ. Энэ хугацаанд Засгийн газрын амлалт салхинд хийсчихвэл бид хэнтэй хариуцлага тооцох юм бэ. Ахиад л эзэнгүй цаас үлдэх үү?**

- Хариуцлага тооцно гэдэг итгэл үнэмшлийн л асуудал болчихлоо. Ерөнхий сайд нь итгэл үнэмшилтэй байгаа, түүнийгээ ч зарласан, бас намын лидер. Тэргүүн шадар сайд нь нөгөө намынхаа лидер. Энэ хоёр нам хоёулаа сонгуулийн өмнө “Бизнесийн орчныг шинэтгэнэ” гэж амласан. Удахгүй 2012 он болно. Амлалт нь яагаад хангалттай хэрэгжихгүй байгаа талаар нухацтай, хатуу тооцоотой хэлэлцэх боломж байсаар байна. Хатуу гар хэрэгтэй байгаа юм. “Ажлаа биелүүлэхгүй байгаа бол суудалтай чинь ярина” гэдгийг хатуу сануулах цаг нь болсон. Ерөнхий сайд удахгүй ирнэ.

“Бизнесийн орчныг шинэтгэх жил”-д сайн ажиллаж байгаа Гаалийн ерөнхий газар зэрэг байгууллага бий. Хамгийн гол нь бүгд хөдөлж, үр дүнд хүрч байж бизнесийн өрсөлдөөнийг бий болгоно. Эцсийн эцэст зах зээл өөрөө үүнийг тодорхойлж байгаа. Энэ бүх мэдээллийг өөртөө хадгалдаг газар нь компаниуд болохоос биш нэг яамны сайд, дарга нар биш. Эдийн засгийн төрөлжүүлэлтийн тухай бид олон ярилаа. Экспортоо нэмэгдүүлэх тухайд ч тэр. Гэтэл гадаадын хэчнээн улсад бид Элчин сайдтай билээ. Нэг Элчин сайд нэг барааг дааж аваад тухайн улсдаа сурталчилж яагаад болдоггүй юм бэ.

### ЦАЛИН НЭМЛЭЭ ГЭЭД ИНФЛЯЦИ ӨСӨХГҮЙ, ЭНЭ ХУДЛАА

**- Ирэх сарын 1 -нээс эхлээд төрийн албан хаагчдын цалин 30 хувиар нэмэх гэж байна. Тэгэхээр хувийн хэвшлийнхэн маань үүнийг дагаж хөлсөө өсгөхөөс эхлээд өнөөх “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” бүдгэрээд байна?**

- Цалин нэмснээр аравдугаар сард инфляци ихээр өснө гэвэл худлаа. Ченжүүдийг буруутгадаг нь ч худлаа. Цалин нэмэгдэхээр, бизнес эрхлэгчид үнээ нэмэгдүүлнэ гэнэ, энэ бас худлаа. Энэ нь инфляцид нөлөөлөх гол зүйл нь биш ээ. Харин зардал чухал. Аравдугаар сарын 1-нээс төрийн албан хаагчдын цалин нэмэгдэхээр, бодит орлого нь тэр хэрээр мэдээж нэмэгдэхгүй. Юу хамгийн их мэдрэгдэж хамгийн аюултай байх вэ гэвэл халамж. Хэтэрхий их халамж, бас түүнийг амлах. Эхлээд 20 мянга, дараа нь 10 мянга гэж иргэддээ амлах нь маш ичмээр шүү дээ. Тэрний оронд хүмүүст тэгш боломжийг нь олгох хэрэгтэй. Чаддаг юмыг нь хийлгэж, чаддаггүйд нь сургах цаг ирээд байна шүү дээ. Хүмүүсийг сайхан амьдруулах тэр чиглэлд зардлаа зориул гэсэн үг. Тиймээс халамж л инфляцид хамгийн их дарамт болно.



- Ирэх оны төсвийн төслийн талаар эдийн засагчид нэлээд ам сайтай байна лээ. Таныхаар 2011 онд халамжийг зөв гольдролд нь оруулж, эдийн засгийн өсөлтийг хангаж чадах болов уу?

- Дараа жилд халамж тараахгүй байвал их сайн. Цалин тодорхой хэмжээгээр нэмэгдэж болно. Төрөөс цалингийн доод хэмжээг 108 мянган төгрөгөөр тогтооход хувийн хэвшлийнхэн хэзээ ч тийм мөнгийг ажилтандаа өгөхгүй, дор хаяж 150 мянгыг олгоно. Ажилчин нь 108 мянган төгрөгөөр амьдарч чадахгүйг мэдэж байгаа болохоор тэр шүү дээ. Үйлдвэрчний эвлэлийнхэн маань “Цалин нэм” гэж мэдэгдээд л байдаг. Түүнд нь Ажил олгогч эздийн холбоо ч багтсан байна лээ. Би сүүлдээ учрыг нь ч олохоо байсан. Цалин мэдээж нэмж болно. Гэхдээ заавал бүтээмжид суурилах ёстой. Ингэж чардайж байхад нь төрийн албан хаагчдын цалинг өсгөж, хувийн хэвшилд ажилтан бэлтгэдэг хүмүүстэйгээ ярилцаж, тохиролцоогүйгээс нийгэмд буруу хүлээлт үүсгэчихлээ.

#### **МОНГОЛБАНК ТОГЛОХООС ӨӨРИЙГ ХИЙХГҮЙ БАЙНА**

- Төрийн албан хаагчдын цалинг өсгөснөөс инфляцид нөлөөлж мэдэх тул бодлогын хүү бууруулах шийдвэрээ Монголбанк түр хойшлуулсан гэж мэдэгдсэн шүү дээ?

- Төвбанкнаас хэлээд байгаа энэ зүйл үнэндээ их инээдэмтэй. “Бодлогын хүүгээ бууруулж болох юм” гэж хэлээд байгаагаараа тэд мөнгөний бодлого хийж тоглоод байгаа байхгүй юу. Уг нь “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-д Монголбанк өөрөө санаачлаад дэд хөтөлбөр оруулж ирнэ гэсэн. Тэр нь одоо болтол сураггүй. Монголын эдийн засгийн орчныг зөвхөн мөнгөний бодлогыг дээш, доош нь болгосноор хийж болохгүй ээ. Мөнгөний бодлогоороо арай гэж эдийн засгаа удирддаг улс орнууд бий. Хөгжлөөрөө өндөр төвшинд хүрсэн нь тэд, уг нь. Б.Обама үг хэлэхэд хөрөнгийн зах зээлд нь өөрчлөлт гардаг тийм л эдийн засагтай орнуудын бодлогыг манай Төвбанкныхан хэрэгжүүлээд байна. Ийм бодлого манай улсад нөлөөлөхгүй. Тиймээс л би үүнийг “Тоглоом хийгээд байна” гэж хэлсэн.

- Тэгэхээр Монголбанк “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-д үйлдвэрлэгчдээсээ тойроод байна гэсэн үг үү?

- Төвбанкинд хоёр арга байна. Тус болдоггүй юм гэхэд, ядаж хор хүргэхгүй байх. “Бид бодлогын хүүгээ бууруулсан учраас инфляци буурлаа. Ингээгүй байсан бол тэгэх байсан юм” гээд хүмүүсийг айлгаад, тоглоом тоглоод явж болно. Энэ бол нэгдүгээр арга. Харин дараагийнх нь гэвэл, банкууд, банк бус

санхүүгийн байгууллагууд эдгээрийн дунд өрсөлдөөн бий болгох. Уг нь О.Чулуунбатын үед овоо өрсөлдөөн өрнөж байсан юм шүү. Тиймээс зээлийн хүүг бууруулж, банкуудын дунд өрсөлдөөнийг бий болгохын тулд мөнгөний бодлогод засвар хийх цаг нь ирсэн.

- Яаж засварлана гэж?

- Инфляцийг онилох бодлого баримтлах ёстой юм уу, үүнийгээ эргэж харах ёстой. Заавал Төвбанкнаас оролцоод байх хэрэг байна уу, үгүй юу. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлт, түүний дотор жижиг, дунд үйлдвэрлэл, экспортод Төвбанкнаас яаж оролцох вэ гэдгийг тодорхойлох ёстой. Энэ бүхэн хөгжингүй улсуудын практикт түгээмэл байдаг зүйл. Ийм маягаар эдийн засгийн тогтвортой, хүний оролцоотой өсөлтийг хангахад Төвбанкны гүйцэтгэх үүргийг гаргаж ирж мөнгөний бодлогыг өөрчлөхгүй бол бид өмнө хэлсэн нэгдүгээр сонголтоор л явна. Түүнийгээ юу ч гэж нэрлэж болно. “Валютын ханшиг тогтвортой байлгах”, “Инфляцийг онилох” гээд. Тэглээ гээд яах вэ.

- “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгттөгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино” гэж Төвбанк цахим хуудсандаа хүртэл тэмдэглэсэн байдаг?

- 2004 оноос хойш бизнес эрхлэгчдийн дунд явуулсан судалгаагаар цалин, инфляцийн тухай хүлээлт дандаа сөрөг гарч байгаа шүү дээ. Эдийн засгийн өсөлт, Төвбанкны талаарх итгэл нь тэгтлээ төлөвшөөгүйгээс “Цалин нэмэгдчихвэл инфляци өсчих байх” гэсэн хүлээлт л байна. Тэгээд ч Төвбанк нэг юм хэлэхээр хэвлэл, мэдээлэл тоть шиг дагадаг байж болохгүй шүү дээ. Монголбанкны хэлснийг огт өөрөөр тайлбарладаг байгууллага байна, жишээ нь МҮХАҮТ. Энэ хоёрын аль нь үнэн яриад байгааг хэлдэг байгууллага нь уг нь Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо.

МҮХАҮТ бизнесийнхний дуу хоолойгоор дуугардаг бол Төвбанк нь банкуудаа ч сонсдоггүй. Сангийн яам харин бизнесээ дэмжих бодлого явуулж байна шүү дээ. Муу, сайн ч гэсэн 20, 30 тэрбум төгрөгөөр жижиг, дунд үйлдвэрлэлүүдийг дэмжих гээд оролдоод байна...

#### **БИ МУУ АМЛАЖ БАЙГАА ЮМ БИШ**

- 2011 оны төсвийн хүрээний мэдэгдэл удахгүй хэлэлцэгдэнэ. Таиы анзаарч буйгаар ирэх жил жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалт хэр хангалттай байна?

- 2013 оноос Төсвийн тогтвортой байдлын тухай хууль хэрэгжиж эхэлнэ. Тэр болтол 2009, 2010 оны төсвийн төлөв

байдал хадгалагдаж байна. Зардлын шинэчлэл хийж чадаагүй. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих 30 тэрбум төгрөгийн хэмжээг нэмэх байх. Миний бодлоор орон нуггийн төсвийг олгохдоо авлигын индексийг нь суурь болгодог байж болно шүү дээ. Авлига ихтэй газар нь санхүүжилтийг нь багасгаж болно.

**- Оюутолгойн бүтээгдэхүүн 2013 оноос гарч эхэлнэ. Харин бид одоо Тавантолгойн олборлолтыг гүйцэтгэгчээ сонгох гэж байна. Их хэмжээний орлого орж ирээд, эдийн засаг хаашаа эргэх бол гэж олон нийт харж, ажиглаж байна. Та харин юу гэж дүгнэж байна даа?**

- Тэрнээс чинь хадгалаад байхаар мөнгө Монгол Улсад гарахгүй биз дээ. АНУ-ын Холбооны нөөцийн санд мөнгө хадгалаад байх нь утгагүй. Монгол Улс мөнгө хадгалаад байхаар тийм мундаг баян орон болохгүй, баталгаатай хэлчихье. Муу амалж байгаа юм биш. Бидний бодит боломж нь ерөөсөө л энэ. Нөөц дээр суурилсан ч гайхамшгийг бий болгож чадахгүй. Бид зөвхөн зөв явбал өндөр хөгжилтэй орон болж чадна. Бид газрын баялаг, нөөцөө хүн амынхаа боловсрол, өрсөлдөх чадварт зориулах ёстой.

*Зууны мэдээ, 2010 он, №233/3611*

## МОНГОЛБАНК ӨВДСӨН НЭГ КОМПАНИДАА ЭМЧИЛГЭЭ ХИЙЖ БАЙНА

*МУХАУТанхимын дарга С.Дэмбэрэлтэй ярилцлаа.*

**- Танай танхим бизнесмэнүүдтэй хамгийн ойрхон ажилладаг байгууллагын нэг. Таныхаар “Анод” банкнийг тойрсон асуудал Монголын бизнесийн салбарт нөлөөлөх үү?**

- Монголын бизнесийн салбарт тэгтлээ нөлөөлөхгүй.

**- Банктай харилцдаг байгууллагуудад огт нөлөөлөхгүй гэж үү?**

- Би яг тэгж хэлээгүй. Мэдээж “Анод” банктай хамтарч ажилладаг компаниудын хувьд нөлөөлөх нь ойлгомжтой. Зөвхөн “Анод”-той харилцдаг байгууллага гэлтгүй бүхэлдээ бизнес эрхэлж буй компаниудын зээлийн нөхцөл хүндэрчихсэн байгаа. Угаасаа зээл зогсчихоор бизнест нөлөөлнө шүү дээ.

**- Анод банк дампуурчихвал юу болох бол?**

- Дампуурлаа гэж яах юм. За яахав дампуурлаа гэж бодъё. 16 арилжааны банк 15 л болно биз. Банк бол бизнесийн байгууллага.

Тэгээд ч компаниуд бизнес рүү орж, гарах явдал байдаг. Ганц компани санхүүгийн хувьд жаахан хүнд байдалд орлоо. Банк хэдий бизнесийн байгууллага ч бусадтай харьцуулахад итгэлцэл дээр тогтодог онцлогтой. Тийм болохоор сандралдаан, сургаар худлаа ярих, эргэлзээ энэ бүхэн хүмүүст нөлөөлдөг. Дэндүү эргэлзэх байдал хэт ихэсчихвэл Сангийн сайд, төв банкны ерөнхийлөгч юу ч гэж хэлээд нэмэргүй. Эдийн засгийн бодитой мэдээллийг анхаарахгүй байх нь сайн үр дүн дагуулахгүй. Тийм учраас хүмүүст хэлэхэд тайван бай, ийм явдал банкны системд тохиолдож болдог асуудал гэдгийг хэлэх байна. Арилжааны 16 банкны хариуцдаг төв байгууллага болох Монголбанк өвдсөн нэг компанидаа эмчилгээ хийж байна.

**- Зөвхөн эмчилгээ хийгээд зогсоогүй удирдлагыг нь хүртэл Монголбанк гартаа авчихсан шүү дээ?**

- Төв банк тухайн банкны удирдлагыг гартаа авна гэдэг одоогийн удирдлага нь зөв үйл ажиллагаа явуулж чадахгүй юм байна гэж үзсэн болохоор хуулиар олгосон эрхийн дагуу ийм арга хэмжээ авч байгаа юм. Тэгээд ч банк итгэлцлийн байгууллага болохоор Монголбанк сургаар худлаа ярих, хүлээлт энэ бүхэн арилжааны банкны үйл ажиллагаанд нөлөөлдөг болохоор системээсээ тасалж арга хэмжээ авч байна. Бусдад нь уг өвчнийг нөлөөлүүлэхгүйгээр гэсэндээ тэгж байгаа юм. “Анод”-д байгаа хадгаламжийг аль нэгэн банкинд байршуулчихна, баахан гаргачихсан зээл нь эргүүлээд ороод ирнэ, үүсгэн байгуулагч хэсэг хүн асар том том төсөл хэрэгжүүлсэн бол тэр нь хураагдана. Тэгэхээр Анод банкны хувьд дампуурна гэж байхгүй.

**- Нэг бус банк дампуурч байсан 1990-ээд оны сүүлчийг өнөөдөртэй харьцуулбал ямар ялгаа байна?**

-1990-ээд оны үеийг өнөөхтэй харьцуулахад газар тэнгэр шиг ялгаатай дүр төрх харагдана. Одоогоос арваад жилийн өмнө жинхэнэ банкны удирдлага, зохистой харьцаа, хяналтын систем гэж байгаагүй банк дөнгөж хөлж орж байсан. Өнөөдөр бол шал өөр. Монгол банкны систем тогтчихсон. Тэгэхээр банк дампуурлаа ч гэсэн харилцагчид арваад жилийн өмнөх шиг хохирохгүй байх боломжтой. Тэгээд ч Монголбанкны удирдлагууд бусдаас нь тусгаарлаад ирэх долоо хоногийн даваа гариг гэхэд эмчилчихнэ гэдгээ олон нийтэд зарласан шүү дээ.

*О.Нямсүрэн*

*Үндэсний шуудан сонин, 2008 он, №296/386)*

## **ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛ 2010 ОНЫ ЭХНИЙ УЛИРАЛД ҮРГЭЛЖЛЭХ ШИНЖТЭЙ БАЙНА**

*МУХАУТ-ын дарга С.Дэмбэрэлтэй ярилцлаа.*

**- Гишүүд тойрогтоо 76 тэрбум төгрөг хуваариллаа. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсангүй?**

- Тойрогтоо хуваарилсан мөнгийг юунд зарцуулах гэж байгааг нь харахаар тодорхой бүс нутгийн хэрэгцээнд суурилсан аар саархан зүйлд зориулах л юм билээ

**- Энэ 76 тэрбум төгрөгөөр үр өгөөжтэй ямар зүйл хийж, бүтээж болох вэ?**

- УИХ-ын гишүүд улс орны бодит байдлыг том хэмжээнд хардаг бол аль ч тойрогт ялгаагүй нэг л аюул нүүрлэж байгаа. Тиймээс энэ 76 тэрбум төгрөгийг болдогсон бол “Ногоон сан” гэж байгуулаад төвлөрүүлж байгаль орчин, утаа, цөлжилт, бэлчээргүйдэл зэрэг тулгамдсан асуудалд зарцуулбал их мөнгө. Түүнээс биш талаар нэг цацах нь эдийн засгийн талаасаа ч үр ашиг муутай, Нөгөө талаас дээвэр засах, хана будах зэрэг нь гишүүдийн хийх ёстой зүйл биш. Гэхдээ аливаа зүйлд туйлширч болохгүй. УИХ-ын гишүүдийг ийм зүйлд гар дүрэх болсон шалтгааныг харахгүй, зөвхөн сонгогчдыг хахуульдах гэсэн арга хэлбэр гээд байх нь ч учир дутагдалтай санагддаг. Яагаад тойрогт мөнгө хуваарилдаг зүйл улам лавшраад байгаа вэ гэдгийг анхаарч тогтолцоог нь өөрчлөх хэрэгтэй гэж бодож байна. Мөн төсвийн хуваарилалтын механизм өөрөө учир дутагдалтай, хэт төвлөрсөн нь ч нөлөөлж байгаа.

**- Гишүүдийн тойрогтоо хуваарилах мөнгө анх арван саяас эхэлж байсан бол одоо тэрбум төгрөгт хүрлээ. Хэрэв энэ мөнгүүдийг нэгтгэвэл нэлээд том тоо гарна. Гэтэл 10 гаруй жилээс хайлуулах үйлдвэр байгуулж чадахгүй л байна?**

- Зөвхөн гишүүдийн тойрогтоо хуваарилсан мөнгөнөөс гадна маш их хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна. “Эрдэнэт”-ийн дэргэд зэс хайлуулах үйлдвэр баригдахгүй байгаа нь хоёр улсын хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа удирдлага болон улс төрийн шийдэл хоёр хоорондоо холилдсон учраас л өнөөг хүрч байгаа юм. Хэдэн жилийн өмнө энэ асуудлыг тавиад үйлдвэрийг

барьж байгуулах улс төрийн хүсэл эрмэлзэл гаргасан бол барьчих л байсан.

76 тэрбум ч, 7.6 тэрбум ч бай үр ашгаар нь эрэмбэлж төсвийн хөрөнгийг хуваарилдаггүй. Хувийн хэвшил болон иргэний нийгэм, иргэдийн санал бодол дээр тулгуурладаггүй, зах зээлээ олигтой олж хардаггүй, улс орны тэргүүлэх чиглэлээ зөв тодорхойлж чаддаггүйн улмаас асар их хөрөнгийг зам, дэд бүтэц рүү цацаад л байдаг. Дээрээс нь нийгмийн халамждаа л анхаараад байна. Эдийн засгийн зохистой байдал, эдийн засгийн үр ашиг гэдэг зах зээлийн эдийн засгийн хоёр гол зүйл, шалгуурыг авч үзэлгүй л төсвийн хөрөнгө оруулалтыг хуваарилаад байгаа юм. Тиймээс миний хувьд зөвхөн 76 гишүүнийг ч биш яам, агентлагийн түшмэдийг ч гэсэн буруутгах хэрэгтэй гэж боддог. Төсвийн хөрөнгийг эрх зүй, институци, эдийн засгийн үр ашгийн хувьд зөв зохистой байршуулахад өөрчлөлт хийхгүй бол бахь байдгаараа л байна.

**- Манай улсад хөгжлийн бодлого гэж байна уу?**

- Өнгөн талаас нь харвал хөгжлийн бодлого байгаа юм шиг харагддаг. Өөрөөр хэлбэл, 2020 он хүртэл Монгол Улсыг ингэж хөгжүүлнэ гээд л мастер төлөвлөгөө, хэтийн бодлого гээд цаасан дээр бичээстэй байгаа. Харамсалтай нь эдгээр зүйлд Монгол Улсын болон дэлхий нийтийн чиг хандлагыг тусгаагүй. Зарим нь хэтэрхий мөрөөдлийн шинжтэй, нэг хэсэг нь дутуу тооцоолсон нь харагддаг. Бидэнд алсад баримжаалах, зөв чигт заах луужин алга. Тийм учраас хөгжлийн бодлого гэдгийг хиилгэх гэж Үндэсний хөгжил шинэтгэлийн хороог байгууллаа. Саяхан 26 том төсөл оруулсан байна лээ. Гэвч түүнийг нь харахаар нөгөө хуучин хандлагаасаа салаагүй л хэвээрээ байна лээ.

**- Тэгээд юу нь алдаатай байна гэсэн үг вэ?**

- Хөгжил гэдгийг зөв ойлгох ёстой. Эдийн засгийн өсөлтүүдийг хангах нөхцөлүүдийг орчны хувьд яаж бүрдүүлэх вэ гэдгийг хөгжлийн бодлогод онцгой анхаарах хэрэгтэй байгаа юм. Түүнээс биш хуучин сэтгэлгээгээр тийм газар ийм объектуудыг барина гэдэг хөгжлийг тодорхойлж байгаа зүйл биш. Энэ нь хөгжлийг дэмжих хүчин зүйл юм. Хөгжил гэдэг эцсийн эцэст та бидний маргаашдаа итгэх итгэл, амьжиргааны түвшин, бизнес хийх, ажиллах өөдрөг орчныг л бүрдүүлэхийг хэлээд байгаа юм.

**- Ерөнхий сайд С.Батболд хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу шилжих түүхэн цаг үе ирлээ гэж мэдэгдсэн. Үүнийг хэрхэн хүлээж авсан бэ?**

- Энэ нь улс төрийн бодлогын хувьд чухал мэдэгдэл. Гагцхүү үүнийг бодит амьдрал дээр л хэрэгжүүлэх нь чухал байна. НҮБ-ын хүний хөгжлийн индексээр Монгол Улс ухарсан. Мөн манай улсын өрсөлдөх чадвар, бизнесийн орчин, авлигын түвшин, Монгол Улс дахь эдийн засгийн эрх чөлөөг тодорхойлдог олон улсын төсөөлөл, индекс, зэрэглэл зэрэгцээд муудаад л байгаа. Энэ нь юу хэлээд байна гэхээр хүн рүү чиглэсэн хөгжлийн бодлогодоо анхаарах, бизнесийнхээ орчныг сайжруулах, зөвхөн уул уурхайд түшиглэхгүй, голланд өвчнөөс зайлсхийх, баялгийн хараал гэдэг зүйлд орохгүйн тулд салбаруудаа тэнцвэртэй хөгжүүлэх, хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэлийг сайн дэмжих, санхүү, эдийн засгийн орчныг бий болгох, банкны салбарыг өрсөлдөх чадвартай болгох шаардлагатай байна гэсэн үг.

**- 2009 оныг үйлдвэржилтийн жил болгон зарласан. Үнэхээр үйлдвэрлэгчдээ дэмжсэн жил болж чадав уу?**

- Чадаагүй, Манай танхимаас үйлдвэржилтийн бүтэц схемийг, газрын зураг, чиглэлүүдийг болон Монгол Улс дунд, урт хугацаанд долоон төрлийн үйлдвэрлэлийг дэмжиж болох юм байна гэдгийг тодорхойлоод өгсөн. Гэтэл үйлдвэржилтийн хөтөлбөрийг хэдэн сар болж байж баталсныг та бүхэн мэдэж байгаа. Төрөөс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд 30 тэрбум төгрөгийн бага хүүтэй зээл олгохоор болсон ч 2009 он гараад хагас жил гаруй болсны дараа буюу долдугаар сард баталж гаргаж байх жишээний. Тэгээд түүнийгээ хурдан авч ашиглахгүй бол буцааж хураана шүү гэж айлган байж хам хум бушуухан үрэн таран хиймээр аядлаа. Цөөн хэдэн компани тодорхой үр ашигтай төсөл хэрэгжүүлж байгааг үгүйсгэхгүй. Гэхдээ л аливаа зүйл үр дүнгээр хэмжигддэг. Саяхан гаргасан статистикийн үзүүлэлтээр үйлдвэрлэл уналтын байдалтай хэвээрээ л байна.

**- Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжихээр олгосон 30 тэрбум төгрөгийн зээл эхнээсээ л хуудуутай хуваарилсан нь илэрч, үйлдвэрлэл эрхэлж байгаа жинхэнэ эздэдээ хүрэхгүй байна гэх гомдол гарах боллоо?**

- Энэ мөнгө хангалттай биш нь тодорхой. Бас жинхэнэ эздэдээ хүрэхгүй байгаа зүйл ч байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, хотын захиргаатай хамтран комисс байгуулмаар аядаад л тэр мөнгийг хуваарилж байна. Тиймээс хуваарилалтын механизмыг цааш цаашдаа сайжруулах шаардлагатай. Ирэх жил үйлдвэрлэгчдэд 30 орчим тэрбум төгрөгийн зээл олгохоор тусгасан байна лээ.

**- Хөгжлийн банк байгуулна гээд байгаа. Та үүнийг дэмждэг үү?**

- Бусад улсын муу туршлагыг харахаар дэмжмээргүй санагддаг. Гэхдээ гадаадад ийм байсан юм чинь Монголд хөгжлийн банк байгуулж болохгүй гэж үзвэл хэтэрхий өрөөсгөл асуудал. Муу суурин дээр хөгжлийн банк байгуулах биш суурийг сайжруулах, банкуудын дунд өрсөлдөөн бий болгох л хэрэгтэй. Маш том төслүүд хэрэгжих гэж байгаа энэ үед нэр хүндтэй, олон улсын том банкны салбарыг Монголд байгуулах нь чухал. Ийм банк жилийн 5-7 хувийн хүүтэй зээлийг олгоод эхэлбэл бизнес эрхлэгчид хошуурна. Тэгэхээр дотоодын банкуудын өрсөлдөх чадвар ч дээшилнэ. Мөн банкнаас гадна мөнгө босгох боломжийг олгодог хөрөнгийн биржийг хөгжүүлэх хэрэгтэй байна. Монголд ганцхан хөрөнгийн бирж байх ёстой юм шиг хандаад байдаг сэтгэлгээгээ ч өөрчлөх цаг болсон гэж боддог. Хөрөнгийн бирж байгуулъя гэж хөөцөлдөөд байгаа залуус байна. Тэднийг дэмжиж өрсөлдөөн бий болговол байдал аяндаа өөрчлөгдөнө.

**- Олон улсын байгууллагын гаргадаг судалгаанаас харахад Монгол Улсын бизнесийн орчин муудаад байна гэсэн таагүй мэдээ байна. Энэ нь эдийн засгийн өсөлтийг чөдөрлөж байгаа нэг хүчин зүйл үү?**

- Хувийн хэвшилдээ эрх чөлөөг нь өгсөн, бизнесийн болон эрх зүй, санхүүгийн орчныг сайжруулсан орнуудын өрсөлдөх чадвар дээшлээд хөгжиж байна. Тиймээс манай улс бизнесийн орчныг сайжруулах шаардлагатай байгаа юм. Ерөнхий сайд С.Батболд надад зөвлөхийн хувьд нэг зүйлийг аминчлан хэлсэн.

**- Ямар зүйлийг...**

- 2010 оныг бизнесийн орчны шинэтгэлийн жил болгоно гэсэн зорилт тавихаар төлөвлөж байна гэсэн. Бичил, дунд гээд бүх төрлийн бизнес эрхлэгчдэдээ мөнгөөр тусалж чаддаггүй юм аа гэхэд бизнес хийх орчныг нь сайжруулж, хүнд суртлыг арилгаж, ийм ч зөвшөөрөл энэ тэр гээд хэрэгтэй, хэрэггүй баахан зүйл бүрдүүлэхийг шаарддаг, элдэв шалгалт, хяналт нэрийн дор дарамталдаг, сүрдүүлдэг байдлыг өөрчилбөл ахиц гарна. 2012 он хүртэл бага хугацаа үлдэж байгаа. Энэ хугацаанд амжуулах ажил их байна. Эхлээд бизнесийн орчны шинэчлэлийг хийх хэрэгтэй. Яагаад шинэчлэл хийх хэрэгтэй гэхээр Монголын бизнесийн орчин нь бохирдоод, хогийн өвс ургамал ургаад эцсийн дүндээ Монгол гэдэг улсын нүүр царайг халтар болгон харагдуулж байна. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид эдийн засгийн өсөлтийг

бий болгодог. Эдийн засгийн өсөлт гэдэг нийгмийн төрөл бүрийн зүйлийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бий болгодог. Манай улсын төр засаг энэ эх үүсвэрээ бий болгодог, баялгийг бүтээж байгаа хэсгийнхээ амьдрах, ажиллах орчныг ерөөсөө анхаарахгүй байна. Халамжиндаа л онцгой анхаарч ирсэн. Ямар сайндаа л Монгол Улсын Төв банк буюу Монголбанк нь хувийн хэвшлийг золиосонд гаргах бодлого хэрэгжүүлж байхав дээ.

#### **- Үүнийгээ тодотгохгүй юу?**

- Монголбанк мөнгөний хатуу бодлого барьж зээлийг зогсоож байсан. Үүний үр дүнд аж ахуйн нэгжүүд нь хүнээр бол сульдаатай хүүхэд шиг унжийсан байдалтай болсон юм. Хувийн хэвшлийнхэн уналтад орохоор дагаад банкууд чирэгдсэн. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн гол судсыг нь тасалсан. Энгийнээр тайлбарлавал төв банк иргэдэд битгий мөнгө зээл, надаас үнэт цаас худалдаж ав гэсэн бодлого барьсан хэрэг. Засгийн газраас боловсруулж оруулсан хямралын эсрэг хэрэгжүүлэх төлөвлөгөө гэгчийг УИХ-аар хэлэлцүүлээд, үүнийг хэрэгжүүлэхэд 1.5 их наяд төгрөг шаардлагатай гээд батлуулсан. Хямралын үед бусад улс орнуудын адил эдийн засаг руугаа, хувийн хэвшил рүү, банк руу, ард иргэдрүүгээ мөнгө хаяж байж, эдийн засгаа нийтэд нь босгох юм байна гэж тооцоо судалгаа муу хийсэн ч зөв харж шийдвэр гаргасан. Гэтэл энэ төлөвлөгөөг баталсны дараа хоёр, гуравхан хоноод л ОУВС-тай Тогтворжуулалтын хөтөлбөр хэрэгжүүлэхээр гарын үсэг зурж 200 гаруй сая ам.доллараас их хэмжээний арилжааны зээл авч болохгүй гэж ам тангаргаа өгсөн юм. Энэ нь эдийн засгаас мөнгийг татаж авах зүйл байв. Нэг нь эдийн засагтаа мөнгө оруулах, нөгөө нь татаж авах хоёр шийдвэр хоорондоо зөрчилдөн саармагжсан учраас эдийн засгийн байдал хүндхэн байна. Энэ оны эцэст инфляци нэг оронтой тоонд хүрсэн мөртлөө ард иргэдийн амьжиргаа дордсоор л байна. Үнэ буурсан уу гэж захын хүнээс л асуухад махны ханш л бага зэрэг унасныг эс тооцвол ихэнх бараа бүтээгдэхүүний үнэ өсөөд амьдрахад хэцүү болоод байна гэж хариулна. Энэ чинь инфляцийн дарамт. Өөрөөр хэлбэл хувийн хэвшлийнхнийг золиослон инфляцийг хүчээр барьж ганц оронтой тоонд оруулсан төв банкны бодлого буруу байжээ гэдгийг харуулж байгаа хэрэг. Үүний үр дүнд банкуудын байдал хүндэрч, аж ахуйн нэгжүүд сөхөрч, иргэдийн амьжиргаа улам л муудсаар байна. Цаасан дээрээс харахад инфляци нэг оронтой болсон ч бодит амьдрал дээр үнийн өсөлтийн дарамт өнгөрсөн жилийнхээс нэмэгдсээр байна.

**- Монгол Улсын мөнгөний бодлогыг зангидаж байгаа төв банкныхан хэрвээ зээлийг зогсоож бодлогын хүүг нэмээгүй бол инфляци хяналтаас гарч эдийн засаг сүйрэх гээд байсан гэж тайлбарладаг шүү дээ?**

- Монголбанкныхан тэгж ярьдаг юм. 2009 оны гуравдугаар сард Монголбанкнаас нэг мэдэгдэл гаргасан. Явуулж байгаа бодлогынхоо бүх учрыг тайлбарласан байсан. Хэрэв түүнийг анхааралтай уншсан бол Монголбанкны явуулж байгаа төрийн мөнгөний бодлого нь бодит амьдралаас тасарсныг харах болно. Түүнд хувийн хэвшлийг золиослох гэсэн өгүүлбэр байгаа. Эдийн засгаас мөнгө татаж авъя, эдийн засгаа л авч үлдье гэж хичээсэн нь харагдана. Гэтэл эдийн засаг гэдэг чинь хоосон хэдэн тоог хэлдэггүй, цаад утгаараа хүнтэй л холбоотой. Эдийн засгийг хөдөлгөж байгаа хүчин зүйл нь хувийн хэвшлийнхэн болон эрэлтийг нь бий болгож байгаа ард иргэд юм. Тэгэхээр зах зээлээ унагаад эдийн засгаа авч үлдэнэ гэдэг аргагүй л үеэ өнгөрөөсөн социалист сэтгэлгээ гэж хэлэхээс аргагүй байгаа биз дээ. Хямралын үед манай танхимаас бодлогын хүүг өсгөх биш таван хувь болгож бууруулах саналыг гаргасан ч авч хэлэлцээгүй. Монголын бизнес эрхлэгчид өөрийн хөрөнгө болон банкнаас зээл авч үйл ажиллагаа явуулж байгаа. Гуравдагч эх үүсвэр болох хөрөнгийн бирж сайн хөгжөөгүй учраас тэндээс мөнгө босгож чадахгүй. Тиймээс банкнаас хамааралтай бизнес эрхлэгч, иргэд олонхи нь байгаа нөхцөлд төв банк бодлогын хүүг өсгөөд банкны нөхцөлийг хатуу болгочихоор банк, бизнесийн оршин тогтнож харилцан бие биеэ арай ядан дэмжиж байсан хэлхээ холбоог дундуур нь тас цавчаад хаясан гэсэн үг. Банкууд хямралын үед аж ахуйн нэгж, иргэдэд зээл өгөх эрсдэлтэй гэж эмээхээсээ илүү эрсдэлгүй сонголтыг Монголбанк нь олгосон учраас гаргасан үнэт цаасыг нь худалдаж авахыг илүүд үзэж байсан. Гэтэл эдийн засаг гэдэг чинь хүмүүсийн амьд харилцаа учраас нөгөө хэлхээ холбоог шаардана шүү дээ.

**- Валютын ханш нэг хэсэг хэт савласан, одоо дахиад өсөх хандлага ажиглагдаад байна?**

- 2008 оны арваннэгдүгээр сараас 2009 оны дөрөвдүгээр сар хүртэл валютын асар их нөөцийг Монголбанк гаргаж зарсан. Түүнийхээ хүчээр ханшийг тодорхой хэмжээнд тогтоон барьсан юм. Гэхдээ манай улсад валютын ханшийн зах зээл нь зөв гольдролоороо хөгжөөгүй. Валютын ханшийн оролцогч нь цөөн хэдхэн банкаар л хязгаарлагддаг. Монгол Улсын валютын ханшийн дэглэм нь өөрөө валютыг гадагшаа урсгах, долларжилт эдийн засагт

хүчтэй болохыг өөгшүүлдэг. Интервенц хийж байж зохиомлоор хэдэн сар валютын ханшийг тогтоон барьсан. Гэтэл эдийн засаг хүчээр барьснаар биш эрэлт, нийлүүлэлтээр тэнцвэржиж байдаг. Валютын зохицуулалттай хөвөх ханш гэсэн дэглэм Монгол Улсад алга. Валютын ханшийн удирдлага менежмент гэдэг зүйл ерөөсөө төлөвшиж чадаагүй байна. Саяхнаас л Монголбанк валютын бирж ярьж байна. Энэ юуг харуулж байна гэхээр төв банк ажлаа хийхгүй байж байгаад 2008 оны эцэс 2009 оны эхэнд ханш гэнэт өсч баахан сандарч арайхийн тогтоож авсан. Одоо үүнийг хийхгүй бол болохгүй нь гэдгийг мэдрээд 2010 оны үндсэн чиглэлдээ тусгаж батлууллаа. Өөрөөр хэлбэл, ажпаа хийхгүй байж байгаад одоо л хийх гэж байгаа хэрэг.

**- Та төв банкны ерөнхийлөгчийг тааруухан ажиллаж байна гэж дүгнэдэг юм уу?**

- Би энэ ерөнхийлөгч нь сайн, тэр нь муу гэж хэлмээргүй байна. Ерөөсөө УИХ төв банктай харьцах харьцаа, төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, батлуулах үйл явцад засвар хэрэгтэй байна. Төрийн мөнгөний бодлогыг тодорхойлох, батлах явц олон жилийн турш хэлбэрдэх маягаар явж ирсэн. Төв банк нь үндсэн чиглэлээ оруулдаг, УИХ нь бага сага өөрчлөөд баталсан болдгийн уршиг оны эдийн засаг, санхүүгийн жилд улам хурцаар илэрч, бодит секторын үйл ажиллагааг золиослох замаар банк санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж, өсөлтийн суурийг тавих гэсэн Монголбанкны оролдлого бүтэлгүйтэж, онд мөнгө санхүүгийн тодорхой бус эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй байх нөхцөлийг бий болголоо. Энгийнээр тайлбарлабал төв банк Сангийн сайд С.Баярцогт оо, Ерөнхий сайд С.Батболд оо та нар аль болохоор эдийн засгаа аваад гарахыг бод, байдал гайгүй болоод ирвэл бид оролцъё гэсэнтэй утга адил.

**- Иргэд урт хугацааны бага хүүгэй зээлийг л авахыг хүсч байна. Бодлогын хүүг бууруулаад мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдуулбэл зээлийн хүү буурах уу?**

- Буурна. Энэ нь зээлийг хүүг бууруулах нэг л арга. Хамгийн гол хүчин зүйл нь өрсөлдөөнийг бий болгох. Өрсөлдөөнийг л бий болговол аяндаа зээлийн хүү хүссэн хүсээгүй буурна.

**- МҮХАҮТ-аас Монголбанкинд нэг бичиг илгээгээд байсан?**

- Монголбанкинд арилжааны банк болон компаниудын хооронд хийж байгаа зээлийн гэрээ эрх тэгш биш байна. Иргэний тухай хуулийн гэрээний эрх тэгш байх зарчмыг алдагдуулж байгаа. Тиймээс энэ чиглэлд зөвлөмж гаргаж арилжааны банкуудад хүргүүлнэ үү гэсэн утгатай захиа бичсэн юм. Гэтэл Монголбанкнаас

бидний оролцдог ажил биш гэж хэлж байна лээ. Ийм сурах бичгийн хүрээнд төв банкны бодлогыг зангидаж болохгүй шүү дээ. Нүдний шил зүүсэн тэнгэр дээр сууж байгаа төв банкны бодлого байж болохгүй. Газар дээр буусан, хувийн хэвшлийнхний цусны лугшилтыг мэддэг байх хэрэгтэй байна. Ингэж л тэдний бодол санааг мэдэж байж эөв бодлого хэрэгжүүлж чадна. Иргэд, аж ахуйн нэгжүүд урт хугацаатай, хүү багатай, өөрийг нь шатаадаггүй, бизнес нь урагшилдаг зээлийн орчныг л бий болохыг хүсч байна. Ийм зээлийн орчныг бий болгох, өрсөлдөөнийг өрнүүлэхийн оронд зүгээр хөгжилтэй орны төв банкны хэрэгжүүлдэг бодлогыг хуулаад сууж байж болохгүй. Үүнд ч УИХ-ын гишүүд үнэмшээд, хэвлэлийнхэн итгээд тэдний гаргасан томъёоллоор дуугардаг болоод удаж байна.

**- Банкууд эхнээсээ дампуурч байна. Цаашид яах бол?**

- Банкны салбарын хямрал ингэс хийгээд зогсоно гэж бодож байгаа. Яагаад гэвэл улс юм байна бонд энэ тэр гаргаж аргацаагаад энэ салбарыг аваад гарах байлгүй дээ. Энэ үед өрсөлдөөний суурийг тавьж цаашид эрүүл гольдролоор замнах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм.

**- Хямралаас гарлаа гээд л байгаа. Гэвч бодит байдал өөр байх шиг байна?**

- Хямралаас гараагүй. Эдийн засгийн хямралт байдал 2010 оны эхний улиралд ургэлжлэх шинжтэй байна. 2010 оноос эхлээд эдийн засаг руу мөнгө гаргаад, төв банк мөнгөний бодлогоо өөрчлөөд, банкуудыг идэвхжүүлэх юм бол барилга ч баригдаад бусад бизнес ч цэцэглэнэ. Гадаадын орнууд аль хэдийнээ хямралаас гараад байна. Экспортод бараагаа гаргая гэвэл зах зээл байж л байна. Мал нядлаад гаргая гэхэд л мөнгө нь байхгүй байна шүү дээ.

**- ”Хүний хөгжил” гэсэн сан байгуулаад ирэх жил бэлэн мөнгө иргэдэд тараах гэж байна. Энэ нь эдийн засагт ямар нөлөө үзүүлэх бол?**

- Заяагдмал нөөцийн олдмол хам шинж илрээд байна. Түүний нэг шинж нь алаагүй баавгайн арьсыг ард иргэддээ хуваарилах гэж оролддог явдал. Энэ нь эдийн засгийн дархлааг сулруулж, хүмүүс тэгш боломжийг эдэлж өөрсдийгөө хөгжүүлэхийн оронд төрөөс авах гээд хараад суудаг бэлэнчлэх сэтгэлгээнд л сургана.

*Д.Доржпагма,*

*Өдрийн сонин, 2010 он*

## БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ 50 ЖИЛИЙН ГАРАА ЭХЭЛЛЭЭ

Бизнесийнхний дуу хоолой нь болсон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим 50 насны ойтойгоо өчигдөр золголоо. “1960 оны долдугаар сарын 2-ны өдөр МАХН-ын Төв хорооны шийдвэрээр Гадаад худалдааны яамны дэргэд анхны Худалдааны танхим байгуулагдаж байжээ. Тухайн үед гуравхан ажилтантай байсан бол өдгөө 20 аймгийн салбарт 3000 гаруй гишүүнтэй болтлоо өргөжсөн” хэмээн МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэл нээлтийн үеэр яриу.

“Эрхэмсэг оршихуйн 50 жил” хэмээн нэрлэсэн өдөрлөгийн үеэр танхимын гишүүн байгууллагууд болох аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргаж, тэд санал солилцож, хундэтгэлийн тоглолт зохион байгууллаа. МҮХАҮТ нь гадаадын 120 гаруй худалдааны танхим, олон улсын худалдааг дэмжих байгууллагатай хамтын ажиллагаатай аж. Тэд өнгөрсөн 50 жилийг Монголын эдийн засгийг хөгжүүлэхэд үндэсний компаниудын үүрэг оролцоог дээшлүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хэмээн дүгнэсэн бол ирэх 50 жилийг байгаль орчинд ээлтэй ногоон эдийн засаг, бизнесийн орчныг бий болгоход анхаарах болно гэдгээ дуулгалаа.

Тус танхимд бүртгэлтэй 3000 гаруй компани манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг хангадаг бөгөөд эдгээр нь 50 салбар зөвлөлд хамрагдан ажилладаг аж. Сүхбаатарын талбайд болж буй “Эрхэмсэг оршихуйн 50 жил”-д зориулсан танхимын гишүүн байгууллагуудын үзэсгэлэн худалдаа өнөөдөр өндөрлөнө.

*Ж.Тэгшжаргал*

## ЗЭЭЛЭХГҮЙ БОЛ МӨНГӨ БАЙРШУУЛАХ ХЭРЭГ ЮУ БАЙНА

Монгол Улсыг хөгжүүлэх санд төвлөрсөн 455.1 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад байршуулах тухай УИХ-аар өнгөрсөн долоо хоногт хэлэлцсэн. Эл хөрөнгийг арилжааны банкуудад хуваан байршуулах тухай хуулийн төслийг эргүүлэн татсан билээ. Дараа нь Засгийн газар Төрийн сангаар дамжуулж, банкуудад энэ мөнгийг байршуулах хуулийн төслийг дахин УИХ-аар хэлэлцүүлж эхэлсэн. Банкуудад хадгаламж эсвэл зээл хэлбэрээр мөнгө байршуулах эсэхэд хүмүүс байр сууриа илэрхийлсээр байгаа. МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлтэй ярилцлаа.

### “ХАРИУЦСАН, ХАРИУЦСАНААР НЬ ИНФЛЯЦИЙГ ТООЦЪЁ”

**- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн мөнгийг арилжааны банкуудад байршуулах тухай УИХ-аар хэлэлцэж байна. Энэ асуудал шийдэгдвэл үр дүнг нь Та хэрхэн төсөөлж байна вэ?**

- Бид мэдээллийн бүхий л сувгаар гадаадын улсуудад болж буй үйл явдлыг харж байна. Европ, Азийн орнуудын засгаас банкууд руугаа асар их хэмжээний мөнгө шилжүүлжээ. Хамгийн сүүлд Хятадад 800 сая юанийг жижиг, дунд бизнесээ дэмжихэд зориулж байна. Үүнээс өмнө ч арилжааны банкууддаа амь тариа болгож санхүүжилт хийсэн. Төвбанк нь зээлийн хүүгээ бууруулчихлаа.

Харин манай улсад Төвбанк нь дөнгөж 0,5 хувиар зээлийн хүүгээ багасгасан нь хангалтгүй шүү дээ. Монголбанк банкны сектороо харахаас гадна зээл авч байгаа жижиг, дунд үйлдвэрлэгчдийн эрүүл мэнд, идэвхжилт нь ямар байна гэдгийг харах хэрэгтэй. Үнэн хэрэгтэй үйлдвэрлэгчдэд зээл олдохгүй, хөгжих бололцоо нь ч тааруу байна. Энэ тохиолдолд юун түрүүнд банкуудыг дэмжих цаг. Төрөөс тавих нөхцөл нь энэ мөнгийг зээлжүүлэлтэд гаргах явдал байх учиртай. Хугацааг нь ч хангалттай тавиу байлгавал зүгээр.

**- Энэ мөнгө банкны салбарыг дэмжихэд чиглэх ёстой гэж УИХ-ын зарим гишүүн үзэж байгаа. Ийм нөхцөлд энэ нь хангалттай хөрөнгө оруулалт болж чадах болов уу?**

- Энэ мөнгө юу ч биш. Том төслүүд яригдаж, маш олон хүн зээл хүсч байна. Бизнесмэнүүд банкнаас зээл авах гээд очихоор

теллерүүд нь хадгаламж гуйгаад сууж байна. Монголбанк гаднаас их хэмжээний хөнгөлттэй зээл олж ирэх хэрэгтэй. Ингэж банкуудаараа дамжуулан бодит сектороо дэмжмээр байгаа юм.

**- Гэхдээ Монголбанкнаас мөнгөний нийлүүлэлт хэт ихэссэнээс инфляц өссөн гэж үзэж байгаа биз дээ?**

- Төвбанкнаас “Бид инфляцийг зургаан хувьд нь барьж болох байсан. Даанч Засгийн газрын зардал өссөн” гэж мэдэгдсэн. Үүгээрээ бид ажлаа хийсэн харин засаг болохгүй байна шүү гэж сэмхэн матаад байгаа биз дээ. Үнэндээ инфляц чинь буруу үйл ажиллагаанаас л болж байгаа юм. Чи анзаарсан бол Ерөнхийлөгч “Хариуцсан, хариуцсанаар нь инфляцийг тооцъё” гэж санал хэлсэн. Зардлын инфляц үүссэн бол засагтай нь ярья. Мөнгөтэй холбоотой бол Төвбангтай нь ярья гэсэн шүү дээ.

#### **УИХ-Д СОНГОГДСОН НЬ ТЭР ХҮНИЙ БУРУУ БиШ**

**- Энэ хуулийг өөрийн гэсэн бангтай хэдэн УИХ-ын гишүүний эрх ашигт нийцүүлж байна гэж зарим хүн шүүмжилж байгаа. Та үүнийг юу гэж үзэж байна вэ?**

- Энэ чинь буруу шүү дээ. Хувийн хэвшлийн хүмүүс УИХ-д сонгогдчихоороо дуугарч чаддаггүй юм. Өөрийнхөө компанид идэх гэж ийм тогтоол гаргалаа гэж хэлүүлдэг учраас тэр. Дорж гэдэг хүн УИХ-д сонгогдсон бол энэ тохиолдолд түүний буруу биш биз дээ.

Банкны асуудал ярьж байгаа юм чинь мэргэжлийн хүний үг хэрэгтэй шүү дээ. Өнөөдөр Монголд шинэчлэл хэрэгтэй байна. Мэргэжлийн хүний, салбараа мэдээд хэлсэн үгийг зөвөөр хүлээж авдаг боловсрол хэрэгтэй.

**- УИХ-аас энэ мөнгийг банкуудад богино хугацаатай байршуулна гэж өмнө нь ярьж байсан. Засгийн газрын шинэ хуулийн төсөлд хугацааны тухай дурдагдсангүй?**

-Хугацаа нь богино байвал түр зуурын амь тариа л гэсэн үг. Богино хугацаатай мөнгө аваад яах юм бэ. Маш хурдан зээл өгөөд, эргүүлээд авах юм уу. Эсвэл хадгаламждаа хийх юм уу. Үүнийгээ ялгаж, салгах хэрэгтэй. Банкийг дэмжинэ гэж л байгаа бол бодит үйлдвэрлэгчдийг дэмжих, хугацаа нь тавиу, зээлийн хэлбэртэй байх ёстой. Үүнээс гадна өнөөдөр төрийн мөнгөний асар их урсгал явж байна, Энэ хөрөнгийг тендерийн журмаар аль нэг банкинд нь төр мөнгөө байршуулах хэрэгтэй, Тэгэхгүй бол манай улс арав гаруй Сангийн яамтай болох гээд байна шүү дээ. Яам бүр бараг хөгжлийн банк болох нь. Үүний оронд бизнесийн

бодитой санхүүжилтийг ямар байгууллагаар дамжуулж, яаж хүргэх вэ гэдгийг зөвхөн банк бус өөр замаар шийдэж болно шүү дээ. Ингэж байж л банкны салбарт өрсөлдөөн бий болгож, зээлийн хүүг бууруулна. Энэ жилээс манай танхимаас гаргасан саналд дурдсанаар Төрийн мөнгөний бодлогод инфляцийг онилдог туршлагаас татгалзаж эхэлж байна.

Харин одоо УИХ-аас Төвбанк бодит үйлдвэрлэгчдийн санхүүжилтийг дэмжих, арилжааны банкуудыг өрсөлдөөнтэй болгоход ямар алхам хийв гэдгийг улирал бүр хянаж эхлэх ёстой. Түүнээс биш бодлогын хүүгээ 0,5 хувиар буурууллаа гээд түүнийгээ банкны салбараар дамжуулан эдийн засгийн өсөлтийг хангаж байна гэж ойлговол эндүүрэл.

**-Та Төвбанкны бодлогод шинэчлэл хийх хэрэгтэй гэж хэлэх гээд байна уу?**

-Тийм ээ. Шууд шинэчлэх хэрэгтэй. Хэн нэг хүнийг халж, солих тухай яриагүй. Монголбанкийг би удирддаг байсан бол цагаан халад өмсөөд үйлдвэрүүдээр явна. Арилжааны банкны захирлуудыг цуглуулаад банкаа, хувийн хэвшлээ ч зэрэг хөгжүүлэх ямар боломж байгааг ярилцах байсан юм.

**- Тэгвэл одоо яах ёстой гэж?**

- Өнөөдөр Төвбанкны зоригтой дуу хоолой үгүйлэгдэж байна. Хаана нэг газар хэвлэлийн хурал хийчихээд түүнийгээ мэдэгдэл хийлээ гэж эндүүрэх ёсгүй. Оронд нь зангарагтай мэдэгдэл хийж, эдийн засаг, иргэдийг тайвшруулах хэрэгтэй байна, Ам.долларын ханш дахин огцом унахгүй гээд зангарагтай мэдэгдэх ёстой шүү дээ. Сайн удирдлагатай Төвбанк Монголын эдийн засгийн өсөлтийг идэвхтэй дэмжигч байж чадна. Үүний анхны суурийг нь УИХ-аас мөнгөний бодлогоороо, одоогийн мөнгө байршуулах тухай гээд олон асуудлаар тавьж өглөө.

Цаашид үүнийг сайн бодлогоор дэмжих учиртай юм. Банкуудад мөнгө байршуулах асуудал шийдэгдвэл Монголбанк хэт үрэлгэн зарлагад өөрийн байр сууриа зоригтой илэрхийлдэг байх хэрэгтэй байна. Заримдаа бүр эсэргүүцдэг баймаар. УИХ-ын харьяаллын бие даасан байгууллага шүү дээ Төвбанк чинь. Засгийн газрын зарлага нэмэгдээд байвал болохгүй гэдгийг нь зоригтойгоор эсэргүүцэж, хэлдэг байвал бүр сайн.



**МӨНГӨ БАЙРШУУЛЖ БОЛНО, БҮХ ЗҮЙЛ ИЛ,  
ТОД БАЙХ ЁСТОЙ,**

- Тэгвэл банкуудад байршуулах төрийн мөнгөнд Монголбанк ямар хяналт тавих хэрэгтэй гэж та үзэж байна?

- Хамгийн гол нь ил тод байлгах ёстой.

- Арилжааны банкуудын ил тод байдал өнөөдөр тийм ч хангалтгүй байгаа шүү дээ?

- Ил тод байна гэхээр бүх харилцагчийнхаа нэр, хадгаламж, зээлийг ил болго гэсэн үг биш. Үйл ажиллагаа нь хэр тунгалаг, баланс нь ямар байна гэдгээ хэвлэж, мэдэгдэнэ гэсэн үг. Гэсэн ч зарим банк энэ үүргээ биелүүлэхгүй байгааг үгүйсгэхгүй. Банкны систем нь ил тод байх тусам харилцагчийн итгэл нэмэгддэг. Зарим банк хувьцаа гаргаж байгаа юм чинь сайн засаглалын зарчмыг биелүүлэх хэрэгтэй. Бас банкны ард байгаа хувьцаа эзэмшигчид нь хэн юм бэ гэдгийг нуух ямар ч шаардлагагүй. Энэ айх зүйл биш.

**- Төрийн сангаар дамжуулан өөр дээрээ мөнгө байршуулах гэж байгаа банкууд хэр найдвартай, эрсдэлгүй байна вэ?**

- Арилжааны банкууд бүгд найдвартай. Тэдэн дотор бусдыгаа авч явдаг 56 банк бий. Бүгдийнх нь эрүүл мэндийн үзүүлэлт Төвбанкинд бий. Харин тэр үзүүлэлтүүдийг харахад айх зүйл ер алга.

Харин яагаад банкуудад мөнгө байршуулах шаардлага гарав. Өмнө нь Монголбанкинд үхмэл байдлаар хадгалуулсан мөнгөө эдийн засгийн эргэлтэд оруулах гэж л тэр. Энэ бол зөвхөн эхний алхам, Үүний дараа бид эх орондоо илүү их мөнгө авчирч, эргэлдүүлэх хэрэгтэй, Хүмүүст зээлж, эсвэл банкаар дамжуулахаас өөр замаар үйлдвэрлэлээ санхүүжүүлж болно шүү дээ.

**ИЗН-ын дарга С.Дэмбэрэл:  
НОСТРАДАМУС МАЯГИЙН ХҮМҮҮС  
НАМАЙГ СҮ.БАТБОЛДЫН ЗАХИЛГААР  
ИЗНН-Д ОРЖ, ДАРГА НЬ БОЛНО ГЭЖ  
ЗӨГНӨЖ БАЙСАН**

Нам бусчуудыг олон жил манлайлж ирсэн МҮХАҮТ-ын дарга улс төрийн цочир сонин алхмыг хийгээд удаагүй дээрээ намын даргаар сонгогдов.

Амьдралдаа 2 дахь удаа 20 жилийн дараа намын хуралд амралтынхаа өдрөөр арав гаруй цаг хуралдсан түүний хувьд шинэ алба тун ч сонирхолтой байгаа бололтой.

Монголын улс төрийн намуудын хувьд шинэлэг, соёлтой, анхдагч уур амьсгалыг мэдрүүлсэн шийдлүүдийг нэвтрүүлсэндээ сэтгэл хангалуун байгаа ИЗНН-ын С.Дэмбэрэл дарга одоогоор намынхаа оффист ч очиж үзээгүй. Үе үеийн ерөнхий сайд нарын эдийн засгийн зөвлөх түүнийг өдгөө ч ерөнхий сайд С.Батболдын нөлөөгөөр сонголт хийж явна гэх хар сэр ч яваа.

**- Гурван даргатай нам тэдний нэг нь шинэхэн гишүүн С.Дэмбэрэл байгаагийн сонинг гайхахгүй хүн алга?**

- Сонин болсондоо баяртай байна. ИЗНН-ын хурал амралтын өдөр хуралдсан. Тэр намын хуралд би хаалгаар нь орсон. Тооно мооно гэж байхгүй байна лээ. Намын хуралд ер нь тооно мооно байдаггүй юм билээ. Индэрт нь суугаагүй, дунд нь суусан. Их хүйтэн зааланд арван хэдэн цаг хуралдсан. Гол үр дүн С.Дэмбэрэл гэдэг хүн намын дарга болсондоо биш.

Бусад улс орнуудад байдаг орчин үеийн либераль чиглэлтэй намуудын ардчилсан нээлттэй удирдлагын шинэ тогтолцоог бий болгосон. Тэр нь юугаар илэрч байна гэхээр улс төрийн бүх намууд шахаж шаардуулж байж дөрвөн жилд нэг удаа хуралддаг бол ИЗНН гишүүн төвтэй болоод жилд 1 удаа хуралдана. Хамтарсан даргын зарчмыг оруулж ирсэн. Олон оронд байдаг гэхээсээ илүү тулгын гурван чулуу гэсэн Монгол сэтгэлгээгээ бодсон.

Чиг үүргээ тус тусдаа хариуцсан гурван дарга юм л даа. Гэтэл зарим хүмүүс тамгаа хэн нь барих юм гэхчилэн сонин асуулт дэвшүүлсэн байна лээ. Хэн нь ч тамгаа барихгүй. Тамга ерөөсөө шаардлагагүй. Тэрийг хариуцдаг хүн нь тусдаа байгаа.

Би намд ороогүй олон жил явсан болохоор дэмжигчдийн асуудлыг хариуцах юм шиг байна.

Арван таван толгойтой атгаалжин мангас гэдэг шиг гурван толгойтой гэж хүмүүсийн хараад байгаагаар энэ гурван хүн хамтын шийдвэр гаргана. Гурван дарга үндэсний хороо, улс төрийн зөвлөл гээд дээрээ бас удирдлагатай. Би намын хуралд суугаагүй 20 жил болжээ. Анх Шинэ дэвшилтэт холбоо намын циркт болсон хуралд эвийн нөхөр гэсэн нэртэйгээр эдийн засгийн илтгэлийг нь бичиж уншиж байлаа.

Түүнээс хойш олон жилийн дараа энэ хуралд суухад бас гоё юм. Гоё гэдэг нь асар олон хүмүүс үг хэлэх гэж оочерлодог, танхимын хурал шиг залуучууд санал бодлоо илэрхийлж байсан.

**- С.Дэмбэрэл ерөнхий сайд Сү.Батболдын дүү шүү дээ гэх хүмүүс ч байгаа?**

- Сү.Батболдоос би насаар бол ах. Маш эртний найз. Өндөр байранд байхад манайхтай ойр ажиллаж байсан. Намайг нэг их хэлдэггүй л болохоос би эдийн засгийнх нь зөвлөх. Би ч бүх ерөнхий сайдуудын зөвлөх байсан хүн шүү дээ. Яагаад дүү нь гэснийг ойлгохгүй байна. Бид хоёрт генетикийн хувьд ямар нэгэн холбоо байхгүй. Сайн нөхдийн харьцаа бий. Энэ маань жишээлбэл С.Дэмбэрэл гэдэг хүнийг улс төрийн сонголтоо хийхэд огт нөлөөлөөгүй.

Маш олон жил намаас хөндий нам бус явчихаад гэнэт сонголтоо хийхдээ учир зүггүй Монголынхоо том нам руу ороод байх нь ч юу юм. Үзэл бодлын хувьд манай орчин үеийн намууд халамжит эцгийн, латерналист төрийг байгуулах гээд өнөөдөр хүртэл нийтээр хувьцаа эзэмшсэн аз жаргалтай нийгэм байгуулах тухай л ярьж байна. Хэрвээ хүмүүс миний ярьж бичсэнийг анхаарч уншдаг бол энэ талыг би дэмждэггүй.

Хувь хүний эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөө, бизнесийн орчин, ногоон хөгжил зэргийг бүх талаас нь бодоод ИЗН руу орж магадгүй гэж 2005 онд хэвлэлд өгсөн ярилцлагандаа би хэлж байсан. Зарим хүмүүс бичсэн байсан л даа. Монголд чинь ирээдүйг таадаг мундаг хүмүүс зөндөө. С.Дэмбэрэл Сү.Батболдын захиалгаар энэ намд ороод дарга нь болно гэсэн чинь нэг биелээд дарга болчихлоо. Нострадамус маягийн тэр хүнийхээр бол цаашаа үйл явдал хэрхэн өрнөхийг ард түмэн харах үлдлээ. Гэхдээ тийм юм байхгүй. Худлаа гэдгийг л хэлье.

**- Намд элссэн нь таны удаан хугацааны турш хийсэн сонголт...?**

- Би намд элсэнэ гээд өдөр болгон бодоод байгаагүй. Ажил

хийлээ, эдийн засаг их ярилаа. Улс орон ингэж хөгжих ёстой гэж асар олон бодлогын баримт бичиг боловсруулаад энэ хүмүүст эрх чөлөөг нь олгооч, хүнд сурталаа арилгаач, бизнесийн орчин сайжрах ёстой гээд явлаа. Хараад байхад Монгол улсыг хөгжлийн зөв зам дээр зогсч байгаа гэж би хэлэхгүй.

Надтай адил бодолтой хүмүүс олон бий. Монгол буруу замаар яваад байна гэдгийг гаргаж хэлэхгүй бол болохгүй. Манай танхим “Монгол 2030 он” гэсэн баримт бичиг гаргахад асар олон хүн баяр хүргэлээ. Монгол улс одоо том том юм ярихын оронд байгаль орчны доройтлыг яаж арилгах вэ гэдгээ ярих ёстой. Ногоон хөгжил рүү дэлхийн бусад орны адил хурдаар орох зэргийг хүмүүст таниулъя гэдэг талаас улс төрийн сонголт хийлээ.

Намгүйгээр яваад байж болно л доо. Тэртээ тэргүй Монголын ард түмний ихэнх нь нам бус. Надтай ижилхэн үзэл бодолтой хүмүүстэй нийлж байгаад энийг өөрчлөх гэж үзье гэж бодсоны үндсэн дээр намд элссэн.

**- Д.Энхбат даргын яриагаар бол таньд намын санхүүжилттэй холбоотой асуудлыг хариуцуулах бололтой. Намын санхүүжилт гэж амаргүй ажил байдаг. Таны толгой энэ талд нилээн өвдөх нь дээ?**

- Намын санхүүжилтыг би хариуцна гэж бодохгүй байна. Тэр чинь их аймаар ажил. Тэгж новширохгүй л дээ. С.Дэмбэрэл гэдэг хүн ганцаархнаа мөнгө бодоод л сууж байдаг. Би бодлогоо л бодно. МУ-ын эдийн засаг, цаашдын хөгжлийн зөв бодлогыг хувь хүний хөгжлийн үзэл дээр суурилж бусад намуудынхаас өөрөөр гаргаж ирнэ. Намын санхүүжилтын хувьд одоогийн улс төрийн намуудын тухай хуулийг өөрчлөх хэрэгтэй.

Хатуу гишүүнчлэлээс гадна санхүүжилтийн ил тод байдлыг жинхэнэ утгаар нь гаргаж ирэх хэрэгтэй. Энэ намын энэ үзэл санааг дэмждэг хүмүүс мэдээж тусаа оруулах ёстой. Тийм учраас дэмжигчдийг үзэл санааных нь хувьд жаахан ч гэсэн дэмжээсэй гэсэн үүднээс угаасаа олон түмэнтэй ажиллаж ирсэн утгаараа хариуцна. Санхүүжилтийн асуудал нийт намын гишүүдийн хэрэг.

Гишүүн болгон татвараа төлөх ёстой, дэмжигчид нь чадах чинээгээрээ хандиваа өгнө. Төр нь улс төрийн намуудын сонирхолын гажигтай бүлгүүдийг нэгтгэхгүйн тулд санхүүжилт өгдөг байх л даа. Энэ бүгдийг нөгөө гурван толгой чинь гурвуулаа хариуцна шүү дээ.

**- Бусад намууд хэдэн арван саяар нь сонгуульд өрсөлдөхийн тулд хандив өргөж байгааг танайх бол өөрөөр хараад байгаа нь үр дүнтэй гарц болж чадах уу?**

- Би намын дотоод бүтэц рүү нарийн ороогүй байна. Хурал дээр мөнгөтэй хүн ордог зарчим байж болохгүй гэж залуучууд ярьж байна. Үндэсний зөвлөлдөх хороо илүү хариуцлага хүлээснээрээ ахиу төлөх байх. Яг үнэндээ би намын оффис дээрээ ч очиж үзээгүй байна. Миний бодлоор энэ намд мөнгөөр цутгаж гарч ирдэг зүйл байхгүй.

Хамгийн түрүүнд дэмжигч гэсэн статусыг албажуулж өглөө. Квотын асуудлыг дүрмэндээ суулгаж өглөө. Удирдлагын ардчилсан гишүүн төвтэй жилд нэг удаа хуралдаж гишүүдээ сонсдог тогтолцоог анх удаа гаргаж ирлээ. Энэ орчин үеийн намын тогтолцоог гаргахгүй бол хүмүүс намд дургүй байна. Гурван даргатай нам хүмүүсийн тархинд буухгүй байна. Хэн нь тамгаа барих вэ гээд л бодоод байна.

Монгол улсад хуучирсан улс төрийн намын сэтгэлгээ өөрчлөгдөөгүй байна. Энийг өөрчлөхөд эхлэлийг нь ИЗНН гэж жмжиг нам тавьлаа. Гэхдээ би ингэж хэлснээрээ нөгөө намууд өөрчлөгдөхгүй байна гэж хэлээгүй. Тэдгээр намууд өөрчлөгдөхийг маш их эрэлхийлж байна. Даанч сонгууль болох гэж байна гээд тэр бүр хөөцөлдөж барьж авахгүй байна. Улс төрийн цэн түрж урин хавар ирж байна. Монголын ард түмний санал бодол, мэдрэмж үүнийг хэлж байна.

Цагийн аясыг мэдэрдэг, хүний төлөө хулхиддаггүй жинхэнэ улс төрчид гарч ирэхгүй бол хойч үед хэцүү. Энэ Монгол чинь муухай Монгол болсон байна. Халтар царайтай деффектэй ардчилалтай байна гээд олон улсын ардчиллын байгууллага дүгнэчихсэн байна. Улс нь болохоор хүмүүсээ ажил хийлгэхийн оронд мөнгө өгдөг.

Эсвэл бүгдэд нь хувьцаа эзэмшүүлнэ гээд дэлхий дээр байхгүй юм яриад байна. Тэгвэл баялаг дуусахад хувьцаа эзэмшигчид яах юм гэж яагаад ярихгүй байгаа юм. Байгаль, хүн амын өвчлөл үүнийг дохиолоод байна. МАН бол Монгол хүний хөгжлийн хөтөлбөр гээд том том самбарын өмнүүр алхаж гараад гоё харагдаж байна. Энийг яаж шийдэх вэ гэсэн механизм чухал байна.

**- Намууд сонгуульд бэлтгэн бужигнаж байхад ард түмний амьдрал амлалт нэхэж үнийн хөөрөгдөлт, утаатай тэмцэж бухимдалтай байна?**

- Ард түмэн бухимдалтай байна. Тайтгарах ганцхан эм л байна. Энэ бол шударга ёс. Хаана ч гарсан оочертой нийгэм болсон байна. Би одоо оочер гэдэг телевизийн нэвтрүүлэг хийе гэж бодож байгаа. Хүмүүсийн бүтээлч цагийг үрж бухимдлыг

нэмэгдүүлж байна. Яахав гэрт өлсгөлөн байж болно. Энэ түр зуурын бэрхшээлийг бид давах ёстой.

Давна, давах арга механизмыг ч бид гаргаж ирнэ. Шударга ёс бол парламент дээр гоё хэлдэг үг биш. Эдийн засгийн асуудлыг эдийн засгийн аргаар нь шийдвэрлэсний дараа төр бүх юманд оролцохоо боль. Төр хүний амьдралын сексээс бусдад нь оролцох гээд байна. Хүмүүсдээ боломжийг нь олго. Түүнээс төр бүхнийг хийнэ гэж орилохоо боль.

- Давосын дэлхийн эдийн засгийн чуулган дээр Монгол хөгжлийн гараан дээр ирлээ, ойрын жилүүдэд эдийн засгийн өсөлт нь эрчимтэй өснө гэж иш татсан байна. Гэтэл дотооддоо үл итгэлцэл улс төрийн хараат байдалд баян хоосны ялгаатай сульдаж байдаг?

- Манайхыг хошгируулж байна. Бид хошгирч болохгүй. Юун дээр бид хошгирууд байна гэхээр 20 хувийн өсөлт. ДНБ 10,000, дараа нь 60,000 болно гэж яриад онгирууд байна. Өнөөдөр дэлхий өөрсдийнхөө амьдралыг ДНБ-ийг нэг хүнд оногдохоор хэмжихээ больж байна. Өнөөдөр МАН-ын хурал дээр эдийн засгийн өсөлтийн чанар гэж ярьж байна.

Давост очсон очоогүй тогтвортой хөгжил, тэнцвэртэй өсөлт, ногоон эдийн засаг ярьдаг. Манайх Үндсэн хуулиа өөрчлөх дуртай. Үнэхээр өөрчлөх юм бол Монгол улсын хөгжлийн тэргүүлэх чиглэл бол ногоон хөгжил байгаль орчин мөн гэсэн нэг л өгүүлбэр хийчих хэрэгтэй. Дэлхий юу гэж хэлэх нь хамаа байхгүй. Дэлхий өөрөө бас буруу боддог байхгүй юу. Дэлхий дандаа зөв байх албагүй.

Би Давост очсон. Монголыг магтаж байгаа ганцхан юм байгаа. Авилгалын эсрэг тэмцэх гэж байгаа нь сайн байна гэж сайшаасан. 2004 онд Давосоос батлагдсан авилгалын эсрэг түншлэлийн санаачилгад Монгол улсын 175 компани нэгдсэнийг профессор К.Шваб илтгэлдээ дурьдсан. Энийгээ одоо нэгэнт магтуулчихсан юм чинь, магтсан хүүхэн хуримандаа унгаж болохгүй.

Бидний царайг халтартуулж байгаа авилга, хүнд суртлаас бий болдог. Хүнд суртлыг яаж арилгах вэ гэхээр тухайн үедээ Ц.Элбэгдорж бульдозероор түрж арилгадаг гэж байсан. Миний ард байгаа шүүртэй зураг байгаа биз. Үүн шиг шүүрдэж арилгана. Үүний гол арга нь бизнесийн орчны шинэтгэл гэж нэг юм байдаг. Үүнийгээ бид дутуу хийсэн. Одоо Монгол улс нүүрээ дутуу угаасан хүүхэд шиг л харагдаж байна.

**- Сонгуулийн хуулийн талаар намын даргын хувиар юу хэлэх вэ?**

- Би мэдэхгүй. Уншаа ч үгүй. Гэхдээ хүмүүс надад ярьж өгсөн. Би телевизээр нэг юмыг их сонсч байна. Ёстой сайхан хууль боллоо. Электрон машинаар тоолно. Урьд нь гараар тоолоход новшроод байдаг байсан гэж сонгуулийн хууль баталсан хүмүүс нь магтаад байгаа. Батлаагүй нь болохоор хоёр нам бие биендээ зориулаад хийчихлээ.

Жижиг намуудыг шахлаа. Босго өндөр байна гэж ярьж байгаа. Энэ бол бас л Монголын царайг халтартуулж байгаа нэг зүйл. Шударга сонгуулийг хэн явуулж чадах аа. Ард түмний хяналт л чадна. Ард түмний хяналтын механизмыг төрийн албан хаагчид орлох нь зөв үү. Урин цагийн аяс ирээд байхад үүнийх нь эсрэг юм хийж болохгүй байх л гэж бодож байна. Монголын улс төрийн намууд ухаантай байгаасай. Үүнийг сонгуулийн хуулийн тэддүгээр заалт гэж би мэдэхгүй. Бүгдийг нь унших гэж аягүй хэцүү гэсэн. Бүгдийг нь өнгөтөөр яриулчихна. С.Оюун, Энхбат хоёрын авчирч байгаад.

*Эх сурвалж: “Монголын нэг өдөр”, 2012 он*

## **ХЭТ ИХ ЗОХИЦУУЛАЛТТАЙ БАЙДАЛ БИДНИЙГ АЛЖ БАЙНА**

*Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга  
С.Дэмбэрэлтэй эдийн засгийн зарим асуудлаар ярилцлаа.*

**-Эдийн засагчид энэ жилийн төсвийг “үрэлгэн” гэж шүүмжилдэг. Үүнтэй Та санал нийлэх үү?**

-Сүүлийн жилүүдэд улсын төсөв их тэлэлттэй байгаа. Ийм байхад буруудах зүйл үгүй. Хамгийн гол нь төсвийн тэлэлтийг юунд зарцуулах вэ гэдэг нь л чухал. Өөрөөр хэлбэл, бид төсвийн хөрөнгө оруулалт бүтээлч салбарт очиж байна уу үгүй юу гэдэгт анхаарлаа хандуулах ёстой юм. Халамж уруу хэт чиглэх эсвэл хэрэглээг дэмжсэн, урсгал зардлыг нэмэгдүүлсэн зүйлд чиглэвэл сайн зүйлд хүргэхгүй. Харин өнөө жилийн төсөвт үр өгөөжтэй зүйл олон багтсан гэж бодож байна. Тухайлбал, төсвийн ихэнх нь хөрөнгө оруулалтад зориулагдсан. Төрөөс анх удаа өрхийн бизнесийг дэмжихээр тодорхой хэмжээний мөнгө гаргалаа. Уг нь улс, нийгэмд үр өгөөжөө өгөх энэ мэт хэрэгтэй ажилд ахиухан мөнгө гаргаж, бодлогоор дэмжих ёстой юм. Гэтэл 30-60 тэрбум

төгрөг гаргасан байна. Ер нь өгөөжөө шууд өгөх бизнесийн үйл ажиллагаанд төсвийн зардлаа илүү чиглүүлэх нь үр дүнтэй.

**- Монголбанкыг мөнгөний бодлогоо барьж чадахгүй байна гэж шүүмжилдэг. Таны бодлоор Монголбанк ямар бодлого барих ёстой юм бол?**

- Төв банк төгрөгийн гадаад валюттай харилцах ханшийг савалгаагүй тогтмол удирдаж явах ёстой. Хуульд ч төгрөгийн ханшийг савлагаагүйгээр тогтвортой барих ёстой гэж заасан. Гэтэл тэд ингэж ажиллаж чадаагүйгээс эдийн засгийн тогтворгүй байдал сая үүслээ шүү дээ. Үүнээс болж эдийн засагт томоохон шок ч бий болсон. Ядуу хэрэглэгчдэд энэ нь илүү хүндээр тусч, үнийн гинжин хэлхээ үүсгэсэн. Хамгийн гол нь гинжин хэлхээгээр нэмэгдсэн бүтээгдэхүүний үнэ эргээд хэзээ ч буудаггүй. Уг нь энэ чиглэлээр ажиллах ёстой газар нь төвбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны гишүүдээс бүрддэг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл. Гэтэл тэд ажиллаж чадаагүй. Иймээс бид Засгийн газрын хэрэгжүүлэгч аль нэг агентлагын дарга эсвэл сайд, төв банкыг дангаар нь чичлээд нэмэргүй. Энэ гурван байгууллага хоорондоо ямар уялдаа холбоотой ажилладаг, бодлогоо хэрхэн зохицуулдаг вэ гэдгийг хянах, ажиглах ёстой юм. Бид өдөр болгон валютын харилцаанд ордог. Манай улсын гадаад худалдааны ихэнх нь ам.доллараар хэрэгжиж байгаа. Ийм болохоор ч бидэнд ам.долларын эрэлт хэрэгцээ их шаардлагатай. Гэтэл энэ эрэлт хэрэгцээгээ тодорхойлж чадахгүй байна шүү дээ. Иймээс валютынхаа зах зээлийг өргөжүүлэх буюу валютын зах зээлийн өөр хэлбэрийг бид бодох цаг болсон.

**- Тухайлбал, Төвбанк валютын ямар зохицуулалт хийх ёстой гэж?**

- Валютын ханшны дэглэм чөлөөтэй хөвөх биш зохицуулалттай хөвөх ханш байх ёстой. Өөрөөр хэлбэл, төв банкинд зөвхөн валютын интервенц хийх биш өөр аргаар шаардлагатай үед эрэлт нийлүүлэлтэд нөлөөлөх боломжийг олгох хууль эрх зүйн өөрчлөлтийг бий болгох ёстой. Хэн нэг даргыг муулах биш харин бодлогынхоо өөрчлөлтийг хий л гэж байна. Төв банк бид интервенц хийгээд зохицууллаа гэх юм. ЭНэ бол зохицуулалт биш. Интервенцээс өөр валютын ханшны зах зээлд нөлөөлөх олон арга хэрэгсэл бий. Үүний нэг нь бодит салбартай ажиллах замаар валютын ханшинд нөлөөлж чадах арга. Төв банк ингэж ажиллаж болно. Засгийн газрын бусад салбартай хамтарч ажиллана гэсэн үг. Өнөөдөр төв банк валютын нөөц, инфляци хариуцдаг гэж ярьж байна. Тэр байтугай тэд мах, гурилын үнэ судалдаг болж.

Төв банкны ажил энэ гэж үү. Эдийн засгийн үйл явцийг удирдахад ийм сул байдал буюу зөвхөн мөнгө талаас нь харсан байгууллага хэзээ ч хол явахгүй. Эдийн засагт оролцох Төвбанкны оролцоог нэмэгдүүлэхийн тулд дээр дурсан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл анхаарах хэрэгтэй юм. Үүний тулд тус зөвлөл Засгийн газартай илүү ойр хамтран ажиллах шаардлагатай. УИХ ч энэ чиглэлд илүү их анхаарч төвбанкны оролцоог нэмэгдүүлэх зүйтэй юм.

**- Өргөн хэрэглээний барааны үнэ сүүлийн үед эрс нэмэгдсэн. Үнийн өсөлтийг зохицуулах гэж хаа хаанаа олон зүйл хийж байгаа ч голыг нь олж ажиллаж чадахгүй байгаа нь анзаарагдах юм?**

- Өдөр тутамдаа бид 12 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг хамгийн ихээр хэрэглэдэг. Энэ бүтээгдэхүүний үнийн өсөлтөд нөлөөлдөг хоёрхон л гол зүйл бий. Нэг нь эрэлт нийлүүлэлт, нөгөө нь төр. Хэрвээ төр чухам юунаас болж махны үнэ өсөв гэдэг гол шалтгааныг нь олж гаргаж чадвал үнийг тогтворжуулж чадна. Төр шатахууны үнэ нөлөөлсөн үү эсвэл валют уу. Махны нийлүүлэлт дутагдсан уу, энэ чиглэлийн бизнесийг хөгжүүлэх санхүүгийн болон бусад нөхцөлийг хангалттай өгөх боломж юу байна гэх зэрэг асуултыг өөртөө үргэлж тавих ёстой. Түүнээс махны үнийн өсөлтөд малчид буруутай биш. Ченжүүд ч буруугүй. Аливаа бараа бүтээгдэхүүнд нийлүүлэлтийн гинжин хэлхээ гэж нэг зүйл байдаг. Өнөөдрийн хувьд нийлүүлэлт дутсан гэсэн үг. Цаашлаад малжуулалт нь буруу яваад байна. Малчдын ихэнх нь ядуу. Тэдэнд таарсан санхүүгийн үйлчилгээ ч алга. Хэдий сар бүр 21 мянган төгрөг өгдөг ч ядуу хэвээрээ л байна. Иймээс махны нийлүүлэлтээ л нэмэгдүүлэх шаардлагатай. Малжуулах хөтөлбөрөө ч өөрчлөх ёстой. Түүнээс ченжүүдийг нүд үзүүрлэх хэрэггүй. Харин ч тэднийг урамшуулах хэрэгтэй байна.

**- Ер нь манайд зах зээлийн зохицуулалт байдаггүй нь энэ мэт зүйлээс үргэлж ажиглагддаг. Тухайлбал дотоодынхоо хэрэгцээг бүрэн хангаж чадахаар улаан буудай хураасан байхад талхны үнэ нь 50-100 төгрөгөөр нэмэгдлээ. Мөн махны үнэ өдөр ирэх тусам өсөөд байх юм?**

- Харин ч хэт их зохицуулалттай байдал биднийг алж байна. Манайх бизнес эрхлэлтийн орчин, эдийн засгийн эрх чөлөө, хөрөнгө оруулалт, өрсөлдөх чадвар, авлигалын төсөөллийн тухай индексээр дэлхийд нэлээн доогуур ордог. Дэлхийн банкны бизнес эрхлэлтийн индексээр Монгол Улс доогуур явдаг нь төрийн зүгээс эдийн засагт оролцох оролцоо буруу байдагтай холбоотой. Нөгөө

талаар иргэдийн тархинд бүх зүйлийг төр зохицуулна гэсэн нэг онгироо бодол орж ирдэг болсон. Үүнээс болж ажил хийхгүй, бэлэнчлэх сэтгэлгээтэй нэгэн болж хувирч байна.

**- Ам.доллар өсөхтэй зэрэгцэн барааны үнэ өссөн. Түүнийг одоо ч зохицуулж чадаагүй л байна шүү дээ. Энэ нь нөгөө эдийн засгийн шоконд орчихоод гарч чадахгүй байна гэсэн ойлголт мөн үү?**

- Манайх ямар нэгэн эдийн засгийн шок ирэхэд үүнийгээ хамгаалах, тогтвортой болгох чадавхи сул байна. Эдийн засгийн тодорхой хэмжээний хүнд хэцүү асуудал тулгарахад хоорондоо ярьж шийдвэрлэх механизм нь муу. Тиймээс бухимдмаар зүйл сая олон боллоо шүү дээ. Цаашид энэ чиглэлээр анхаарах ёстой.

**- Манайд эдийн засгийн прогноз хийдэг байгууллага байна уу. Гаднын орнуудад их байдаг. Харин манайд ховор. Ганцхан байгаа нь ШӨХТГ. Энэ байгууллага зах зээлийн эдийн засгийг зохицуулдаг, хяналт тавьдаг газар мөн үү. Эдийн засагч хүний хувьд энэ талаар Та ямар бодолтой байна вэ?**

- Хамгийн гол нь үнэ яагаад өсдөг вэ гэдгийг харах хэрэгтэй. Гол өсөлт нь нийлүүлэлттэй холбоотой. Нийлүүлэлт доголдсоноос ийм байдал үүсдэг. Тиймээс өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үед гардаг бэрхшээлүүдийг хамгийн түрүүнд авч хаях хэрэгтэй. Тухайлбал, импортын цагаан будаа хэчнээн шат дамжлага дамжиж байж орж ирдэг билээ. Үүнээс болж үнэд өөрчлөлт ордог. Үнэнийг хэлэхэд бид тээвэрлэлтийн олон шат дамжлагыг нь орхигдуулаад зөвхөн үнэ өсчихлөө л гэж яриад байх юм.

**- Сүүлийн үед УИХ-ын зарим гишүүн эдийн засгийг солонгоруулах гэж яриад байх юм. Манайд эдийн засгаа солонгоруулах боломж бий юу?**

- Нэг талаар энэ нь олон мөчиртөй мод шиг бай гэсэн үг. Тиймээс зөвхөн уул уурхай биш аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх шаардлагатай байна. Эндээс мөнгө босгох боломж бололцоо дэндүү их. Уул уурхай тэртээ тэргүй өөрийнхөө голдрилоор явчихсан. Иймд аялал жуулчлалын салбартаа илүү анхаарч байгаль орчныг дээд зэргээр хөхиүлэн дэмждэг ногоон бизнесийг хөгжүүлэх хэрэгтэй байна.

*Монголын Үнэн Сонин  
Д.Мягмарсүрэн*

## СЭТГЭЛГЭЭ, ХӨГЖЛИЙН ЗАГВАРАА ӨӨРЧЛӨХ АСУУДЛЫГ УЛС ТӨРИЙН НАМУУД ЭХЛЭХ ЁСТОЙ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дарга С.Дэмбэрэлтэй ярилцлаа.

**-Та өчигдөр твиттэртээ Хятадын арилжааны банкууд зээлээ хааж эхэлж байгаа талаар бичсэн байна билээ. Мөн энэ нь манай улсад алсдаа сөрөг үр дагавар авчирч мэдэхийг хэлээд байсан?**

-Ш.Үнэнтөгс гэдэг залуу банкууд зээлээ хааж байгааг бичсэн. Би яг тэгж бичээгүй л дээ.

**-Тэгвэл та тэр асуудалд нэлээд анхаарлаа хандуулж байсан шүү дээ?**

-Ер нь бол ирэх жилийн Монголын эдийн засгийн байдлын талаар ярьсан л даа. Мөнгөний бодлого хатуурсан байгаа энэ нөхцөлд бодит сектор буюу бизнесийнхэн цаашаа яаж явах юм бэ, төсөв гэхэд л сонгуулийн жилд зориулагдаж тэлэлтэйгээр батлагдлаа. Гэхдээ тэлэлт гэдэг бол зөвхөн хэрэглээг тэлэх тухай юм гэж бодож болохгүй. Үйлдвэрлэлийг тэлэх асуудлыг яримаар байгаа юм. Өөрөөр хэлбэл бизнесийн идэвхжлийг хангах тодорхой санхүүжилт орж ирж байна уу гэдгийг ярьсан. Өнөөдөр төсөв, мөнгөний бодлого хоёр уялдаж чадаж байна уу. Чадахгүй байна. Одоо инфляцийн талаар нэлээд ярих боллоо. Инфляцийн өсөлтөд мөнгө их байгаа нь нөлөөлж байна уу эсвэл үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ тэр дундаа ард түмэнд хэрэгтэй 10 төрлийн хүнсний зүйлийн замын зургийг нь хийгээд үзэхэд нийлүүлэлтийн А цэгээс Я цэг хүртэлх энэ замд ямар садаа учирч байна гэдгийг гаргасан.

**-Энэ нь юу гэсэн үг билээ?**

-Энэ нь инфляцид илүү нөлөөлж байна гэсэн дүгнэлтийг манай танхим гаргаад байна. Бизнесийн замын зураг гэсэн судалгаа хийлээ. Энэ судалгаа байхад хүн жишээ нь цагаан будаа, элсэн чихэр импортоор оруулж ирэхээс авхуулаад, хил, мэргэжлийн хяналт, лабораторийн дээжийн түвшин гээд дамжлагуудыг дамжсаар эцсийн хэрэглээнд очиход үнэ дээр нь зардал хэр нөлөөлж байна, хүнд суртал яаж нөлөөлж байна гээд энэ бүхнийг

гаргана. Ингэснээр Монголын инфляци нийлүүлэлтийн талын хүчин зүйлүүдээс ихээхэн хамаарч байна. Тэр дундаа хүнд суртлын инфляциас нэлээд хамаарч байна гэдгийг гаргах юм. Түүнээс биш учир зүггүй цалин нэмэхэд инфляци тэнгэрт цойлчихно гэж бодохгүй байгаа.

**-Цалин нэмэх тал дээр та ингэхэд ямар байр суурьтай байна?**

-Багш нарын цалинг нэмэх хэрэгтэй. Тэтгэврийн хөгшдөд мөнгийг нь өгөх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мөнгө өгөх хэрэгтэй гэж бодож байна. Харин халамжийн хавтгайруулсан байдлыг зогсоох шаардлагатай гэж бодож байна. Өөрөөр хэлбэл нийтэд нь 21 мянган төгрөг тарааж өгснөөр болохгүй нь ээ гэдгийг манайхан хэлээд байгаа. Дээр нь бас нийтэд нь хувьцаа эзэмшүүлнэ гэдэг компанийн засаглал талаасаа буруу. Бүр загвар талаасаа ч зүйтэй биш. Хүнд нөлөөлж байгаа сэтгэлзүйн эффект талаасаа залхуурал, бэлэнчлэх сэтгэлгээнд сургаад байна шүү дээ. Хүн хөдөлмөрлөж байж л хөрөнгө оруулалт хийдэг. Түүнээс биш газрын доорхи баялаг бол ард түмний өмч. Тийм учраас бүгдэд нь хувьцаа эзэмшүүлье гэж байгаа нь үнэндээ явуургүй. Тэгш боломж гэдгийг шударга ёсны хамгийн гол шалгуур гэж би үзэж байна. Тэгш боломж бол бүгдэд нь тэгш хуваарилах хэрэгтэй гэсэн үг биш. Нийгэм гэдэг маш олон сонирхолтой, чадвартай, хүсэл эрмэлзэлтэй нийгмийн амьтдын бөөгнөрөл. Жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрөө хөгжих сонирхолтой байна. Багш, эмч, бичил бизнес эрхлэгчид өөрийн сонирхолтой. Энэ бүхэнд нь таарсан боломжийг нь олгооч л гэж хэлмээр байна. Түүнээс биш бүгдэд нь өгмөөргүй байна. Бүх хүнд 21 мянган төгрөг өгөх нь шударга ёс биш. Энэ бол социализмын шударга ёс. Хувьцаа өгч байгаа нь ч ялгаагүй. Харин хувьцаа эзэмших эсэх нь сайн дурын асуудал байж яагаад болохгүй гэж. Жишээ нь бичил бизнес эрхлэгчдэд юу хэрэгтэй вэ. Мөнгө хэрэгтэй. Гэхдээ зээлийн хүү нь бага, эргүүлж төлөх хугацаа нь урт тийм бизнесийн орчин хэрэгтэй байгаа. Бичил, томгүй бүгдэд нь бизнэсээ чөлөөтэй эрхлэх эдийн засгийн эрх чөлөөг нь олгох ёстой. Ийм мэтээр л эдийн засгийн ойлголтын зөрүү байна. Танхим гэхэд л зах зээлийн эдийн засгийн хэлээр ярьж байхад төр халамжит төрийн буюу эцгийн байдлаар хандаад байна.

**- Ингэж харж байгаа нь асуудал гэж үү?**

- Чамайг болон намайг зүгээр л биологийн амьтан гэж үзээд байна шүү дээ. Гэтэл бид хоёр хоёулаа нийгмийн амьтан байхгүй юу. Өөр өөрийн хүсэл эрмэлзэлтэй. Өөр өөрийг хөгжүүлэх,

амьдралаа авч явах, өөрийн бодолтой хүмүүс. Ийм хүмүүст зориулж бодол хүслээ амжилттай биелүүлэхэд нь туслан эрхзүй, санхүүгийн хувьд бүрдүүлж өгмөөр байна. Үүнийг л би тэгш боломж гэж хэлнэ. Нөгөө талаас ерөөсөө Монгол Улсын хөгжих гээд байгаа зам зөв үү. Өөрөөр хэлбэл бүх төрлийн нөөц буюу газрын доорхи болон дээрх баялгаа дээд хэмжээгээр, маш эрчимтэйгээр, эргэж нөхөгдөх хугацааг нь үл харгалзан ийм хүрэн эдийн засгийн байдлаар яваад байна. Өнөөх орлогоо ногоон эдийн засаг руугаа хийе гэсэн концепци явах юм уу. Эсвэл уул уурхайгаа зохистой ашиглаж хажуугаар нь бусад салбараа анхаарах уу. Мал аж ахуй, жижиг дунд бизнесээ анхааръя. Мэдээж ингэж анхаарахад мөнгө хэрэгтэй. Ингэхдээ нэгийг хохироож мөнгө олно гэсэн үг биш. Нөгөө талдаа урам өгөх ёстой. Механизмыг нь уул уурхайн бус секторуудад боломж болгон гаргах хэрэгтэй. Ингэж байж л нийт эдийн засаг маань тогтвортой, хүмүүст мэдрэгдэхээр болно. Хэрвээ ийм бодлого явахгүй бол өнөөдөр Монголын эдийн засгийг ямар ч үнээр хамаагүй өндөр өсөлтөд хүргэх, нэг хүн оногдох ДНБ-ээрээ бахархах, хүн амын 50 хувь нь ДНБ-ий өсөлтийг мэдрэхгүй явах замдаа орно. Харамсалтай биз дээ.

**- Тэгвэл яах ёстой вэ?**

- Хүн эдийн засгийн 17, 20 хувийн өсөлтийг мэдрэхийн тулд үүнд оролцох ёстой. Тиймээс л түрүүний миний хэлдэг тэгш боломж, оролцоог нь хангах хэрэгтэй байгаа юм. Бичил бизнес эрхлэгч бизнесээ жижиг дунд бизнес болгох бодолтойгоор цааш явах хэрэгтэй байна. Улмаар жижиг дунд бизнесээ том болгох боломж хэрэгтэй. Ингээд бизнесийн талбарт ажиллаж байгаа нь бүтээмжээ дээшлүүлэхэд анхаарч, юм хүлээхээ больж эхэлнэ. Зүгээр л нийгмийн ядуу хэсэг нь зүгээр суугаад зуух авдаггүй, мөнгө авдаггүй, архи уудаггүй байх, өөрийнхөөрөө хөдлөх эрмэлзлийг нь төрийн бодлогоор суулгаж өгөх ёстой. “Та хэрвээ 21 мянган төгрөг авах гэж байгаа бол хашаандаа мод тарь” гэж болно биз дээ.

**- Ойрын хоёр жилийн эдийн засгийн өсөлтөд баясаж, дэвээд яваа нь улс төрийн халамж буюу эдийн засгаа халааж, ёстой өнөөх хөөс гэдэг нь болоод байгаа гэдэг биз дээ. Ийм үед юу хийх ёстой юм бол?**

- Гэхдээ үүний цаана бид ямар төртэй байна вэ гэдгээ харах ёстой. Бид халамжит эцгийн төртэй яваад байна. Чиний эсвэл миний өмнөөс чи бид хоёрын сайхан амьдрах эрхийг төр гаргаад байна шүү дээ. Энэ зөв юм уу. Гэтэл чи сэтгүүлчээ хийгээд, энэ камераараа улам сайн зураг аваад явах, түүнийгээ өөрийн карьер

болгох бүрэн боломж байна. Тиймээс л дээр хэлснээр чиний энэ сурах, тэмүүлэх эрмэлзлийг чинь дэмжих орчинг шаардаад байгаа хэрэг. Олон залуу бий. Тэр залуу зураг дарахыг хүсээд дуртай газраа очоод фото камер авахад л лизинг гэдэг орчин бүрдсэн байх ёстой. Ингээд чи дуртай ажлаараа бизнес хийгээд явдаг орчин хэрэгтэй биз. Эсвэл чи энэ ажлаа бизнес болгож өргөжүүлээд компани байгуулж банк, санхүүгийн байгууллагад очиход чамайг инээмсэглэж угтдаг тийм орчин чухал биш гэж үү. Тиймээс та Тавантолгойн хувьцаагаа хүлээж бай гэдэг орчин хэрэгтэй байна. Бидний сонголтын асуудал болчихлоо. Ийм орчныг бидэнд бий болгож өгөх ёстой.

**- Ирэх жилийн сонгуулийн дараа иргэдэд хандсан их амлалтууд алга болно гэж байгаа. Ингэхээр таны хэлээд байгаа шиг тийм бүтээлч орчинг бий болгох боломж бүрдэж эхлэх болов уу. Та хэр хүлээлттэй байна?**

- Энэ сонгуулийн хувьд би хэлж мэдэхгүй байна. Зүгээр л бид сайн төрийг л хүсдэг. Харин ямар төрийг хүсдэггүй вэ гэхээр хүнд сурталтай, гол нь миний зөвшөөрөлгүйгээр дансанд минь мөнгө хийдэг төрийг хүсдэггүй. Зүгээр сууж байхад мөнгө өгөөд байгаа нь амар юм шиг мөртлөө миний өөрийн хөгжих боломжийг, эрмэлзлийг сэтгэлзүйн хувьд унагааж байна. Үүнд дургүйцдэг хүмүүс иргэдийн 50 хувийг эзэлж байгаа. Тэгвэл үлдсэн 50 хувь буюу мөнгийг дуртайяа аваад байгаа хүмүүсийг бид ойлгоно. Гэхдээ тэр хүмүүст хүртэл үр хүүхэдтэй учраас мөнгийг тэгж тэжээлгэх сэтгэлгээгээр авч, түүндээ дасаж амьдрах ёсгүй гэсэн бодол төрнө. Улстөрчид одоо бэлэн болон бэлэн бус амлалтаас татгалзчихлаа. Тодорхой хэлбэл, цалингуурав дахин өсгөнө гэж хэлэхгүй. Энэ зөв. Цалин бол бүтээмжтэйгээ уялдах ёстой гэдгийг бид мэднэ. Төр харин ажил олгогчийнхоо хувьд төрийнхөө менежментийг хийгээд явах хэрэгтэй. Үр дүн, гүйцэтгэл чанараар нь ажлыг үнэлдэг, хүнд сурталгүйгээр нь хэмждэг цалингийн системийг төсөв захиран зарцуулагчид нь өгөх ёстой. Түүнээс биш Засгийн газар нь 3-3.5 дахин гэх мэтээр ярьдагаа болих хэрэгтэй. Ийм социализмын сэтгэхүйн үлдэгдлээсээ салах болсон. Сэтгэлгээ, хөгжлийн загвараа өөрчлөх асуудлыг улс төрийн намууд эхлэх ёстой гэж би боддог. Монгол Улсад бодит байдал дээр нам нь төрийнхээ дээр гарчихсан явж байна шүү дээ. Тиймээс орон нутгийн түвшинд л гэхэд намаа болье гэх байр сууриуд гарч байна. Хүмүүс ойлгоод “Энэ нам гэдэг чинь дэмий юм” гэх боллоо. Ерөөсөө орон нутгийн түвшний сонгууль байлаа гэхэд намаас нэр дэвшүүлэхээ болье гэж байна. Энэ бол хамгийн

зөв. Хотынхоо даргыг иргэд өөрсдөө сонгодог больё гэж байна. Иймэрхүү олон асуудлыг өөрчлөх шаардлага гарч байна л даа. Мэдээж дараагийн сонгуулиас эхэлнэ. Яг 2012 оны сонгуулиас иймэрхүү суурь өөрчлөлтийг, сэтгэлгээний бодлогын шинэчлэлийг намууд нь мөрийн хөтөлбөртөө тусгаад, сонгогчид нь энэ чиглэлээр мөнгөний биш үзэл бодлын сонголтыг хийж чадвал болно. Дараа дараагийн жилдээ бүр ч зүгширнэ. Харин үүнийг хэвшүүлж эхлэхгүй бол 2016 оны сонгууль болоход асуудал бүр хурцдана.

**-Ярилцсанд баярлалаа.**

*Т.Есөн-Эрдэнэ  
2011 оны 11 сарын 2*

---

## ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭЧЛЭЛ БА ХӨГЖИЛ: ЮУГ ЯАЖ ХИЙХ ВЭ?

---

### 1. ЯАГААД?

Монгол улсад эдийн засгийн шинэтгэл явагдаж байна уу? 90-ээд оны эхэн үед гэнэн итгэлтэй, дунд үеийн өөдрөг бадрангуй, 2000 оноос хойшхи хөгжилд чиглэсэн гэж нэрлээд байгаа реформын шатууд үр дүнгээ өгсөн үү? Шинэчлэл өөрөө үйл явц болохоор “явагдаж байна” гэсэн товч хариулт өгч болно. Реформын үе шатууд ч өөрийн тавьсан зорилго, хамрах хүрээ, цаг хугацааныхаа орон зайд тодорхой үр дүнгээ өгсөн. Гэтэл яагаад шинэчлэлийн үйл явцаар бий болох ёстой эдийн засгийн тогтвортой өсөлт ард түмэнд бодитойгоор мэдрэгдэхгүй байна? Яагаад 10,6 хувийн өсөлт гарлаа гэж нэг хүн нь бахархаж байхад ихэнх хэсэг нь бахархахгүй, харин ч гайхаж эгдүүцэж байна? Яагаад эдийн засгийн шинэчлэл хийгээд л байсан юм бол авилга газар аваад, ядуурал нэмэгдээд байгаа юм? Яагаад бүгд л макро эдийн засаг, мөнгөний бодлого гэж жил бүр яриад л боловсруулаад л батлаад байгаа мөртлөө үр дүнд нь хүнд суртал улам нэмэгдээд бизнес хийх эдийн засаг, санхүүгийн орчин муудаад байгаа юм? Яагаад хүмүүс татвараас, төрөөс, эх орноосоо дайжиж зугтаад байна? Яагаад бид агуу их Монгол, Чингис хаан гэж гадны жуулчдад бахархан танилцуулаад байгаа мөртлөө яг үнэндээ одоо бахархдаг юм маруухан байна? Яагаад ардчилал, түүний үргэлжлэлүүд нийгмийн биед олигтой шингэхгүй байх, гэмт хэрэг, ядуурал, архидалт, нийгэм сааралтан гундах энэ бүхний уг шалтгаан, учир холбогдол нь хаана, хэнд, юунд байна?

Энэ олон асуултыг бид өөрсдөөсөө асуух уу эсвэл том том цаас боть бүтээлүүд хэтийн хөгжил, төсөл яриад косметик маягийн өнгөн засал хийгээд Чингисийн нэрийг бариад л хоосон бахархаад өөрсдөө ч халтуурдаад явах уу? Асуух, тэр байтугай тодорхой хариултууд өгөх ёстой байхаа.

Хүний амьдралд тодорхой хугацааны дараа гишгэсэн мөрөө эргэн харах, эрэгцүүлж цэгнэх, сургамж авч явдгийн адил реформ сүүлийн 15 жилийн туулсан замаа Монголын нийгэм, монголын



төр эргэн харж ултай суурьтай дүгнэлт, урагшаа харсан бодлогоо нягтлан тодорхойлох шаардлага бий болчихжээ. Нөгөө бидний “элэг зүрхнээс уяатай” гэж дуулах дуртай Монголынхоо хөгжлийг, түүнийг хангах бодитой арга замыг тодорхойлох цаг нэгэнт болжээ. Гэхдээ 2020, 2030 онд тэгж хөгжинө, тийм түвшинд хүрчихсэн байна ч гэдэг юмуу эсвэл Монгол Азийн бар, Азийн санхүүгийн төв болно, Хөдөлмөр, капитал, баялагийн урсгал Монгол руу чиглээд л Монгол хөгжлийн цоо шинэ мундаг загвар болно гэсэн нэг болон далд мөрөөдөл, санаа, агуулгатай одоо байгаа олон мянган хуудас цаас, ботинуудын нийлбэрийг халж байгаа юм биш шүү. Бидэнд дэндүү их үйлдвэрлэгдчихсэн цаас өөрсдөө бас олон улсын төслүүдтэй нийлээд өнгөрсөн жилүүдэд хангалттай үйлдвэрлээд нөөцлөөд авчихсан. Улс оронд Mission нэж нэрлэдэг эрхэм зорилго, vision гэж нэрлээд байдаг алсын хараа хэрэгтэй юу гэвэл үнэхээр хэрэгтэй. Хөгжлийн гол /core values/ нь ч хэрэгтэй, стратеги нь ч хэрэгтэй. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь харин маш тодорхой, бодитой, жижигхэн юмнаас л эхэлдэг. Энэнд цаас хэрэггүй. Малаа хариулж буй малчин хүн, төрд алба хашиж буй хүмүүс, сургууль төгсөж буй эсвэл элсэх гэж буй залуус, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээд явж буй бизнес эрхлэгчид, эсвэл яаж олдог юм билээ гэж санаашран яваа ажилгүйчүүд энэ бүх хүмүүст л яаж шүү сайн амьдрах нөхцлийг нь бүрдүүлэхээс хөгжил эхэлдэг.

Өөрөөр хэлбэл эцсийн дүндээ хөгжлийн тухай асуудал нь хүний сайн сайхан амьдрах чадварыг дээшлүүлэх л асуудал байдаг. Өөр юу ч ярисан эцсийн дүндээ энэ цэг дээр л тулж очдог.

## II. ШИНЭТГЭЛ, ХӨГЖИЛД ЮУ СААД БОЛЖ БАЙНА?

Үүний хариулт маш энгийн бөгөөд тодорхой байна: Төр саад болж байна.

Тэгвэл төр яагаад саад болоод байдаг юм? Оролцох юмандаа оролцдоггүй, оролцохгүй юмандаа оролцоод байхаар л саад болж эхэлдэг. Өөрөөр хэлбэл төрийг засах /засаглах/ арга ухаан буруу, хоцрогдсон гэсэн үг. Албаны үгээр хэлбэл төрийн зохицуулалт буруу хэрэгжиж байна гэсэн үг. Төрийн засаглалын технологи нь хоцрогдчихсон байна гэсэн үг. Монголын өнгөрсөн 15 жилийн

реформын түүхийг аваад үзвэл төрийн зохицуулалт 2 экстрим буюу туйлшрал ажиглагддаг. Эхнийх нь реформ эхэлсэн 90-ээд оны эх, дунд үе буюу “зах зээл, үл үзэгдэх гар л бүхнийг шийднэ” гэсэн номлол, түүнд тулгуурласан үйлдэл, уг үйлдлүүд байсан. Мөнгөжөөгүй эдийн засгийг мөнгөжүүлэх, капиталжаагүй эдийн засгийг капиталжуулах, реформын суурь тоонуудыг өрөх буюу 4Л+Х /үнийн, гадаад худалдааны валютын ханшийг, санхүүгийн либералчлалууд дээр нэмэх нь хувьчлал/ гэж нэрлэж болох реформын хандлагыг хэрэгжүүлэхэд энэ экстримийг хэрэглэхээс өөр аргагүй байсан. Улс төр нь ч цаг үе нь ч, хүмүүс нь ч нийгэм ч үүнийг шаардаж байсан, мэдээж дээр нь одоохүртэл бидний хувьд “хадны мангаа” хэвээр байгаа Олон улсын Валютын сан болон бусад улс орнуудаас ирсэн гадны зөвлөхүүд үүнийг бас зөвлөсөн. Мөнгөжөөгүй, капиталжаагүй эдийн засагт ийм туршилт хийхэд хүнд урвал нь судлаачдийн нүдээр харахад их л сонин харагддаг байсан. Гэхдээ нэг тодорхой зүйл бол эдийн засгийн тодорхой шинэчлэлийн үр дүн нь нийгмийн асар том золиосыг шаарддаг юм байналээ. Нөгөө нэг экстрим нь “зах зээл бас бүхнийг чаддаггүй юм байна, төр ерөөсөө эдийн засагт оролцох, заримдаа бүр их оролцох шаардлагатай юм байна” гэсэн үзэл бодол, давамгайлж ирсэн үе буюу 90-ээд оны дундаас хойш үргэлжилсэн үе. Энэ үеэс төрийн цээж томорч, бяр нь амтагдаж, толгой нь данхайж ирсэн. Том том реформуудыг зах зээлд зориулж хийсэн мөртлөө зохицуулалтууд нь зах зээлд эрх чөлөө өгч байгаа мэт хирнээ цаагуураа л зах зээлийг хүлээд, баглаад эхэлсэн үе, зах зээлийн тоглоомын дөнгөж эхэлж хөгжиж буй “тоглоомын дүрмийг” зөрчин төрийн “тоглоомын дүрмийг” гаргаж ирсэн. Ингэснээр байгуулагдсан Засгийн газар бүрийн хамгийн түрүүнд барьж авдаг зүйл нь Засгийн газрынхаа бүтэц, яамдынхаа тоог тогтоох, түүнийхээ аргуудыг зөвтгөхийг оролдох ингэснээрээ “Засгийн газар л хамгийн ухаантай” “Засгийн газар зах зээлийг зохицуулна, засна” гэсэн өөрсдөө сайн ухамсарлаагүй зөн билэгт тулгуурласан хортой хандлага газар авч эхэлсэн үе. Энэ үеийг улс төрийн талаас нь аваад үзэхэд ямар нэг улс төрийн өнгө “улаантан, цагаантан”, “либерал, консерватив”, “баруун, зүүн” гэх мэт “өнгө” байдаггүй, аль ч төрийн хүчин засгийн эрхэнд гарсан төрийн түүний зохицуулалтыг л шүтэж ирсэн хандлага илт ажиглагддаг.

Улс төрийн 2 гол намын эдийн засгийн номлол нь цаасан дээр өөр байдаг ч үнэн хэрэг дээрээ амьдрал дээр болохоор зах зээлд

итгэхэсээ илүү зохицуулалтыг л дулдуйдсан, түүнийг хэтрүүлсэн, буруу хэрэгжүүлж ирсэн. Ийм л үед бид одоо орчихоод байна. Тийм ч учраас би “засаглалын өнгө нь гол бус технологи нь чухал юм байна” гэж хэлэх дуртай болсон. Манай Засгийн газрын үед төр бага оролцдог байсан эдний засгийн газрын үед их оролцож байна гэх мэтээр улс төрчид маргахыг сонсоод би дээрх үгийг хэлдэг юм. Тэгвэл төр эдийн засаг, зах зээлд ингэж хөндлөнгөөс дэндүү их оролцож байгаагаас ухаарч ухамсарлаж байна уу? Тийм гэхдээ бүрэн бус бас итгэл үнэмшил багатайгаар гэж би хэлнэ. Бид өнгөрсөн түүхэн богино хугацаанд Монгол улсын эдийн засгийн ерөнхий орчин, дэглэмийг нээлттэй зах зээлийн баримжаатай болгож олон улсын байгууллагууд, дэлхийн улс орнуудаас зохих ёсны эерэг үгэлгээ, дүгнэлт авч байгаа нь хэн ч маргашгүй зүйл. Гэхдээ л өнгөрсөн жилүүдэд бид санаатай болон санамсаргүйгээр энэхүү харьцангуй чөлөөтэй байсан эдийн засгийн эрх чөлөөг боогдуулж, хувийн хэвшлийн хөгжлийг чөдөрлөсөн, бизнесийн овсгоо, самбаачлагыг үл дэмжсэн төрийн бүхийл зохицуулалтыг дэндүү ихээр бий болгосон нь бас л маргашгүй үнэн зүйл юм. Бүх зохицуулалтууд “эерэг буюу зөвшөөрөх жагсаалтаас”, “сөрөг буюу хориглох жагсаалт” руу шилжих учиртай байтал их төлөв “зөвшөөрөх жагсаалт” дээр тулгуурласан хууль, тогтоол дүрэм, журам олон зуугаараа үйлдвэрлэгдэж энэ нь төрийн зохицуулалтын гол технологи нь болж хувирсан байна. Төр нэг гараараа 600 тусгай зөвшөөрлийг 100 болгосон нь үнэн адил нөгөө гараараа дээрх цааснуудыг үйлдвэрлэсээр байгаа нь бас л үнэн.

Ингэхлээр Монгол улсад өнөөдөр оршин байгаа эдийн засгийн дэглэмийг төрийн хэт их зохицуулалтаар гажуудсан зах зээлийн эдийн засаг гэж томъёолон дүгнэж болно.

### **III. ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭТГЭЛИЙН ЦААШДЫН ЧИГЛЭЛҮҮД, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД**

Нэн тэргүүнд хийх ёстой зүйл бол төрийн зохицуулалтын шинэтгэлийг жинхэнэ утгаар нь иж бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энд би шинэтгэл гэдэг үгийг онцлон хэлж байна. Учир нь эдийн засгийн тогтвортой өндөр өсөлтийг хангаж ядуурлыг бууруулах гэж хүсч буй төрд ч хувийн хэвшилд ч эдийн засаг,

бизнесийн орчин, хувийн хэвшлийн экосистемийг гажуудуулж буй хууль, тогтоол, дүрэм журам зэрэг бүх төрлийн зохицуулалтуудын өнгөн засал буюу косметик засвар огт хэрэггүй. Төрийн зохицуулалтын шинэтгэл зөвхөн Монгол улсад шаардлагатай байгаа юм бишээ. Хөгжиж буй орнууд түүний дотор шилжилтийн дараах эдийн засагтай улс орнууд төрийн зохицуулалтын шинэтгэлийг хийж байна. Олон улсын байгууллагууд ч тухайлбал, НҮБ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк бүгд л эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж ядуурлыг бууруулахын тулд хөрөнгө оруулалт, бизнесийн тааламжтай орчин бүрдүүлэх, үүний тулд зохицуулалт шинэтгэл хийхийн чухлыг онцолж байна. Монголын бизнес эрхлэгчдийн 2-р их чуулган дээр Ерөнхийлөгч Н.Энхбаяр энэхүү шинэтгэлийн агуулга, ач холбогдол, арга замын тухай онцлон хэлж байсан. Ерөнхий сайд ч хэд хэдэн ярилцлагадаа хүнд суртлыг үгүй хийх, бизнесийн тааламжтай орчин бүрдүүлэхийн чухлыг онцолсон.

Монгол улсын Их Хуралд ч ийм эрмэлзэл, санаа бодол байгаа гэдэгт итгэж байна. Засгийн газар бульдозер хөтөлбөр яриад байгаа нь угтаа зохицуулалтын шинэтгэлийг л хэлээд байгаа хэрэг. Ингэснээр засаглалын дээд түвшинд үүнийг хийх эрмэлзэл, итгэл үнэмшил байна гэж найдаж болох нь.

Гэтэл зарим яамд, агентлагууд, хот, дүүргийн засаглалын дунд, доод түвшинд ийм итгэл үнэмшил байна уу? Үнэн хэрэгтээ байхгүй байна, сонирхол ч алга байна гэж хэлж болно. Монголын бизнес эрхлэгчдийн 2-р их чуулганы өмнө бидний хийсэн судалгаа /Бизнесийн орчинг сайжруулахтай холбогдон гарсан санал, судалгаа, тайлангуудын эмхтгэл 2005 он/ - цаас харахад төрийн үйлчилгээний байгууллагуудын хүнд суртал, олон талт дамжлага бизнес эрхлэхэд хамгийн их саад болж байна гэж судалгаанд хамрагдахыг хот, хөдөөгийн 1745 бизнес эрхлэгчдийн 85,3 хувь нь үзсэн байна. Энэ мэтчилэн төрийн зохицуулалтын шинэтгэлийг шаардсан олон арван хуудас баримт байна. Өнөө сурталчилгаанд гардаг шиг-өөрөө амьдарцгаая” алсын хараатай амьдарцгаая” л даа. Үүнийг дээрээсээ доош нь доороосоо дээш нь зэрэг эхлэх шаардлагатай байна. Гэхдээ яриад байгаа, хийх гээд байгаа бодлого, үйл ажиллагааны арга барил нь буруу, нэг л итгэл үнэмшил төрүүлэхгүй, хуучин арга барил, хэв маягт баригдсан харагдаад байна. Шинэтгэлийг хэрэгжүүлж буй улс орнуудын туршлагаас харахад дараах санаа авмаар зүйлүүд байна. Үүнд:

- Засгийн газар, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн төлөөлөөс бүрдсэн “зохицуулалтын шинэтгэлийн хороо” тусгайлан байгуулах, үүнд Ерөнхийлөгч, Их Хурал, Засгийн газар онцгой ач холбогдол өгөх шаардлагатай байдаг байна:

- Эдийн засаг, бизнесийг зохицуулж буй бүх төрлийн зохицуулалтуудад үндэсний хэмжээний үзлэг шалгалт, мониторинг шинжилгээ, аттестатчилал гэж манайхан ярьдаг/ хийж халж устгах, хүчингүй болгох, цөөрүүлэх гэх мэтээр бүх зохицуулалтыг хялбаршуулан цэгцэлж, эмх замбараанд нь оруулах:

- Үүний дараа төрийн аливаа зохицуулалтыг боловсруулах, баримтлах технологид зарчмын шинжтэй өөрчлөлт оруулах:

- Төрийн аливаа зохицуулалт нь батлагдахын тулд 3 “шалгалт, сорилтыг” давах, өөрөөр хэлбэл 3 төрлийн асуултанд холбогдох субъектууд уг хорооны өмнө хариулах хэрэгтэй болно. Үүнд:

а/ тухайн зохицуулах гэж байгаа объектод нь зах зээлийн зохицуулалт дангаараа байж болохгүй байна, иймээс төрийн зохицуулалт шаардлагатай гэдгийг бүрэн батлаж нотлох,

б/ зах зээл дангаараа зохицуулж болохгүй гэдгийг үнэнээр баталж нотолж чадвал 2 дахь сорилт буюу асуулт: тэгвэл тухайн объектод /тодорхой зах зээл, үйл ажиллагааны тодорхой салбар гэх мэт/ “бараг зохицуулалт буюу /quazi-regulation/ тодорхой чиглэлийн мэргэжлийн төрийн бус байгууллагуудад ч юмуу компаниудын нэгдэл өөрийн зохицуулалт нь зүр ашигтай хэрэгжүүлээд байх боломжтой эсэх, үгүй бол үүнийг мөн л баталж нотлох,

с/ эцэст нь буюу төрийн зохицуулалт үнэхээр шаардлагатай, тэр нь зах зээлийг гажуудуулахгүй энгийн, хүнд сурталгүй байх, засгийн газрын зохицуулалт бүтэлгүйтэхгүй /government failure vs market failure/ хүрэхгүй үнэхээр үр дүнтэй зохицуулалт болж чадна гэдгийг баталж нотлох,

Энэ мэтчилэнгээр зохицуулалт шинэтгэл хийсэн орнуудад шинэтгэлийн үр дүн, зардлын харьцаа / benefit / cost ratio / нь 25:1 болж байна! Манайхаас хамаагүй илүү баян, хөгжилтэй орон болох Бельгид хүртэл 2600 бизнесийн байгууллагуудын дунд судалгаа явуулж үр дүнг нь парламент нь авч хэлэлцэн бизнесийн бүртгэлийн нүсэр үйл ажиллагаа, лиценз зөвшөөрлийн асуудлаа эрс шинэтгэж хялбаршуулсан байдаг. Гэтэл манай парламент яагаад ингэж болохгүй гэж хот, хөдөөгийн 1745 бизнес эрхлэгчдээс

авсан бодитой судалгаа, тоо баримт, түүнчлэн бичил бизнес эрхлэгчид буюу албан бус хэвшлийнхний дунд явуулсан судалгаа, дээр нь Азийн Хөгжлийн банкнаас хийсэн “Хувийн хэвшлийн үнэлгээний” баримт бичиг, Дэлхийн банкнаас хийж буй хөрөнгө оруулалтын орны судалгаа, Үйлдвэр худалдааны яамнаас жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд явуулсан судалгаа гэх мэтээр хангалттай баримт, цаас байна. Бүгд л манай тойрог гэж санаа зовдог, түүн дээрээ мөнгө хуваарилуулахыг хөөцөлддөг хэрнээ тэр 76 тойрог чинь бүхэлдээ хүнд сурталд идэгдэж бизнесийн хүнд орчинтой байгааг анхаарч болохгүй гэж үү. **Энэ бол үнэхээр Монголын парламентын нухацтай, иж бүрэн авч хэлэлцэж шинэтгэлийг яаралтай эхлүүлэх талбар мөнөөсөө мөн.**

Эвслийн Засгийн газрын зайлшгүй хийх ёстой, хийх “үүлэн чөлөөний нар” нь гарчихсан гэж яриад л байгаа засаг, захиргааны шинэтгэл хийгдээгүй л байна. Ард түмэн учир начир, ач холбогдлыг нь төдийлөн сайн ойлгоогүй байгаа энэхүү шинэтгэлээсээ өмнө(улс төрийн хүсэл зориг байвал үүнтэйгээ зэрэгцүүлж) зохицуулалтын шинэтгэлийг хийвэл хүн ардын дэмжлэгийг гарцаагүй авна. Учир нь ард түмэн энэ хүнд суртлаас нэгэнт залхчихсан, дэндүү их яс махаараа мэдэрчихсэн болохоор хоёр гараа өргөн дэмжинэ. Харин засаг захиргааны шинэчлэлд бэлтгэл хугацаа хэрэгтэй. Тиймээс засаг захиргааны шинэтгэлхий хийн ач холбогдлыг өргөн хэмжээгээр сурталчилахын сацуу орон нутаг, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, орон нутгийн ард иргэд доороосоо, өөрсдөө сайн дурын үндсэн дээр нэгдэн нийлэх бололцоо, эрхмэдэл, дэмжин урамшуулах механизмыг нь нэн тэргүүнд бий болгож өгөх нь зүйтэй бизээ.

**Эдийн засгийн шинэчлэлийг эрчимжүүлэх, өсөлтийг хангаж ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх, ер нь Монгол Улсын хөгжлийн холбоотой аливаа зохицуулалт, бодлого, хөтөлбөрийг боловсруулахаас эхлэн хэрэгжүүлэх бүхий л шатанд хувийн хэвшлийнхний санал бодлыг ул суурьтай сонсож тэдэнтэй зөвлөлдөж, зөвшилцөж байдаг түншлэлийн механизмыг хөгжүүлэх нь шинэтгэлийн бас нэг чиглэл болж байна.**

НҮБ-ын Хувийн Хэвшил ба Хөгжлийн Комиссоос НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Даргад өргөн барьсан илтгэлд энэхүү асуудлыг онцгой чухалчлан хөгжиж буй орнуудын Засгийн газруудад бодитой, үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийг зөвлөмж

болгосон байсан. Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк ч мөн л энэ асуудлыг ярьж бичиж, цаашид энэ чиглэлээр үйл ажиллагаагаа эрчимжүүлэх төлөвтэй байна. Дэлхийн Банкны 2005 оны дэлхийн хөгжлийн илтгэл нь “Хүн бүрд хөрөнгө оруулалтын тааламжтай орчин” гэсэн гарчигтай гарсан нь санамсаргүй зүйл биш бөгөөд 53 орны 30 мянган аж ахуйн нэгжүүд, 11 орны 3 мянган бичил болон албан бус нэгжүүдийн судалгаа 130 орны бизнесийн зардлын судалгаан дээр үндэслэсэн байна. Тэгвэл энэхүү хүн бүрд хөрөнгө оруулалтын илүү тааламжтай орчин бүрдүүлэх нь гагцхүү түншлэлийн механизмаар дамжин амжилттай хэрэгжинэ гэдгийг дээрх илтгэл, судалгаануудад дурдсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бизнесийн чуулган дээр хэлсэн үгийн гол санааны мөн үүнд л байсан. Ерөнхий сайд сар бүрийн сүүлийн 7 хоногт бидэнтэй уулзаж тодорхой асуудлыг ярилцаж шийдэж байя гэж хэлсэн нь мөн л үүнд чиглэсэн байна. Тэгвэл түншлэлийн механизмаар халтуурддаггүй, жинхэнэ бодитойгоор Засаглалын бүх төвшинд хөгжүүлэх шаардлагатай байна. Засгийн газар, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо 2002 онд байгуулагдаж, саяхнаас шинэ бүтцээр ажиллаж эхэлсэн, зарим аймгуудад мөн байгуулагдаж эхэлсэн гэх мэтээр нааштай үүсгэл санаачилга, түншлэлийн механизмын суурь тавигдаж л байна. Гэхдээ л энэ механизмд хандах төрийн ихэнх байгууллагуудын хандлага үнэн хэрэгтээ ёс төдий, хэлбэрдсэн шинжтэй, итгэл үнэмшилгүй байна. Саяхан Зөвлөлдөх хороо хуралдахад Үйлдвэр Худалдааны Сайд С.Батболд /Зөвлөлдөх хорооны засгийн газрыг төлөөлсөн дарга/ ирчихээд төрийн яам, агентлагуудын төлөөлөгчдийг хүлээж бүтэн цаг гаруй суусан, ирээгүй байгууллагын ихэнх нь саяхан Танхимаас гаргасан “Хүнд суртлын зэрэглэлийн индекс”-д дээгүүр байранд “цохиж явах” шинжтэй.

Эцсийн дүндээ энэхүү түншлэлийн механизм нь янз бүрийн хурал, зөвлөлгөөн, хэлэлцүүлэг, семинар эсвэл “нээлттэй вэб хуудас /сүүлийн үеийн моод/, интернэтээр чаатлах, hotline утас ажиллуулах төдий асуудал бус өнөөг хүртэл Монгол Улсад мөрдөж хэрэгжүүлж ирсэн засаглалын технологийг шинэтгэх асуудал юм. Энэ бол засаглалын бүх төвшний удирдагчдийн ажлын үр дүн нь тэдний хариуцсан салбар, хэсгүүдэд бизнесийн орчин хэрхэн сайжирч байна, ядуурал бодитойгоор яаж буурав, түншлэлийн механизм хэрхэн үр дүнтэйгээр хөгжиж байна зэрэг тодорхой үзүүлэлт, шалгуураар хэмжигдэх ёстой гэсэн үг юм.

Бизнесийн байгууллагууд шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ чанар, бүтээмжийг нэмэгдүүлдгийн адилаар хууль тогтоогчид, бодлого боловсруулагч ид засаглалын үйл явцдаа шинэ технологи нэвтрүүлэхийг хөгжлийн эрх ашиг шаардаж байна. Яагаад гэвэл ард түмний, түүний дотор эдийн засгийн өсөлтийн зүтгүүр хүч нь болж байдаг хувийн хэвшлийнхээ дуу хоолойг сонсож тэдэнтэй зөвлөлдөж байсан цагт ямарч шийдвэр бурууддаггүй нь энгийн үнэн. Энэ л үнэнийг дагаж мөрдөцгөөе, шаардлагатай бүх нөхцлийг бүрдүүлцгээе. Хууль болон бусад зохицуулалтыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх технологгоо түүнд нийцүүлж өөрчилцгөөе. **Чухамдаа энэ бол бидний яриад байгаа “ардчилсан, сайн засаглал” мөн. Энэ бол мөн л бидний яриад байгаа электрон засаглалын гол агуулга нь юм.**

Улсын Их Хурлаас баталсан хуулийг боловсруулах. өргөн барих, батлах тухай урт нэртэй хуулийг би саявтархан уншлаа. Хууль санаачлагчид хэрэв ард түмний хэлсэн үг, санал бодлыг “үндэслэлтэй гэж үзвэл” боловсруулж байгаа хууль тогтоомждоо “харж үзэн” тусгаж болох юм байна л даа. Ийм л инээдэмтэй ч, эмгэнэлтэй ч гэмээр хууль тогтоомжоо өөрчлөхөөс шинэ технологи нэвтрүүлэх ажлаа эхэлцгээе.

**Хувийн хэвшлийн экосистемийг зохистойгоор хөгжүүлж эдийн засаг дахь албан бус секторын хэмжээ, гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдлыг бодитойгоор тодорхойлж үнэлгээ өгөх, түүнийг албан секторт татан оруулах буюу албажуулах де Сотогийн хэлсэн “үхмэл капиталыг” “амь оруулах” хууль зүй, эдийн засгийн зохицуулалт, зохистой механизмыг бүрдүүлэх нь шинэтгэлийн бас нэг гол чиглэл мөн.**

Энэ чиглэлээр олон улсын бэлэн зэлэн туршлага, жор байхгүй. Гэхдээ энэ нь хөгжиж буй ертөнцөд, түүний дотор шилжилтийн болон шилжилтийн дараах эдийн засагтай орнуудад түгээмэл байгаа үзэгдэл гэж ойлгох нь зүйтэй. Тиймч учраас өмнө дурдсан НҮБ-ын илтгэлд энэ асуудлыг чухалчлан үзэж бизнесийг хүлээснээс нь чөлөөлөх буюу зах зээлийн овсгоо самбаачлалыг чөлөөтэй хөгжих бололцоо, нөхцлийг тавьж өгөх, пирамидын ёроолын зах зээлийг хөгжүүлэх нь төрийн бодлогын нэг чухал чиглэл болохыг дурджээ. Ядууралд орохгүй гэж, ядуурлаас гарах гэж олон зуун мянган иргэд маань хоёр нарны хооронд зүтгэж байна. Үүний хажуугаар бас ядуугаараа гул барих, бэлэн хоол хүлээн суух буруу дадал

тогтоод байгаа нь ч бас нууц биш. Ядуурлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх, бизнесийн овсгоос амбаачлалыг өрнүүлэх чиглэлээр олон хөтөлбөр, төслүүд хэрэгжиж байгаа хэдий ч үр дүн нь тэр болгон олигтой биш байгаагийн учир шалтгаан нь юунд байна? Эдгээр төсөл, хөтөлбөрүүд хоорондоо уялдаагүй, нэгдмэл удирдлага дутагдах гэх мэт олон шалтгаан тоочиж болох боловч эцсийн дүндээ бизнесийн овсгоо самбаачлал, ядуурал хоорондын хэлхээ холбоо сул, түүнийг хангасан бодлогын үзэл баримтлал, үйл ажиллагаа тодорхой болж чадаагүй, өргөн утгаараа албан болон албан бус хэсгээс бүрдэж буй хувийн хэвшил, ядуурал хоёрын хоорондын амилаг уялдааг бодитойгоор хангасан тодорхой бодлого, үйл ажиллагаа байхгүй байна. Харин “Гэр санаачилга” төсөл, “Кредит Монгол” гэх мэт ББСБ-уудын үйл ажиллагаанаас харахад 2Е буюу бизнесийн овсгоо самбаачлал (entrepreneurship), хүмүүст эрх мэдэл, бололцоо нөхцлийг нь тавьж өгсөн бодлого үйл ажиллагаа (empowerment) хоёрыг хослуулсан үед л амжилт гарч байна.

Энгийнээр хэлбэл мянгат малчин Доржийн төрөлхийн болон амьдралын явцад олж авсан овсгоо самбаачлал, амьдралын туршлага, мэдлэгийг ядуу малчин Дондогт хэрхэн яаж шилжүүлэх, сэтгэл санаа, амьдралын үзэл баримтлал, үйл ажиллагаанд нь хэрхэн нутагшуулах буюу өргөн утгаараа хувийн хэвшлийн санаачилга, сэдэл санааг ядуурлын эсрэг дайнд хэрхэн яаж ашиглах вэ гэсэн хэрэг юм.

МҮХАҮТанхимаас боловсруулсан “Эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах 2И-гийн хандлага” гэсэн энгийн, хэнд ч ойлгогдохоор үзэл баримтлалд чухамдаа энэ л энгийн үнэнийг түшиглэсэн. Үүнийг харж ойлгох илбэ шидийн, билгийн хараа ердөөсөө хэрэггүй, гагцхүү хүнийг ойлгох, зовлон жаргалыг нь хуваалцах, хийж бүтээх эрмэлзлийг нь дэмжсэн хүнлэг улс төр, хүнлэг эдийн засгийн бодлого л байх хэрэгтэй байна.

Өнөөдөр Монгол Улсад албан бус секторт хичнээн хүн ажиллаж байна гэсэн албан ёсны судалгаа байхгүй боловч 400 гаруй мянган хүн гэдэг албан бус тоо баримт бий. Албан бус сектор дотоодын нийт бүтээгдэхүүний 17-20%-ийг эсвэл 30 гаруй хувь ч гэсэн тооцоо бий. Ямар ч гэсэн албан бус сектор дээрх тоонуудаас илүү их хувь эзэлж байна гэдгийг бодит амьдралын “статистик” өгүүлдэг. Зөвхөн худалдааны салбарт 2003 оны албан ёсны статистик судалгаагаар 62 орчим мянган хүн ажиллаж,

судалгаанд хамрагдсан 10138 аж ахуйн нэгж, лиценз, “патент”-ын зөвшөөрөлтэй 31,1 мянган нэгж тухайн оныхоо үнээр 1,3 триллион төгрөгийн борлуулалт хийсний 43,6 хувь, нийт борлуулалтаас борлуулсан барааны өртгийг хассан дүн буюу нийт үйлдвэрлэлийн /335,3 тэрбум/ 52,6 хувийг албан бус сектор эзэлж байна. Дээрх 31,1 мянган бичил бизнесийн 22,3 мянга буюу 71,7 хувь нь лангуугаар үйл ажиллагаагаа явуулсан байна. 2004 оны эцсээр МҮХАҮТанхимаас бичил бизнес эрхлэгчдийн дунд явуулсан судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан 584 бичил бизнес эрхлэгчдийн 428 нь өөрийн өмч хөрөнгөөр бизнес эрхэлж, 73,8 хувь нь сарын 200 мянга хүртэл орлоготой, энэхүү орлого нь ахуй амьдралд нь хүрэлцдэггүй гэж 68,4 хувь хариулсан байх юм.

Түүнчлэн ихэнх нь ажлын байргүй, хүрэлцээ муу тул түрээсийн байранд үйл ажиллагаагаа эрхэлдэг бөгөөд, түрээсийн төлбөр хэт өндөр, энэ нь ялангуяа Улаанбаатарт улам бүр газар авч буй талаар дурьджээ. Судалгаанд хамрагдагсдын 74,7 хувь нь сард түрээсийн төлбөрөөс гадна 70 мянга хүртэл төгрөгийг бусад төрлийн хураамжид төлдөг ба 46,3 хувь нь өөрийн хөрөнгөөр 32,7 хувь нь банкны зээлийн эх үүсвэрээр бизнесээ эхэлсэн, гэхдээ энэ харьцаа нь хот, хөдөөд өөр өөр байх жишээтэй.

Сүүлийн үед манайхан их мэддэг болсон Эрнандо де Сотогийн удирддаг “Ардчилал ба Эрх Чөлөөний Хүрээлэн” манайд энэ чиглэлээр судалгаа, төсөл хэрэгжүүлэх гэж байгаа юм байна. Нэлээд зузаан боть Ерөнхий Сайдын ширээн дээр байхыг харсан. Ямар ч гэсэн албан бус секторыг албажуулах, хуулийн засаглалыг сайжруулах, “үхмэл капиталыг” ажилладаг капитал болгох чиглэлээр юм хийгдэх бололтой. Саяхан н.Ганхуяг, Сү.Батболд, Б.Батбаяр зэрэг төрийн түшээд бичил, жижиг, дунд бизнесийн хууль зүйн тодорхойлолт, төрийн дэмжин урамшуулах бодлого, санхүүгийн орчныг сайжруулах, шинэ институтуудийг үүсгэн хөгжүүлэх зэрэг нэлээд иж бүрэн бодлого агуулсан жижиг, дунд үйлдвэрлэлийн ерөнхий хууль санаачлан өргөн барьчихаад байгаа. СаяханТанхимаас бичил, жижиг, дунд бизнесийн хөгжилд шаардлагатай санхүүгийн институтуудыг хөгжүүлэх, эдийн засаг, техникийн туслалцааны чиглэлээр Монгол Улсад хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, үйл ажиллагааны техник-эдийн засгийн үндэслэл, үнэлгээ бүхий баримт бичгийг боловсруулж Мянганы Сорилтын Сангийн Үндэсний Зөвлөлд танилцуулсан

**Гэхдээ энэ бүх үүсгэл санаачилгыг дэмжих улс төрийн орчин, бодлогын итгэл үнэмшил нэн чухал.** 90-ээд оны эхээр манайд ирж зөвлөгөө өгч байсан эдүгээ НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын тусгай зөвлөх Жефри Загс “Ядуурлын төгсгөл” хэмээх номондоо бодлогын итгэл үнэмшил үндэсний болон глобал түвшинд нэн чухал байгаа талаар санаандгүй бичээгүй биз ээ.

Хүн нэг л өдөр пал хийтэл ядуурлын ангалруу уначихдаггүй нь ойлгомжтой. Ядуу болж төрдөггүй, ядуу айлд төрсөн хүн насан туршдаа ядуу амьдарна гэсэн үг биш гэдэг нь бас л ойлгомжтой. **Тэгвэл бид ядууралтай тэмцэх үйл ажиллагаагаа яг л аливаа өвчнийг урьдчилан сэргийлэх, оношлон эмчлэх, эмчилгээний дараах шат гэсэн 3 талбарт бодлогын арга зүйн хувьд хувааж энэхүү шат бүрд тохирсон бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь зүйтэй.** Энэхүү үйл ажиллагаанд хувийн хэвшлийнхэн ялангуяа томоохон компаниуд өнөөдөр буяны үйл ажиллагаа эсвэл корпорацийн нийгмийн хариуцлагаа ухамсарласны үндсэн дээр идэвхтэй оролцож эхэлж байна. “Спирт Бал Бурам” ХХК-ийн “Алсын хараа” аян, НИК-Петровисийн “Ядуурлын эсрэг хамтдаа” гэх мэт нэлээд үүсгэл санаачилга хөгжиж байна. Хөдөө орон нутаг ч юмуу эсвэл захын ядуу хороололд ажлын байр бий болгох мэтээр компаниуд ажиллаж л байна. **Гагцхүү эдгээр үүсгэл санаачилгыг өргөжүүлэх, дэмжих эдийн засгийн болон нийгмийн сэдэл санаа, хөшүүргийг төрийн зүгээс бий болгох, хувийн хэвшлийн албан болон албан бус секторынхон зах зээлийн зөв дохиолол, тоглоомын шударга дүрэмтэй бизнесийн орчинд үйл ажиллагаа явуулж пирамидын ёроолын зах зээл буюу ядуурлын пирамидыг зах зээлийн боломж гэж харж шинэлэг, санаачилгатай, овсгоо самбаатай үйл ажиллагаа өрнүүлэн хөгжүүлэх нөхцөл, бодлогын орчинг нь төр бий болгон дэмжин урамшуулах шаардлагатай.** Өнөөдөр дэлхий дээр 4 миллиард хүн өдөрт 2 америк доллароос бага, 2 миллиард хүн 1 америк доллароос бага орлоготой амьдарч “пирамидын ёроолыг” дүүргэж байна. Монгол Улсад маань ч энэхүү “пирамидын ёроолд” хүн амын 50 гаруй хувь нь амьдарч үлдсэн ихэнх хэсэг нь энэ ёроол руу уначихгүйг хичээн хөдөлмөрлөж байна. Ядуурлын эсрэг дайн зарлаж, ядуурлыг түүх болгон үлдээхээр хүн төрөлхтөн оролдож байна. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн Газарч ядуурлыг түүх болгож үлдээх талаар өөрсдийн итгэл үнэмшил, бодлого,

чиглэлээ тодорхойлсон. Гэхдээ дээр тодорхойлсон “пирамидын ёроолыг” зах зээл хэмээн үзэж “пирамидын ёроолын зах зээлийг” хөгжүүлэхэд хувийн хэвшлийн дотоод эрчим, сэдэл санаа, санаачлагыг өрнүүлэх бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэхгүйгээр, бидний тодорхойлсноор “Ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах 2И-ийн зарчмын хандлагыг амьдрал дээр бодитойгоор хэрэгжүүлэхгүйгээр ядуурлыг түүх болгон хөшөө дурсгал босгож чадахгүй.

**Бичил бизнес, бичил санхүү нь нэг зоосны хоёр тал бөгөөд энэ бол зөвхөн нэг жилийн биш байнга тасралтгүй явагдаж байх учиртай онцлон зарласан үйл ажиллагаа байгаа шинэтгэлийн үйл явцын нэг чухал хэсэг юм.**

Бичил бизнесийн хууль эрх зүйн тодорхойлолтыг зөв гаргах, түүний үйл ажиллагаа эрхлэх орчинг нь тааламжтай болгох, түрээс, татвар, нийгмийн даатгал, ажлын байрны зохицуулалтыг төрөөс оновчтой болгох чиглэлээр хийх ажил үнэхээр их байна. Энэхүү өгүүллийн хавсралтад байгаа бичил бизнесийнхний дунд явуулсан цомхон судалгаа, мөн Монголын бизнес эрхлэгчдийн их чуулган дээр бизнес эрхлэгчдийн хэлсэн үг, хүндрэл бэрхшээлүүдийн талаар манай улс төрчид зориуд цаг зав гарган унших хэрэгтэй байгаа юм, ямарч мундаг эдийн засгийн ном сургаалиас илүү их “амьд” мэдлэг, сургамж санаа өгнө гэдэгт огт эргэлзэхгүй байна. Ядууралд орж байгаа хүмүүсийн тоо ядуурлаас гарагчдын тооноос бага байх, бичил бизнест орж буй хүмүүсийн тоо, гарч буй хүмүүсийн тооноос их байх, албан бус сектороос албан секторт шилжигчдийн тоо нь албан сектороос албан бус руу шилжигчдийн тооноос их байх, ядуурлаас гарч албан бус секторт орж буй хүмүүсийн тоо албан бус сектороос эргээд ядуурал руу орж буй хүмүүсийн тооноос их байх зэрэг харьцангуй үзүүлэлтүүд буюу нөхцлүүдийг хангаж чадаж байгаа эсэхээр дээрх бодлого, үйл ажиллагааны үр дүн нь хэмжигдэх ёстой.

**Бичил санхүүгийн байгууллагууд нь үндсэндээ банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод гэсэн бүтэцтэй нөхцөлд тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчинг оновчтой болгох, санхүүгийн секторт өрсөлдөөнийг хүчтэй болгон урамшуулах чиглэлээр бодлого хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд энэхүү бодлого, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхдээ дан ганц төрийн зохицуулалт гэхээсээ илүү “бараг зохицуулалт” /quazi regulation/-аар**

**дамжуулан төрийн бодлого хэрэгжүүлэх эсвэл хосолсон хувилбараар хэрэгжүүлэх нь зүйтэй.** Түүнээс биш бидний тархинд ёс юм шиг тогтчихоод байгаа “энд ер нь байдал хэцүүдлээ, тиймээс төрийн зохицуулалт шаардлагатай байна” гэх маягийн сэтгэлгээгээр хандах зах зээлийг улам гажуудуулах үр дагавартайг анхаарах л хэрэгтэй.

Санхүүгийн зохицуулах хороо байгуулахдаа энэ хандлагыг баримтлах, Төв банкнаас банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг хянаж буй чиг үүргийг холбогдох төрийн бус байгууллагад шилжүүлэх, банк санхүүгийн байгууллагуудын зэрэглэлийг хамтран тогтоож зээлийн мэдээллийн бодитой. Бааз бүрдүүлсний үндсэн дээр төрийн дэмжин урамшуулах бодлогын чиглэлүүдийг нэн түрүүнд тогтоох хэрэгтэй.

**Хувийн хэвшлийн эрчимтэй хөгжлийг хангах, зах зээлийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн тоглоомын шударга дүрэм тогтоох, бизнесийн овсгоо самбаачлалыг дэмжих, компанийн сайн засаглалыг төлөвшүүлэн хөгжүүлэх нь шинэтгэлийн бодлогын бас нэг чиглэл болж байна. Нэн тэргүүнд Монгол Улсын хувийн хэвшлийн хөгжлийн стратегийн баримт бичгийг Олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр Засгийн Газар, хувийн хэвшлийн төлөөллийн байгууллагууд хамтран боловсруулах шаардлагатай байна.** Азийн Хөгжлийн Банк Монгол Улсын хувийн хэвшлийн үнэлгээний баримт бичиг боловсруулсныг емнө дурдсан. Дэлхийн Банк ч холбогдох судалгаа, дүн шинжилгээ хийсэн. Дотоодын төрийн болон төрийн бус байгууллагууд ч хангалттай судалгаа хийсэн байгаа. Өөрөөр хэлбэл Монголын хувийн хэвшлийн өнөөгийн байдал, тулгарч буй саад бэрхшээл, цаашдын хөгжлийн ерөнхий чиг хандлага тодорхойлогдсон гэсэн үг. Хөгжиж буй олон орнууд үндэсний хөгжлийнхөө стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг гол бүрэлдэхүүн хэсэг болгож тийм баримт бичиг боловсруулан хэрэгжүүлдэг байна. Хувийн хэвшил эдийн засгийн өсөлтийг хангаж түүний зүтгүүр хүч нь болдог юм бол, ядуурлыг бууруулж нийгмийн олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцож улс үндэсний хөгжлийг хангагч нэг гол хүч нь болдог л юм бол дээрх баримт бичгийг боловсруулахын ач холбогдлыг учир зүйн талаас нь ойлгоход төвөггүй бизээ. Тэр тусмаа Монгол Улсын Ерөнхийлөгч нь энэхүү баримт бичгийг боловсруулах ач холбогдлыг үнэлж өөрийн ивээл дор авахаа тунхаглачихсан байхад хаана хаанаа шуурхай

хөдөлж холбогдох олон улсын байгууллагуудтай тохиролцож уг баримт бичгийг цаг алдалгүй боловсруулах нь зүйтэй юм.

## **IV. ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨГЖИЛД ШУУД ХАМААРАЛТАЙ ШИНЭТГЭЛИЙН ЧИГЛЭЛҮҮД**

**1. Дотоод зах зээл дээр компаниуд ижил тэгш, шударгаар өрсөлдөх дүрэм, журам тэдгээрийг үр ашигтай хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх нь чухал болж байна. Аливаа компани, хуулийн этгээд, албан бус секторынхонзах зээлд орох, зах зээлд үйл ажиллагаа явуулах, түүнээс гарах тоглоомын дүрэм нь шударга, ижил тэнцүү, хүнд сурталгүй, нээлттэй байх ёстой.**

Зах зээлд орсноос хойш 15 жилийн дараа Шударга Бус Өрсөлдөөнийг Зохицуулах Агентлаг нь байгуулагдаж зах зээлээс гарах гол зохицуулалт болох “Дампуурлын тухай” хууль нь бараг үйлчилдэггүй, зах зээлд буюу бизнест орох зохицуулалтууд нь дээд зэргийн хүнд суртал, өндөр өртөг зардалтай ийм тоглоомын дүрэм үйлчилдэг улс орон дэлхийд цөөхөн байдгийн нэг нь манайх юм.

Лиценз, зөвшөөрлийн хүнд тогтолцоо, хөдөлмөрийн зах зээлийн “бүтээмж нэмэгдүүлдэггүй бас хүн халж болдоггүй” зохицуулалтууд, нийгмийн даатгалын шимтгэлийн дарамт, газартай холбогдсон авилгалын сүлжээ, бараа үйлчилгээний зах зээл, түүний дотор экспорт импортын дотоод зах зээл дээр гардаг хүндрэл, захиргааны саад бэрхшээл гэх мэтээр зах зээлийн тоглоомын дүрмийг гажуудуулж буй олон хязгаарлалт, хориг саадуудыг иж бүрнээр авч үзэж шинэчлэх шаардлагатай байна. Энд би татвар, гааль, нийгмийн даатгалын талаар зориуд дурьдаагүй. Учир нь татварын шинэтгэлийн асуудал энэхүү өгүүллийн хүрээнд багтах ааргүй бие даасан том асуудал бөгөөд энэ чиглэлээр нийгмийн хамгийн идэвхитэй хэсэг болох татвар төлөгчдийн байр суурь, бодит санал хангалттай илэрхийлэгдчихсэн байгаа. Гаалийн тогтолцооны шинэтгэл нь Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдаа бизнесийг хөнгөвчлөх бодлогын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзэн тусгайлан авч үзэх шаардлагатай. Засгийн Газрын мөрийн хөтөлбөрт энэ чиглэлээр заримдаг маягийн бус жинхэнэ шинэтгэл хийх үзэл санаа бүхий

заалтууд байгаа. Улсын Их Хуралд төлөөлөлтэй намуудын мөрийн хөтөлбөрт татварын шинэтгэлийн асуудал чухалчлан тавигдсан, дотоодын болон гадаадын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын зүгээс татварын орчин сайжирна, шинэтгэл хийгдэнэ гэсэн асар их хүлээлт талаар өнгөрөхгүй, Олон Улсын Валютын Сан ингэж зөвлөсөн, тэгж зөвлөсөн гэх мэтийн “аргумент”-аар Их Хурал дээр гул барихгүй, эсвэл төсөвт ингэж хүндрэл учирна, зардлыг танах, тойрогт мөнгө дутуу хуваарилагдах гэх мэтээр “айлгахгүй” гэсэн найдвар байгаа юм. Эцсийн эцэст бид татварын шинэ тогтолцооруу явах ёстой, тэрнээс биш “төр байгаа цагт татвар байдаг” гэсэн муйхраар гул барьсан номлол бус, “татвар төлөгчид байгаа болохоор төр байгаа юм” гэдэг талаас нь хандаж төсөв, эдийн засгийн өсөлтийг урамшуулах үзэл санааны аль алинд нь тулгуурласан татварын орчин бий болох ёстой. Татварын шинэтгэлийн асуудлыг татвар хураагчид нь дангаараа боловсруулж татвар төлөгчдийн санал бодлыг “үндэслэлтэй гэж үзвэл” тусгадаг бодлогын технологитой улс оронд татварын шинэтгэл жинхэнэ ёсоор хийгдэнэ гэсэн итгэл үнэмшил бага байгаа учраас саяхан шударга татварын шинэтгэлийн төлөө төрийн бус байгууллагуудын эвсэл байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэллээ. Одоо гагцхүү Сангийн Яам, Татварын Ерөнхий Газрын ганц талын аргумент, “айлган сүрдүүлэлтэнд” автагдахгүй, бүх талын санал бодлыг энэ тэнцүү сонсон шийдвэрээ гаргах байх хэмээн Их Хуралд л найдах ганц зам үлдэж байна.

**2. Бизнесийг санхүүжүүлэх, санхүүжилтын нөхцөл, хугацааны бизнесийн байгууллагуудад боломжтой бөгөөд хүрэлцээтэй байх, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, зах зээлдээр “бүтээлч устгалт” /creative destruction” хэмээх Шумпетерийн үзэл санаа буюу зах зээлд компаниуд орох, түүнээс гарах үйл явцын харьцааг харуулсан үзэгдэл бөгөөд энэ нь эдийн засгийн сектор бүрд бүтээмжид өөр өөрөөр нөлөөлдөг /явагдах үйл явцад дэмжлэг үзүүлэх, эцсийн дүндээ эдийн засгийн өсөлт, хөгжлийн хурдасгуур болох учиртай санхүүгийн хүчирхэг, үр ашигтай секторыг бий болгох онцгой шаардлагатай байна.** Санхүүгийн институцуудын сул бөгөөд дутуу хөгжил, санхүүгийн капиталын дутагдал, зээлийн хангагдаагүй эрэлтээс гадна зээлийн барьцаа, баталгаа, даатгалын тогтолцоо сул хөгжсөн буюу огт байхгүй, энэ талын эрх зүйн зохицуулалтууд хийгдээгүй зэрэг нь санхүүгийн секторын

эрчимтэй өрсөлдөөн, хөгжилд саад болж бодит сектор дахь бизнесийн идэвхжлийг бууруулж дотоодын хөрөнгө оруулалт, жижиг дунд бизнесийн тогтвортой өсөлтөд саад тушаа болж байна.

Улс төрчид нь “мөнгөний нийлүүлэлт” гэх мэтийн хэллэгийг ягштал цээжилчихсэн, банкны тухай хууль тогтоомж нь 90-ээд оны эхэн болон дунд үед цэвэр монетор үзэл баримтлал дээр тулгуурлан боловсруулагдсанаас хойш олигтой өөрчлөлт хийгдээгүй, эдийн засгийн өсөлт, бодит секторт төв банкны зүгээс нөлөөлөх арга хэрэгслүүд, механизм нь хязгаарлагдмал, арилжааны банкны олигополи зах зээлийн гажуудсан хэв шинжит дүр төрхтэй, өрсөлдөөн эрчимтэй өрнөх боломжгүй ийм орчноос жижиг, дунд бизнесийнхэн, хувийн хэвшлийнхэн зээлийн хүү буурна гэж нэг их горьдох хэрэггүй бизээ.

**Арилжааны банкуудын өсөлтөнд нь саад болж буй хязгаарлалтуудыг арилгах, татварын зөв орчин бүрдүүлэх, Төв Банкны хууль тогтоомжуудад хөгжиж буй орнуудын төв банкуудын сайн жишээ, туршлагын үндсэн дээр өөрчлөлт оруулах, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоодын эрх зүйн болон институционал бүтцийг төгөлдөржүүлэх гэх мэт санхүүгийн секторт шинэтгэл хийх олон асуудал хуримтлагдсан байна. Зээлийн мэдээлэл, зэрэглэлийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүй, удирдлага-зохион байгуулалтын бүтэц бий болгох чиглэлээр ч хийх зүйл байна.** МҮХАҮТ-аас компаниудын зээлийн зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эхэлж “TOP-100” компани шалгаруулах, банк санхүүгийн байгууллагуудын зэрэглэлийг тогтоох, зээлийн мэдээллийн товчооны чиг үүргийг хөгжүүлэх, зээлийн баталгааны агентлаг байгуулах чиглэлээр бие даасан эхлэл, үйл ажиллагаа хэрэгжүүлж буйг санхүүгийн секторын шинэтгэлийн нэг хэсэг гэдэг талаас нь ойлгон хүлээн авч хамтран ажиллах, дэмжих үйл ажиллагаа Их хурал, Засгийн газар, Төв банкны зүгээс шаардагдаж байна.

**Хадгаламж зээлийн хоршоод нь хаа ч байдаггүй хадгаламжийн өндөр хүү өдөр шөнөгүй амлан санхүүгийн секторт “савангийн хөөсний эдийн засаг”-ийг хөөрөгддөг, энэ нь нийт активд эзэлж буй өчүүхэн хувь тань харьцуулахад хэдэн арав, зуу дахин нийгэм - сэтгэл зүйн буруу хүлээлт, муу эффектийг санхүүгийн секторын хөгжилдөө үзүүлдэг,**



нийт хадгаламж эзэмшигчдийн ердөө арваад хувь нь нийт хадгаламжийнхаа ер гаруй хувийг эзэмшдэг ийм санхүүгийн орчинд зээлийн хүүг бууруулах талаар гурван талын уулзалтын үеэр Ерөнхий Сайд нь тодорхой чиглэл, санал бодол илэрхийлэхгүй ерөнхий дүү юм яриад, Төв Банк нь “манай эдийн засаг ийм их шингээх чадвартай юм байхдаа...” гээд гайхшран суугаад байж таарахгүй байхаа. Эдийн засгийн шингээх чадварыг доноруудаас гуйж амлуулдаг 330 сая долларын хүрээнд сэтгэх, Монголд зээл, тусламж өгөхгүй байх нэг шалтаг, шалтгаан болгох гээд байдаг болчихсон энэ “эдийн засгийн шингээх чадвар” гээчийг хэн, хэзээ, яаж тооцоолчихсон юм? Хувийн хэвшлийн амьд үйл ажиллагаа, босоо, хэвтээ, албан, албан бус бүх хэлхээ холбоогоор нөхцөлдөж байдаг санхүүгийн капиталын хэрэгцээ, түүнийг хангах учиртай зээлийн институтуудын чадавхи, бодит үйл ажиллагаа Монгол Улсад гаднаас санхүүгийн нэмэлт нөөц, “тарилга” хэрэгтэй байна гэдгийг харуулж буй болохоос биш “эдийн засгийн шингээх чадвар”, өөрсдөө бие даан эрсдлээ тооцоолж үүрэх чадвартай болчихсон “арилжааны банкуудын эрсдлийн менежментэд” огт падлий байхгүй.

Уул нь Монгол Банкинд практик амьдрал руу жаахан ойртуулчихвал судалгаа, шинжилгээний гайгүй сайн багтай юм байна лээ. Түүнийгээ сайн ашиглаж мөнгөний бодлого, түүний арга хэрэгслүүдээ Монголын эдийн засгийн бодит нөхцөл, хөгжиж буй орнуудын мөнгөний бодлого, туршлагад тулгуурлах ялангуяа, мөнгөний үүд, валютын ханшны бодлогоор дамжуулан бодитсектор, түүний дотор импортыг зохистой орлуулах, экспортыг дэмжин урамшуулах бодлогод хэрхэн бодитой, үр дүнтэй нөлөөлөх талаар бодох нь зүйтэй. Урд хөршийн валютын ханшны бодлогод өөрчлөлт орж худалдааны гол түншүүдийнхээ валютын сагсан дээр суурилсан зохицуулалттай хөвөх ханшийн дэглэмд орж байх шиг байна. Монгол Улсын хувьд ч валютын ханшны өнөөгийн дэглэмдээ бодитой дүн шинжилгээ хийж худалдааны гол түншүүдийн эдийн засгийн хөгжлийн хандлага, валютын ханшны дэглэмтэй харьцуулж ханшийнхаа бодлого, дэглэмийг эргэн харах нь хэрэгтэй байхаа.

**3. Бизнесийн сектор дахь хүний нөөцийн хөгжил, хүний капиталын ашиглалтын бүтцийг эрс сайжруулан эдийн засгийн өсөлт, хөгжлийн гол зүтгүүр хүч болдог талаас нь төр онцгой анхаарч ялангуяа бизнест нэн шаардлагатай байгаа**

мэргэжлийн боловсролын тогтолцоо, инженер, техникийн боловсролд тэргүүлэх ач холбогдол өгөн хөгжүүлэх нь шинэтгэлийн нэг чухал чиглэл болж байна. Яг үнэндээ эдийн засаг, менежмент, хууль, гадаад хэлний чиглэлээр төгссөн “бакалавр, магистр” нэртэй баахан чанаргүй бүтээгдэхүүнийг бизнесийн хэвшлийнхэн хүлээн авч байна. Авахаас ч өөр арга байхгүй, яагаад гэвэл чанартай, чанаргүйг нь сорьдог, шалгадаг “лабораторийн тогтолцоо” бизнесийн секторын дотор нь ч, гадна нь ч байхгүй.

Бизнес түүхэн хавьдаа энэ тэндээс төсөл гэх мэт хэрэгжүүлээд өнгөцхөн хандаад явах ажил огт биш, бизнесийн төлөөллийн байгууллагууд, боловсрол, хөдөлмөр, эдийнзасаг, худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвхтэй, жинхэнэ ажил хэрэгч түншлэлийн механизмаар дамжин хэрэгжих цогц шинжтэй үйл явц гэдгийг эхлээд төр, Боловсролын яам ойлгох хэрэгтэй.

**4.Компанийн сайн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх нь хувийн хэвшил эрүүл, нийгмийн мэдрэмжтэй байх, бизнесээ тогтвортой хөгжлийн замд оруулах гол арга зам гэдэгт тулгуурлан компанийн төвшинд холбогдох стандарт, бизнес төлөвлөгөө боловсруулах, нийгмийн бизнесийн бус хэсгүүдэд, ард иргэдэд бизнесийн хариуцлага, ёс суртахууны үнэлэмжүүдийг түгээх үйл ажиллагааг компани бүр үйл ажиллагааныхаа алсын хараа, стратегийн чиглэл, хөгжлийн гол үнэлэмж болгох нь эрүүл, саруул, хөгжлийн зөв голдиролтой хувийн хэвшлийг хөгжүүлэх гол шалгуур, гол стратеги мөн.**

Энэ чиглэлд үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа зохицуулсан хууль тогтоомжийг өөрчлөн сайжруулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн өмчлөл, үйл ажиллагааны эрх ашгийг хөндсөн асуултууд багагүй байна. Хувийн өмчийн эрх зүйн зохицуулалтууд, гэрээ контрактын харьцаа, түүний хэрэгжилтийг хангах чиглэлээр илүү нарийвчлан авч үзэх, ялангуяа хувийн өмчийн баталгааг хангах чиглэлээр тодорхой болгож өгөх эрх зүйн ч эдийн засгийн ч шаардлага тавигдаж байна. Ялангуяа гэрээ контрактын хэрэгжилтийг хангах, маргаан шийдвэрлэх зэрэгцээ хувилбар, арга замыг өргөнөөр хөгжүүлэх талаар хийх зүйл бишгүй байна. Арбитрын талаарх эрх зүйн орчин бүрэлдэж

дотоод, гадаадын маргаан шийдвэрлэх орчин үеийн механизм хөгжиж буй хэдий ч шүүх ба арбитрын хоорондын “хөдөлмөрийн хуваарийг” улам сайжруулах, ачааллыг тэнцвэржүүлэх, орон нутагт арбитрын үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх талаар төрийн дэмжлэг үгүйлэгдэж, арбитрыг шүүх, эрх зүйн тогтолцооны шинэтгэлийн гадна үлдээж, арбитрын институцийг бэхжүүлэх асуудлыг үл ойшоох, бичил бизнесийн маргаан шийдвэрлэх альтернатив механизм хөгжүүлэх, арбитрын шийдвэрийг ягштал биелүүлэх гэх мэтээр засаж залруулах, хөгжүүлэх зүйл их байна.

Хэдийгээр шинэтгэл хэрэгжиж буй хэдий ч хүнд суртлынхаа зэрэглэлээр шүүх, прокурорын байгууллагууд “баталгаатай” 4-р байранд орсоор байгаа нь “хуулийн засаглал”-ын технологидоо өөрчлөлт оруулах нэн шаардлагатай буйг баталж, хуулийн засаглалд хандах ард нийтийн итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр ихээхэн санаачилгатай ажиллахыг сануулж буй хэрэг мөн. **Тиймч учраас Монгол Улсад хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэхдээ эдийн засгийн хөгжил ба хуулийн засаглалыг нягт уялдаатайгаар авч үзэх хандлагыг бий болгох, шүүх засаглалын зүгээс эдийн засгийг зохицуулж буй төрөл бүрийн хууль эрх зүйн зохицуулалтуудын үр дагаварт анхаарахаасаа илүү уг шалтгаануудад нь илүүтэй анхаарах зэргээр хуулийн засаглалыг хүчтэй болгох, эдийн засгийн хөгжилд үзүүлж буй үр нөлөө, ач холбогдлыг нь нэмэгдүүлэх зэргээр Их хурал-Шүүх засаглал, Засгийн газар-Шүүх засаглал, Хувийн хэвшил-Шүүх засаглал, Иргэний нийгэм-Шүүх засаглал чиглэлүүдээр тодорхой бодлого, үйл ажиллагаа шаардлагатай байна.**

**5. Дэлхийн бизнесийн хөгжлийн алхаанаас хоцрохгүйн тулд компанийн удирдлагын шинэ, дэвшилтэт аргуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, компаний нийгмийн хариуцлага, сайн засаглалын стандартуудыг төрийн холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулах, мянганы хөгжлийн зорилтуудыг хангахад бизнесийн байгууллага бүрийн идэвхтэй оролцоог хангах, НҮБ-ын “Global compact” буюу “Даян дэлхийн иж бүрдэл” баримт бичгийн үг үсэг, үзэл санаанд Монголын бизнесийнхэн нэгдэн орох гэх мэт чиглэлээр хийх ажил их байна.** МҮХАҮТ-аас НҮБ-ын суурин төлөөлөгчийн газартай хамтран “Монголын бизнесийнхэн мянганы хөгжлийн зорилтуудын төлөө” сэдвийн хүрээнд үйл ажиллагаа эхлүүлэн энэ намраас дүгнэх, түүнчлэн бичил бизнес, санхүүгийн

талаар хамтран ажиллах, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк, НҮБ-ын төлөөлөгчийн газруудтай эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах, бизнесийн тааламжтай орчин бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллах зэргээр үйл ажиллагаа эхлүүлж байна.

2004 оны Хандивлагчдын зөвлөгөөний үеэр 2005 оны уулзалтыг хувийн хэвшлийн хөгжлийн сэдвээр хийх саналыг МҮХАҮТанхимаас Засгийн Газар болон Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн газар хүргүүлсэн, тодорхой хариулт аваагүй л байна. Засгийн Газар нь энэ асуудлыг анхаарахгүй бол гадны байгууллага учир зүггүй анхаарч гүйх нь юу л бол.

## **V. ТӨГСГӨЛИЙН ОРОНД БУЮУ ХӨГЖЛИЙН ТУХАЙ ДАХИН ӨГҮҮЛЭХ НЬ**

Монгол Улсын өрсөлдөөнт давуу талуудыг хөгжүүлэх, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гэж бид их ярьдаг болсон. Ярихаас ч аргагүй болсон. Зэс, алт, жонш, ноос, мах, арьс шир, аялал жуулчлал гэх мэтээр тодорхой бүтээгдэхүүн, тодорхой секторын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, Монголын эдийн засгийн гадагш харсан, экспортын баримжаатай бүтцийг хөгжүүлэх чиглэлээр бодлогын баримт бичгүүд бий. Хамгийн сүүлдлгэхэд Үндэсний хөгжлийн урт хугацааны хөтөлбөр боловсруулж XXI зууны эхний арав, хорин жилийн хөгжлийн төсөөлөлөө хийж авсан. Гэхдээ математикийн хэлээр бол цаасны хувьд хүрэлцээтэй нөхцөл бүрдсэн ч хэрэгжүүлэх арга зам, санхүүгийн нөөцийн төлөвлөлт, байршлын хувьд зайлшгүй нөхцөл нь бүрдээгүй байгаа. Энэ нь эдгээр баримт бичиг урьдын адил их төлөв цаасан дээр үлдэх магадлал өндөр байна гэдгийг харуулж байгаа хэрэг юм. Сүүлийн үед “Монголын эдийн засаг”-т “голланд өвчний” шинж тэмдэгүүд илэрч байгаа талаар, Монгол Улс хөгжлийн “үүцээ задалж” ард түмэндээ “баялгийг шударгаар хуваарилах” талаар ярьж бичиж эхэлсэн. Ялангуяа улс төрчид “баялагийг шударга хуваарилалт” хийх талаар сонгуулийн үед бүрчихээр ярьж ард түмэнд “аан, бид чинь асар их уул уурхайн баялаг” дээр сууж буй гуйлгачид юм байна. Монгол орны эзэн болсон бидэнд юу ч хүртээхгүй, зөвхөн гадныхан хамгийг нь зөөх нь байна, ингэхлээр энэ баялгаа “шударга хуваарилахын төлөө” нэгдэх нь зүйтэй юм байна” гэх маягийг сэтгэгдэл, төсөөлөл бий

болгохыг оролдож байна. Энд хөгжилд хор уршигтай хэд хэдэн зүйл ажиглагдаж байна.

1. Зөвхөн газар доорхи баялагт л нийгмийн анхаарлыг хандуулах, ингэснээр нийгмийн бусад баялаг, ялангуяа хүнд өөрт нь байдаг “баялгуудыг” ашиглах, хөгжүүлэх талаар, улс орон яаж хөгжих талаар буруу ойлголт, төсөөллийг сурталчлах;

2. “Голланд өвчин”-ний шинж тэмдгүүдийг нийгэмд улам халдварлуулах, хөгжлийн бодлогыг зөвхөн газрын доорх нөөцийн бодлогоор орлуулах хандлагыг өөгшүүлэх, нөөцөөр баялаг аливаа улсын эдийн засгийн хөгжил нь нөөц баялгийнхаа хэмжээтэй урвуу хамааралд оршдог гэсэн Кузнецийн таамаглал буюу одоо аль хэдийн бодит зүйл болчихсон амьдралын үнэн баримтыг огоорох;

3. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах гэж Ерөнхийлөгчөөсөө эхлээд л бүгд сурталчилдаг, зээлийн зэрэглэлээ ахиулсан, хөрөнгө оруулалтын тааламжтай орчин бүрдүүлж байгаа гэдэгэнэ улсад хууль дээдлэх буюу яг үнэндээ агуулга талаас нь зөв орчуулбал хуулийн засаглал /rule of law/ гэдгийг оросууд верховенство закона гэж орчуулсныг манайх хууль дээдлэх хэмээн махчлан орчуулсан байдаг/ бүхний дээр байдаг, хөрөнгө оруулалтын баталгаа, хамгаалалт байдаг гэдэгт эргэлзээ төрүүлэх;

4. Муу сайн хэлүүлдэг социализмын үед эдийн засгийн ухаалаг дипломат үйл ажиллагааны ачаар л Эрдэнэт үйлдвэр, түүнийг даган бүхэл бүтэн хот хөгжиж байгаа гэдгийг мартаж, Монголын эдийн засгийг олон жил авч яваа “Эрдэнэт” гэдэг энэ “case” аяндаа дахин давтагдаж “баялгийг шударга хуваарилснаар” л, гадаадын хөрөнгө оруулагчдад эргэлзээ төрүүлэх “тулган шаардах” маягийн ойлголт төрүүлэх замаар, ингэснээрээ хөрөнгө оруулалтыг дэмжин урамшуулах чиглэлээр хийгдэж ирсэн улс төр, эдийн засгийн дипломат үйл ажиллагааны ололт, хүрсэн төвшингээс ухрах замаар “Оюутолгой хот”, “Таван толгой муж” шинээр цэцэглэн хөгжинэ гэсэн хуурамч эх орон ч үзэл түгээн дэлгэрүүлэх;

Үнэхээр уул уурхай, газрын нөөцийг зохицуулж буй хууль тогтоомж, зохицуулалтуудад өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа нь үнэн. Нөөцөөр баялаг хөгжиж буй орнуудын энэ чиглэлийн хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны арга хэлбэрүүд, бодлогыг судлах, дэлхий даяар хэрэгжиж буй уул уурхайн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, бодлогыг Монгол оронд хэрэгжүүлэх, байгаль орчныг эвдэн сүйтгэдгийн эсрэг, газар нутгийнхаа амьдрах орчинг эвдүүлэхгүйн төлөө нутаг нугаараа

нэгдэн хөдөлгөөн байгуулах хүртлээ тэмцэж буй хүмүүсийн дуу хоолойг сонсох нутаг дэвсгэр дээрээ байгаа орд газруудын ашиглалтын үр өгөөжөөс орон нутгийн хөгжилд зориулах талаар орон нутгийн эрх мэдэл, бололцоог нь нэмэгдүүлэх, ялыг нь ч үүрдэг ямбыг нь ч эдлүүлдэг болгох, амьдрахын тулд сүүлчийн арга чаргаа дайчлан алт хууль бусаар ухан сүүлдээ бүр хүний эзэмшил рүү дайран орж бор хоногийг залгуулж яваа “нинжа” хэмээх албан бус секторынхонд хуулийн засаглалын хүрээнд амьдрах, ажиллах орчинг нь бүрдүүлж өгөх зэргээр олон талт үйл ажиллагаа хэрэгтэй байгаа нь бас үнэн. Гэхдээ л энэ нь “баялгийг шударга хуваарилах”-ын төлөө хуулийн засаглалыг огоорох, улс төржүүлэх, олон нийтэд “очкоов” авах асуудал огт бус, уулуурхай, нөөц баялгийн тогтвортой хөгжил буюу “алтыг нь аваад авдрыг нь хаядаггүй алтны бодлого, арьс шир боловсруулаад гол усаа бохирдуулдаггүй үйлдвэрлэлийн бодлого, газрын дорхи баялгаа олборлож боловсруулах бодлогын цөм нь зөвхөн эдийн засгийн зардал, үр ашиг бус, байгаль орчны болон нийгмийн зардал, үр ашгаар энэ тэнцүү хэмжигддэг, эдгээрийг нөөц баялгийн салбарын хөгжлийн гол шалгуур болгохыг л хэлж байгаа хэрэг. Саяхан Германы эдийн засгийн хүрээлэнгээс маш сонирхолтой, яг өнөөдрийн Монголд шууд хамааралтай илтгэл гаргасан байна. Тэр нь “Түүхий эдийн баялаг-зовлон уу жаргал уу?” гэсэн нэртэй бөгөөд газрын доорхи нөөцөөр баялаг 21 орны эдийн засгийн хөгжлийг 1980-2002 оны хүрээнд харьцуулан судалж түүхий эдийн баялаг нь тэдгээрийн экспортын орлого “эдийн засгийн өргөн цар хүрээний хөгжлийн үндэс нь болж чадаж байгаа тохиолдолд улс орны хөгжилд эерэг ач холбогдолтой байгааг тогтоосон. Өөр нэг зүйл нь нөөцөө баялаг эдгээр улсад бидний одоо хүсээд мөрөөдөөд байдаг эдийн засгийн өндөр өсөлт тэр болгон байгаагүй, тэр тусмаа нөөц баялагийн ашиглалт нь хэдхэн сонирхлын бүлгийн эрх мэдэлд, коррупц идэгдсэн, ил тод дүрэм журамгүй үед эдийн засгийн өсөлтийн үр өгөөж ард түмэнд наалддаггүйг баталсан байна.

Гэхдээ өмнө миний шүүмжилсэн “баялагийг шударга хуваарилах” замаар бус уул уурхай, газрын доорхи баялагийнхаа олборлолт ашиглалтын механизмыг зөв тогтоох, үр өгөөжийг нь эдийн засгийн хөгжлийнхөө жинхэнэ тэргүүлэгч чиглэлүүдэд зөв механизмаар хуваарилахыг л хэлж байгаа хэрэг. Дээрх судалгаагаар ингэж чадаж байгаа орны сайн жишээгээр Норвеги

улсыг дурьдсан бөгөөд тэнд тусгайсан байгуулж тэндээсээ боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд гэх мэтдээ хөрөнгө оруулдаг ажээ.

Чухамдаа иймэрхүү саналыг саяхан Ерөнхий сайд дэвшүүлсэн нь бодлогын хувьд маш дэмжүүштэй санал юм.

**Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжин урамшуулах бодлогыг хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлүүдтэйгээ улам илүү уялдуулах, энэ зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг ялгаварлахгүй байх, гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиндаа өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулагчдыг дэмжин урамшуулах бодлогыг нэг агентлагийн санхүүгийн ядмагхан нөөцөөр хязгаарлахгүй байх, хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлээ зохистой болгох зайлшгүй шаардлага гарч байна.** 15 жилийн турш бид гадаадын хөрөнгө оруулалтыг ялгаварлахгүй, сонголтгүйгээр урьсан, сайн нь ч, саар нь ч орж ирсэн. Өдгөө тэгвэл гадаадын хөрөнгө оруулалтын чанарт нь илүү анхаарч сорилт сонголттой урих цаг болсон. Ямар ч гэсэн ядарсан Монголд “шанаган тогоо”-ны гадаадын хөрөнгө оруулалт хэрэггүй, бас караоке, шөнийн цэнгээний газрын “гадаадын хөрөнгө оруулалт” хэрэггүй. Хуучирсан тоног төхөөрөмжийг будаад “шинэ” болгочихоод оруулаад ирдэг, байгаль орчныг шаардлагыг хангаж чадаагүйн улмаас өөрийнхөө улсаас шахагдаад “хөөгдчихсэн” үйлдвэрлэлийн гадаадын хөрөнгө оруулалт эсвэл гэнэн монголчуудыг орон сууц барьж өгнө гэж залилаад “хулхидчихдаг”, тамхины галаа монгол хүний нүүрэн дээр унтраадаг “гадаадын хөрөнгө оруулагчид” хэрэггүй.

Хөгжлийн төсөөлөл, номлол, үзэл баримтлал, бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд арга зүйн хувьд бид нэг зүйлийг анхаарах хэрэгтэй юм шиг санагддаг. Өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлт, хөгжлийн асуудал боловсруулахдаа нэн тэргүүнд:

а/. хөгжлийг дэмжигч секторууд/хүчин зүйлүүд

б/. хөгжлийг тодорхойлогч секторууд /хүчин зүйлүүд гэж ангилан энэ хандлагаас хөгжлийн бодлого, түүнийг тэргүүлчлэх /prioritization/, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн үг. Зах зээлээс гадна Засгийн газар хөгжлийн ямар секторуудад илүү ач холбогдол өгөхөө зөв тодорхойлж “интервенц” хийх, энэ нь “Засгийн газрын бүтэлгүй оролдлого” /government failure/ болохгүй байж зах зээлийн механизмд нэмэлт хүч, дэмжлэг болох үед л хөгжил урагшилдаг.

Дээрх ангиллынхаа үүднээс би уул уурхай, дэд бүтцийн секторууд, энэ чиглэлийн бодлого, арга хэмжээг “хөгжлийг дэмжигч секторууд / хүчин зүйлүүд” гэдэгт хамруулдаг. Гэхдээ энэхүү ангилал нь хөгжлийн бодлогын арга зүй талаас нь хийсэн ангилал гэдгийг дурьдах хэрэгтэй бөгөөд манай хөгжлийн бодлогын практикт дэндүү их тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлдог, энэ нь үнэн хэрэгтээ тэргүүлэх чиглэлүүдийг тэргүүлэх биш болгон бүдэгрүүлдгээс зайлсхийх, хөгжлийн гол үзэл баримтлалыг хүн рүү чиглүүлэх зорилгоор ийнхүү ангилж буйх эрэг юм. Тавантолгой, Оюутолгойн орд газруудын хөрөнгө оруулалт хийгдэж, түүнийг дагалдан дэд бүтцийн хөгжил, ажлын байр, эдийн засгийн өсөлт нэмэгдэх, экспортын орлого эрс нэмэгдэж түүнээс нийгмийн асуудлуудад зарцуулах хөрөнгө оруулалт, санхүүжилт өсөх эсвэл “Эрдэнэт”-ийн зэсийн баяжмалыг эцсийн бүтээгдэхүүн болгон нэмэгдсэн өртөг бүтээх үйл явц хэрэгжих гэх мэтээр хөгжлийг дэмжигч сектор/ тодорхойлогч секторын холимог, сүлэлдсэн үйл явц дунд болон урт хугаацаанд хэрэгжих нь мэдээж. Гэхдээ л эдгээр нь дэлхийн хөгжлийн ерөнхий хандлага талаас нь авч үзвэл Монгол Улсын тогтвортой хөгжлийг тодорхойлогч секторууд биш. Тэгвэл Монгол Улсын нөхцөлд хөгжлийг тодорхойлогч секторууд/ хүчин зүйлүүд гэж юу вэ?

Дэлхийн хөгжлийн ерөнхий хандлага, Монгол Улсын хөгжлийн өнөөгийн болон байж болох өгөгдлүүд, ерөнхий сценар /гэхдээ өнөө телевизээр гараад байсан иргэн Гочоогийн 4 сценар биш/, эдийн засгийн тогтолцоо, зах зээлийн байршил, бид одоо их төлөв везуаль байдлаар нэрлээд байгаад авуу болон давуу бус талуудыг өөрийн жижигхэн бор тархины хэмжээ, хязгаарлагдмал мэдлэг, туршлага, алсын харааныхаа хэмжээнд аваад үзэхээр “5Ц+ХҮ” гэж томъёолж болмоор санагддаг юм.

1. Цэвэр байгаль орчин
2. Цэвэр хүнс
3. Цэвэр үйлдвэрлэл
4. Цэгцтэй мэдлэг буюу цэгцтэй боловсрол, шинжлэх ухаан
5. Цахим нийгэм.

Эдгээр 5Ц дээр “худалдаачин үндэстэн” /Trading nation гэж нэрлэгддэг үзэл номлол, бодлого/ буюу эдийн засаг зах зээлийн байршил, хэмжээ, бүтцээ харгалзсан, олон улсын худалдааны

давуу талуудыг бүрэн дүүрэн ашигласан транзит орны ложистик дэд бүтцийг дээд зэргээр бүрдүүлэн гадагш чиглэсэн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх ёстой гэсэн үг. Эдгээрийг тус бүрд нь товчлон авч үзье.

**1. ЦЭВЭР БАЙГАЛЬ ОРЧИН.** Энэ асуудлын чухлыг хамгийн сайн ойлгож юм хийх гэж оролдож байгаа нь Байгаль орчны яам, Онгийн гол хөдөлгөөнийхөн, Дархан цаазтай газрын хамгаалагчид, төрийн бус байгууллагууд дээр нь олон улсын байгууллага, гадаад улс орноос төсөл хэрэгжүүлж буй хүмүүс. Хамгийн ихээр ойлгохгүй байгаа нь улс төрчид, Их хурал, УБ хотын захиргаа, ногоонтны нам, хөдөлгөөнийхөн, дээр нь хотын иргэд бид өөрсдөө, бизнесийнхэн. Хамгийн түрүүнд ядахдаа нийслэл хотоо болж өгвөл Монгол орноо “золбин шар” гэж ард түмний нэрлээд байгаа “цагаан бохирдол” шар уутнаас цэвэрлэх хэрэгтэй байна. Аялал жуулчлалын салбарыг одоохондоо онгон байгаа байгалийнхаа давуу талуудад тулгуурлан “ногоон аялал жуулчлалын бодлогоор хөгжүүлэх нь хамгийн ирээдүйтэй чиглэл. **Дэлхий дээр байгаа ядуу орнуудын дотроос амьдрахад хамгийн сайхан орон бол үнэндээ Монгол мөн гэдэгт би эргэлздэггүй.**

Хүн төрөлхтөн буруу амьдарч, буруу хөгжиж, тэр хөгжлийг буруу хэмжиж ирснийхээ гор, гайгамшгийг одоо амсаад эхэллээ. Монгол орон маань ч ялгаагүй. Бид улс орнуудыг яаж хөгжсөн туршлагаас суралцах, “хоцрогдлын давуу талаа” ашиглаж “амдан хөгжих” гэх мэтийг ярихаасаа илүү “явал тэдэн шиг хөгжихгүй” байх, яаж “буруу хөгжихгүйг” “амдан хөгжих” харьцангуй орон зай, цаг хугацаа одоохондоо бидэнд байна. Эдийн засгийн хөгжил гэдэг асуудал “economics” гэдэг шинжлэх ухааны хүрээнээс нэгэнт халингарч “economics” /ийм шинжлэх ухаан Одоохондоо байхгүй шүү/ гэсэн шинжлэх ухаанаар залуурдуулах цаг ойрхон болсон байж магадгүй. **Ямар ч гэсэн хүн төрөлхтний нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд “тогтвортой хөгжил” гэсэн тодотгол улам бүр нэвтэрч энэ мянганд яаж хөгжихөө, хөгжлөө мөнгөөр бус, амьдралын чанар, амьдарч буй орчин, амьсгалж буй агаарынхаа хортой эсэхээр нь үнэлдэг, шалгуур хийдэгт огтолцооруу орж эхэллээ.** Ундаалдаг Туул голоо аврах, утаа униар дүүрсэн нийслэл хотынхоо бохирдлыг арилгах ажлыг зөвхөн УБ хотын Захиргаа, Байгаль Орчны Яамны ажил гэж үздэг сэтгэлгээнээс ангижирч Монголын хөгжлийн асуудал юм шүү

гэдгийг төр нь ч түмэн олон ч ойлгож ухамсарласнаар л тогтвортой хөгжлийн гараа эхэлнэ. Байгаль орчин, тогтвортой хөгжлийн яам гэсэн шинэ яам бий болгон тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг бодитойгоор хэрэгжүүлж эхлэх цаг болсныг Монголын нийгэм хэдий чинээ эрт мэдэрнэ төдий чинээ сайн.

**2. ЦЭВЭР ХҮНС.** Монголчууд бид цэвэр байгаль орчинд амьдрахаас гадна цэвэр хүнс идэх ихээхэн шаанстай. Экологийн цэвэр, натурал бүтээгдэхүүн эсвэл био, органик бүтээгдэхүүн гэх мэтээр янз бүрийн тодорхойлолттой хэдий ч уг чанартаа хүний эрүүл мэндэд хэрэгтэй цэвэр хүнсний асуудал өнөөдөр дэлхий даяар, ялангуяа хөгжилтэй орнуудын анхаарлын төвд орж шинэ зах зээл, зах зээлийн шинэ сегментүүдийг үүсгэж байна. Монголд ургадаг төмс, хүнсний ногоо, цаашдаа ургуулж болох маш олон төрлийн хүнсний болон хүнсний бус ногоо, эмийн ургамлууд, чацаргана, уртариа, Монгол малын мах, дайвар бүтээгдэхүүнүүд органик бордоо, монгол мал гэдэг байгалийн амьд органик лаборатори... энэ бүхнийг шинжлэх ухаанчаар хөгжүүлж дэмжих, тэргүүн ээлжинд санхүүжүүлэх, шинжлэх ухаан-бизнесийн үр ашигтай хэлхээ холбоог төрийн зүгээс зориуд дэмжиж урамшуулах, хувийн хэвшлийн сэдэл санаа, санаачилгыг өрнүүлэх, эрдэмтэд, бусад улс орны бүтээл туурвил, туршлага, ололтыг төрийн бодлого болгох гэх мэтээр цаг алдалгүй хэрэгжүүлж чадвал жижиг Монголын хөгжлийн өрсөлдөх том давуу тал болж чадна. Ядахдаа “Дал”, “Өнөөдөр” сонин мэтийн хэвлэлийн “шарголдуу нууранд” цуцалтгүй сэлж хөгжлийн төлөө олон санаа, саналыг дэвшүүлж байдаг “цагаан хунгуудаа” дэмжээд явбал ядахдаа оюуны ядуурал багасахсан.

Саяхан Танхимын дэргэд “Органик бүтээгдэхүүний хөгжлийн зөвлөл” байгуулсан. Органик болон экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилгоор үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” гэсэн уриаг МҮХАҮТанхимаас “Нэг органик бүтээгдэхүүн-нэг аймаг” гэсэн хөдөлгөөн болгох чиглэлээр санаачилга эхэлж байна. Хүнсчдийн холбоо болон бусад энэ чиглэлийн байгууллагуудын үүсгэл санаачлагыг бодитойгоор дэмжиж зөвхөн “хүнсний аюулгүй байдал” гэсэн талаасаа бус эрүүл, органик хүнсний бодлого талаас нь хандаж төрийн бодлогын тэргүүлэх чиглэл болгох шаардлагатай байна. Хүнсний импортын

зохистой бодлогыг гааль, татварын бодлогоор дамжуулан хэрэгжүүлэх, хүнсний биотехнологийн судалгаа ба хөгжлийн чадавхийг нэмэгдүүлэх, хүнсний импортлох үйлдвэрлэлийн зохистой чиглэлүүдийг тогтоох, Монгол орон органик хүнс, бүтээгдэхүүн экспортлогч орон болж хувирах боломж, бааз суурь нь бидэнд байна. Усалгаатай тариалан хөгжүүлэх шинэ технологи оруулж байгаа болон наранцэцгийн тос гэх мэт бүтээгдэхүүний импортыг орлох үйлдвэрлэлийн санаачилга, гадаад зах зээлийн боломж ихтэй, хүнсний болон эмийн үйлдвэрлэлд өргөн хэрэглэгддэг зарим ургамлыг тарималжуулах... гэх мэт хувийн хэвшлийн олон үүсгэл санаачилга байна.

Гагцхүү эдгээрийг “бүтээгдэхүүний хөгжил” гэсэн маркетингийн мөчлөгүүдэд нь тохирсон бодлогын арга хэрэгслээр дэмжих нь чухал байна.

**3. ЦЭВЭР ҮЙЛДВЭРЛЭЛ.** /Cleaner production гэж нэрлэдэг/ Энэ бол үйлдвэрлэлийн зорилго, үйл явц, технологи, менежментийн улам бүр хүчээ авч буй дэлхийн хэмжээний хандлага, чиглэл юм (Хавсралт 11). Голландын Засгийн газрын тусламжтайгаар Танхимаас цэвэр үйлдвэрлэлийн зарчмуудыг Монголын аж үйлдвэрийн секторт нэвтрүүлэх чиглэлээр, эрчим хүчний хэмнэлтийг урамшуулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Цэвэр үйлдвэрлэлийн үндэсний төвийг Байгаль орчны яам болон бусад холбогдох газруудтай хамтран энэ намраас бид байгуулах гэж байна. “Ногоон” хөрөнгө оруулалтыг дэмжих, “ногоон” зээлийн баталгааны сан байгуулах асуудлаар ч бодож төлөвлөж байгаа зүйл байна. Цэвэр хөгжлийн механизмын асуудал ч бас Монгол Улсад яригдаж эхэлж байна. Үйлдвэрлэлийн бааз суурь хоцрогдмол, хязгаарлагдмал Монгол орны хувьд цэвэр үйлдвэрлэлийн үзэл баримтлал, зарчмуудыг төрийн бодлогын тэргүүлэх чиглэл болгон тавибал хөгжлийн нэг өрсөлдөх давуу талын хаа суурийг тавьж байна гэсэн үг. Одоо байгаа болон цаашид хөгжих үйлдвэрлэлийн салбарууддаа цэвэр үйлдвэрлэлийн зарчмуудыг нэвтрүүлэх эдийн засаг, эрх зүйн нөхцлүүдийг бүрдүүлэх, татвар, гаалийн бодлогоор дэмжих, “ногоон” татвар, “ногоон” зээлийн механизмыг цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ашиглах гэх мэтээр “амдан хөгжих” боломж байна. Үүний зарим эхлэлүүд, тухайлбал, перлитийн үйлдвэрлэл гэх мэт импортыг орлох төдийгүй экспортын

баримжаатай хөгжүүлэх хувийн хэвшлийн үүсгэл санаачилга хэрэгжиж байна. “Сэргэн мандал” групп саяхан таар шуудай ны шинэ үйлдвэр ашиглалтад оруулсан. Энэ үйлдвэртэй танилцаж байхад орчин үеийн цэвэр үйлдвэрлэлийн үзэл баримтлал бодит амьдрал дээр, Монголын эдийн засагт хэрхэн бодит биелэлээ олж болохын сайн жишээг олж харсан. Гэтэл хашааны гадна нь “цэвэр биш үйлдвэрийн”, байгаль орчинд хор хохиролтой үйлдвэрлэлийн бодит жишээ, “гадаадын хөрөнгө оруулалт” бүхий цонхны үйлдвэр ажиллаж байх жишээтэй. Тэгвэл бид энэ хоёрын алинд нь илүү ач холбогдол өгөх, алиныг нь дэмжих бодлого барих гэдгээ сайтар цэгнэж үзэх цаг иржээ. Тийм ч учраас МҮХАҮТ-аас 10 дугаар сарын 19 -нд “Дотоодын хөрөнгө оруулагчдын анхдугаар чуулга уулзалт” санаачлан зохион байгуулж байгаа. Тиймч учраас УИХ-аар хэлэлцүүлэх татварын багц хуулинд дотоодын хөрөнгө оруулалт, цэвэр үйлдвэрлэлийг дэмжин урамшуулах заалтуудыг оруулах саналыг бид тавиад байгаа. Гагцхүү үүнийг бодлогын түвшинд ойлгож итгэл үнэмшил бий болгох, тодорхой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**4. ЦЭГЦТЭЙ БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН.** Боловсролыг тэргүүлэх чиглэл болгоно гэж олон жил ярьсан, ном судраас нүдээ анин адис авч хүндэлдэг улс төрчидтэй улс оронд энэ асуудал дээд зэргийн ойлгомжтой гэж үзээд гагцхүү энэ бодлогыг хэрхэн боловсруулж үр дүнтэй хэрэгжүүлэх асуудлыг нь П.Цагаан сайд болон түүний багийнханд үлдээе. Шинжлэх ухаан, бизнесийн хэлхээ холбоог зохистой хангах, хувийн хэвшлийн судалгаа ба хөгжлийн (R&D) чадавхи, санаачилгыг дэмжин урамшуулах, шинжлэх ухаанд хандах төрийн хандлагыг “шинжлэх ухаанч” болгох, “оюун ухаан дайжих” үйл явц зөвхөн гадагшаа бус бас дотооддоо явагдаж байна гэдгийг ойлгох хэрэгтэй байна. Мэдлэгт суурилсан нийгэм гэдэг чинь маш энгийн зүйлээс, тухайлбал шинжлэх ухаанд хандах төрийн хандлагыг өөрчлөх, түүний тэргүүлчлэлийг хөгжлийн зорилго, зорилтодоо тулгуурлан тогтоох, уур ус, байшин барилгын төлбөр, сэдэл санаа, урам зориг өгдөггүй цалин гэх мэт эд ихэвчлэн зарцуулагддаг санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх зэргээс л эхэлнэ.

2006 онд тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг Монгол даяар тэмдэглэнэ. Энэхүү их ойгоо тэмдэглэхдээ зөвхөн өнгөрсөн түүх бус хөгжлийн ирээдүй үерүүгээ хандаж тэмдэглэх хэрэгтэй

байна. Ядахдаа гадаад амьдарч, тодорхой салбаруудад амжилттай ажиллаж хэнд ч гологдохгүй яваа оюунлаг монголчуудаа урьж, “Монголын оюуны хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг” зохион байгуулж хөгжлийн төлөө шинэ санаа, чин сэтгэлийн үгийг нь сонсох хэрэгтэй юм.

**5. ЦАХИМ НИЙГЭМ.** Ийм нийгэм байгуулахын ач холбогдлыг бүхнээс хүчтэй сурталчилж “өдөөж яваа” Ерөнхий сайд, түүнийг нь хэрэгжүүлэх гэж дотроо “шатаж яваа” Ч.Сайханбилэг нарт энэ хэсгийг үлдээгээд энэ цахим нийгэм чинь компьютер гэж нэрлэгддэг тэр хайрцагнаас гадна хамгийн гол нь хүн гэдэг бас нэг тархины хайрцагнаас хамаарах болно гэдгийг л хэлье. Айл бүрт компьютер хөтөлбөрөө бас anti-spam” /spam-хүсээгүй e-mail/ хуультай хамт хэрэгжүүлэх, айл бүрийг аятай тухтай амьдрах орчин нөхцлөөр хангах, ядуурлын эсрэг дайны нэг арга хэрэгсэл болох талаас нь хандаж хэрэгжүүлбэл нийгмийн дэмжлэгийг илүү авах, бодитой хэрэгжүүлэх магадлал нь өндөрсөх бизээ. Айл бүрд компьютер гэхийн зэрэгцээ хамгийн түрүүнд айл бүрийг телевизортой болгож мэдээлэл, боловсролын сувгуудаар дамжуулан ард түмэндээ хүрч үйлчилбэл өгөөж нь их, цаг хугацаа нь ч таарахсан.

**6.”ХУДАЛДААЧИН ҮНДЭСТЭН”.** Энэ бол хүн бүр толгой дараалан худалдаа наймаа эрхлээд яв гэсэн үг бус, энэ үзэл баримтлал, бодлогыг хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагыг ул суурьтай судалж миний өмнө товч томъёолсон бодлогыг Монгол Улсын хөгжлийн бодлого болгон дэлгэрүүлж хэрэгжүүлнэ гэсэн үг. **“Сэндвич орон”, эсвэл Гуливер эдийн засгуудын дунд байдаг одой эдийн засагт ийм л бодлого шаардлагатай. Худалдаа, бизнесийг хөнгөвчлөх /trade facilitation гэж олон улсын баримт бичгүүдэд томъёологддог/ бодлого, үйл ажиллагаа нь хоёр хөршөөсөө хамаагүй илүү дэвшилттэй байх, энэ чиглэлийн эдийн засгийн дипломат үйл ажиллагааг хэрэгжүүлэх, энэ чиглэлээрээ хөгжиж буй орнуудад “сайн үлгэр жишээ” болох боломж ч шаардлага ч Монгол Улсад байна. Хэдийгээр бид далайд гарцгүй ч оюуны гарцтай гэдгээ санаж тээвэр ложистикийн хөгжлийн үндэсний хөтөлбөр боловсруулж экспорт, импортын үйл ажиллагааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, нэмэгдсэн бус өртгийг багасгах, цаг хугацаа, зардал хэмнэх чиглэлээр хийх зүйл их байна.**

Монгол шиг ийм байршил, эдийн засагтай улсад экспортыг хөгжүүлэх, дэмжин урамшуулах бодлогыг хэрэгждэггүй цаасан боть бус харин төрийн бодлогын нэг гол тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлж нийт үндэстний итгэл үнэмшил болгох хэрэгтэй байгаа юм. Дотоод зах зээл ба импортын өрсөлдөөн, импортыг орлуулах үйл явцыг зах зээлийн дохиолол, механизм, Засгийн Газрын ухаалаг оролцоог хослуулан хөгжүүлэх шаардлага үүсч буйг анхааран дээрх чиглэлүүдээр Засгийн Газар, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх хэрэгтэй байна. Сангийн Яамны дэргэд бус, Үйлдвэр Худалдааны Яамны дэргэд эсвэл бие даасан гааль тарифын зөвлөл байгуулаад (энэ нь Засгийн Газар, хувийн хэвшлийн тэнцүү төлөөлөлтэй байх) түүгээрээ дамжуулан гааль тариф, худалдаа хөнгөвчлөх асуудлыг авч хэлэлцэн шуурхай шийдвэр гаргадаг, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлага гарвал түүнийг шийдвэрлэх эрх зүйн шуурхай механизм бий болгох шаардлагатай байна. Экспортыг дэмжин урамшуулах бодлого гэдэг маань угтаа төрийн зүгээс экспортын зах зээлийн хөгжил, экспортын диверсификац, бүтээгдэхүүний хөгжилд интервенц буюу хөндлөнгөөс оролцож байгаа, оролцвол зохих талбар бөгөөд хөгжиж буй олон орнууд энэ чиглэлээр ихээхэн туршлага хуримтлуулсан. ОУВ Сангаас Монголд ийм бодлого хэрэгжүүл гэсэн зөвлөмж хэзээ ч өгөхгүй, яагаад гэвэл хэзээ ч ойлгоогүй ирсэн, ойлгох ч үгүй. Бид олон жил энэ асуудлыг ярьсан, хэрэгжүүлэх гэж оролдсон. Амжилттай болдоггүйн гол шалтгаан нь экспортыг дэмжин урамшуулах бодлогын санхүү банкны орчинг нь бүрдүүлдэггүй, их төлөв техник-эдийн засгийн талаас нь ханддагт байдаг. Монголын эдийн засаг, экспортын олон жил зэс, алт мэтийн “шар эдийн засгийн” өрөөсгөл бүтэцтэй явж ирснийг өөрчилж “шар, хар, ногоон” гэх мэтийн олон “өнгө” хосолсон экспорт, эдийн засгийн бүтэцтэй болох хэрэгтэй байна.

Эдийн засгийн өсөлтийг хангах 2И-гийн талаар өмнө дурьдсан. Entrepreneurship буюу бизнесийн овсгоо самбаачлал, empowerment буюу эдийн засаг, зах зээлийн агентуудад эрх мэдэл, эрх чөлөө, боломж бололцоог нь бүрдүүлж өгөх бодлогын орчин, энэ хоёрын дээрээс endowment буюу байгаль, хүний заяагдмал өгөгдөл, хишгийг нэмж энэхүү 3И-г хэрхэн оновчтой, үр дүнтэй хослуулан хэрэгжүүлэхээс хөгжил шалтгаална.

Энэхүү өгүүллийг бичихдээ том том онол, урсгалын төлөөлөгчдөөс ишлэл авч том, том гэхдээ амьдралаас тасархай зүйл бичихийг зорьсонгүй. Нобелийн шагналтай мундаг эдийн засагчдын бүтээлээс ч ойлгодоггүй болохоороо айгаад дурдсангүй. Гагцхүү монгол хүнийхээ хувьд Монголынхоо хөгжил, шинэтгэлийн үйл явцын гэрч нь, оролцогч нь байсан, байж байгаагийнхаа хувьд санаа бодлоо олон түмэнтэйгээ хуваалцах нь зүйтэй гэж үзсэн. Яагаад гэвэл ийм шаардлага Монгол Улсын хувьд байна. Монгол Улс эрчимтэй хөгжих хэрэгтэй байна. Монгол гэдэг жижиг улсын талаар дэлхий дээр өнөөдөр хоёр л янзын имиж байдаг; нэгдэх нь биднийг өнгөрсөн түүх, Чингис хаанаар л мэдэх, нөгөөдөх нь биднийг хэн ч мэддэггүй. Бид бүтээсэн түүхээрээ бахархахаасаа илүү бүтээх түүхээрээ бахархах хэрэгтэй байна. Өөр зам, өөр гарц байхгүй.

***2005 оны 8 дугаар сар***





*Ур хойчийнхоо  
Жогоон ирээдүйн  
төлөө!*